

“Bible Basics” in Mongolian
Duncan Heaster
Carelinks, PO Box 152, Menai NSW 2234 AUSTRALIA
www.carelinks.net info@carelinks.net

1.1 Ертөнцийн Эзэний Оршин Тогтнол

“Итгэлгүйгээр таалагдана гэдэг боломжгүй юм. Учир нь Бурхан руу ирж буй хүн Тэр байдаг гэдэгт болон өөрийг нь хайгч хүмүүст Тэр Шагнагч нь болдог гэдэгт итгэх ёстой” / Еврей 11 : 6 / Энэхүү гарын авлага нь “ Тэр байдаг” хэмээн эхэлж итгээд, Ертөнцийн Эзэн рүү очихыг хүссэн хүмүүст туслах зорилго агуулсан тул Ертөнцийн эзэн гэж байдаг хэмээх итгэл үнэмшлийг нотолсон элдэв баримт нуршин дурдсангүй. Махан биеийнхээ !өвөрмөц зохион байгуулалт, / “Би аймшигтай болоод гайхамшигтай бүтээгдсэн тул Танд талархал өргөнө. Таны үйлс бол гайхалтай бөгөөд Миний сэтгэл ч үүнийг маш сайн мэддэг юм”. Дуулал 139:14/ цэцэгний үнэмшил төрөм дизайн, цэлмэг шөнө огторгуйн уудмыг ширтэж нүд алдах гээд л эдгээр болон бусад тоо томшгүй амьдралын үнэмшилт тусгалууд атеизм буюу бурхангүйн үзлийн хуудуутай болохыг илт харуулж байна. Ертөнцийн эзэн байдаггүй гэж итгэх нь Ертөнцийн Эзэн байдаг гэж итгэхээс хавьгүй хэцүү байж таарна. Ертөнцийн эзэн гэж үгүй бол дэлхий ертөнцөд дэг журам, зорилго, туйлын тайлбар гэж үгүй болох бөгөөд иймээс ч энэ нь Эзэнд үл итгэгчийн амьдралд өөрийн тусгалаа олох болно. Үүнийг анхааралдаа авахын сацуу, хүн төрөлхтний дийлэнхи нь Ертөнцийн Эзний итгэл үнэмшилд ямар нэг хэмжээгээр итгэдэг нь гайхалтай зүйл биш бөгөөд тэр ч байтугай хүмүүсийн нь аж амьдралд материалист үзэл илт давамгайлдаг нийгэмд ч Эзнийг хүлээн зөвшөөрдөг юм.

Гэхдээ өөрөөс нь илүү хүч чадал байдаг гэсэн бүдэг бадаг ойлголттой байх, Түүнд үнэнчээр үйлчилсний хариуд Тэр өөрт нь хэрхэн хандахыг нэгд нэгэнгүй мэддэг байх хоёрын хооронд газар тэнгэр шиг ялгаа бий.

Еврейн 11 : 6 д энэ санааг:

“ Бурхан руу ирж буй хүн Тэр байдаг гэдэгт болон

2 БУРХАН

өөрийг нь хайгч хүмүүст Тэр Шагнагч нь болдог гэдэгт итгэх ёстой” хэмээжээ.

Библи судрын нэлээд хэсэг нь Ертөнцийн эзний хүмүүс болох Израильийн түүх, цаг хугацаа болон тэд Ертөнцийн эзэн гэж байдгийг хүлээн зөвшөөрсөн итгэл нь, Түүний амлалтад итгэсэн итгэлээс зөрсөн тухай түүхийг харуулдаг. Тэдний агуу их удирдагч Моссе нь тэдэнд хэлэхдээ: “ Дээд тэнгэр, доод газарт Эзэн бол Бурхан, Түүнээс өөр Бурхан байхгүй гэдгийг чи өнөөдөр зүрх сэтгэлдээ шингээж, мэдэж ав. Чи болон чиний үр удам сайн сайхан явахын тулд, чиний Бурхан Эзэнээс чамд өгч буй газар нутаг дээр бүхий л үед урт наслахын тулд чи өнөөдөр миний чамд тушааж байгаа Эзэний зарлиг тушаалыг сахь гэв.” / Дэд хууль 4: 39, 40/ гэжээ.

Ингэснээр, Ертөнцийн эзэн байдаг тухай олж мэдсэнээр бид шууд Түүнтэй харилцах боломжтой болно гэсэн үг биш гэсэн ижил дүгнэлт гарч ирж байна. Үнэхээр та бид, биднийг бүтээсэн Ертөнцийн эзэн гэж байдагт үнэн голоосоо итгэдэг бол “Бид *Эзэний зарлиг тушаалыг сахих ёстой*”. Чухам ямар зарлиг тушаал байдаг, түүнийг хэрхвэл сахин биелүүлэхийг тайлбарлахад л энэхүү цуврал сурах бичгийн маань гол зорилго оршиж байгаа юм. Энэ бүхнийг таньж мэдэхээр энэхүү Ариун Судрыг судлах явцад Ертөнцийн Эзэний оршин тогтнолд итгэх итгэл үнэмшил тань илүү их хүчийг олсон байхыг та мэдрэх болно.

“ Тиймээс итгэл нь сонсохоос, сонсох нь Христийн үгээр ирдэг. / Ром 10:17/.

Үүнтэй адил, Исаиан 43:9-12т ирээдүйн талаархи Эзэний зөгнөлийг ойлгосноор “Би бол тэр юм”/ис.43:13/ гэдгийг бидэнд мэдүүлж, өөрөөр хэлбэл, Ертөнцийн Эзэний нэрийг “Би бол Би байдаг” / Египетээс гарсан нь. 3:14/ гэдэг нь төгс үнэн болохыг харуулж байгаа юм. Ном айлдагч Паул одоогийн умард Грек дэхь Берой хэмээх хотод иржээ. Тэр, заншил ёсоор, Эзэний сайн мэдээг номлож явжээ. “ Харин тэд үгийг дуртайяа хүлээн авч, эдгээр нь үнэн эсэхийг мэдэхийн тулд Судрыг өдөр бүр нягтлан үзэж байлаа. Тэдний олонхи нь итгэв.”/Үйлс 17:11,12/ Тэд илэн далангүй байж, Библи судрыг байнга / өдөр бүр/, / эдгээр нь үнэн эсэхийг мэдэхийг тулд

/системтэй/ судалсны ачаар ийнхүү итгэжээ. Үнэн итгэл үнэмшил олж авах нь Ертөнцийн эзэн хүмүүст Эзний ертөнцөд огт хамаагүй байдлаар, гэв гэнэт сүнслэг зүрх сэтгэлийн мэс засал хийнэ гэсэн үг биш юм. Ингэхлээр Билли Грамын загалмайн аян

дайн, аль эсвэл Пентекосталын дахин амилсан цуглаанд оролцсон дэлхийн хүмүүс хэрхэн “итгэгч” чигээрээ гарах болж байна? Иймэрхүү тохиолдолд Библи судрыг өдөрт хэр зэрэг судалсан байж таарах вэ? Ийнхүү Библи дээр үндэслэсэн жинхэнэ итгэл үнэмшил үгүйлэгддэг болон яагаад ийм олон хүн евангелийн хөдөлгөөнөөс нүүрээ буруулдгийг аливаа шашинд шинээр орж ирж буй хүмүүс хожим итгэгч болоод ирэхээрээ хүлээн зөвшөөрдөг.

Энэхүү гарын авлага нь Библи судрыг шат дараалалтайгаар судлахад туслах зорилготой бөгөөд ингэснээр та ч бас итгэдэг болж болох юм. Үнэн түүх сонсох болон жинхэнэ итгэл үнэмшилтэй байхын уялдаа холбоог Түүхийн номлолд ямагт онцолж бичдэг:

- “ Синагогийн тэргүүн Крисп бүх гэрийнхнийхээ хамт Эзэнд итгэж бас коринтчуудаас олон хүн үгийг сонсоод итгэж, баптисм хүртэцгээж байлаа” /үйлс 18:8/
- “ Хүмүүс Сайн мэдээний үгийг сонсож итгэдэг. / үйлс 15:7”
- “ Бид тийнхүү тунхаглаж, та нар түүнчлэн итгэсэн билээ. /1 коринт 15:11”
- “ Энэхүү сургаалт зүйрлэл нь ийм юм. Үр нь Бурханы үг.” /лук 8:11/, “ Эзэн : Хэрэв та нар гичийн үр шиг итгэлтэй байвал,.” / Лук 17:6/, “Энэ нь бидний тунхаглаж буй итгэлийн үг юм.” / Ром 10:8/, “ эрүүл сургаалын болон итгэлийн үгсээр тэжээгдэн” /1 Тим 4:6/, “ нэр хүндтэй хүмүүст хувьчлан хэлнэ” / Гал.2:2/
- Номлогч Иохан Эзэний амьдралын тухай бичмэл түүхийг ийнхүү өгүүлсэн байдаг: “ Түүний гэрчлэл нь үнэн бөгөөд та нарыг ч мөн итгүүлэхийн тулд үнэн ярьдаг гэдгээ тэр мэднэ.” /Иох. 19:35/. Ингэхлээр “ Таны үг бол үнэн мөн.” /Иохан 17:17/ - бид үүнд итгэж мэдэх юм.

1.2 Бурханы Хувийн Зан Чанар

Ертөнцийн Эзэн бодит, биет, махан биеэрээ оршдог хүний дүрээр илэрсэн нь Библи судрын агуу их, ариун сэдэв юм. Мөн үүний зэрэгцээ Есус бол Ертөнцийн Эзэний хүү юм гэдэг нь христч үзлийн үндсэн зарчим юм. Хэрэв Ертөнцийн эзэн бодитоор оршин тогтнодог нэгэн байгаагүй сэн бол, Тэр “ Түүний алдрын

4 БУРХАН

туяа, түүний мөн чанарын бодит илэрхийлэл” /Евр. 1:3/ болох хүүтэй байх ямар ч үндэсгүй байх байсан. Түүнчлэн, хэрэв “Ертөнцийн эзэн” бидний оюун санаан дахь ойлголт төдий байсан бол, огторгуйн уудмын хаа нэгтээх бүдэг бадаг сүнс төдий байсан бол, Ертөнцийн Эзэнтэй жинхэнэ, амьд харилцаа тогтооход бэрх болох байсан биз ээ. Ихэнх шашин, Бурхны талаар ийм хийсвэр, бодит бус ойлголттой байдаг нь нэн эмгэнэлтэй.

Ертөнцийн эзэн биднээс хавьгүй агуу хүчирхэг болохоор, бид эцсийн эцэст Ертөнцийн Эзнийг нүдээр харах болно гэх амлалтад нь олон хүний итгэл яагаад алдардгийг ойлгож болох юм. Израилууд, Түүнийг бодит төрхтэй хэмээх Ертөнцийн Эзэний “ дүр төрхийг” / ИОх. 5:37/ олж харах итгэл олж чадаагүй. Ертөнцийн Эзэнийг таньж мэдэж, Ертөнцийн Эзэний үгэнд итгэснээр ийм итгэлийг олж авдаг юм:

“ Зүрхэн дотроо цэвэр ариун байгч хүмүүс ерөөлтэй еэ. Учир нь тэд Бурхныг харах болно.” /Мат 5:8/

“ Би түүн дээр өөрийн Бурханы нэр, тэнгэрээс Миний Бурханаас буун ирэх шинэ Иерасулим буюу өөрийн Бурхны хотын нэр, өөрийн шинэ нэрээ бичнэ ” /Илч 3:12/, “Боолууд нь түүнд үйлчилнэ. Мөн түүний нэр тэдний духан дээр байх болно” /Илч.22:3,4/

Бид үнэн голоосоо итгэж чадвал ийм гайхамшигт итгэл найдвар нь бидний аж амьдралд онцгой үр нөлөө авчрах юм:

“Бүх хүнтэй эвтэй байхыг болон ариусгалыг мөшгөгтүн. Үүнгүйгээр хэн ч Эзэнийг үзэхгүй болой.” /Евр.12:14/

“ Тэнгэрээр тангараглагч нь Бурханы сэнтийгээр болон дээр нь залрагч Түүгээр тангараглаж буй” / Мат.23:22/ учир бид тангараглах хэрэггүй. Хэрэв Эзэн бодитоор оршин тогтнодоггүй байсан бол энэ ямар ч учир утгагүй зүйл болох байсан.

“ Түүнийг үзэгдэх үед бид түүнтэй адил болно гэдгийг мэднэ. Учир нь бид Түүнийг яг байгаагаар нь харах болно.” /1 иох.3:2,3/

Бид Тэнгэрлэг Эцгийн тухай тун бага зүйл мэднэ. Гэвч амьдралын харанхуй дундаас Түүнтэй уулзахыг ямагт эрмэлзэх хэрэгтэй. Түүнийг сэтгэл санаандаа агуу ихээр ойлгож явдгийнхаа

ачаар бид Түүнийг бодитоор нь олж үзнэ гэдэг нь эргэлзээгүй юм. Ийнхүү Иов хүмүүн төрөлхтөний туйлын зовлон дундаас Эзэнтэй тогтоосон жинхэнэ хувийн харилцаандээ туйлын сэтгэл хангалуун байж, сүүлчийн өдөр биеэрээ биеэрээ юу амсах тухайгаа ийнхүү хэлжээ:

“ Арьс минь устгагдсан хойно ч би махан биеэрээ Бурханыг харах болой. Түүнийг би өөрөө харах бөгөөд Түүнийг, өөр хэнийг ч биш миний нүд үзэх болно.” / иов 19:26,27/

Мөн айлдагч Паул үжиг өвчин, дэг замбараагүй нүүрлэсэн өөр нэгэн зовлонт амьдрал дундаас ийнхүү хашгирчээ:

“ бид одоо толинд бүдэг бадаг хардаг ч , харин дараа нь нүүр нүүрээ харна.” / 1Кор. 13:12/

Эзэнийг зөв ойлгох нь Библи судрын судлалын бусад олон чухал хэсгийг нээн илрүүлэхэд онцгой чухал үүрэгтэй. Гэвч нэг удаа худал хэлэхэд дараагийн удаа дахин худал хэлэх болдог учраас Эзэнийг буруу ойлгох нь Библи судрын дэлгэж буй үнэний тухай системийг бүрхэгдүүлэх болно. Танд хэрэв энэ бүлэг тэр чигээрээ, магадгүй, тэн хагас нь ч бай, үнэмшилтэй санагдсан бол “ Бид үнэхээр Эзэнийг мэдэх үү?” гэдэг асуулт урган гарч ирнэ. Бид цаашид Түүний тухай Библийн сургалтаар лавшруулан судлах болно.

1.3 Бурханы Нэр ба Түүний Зан Чанар

Хэрэв Ертөнцийн Эзэн гэж байдаг бол Тэр Түүний тухай бидэнд өгүүлж чадах ямар нэг арга хэрэгсэл бүтээсэн байх нь лавтай. Библи судар бол хүн төрөлхтөнд Ертөнцийн Эзэнийг илчилж өгч байгаа учир бид үүнээс Ертөнцийн Эзэний зан чанарыг таньж илрүүлж болох юм. Чухам ийм учраас л Ертөнцийн Эзэний үгийг Түүний “ үр” хэмээн дүрсэлдэг билээ, /1 Пет. 1:23/, учир нь “Тэр өөрийн хүслээр биднийг үнэний үгээр төрүүлэв. Ингэснээр бид түүний бүтээлүүдийн анхны үр жимс нь болох юм.” /Иаков 1:18, Кор. 5:17/. “ Ийм учраас бид өөрснийгээ Эзэний ертөнцөд авачих тусам, илүү олон зүйл судлах тусам “Түүний Хүүгийн дүртэй адил болох” /Ром8:29/. “Тэр бол үл үзэгдэгч Бурханы дүр мөн бөгөөд бүх бүтээлийн ууган нь мөн. /кол.1:15/. Чухам үүнд л Библи судрын түүхэн хэсгийг судлахын ач холбогдол оршиж байгаа юм:

6 БУРХАН

үүнд Эзэн хүн төрөлхтөн болон улс үндэстэнтэй хэрхэн харилцаж байсан, ямагт үндсэн зан чанараа дэлгэн харуулдаг байсныг харуулах үй олон жишээ байгаа.

Еврэй хэлэнд хүний нэр ус нь эзнийхээ зан чанар, эсвэл тэдний талаархи мэдээллийг агуулж байдаг. Жишээлбэл:

“Исус” - “Аврагч” – учир нь “Мариагаас хүү төрнө. Тэр хүүг Есус гэж нэрлэ. Тэр хүү ард түмнээ нүгэл хилэнцээс аварна.” / Маф. 1:21/.

‘Абрахам’ = “Би чамайг олон үндэстний өвөг болгосон учир” (Эхлэл 17:5) ‘олон хүний эцэг’ мөн.

Иймээс Бурханы нэрүүд ба өргөмжилөлүүд нь Түүний талаар ихээхэн мэдээлэлүүд өгөх үндэслэлтэй юм. Учир нь Бурханы шинж чанар, зорилгын маш олон төлөвүүд байдаг юм. Түүнд үнэндээ бол нэгээс илүү Нэр бий. Усны ёслолыг үйлдсэний дараа Бурханы нэрийг нарийвчлан судлахыг зөвлөж байна. Бурханы нэрэнд илэрхийлэгддэг Түүний шинж чанар нь бид Эзэн дахь амьдралынхаа туршид бишрэн дагах ёстой зүйл билээ. Иймээс доор гарах зүйлс бол танилцуулага маягийн зүйл юм.

Моше амьдралынхаа маш хүнд үед итгэлээ бататгахын тулд Бурханы талаар гүнзгий мэдлэгтэй болохыг хүсэхэд Тэнгэр Элч “Эзний нэрийг тунхаглаж: --ЭЗЭН, ЭЗЭН Бурхан өрөвч нигүүлсэнгүй, уурлахдаа удаан ба энэрэл хайр үнэнхээр бялхам билээ. Тэр энэрэл хайрыг мянган үеийн турш хадгалж, гэмт хэрэг, гэм буруу, гүглийг уучилдаг. Гэсэн ч тэр гэмтнийг шийтгэлгүй орхихгүй.” /Египт. 34:5-7/.

Бурханы нэрүүд Түүний шинж чанарыг багтааж байгааг энэ нь тодорхой нотолж байна. Тийм нэрүүдтэй байгаа нь Бурхан бодилоор оршиж байдаг нэгэн гэдгийн нотолгоо мөн. Хүн бидэнд ч байж болох шигж чанарын эдгээр төрхүүдийг хоосон хий сүнсэнд байж болдог гэж үзвэл дэмий хэрэг болно.

Бурхан Өөрийгөө ард түмнээрээ мэдүүлж, сануулж байхаар чухам нэг Нэрийг сонгож авсан бөгөөд энэ нь хүний талаар Түүний тавьсан зорилгын товч өгүүлэмж, товчлол юм.

Израилчууд Египтэд боолууд байсан ба тэдний талаар Бурхан ямар зорилготой байгааг тэдэнд\сануулах ёстой байлаа. Тэднийг

Египтээс явж тэдэнд амалсан газарлуу хөдлөхөд нь зоригжуулахын тулд Мозег тэдэнд Бурханы нэрийг хэл хэмээсэн юм./1Кор. 10:1/. Бид усны ёслол үйлдүүлж Бурханы Хаант Улсруу хөдөлж эхлэхийн өмнө Бурханы Нэрийн гол зарчимуудыг ойлгох хэрэгтэй.

Бурхан Израильд Нэрээ ЯВХЕ гэдэг гээд “Би бол Би Байдаг” буюу зөвөөр орчуулбал ‘Би хэн болохов тэр л болно’ гэсэн утгатай гэлээ./ Египт. 3:13-15/. Энэ нэр цаашаа жаахан тэлж “Цааш нь Бурхан Мосед /нэмж өгүүлрүүн/ --Израилын хөвгүүдэд чи “Та нарын өвөг дээдсийн ЭЗЭН (Яхве) Бурхан, Абрахамын Бурхан, Исаакийн Бурхан, Иаковын Бурхан болох ЭЗЭН намайг та нар уруу илгээв...Энэ бол мөнхөд миний Нэр бөгөөд үеийн үед Миний дурсгалт нэр юм” гэж хэл гэжээ./Егип. 3:15/.

Иймээс Бурханы бүтэн нэр нь “ЭЗЭН Бурхан” бүлгээ.

Хуучин гэрээ нь ихэвчлэн Еврей хэлээр бичигдсэн байдаг бөгөөд англиар хийсэн манай орчуулгуудад еврейгээр `Бурхан` хэмээсэн үгсийг хөрвүүлэхэд мэдээж нарийн зүйлүүд нь гээгдсэн байдаг юм. `Бурхан` хэмээн орчуулсан нэг иуда үг нь `Елохим` ба энэ нь `хүчирхэгүүд` гэсэн утгатай. Тэрээр өөрийгөө Бурханы “дурсгал” болгон биднээр санагалзуулах Нэр нь тиймээс

ЯХВЕ ЕЛОХИМ

бөгөөд энэ нь

Хүчирхэгүүдийн Дотор Нээгдэх Хэн боловч Тэр Мөн болой гэсэн утгатай юм.

Тиймээс Өөрийнхөө шинж чанар, Өөрийнхөө мөн чанарыг томоохон бүлэг хүмүүст нээж өгөх нь Бурханы зорилго юм. Бид Бурханы үгийг дагсанаар одоо Түүний шинж чанарын заримаас өөрсийн дотор хөгжүүлж болох юм. Иймээс Бурхан Өөрийхөө амьдралд жинхэнэ итгэгчидэд Өөрийгөө маш хязгаарт утгаар нээж байдаг юм. Бурханы нэр бол манай ертөнц шинж чанар, мөн чанараараа Түүн лугаа адил хүмүүсээр дүүрэн болох цаг ирэхийг зөгнөсөн хэрэг билээ. /2 Петр. 1:4/ Хэрвээ бид Бурханы зорилготой холбогдож үхэлгүйгээр мөнхөд, төгөс төгөлдөр ёс суртахуун дор амьдаръя гэж хүсэж байгаа бол бид Түүний нэртэй өөрсдийгөө холбох ёстой. Ингэх зам бол Түүний нэрээр, өөрөөр хэлбэл Яхве Елохим нэрээр усны ёслол үйлдэгтүн. /Матай 28:19/

8 БУРХАН

Энэ нь биднийг, Бурхан дэлхийг залгамжлуулахаар амласан /Эхлэл 17:8;/ Абрахамын /Галатиа 3:27-29/ удам угсаа("үр"), Бурханы Нэрийн зөн билэг биелэгдэх`хүчтэнгүүд` (Елохим) бүлэг юм. Энэ талаар Хичээл 3.4-д дэлгэрэнгүй тайлбарлана.

1.4 Авралын Элч нар

Энэ хичээлээр одоогоор бидний үзээд байгаа зүйлүүдийг Тэнгэр Элчийн ойлголттой хамтруулж үзвэл Тэнгэр Элч нь:

- биет, хувь хүн
- Бурханы Нэрийг зүүж яваа
- Бурхан хүслийг биелүүлдэг Бурханы Сүнсний зам
- Түүний шинж чанар, зорилгын дагуу явдаг учраас
- Түүнийг илгэж байдаг.

`Бурхан` ыг орчуулсан хамгийн түгээмэл Еврей үг бол`Елохим` гэдгийг бид Хичээл 1.3-д үзсэн бөгөөд энэ нь үнэндээ `хүчэрхэгүүд` гэсэн утгатай юм; Бурханы Нэрийг зүүгч эдгээр `хүчирхэгүүд` Түүнтэй ойр холбоотойн хувьд `Бурхан` хэмээн нэрлэгдэж бүрнээ болох юм. Эдгээр нь бол Тэнгэр Элч нар юм.

Эхлэл 1-д өгүүлэгдсэн газар дэлхийг бүтээсэн түүхээс үзэхэд Бурхан бүтээн буй болгох талаар тодорхой тушаалууд гаргаж "тэр нь хийгдэв". Чухам Тэнгэр Элч нар тэдгээр тушаалыг гүйцэтгэсэн байна:

"Түүний үгийн дууг даган
Түүний үгийг биелүүлдэг, хүч чадалтай, Түүний тэнгэр элч нараа..." /Дуулал 103:20/

Тиймээс газар дэлхийг бүтээсэн `Бурханы` тухай бид уншихдаа чухам энэ ажлыг Тэнгэр Элч нар хийсэн гэж үзэх нь ухаалаг хэрэг болно. Иов 38:4-7 –д ч энэ санааг өгүүлсэн байдаг. Эхлэл 1-д тэмдэглэгдсэн бүтээн байгуулсан үйл явдлуудыг товчлон зангидаж одоо болох боллоо:

1 дэх өдөр "Тэгээд Бурхан

--Гэрэл бий болог! Гэсэнд гэрэл бий болов. /Ишлэл 3/

2дахь өдөр "Бурхан

--Усан дотор огторгуй бий болгож, усыг уснаас салга! гэж айлдав. Тийнхүү Бурхан огторгуйг бий болгоод, огторгуйн дээрхи усыг огторгуйн доорхи уснаас салгасанд тэр нь ёсоор болов” /ишлэл 6,7/.

3 дахь өдөр Бурхан

--Тэнгэрийн доорхи ус нэг дор хуримтлагдаж (далай тэнгисийг буй болгож), хуурай газар ил гарга! хэмээсэнд тэр нь ёсоор болжээ. / ишлэл 9/

4 дэх өдөр Бурхан

--Тэнгэр огторгуйд гэрэлтүүлэгчид байг..гэсэнд ёсоор болов. /ишлэл 14,15/

5 дахь өдөр Бурхан

--Уснууд амьтадаар дүүрч, жигүүртэн шувууд газар дэлхий дээгүүр, тэнгэр огторгуйгаар нисэг гэв...тэгээд Бурхан бүх л амьтан амьтадыг *бүтээв* /ишлэл 20,21/ өөрөөр хэлбэл “ёсоор болов”.

6 дахь өдөр Бурхан

--Газар дэлхий буюу мал адгуус, мөлхөгчид зэрэг амьтадыг төрөл төрлөөр нь бий болго...гэсэнд ёсоор болов” /ишлэл 24/

Хүн 6 дахь өдөр бтээгджээ. “Бурхан: --Бид өөрсдийнхөө дүр төрхийн дагуу Өөрсөдтэйгөө адилхан хүнийг бүтээе гэж хэлжээ” /Эхлэл 1:26/ Бид энэ мөрүүдийг Хичээл 1.2-т дурьдсан. Энд “Бурхан” зөвхөн Бурхан гэж өөрийнхөө хувьд хэлэхгүй байгааг одоогоор бид тэмдэглэхийг хүсэж байна. “Хүнийг бий болгое” хэмээсэн нь `Бурхан` нэгээс илүү хүнийг хэлж байгааг харуулж байна. Энд `Бурхан` гэж орчуулсан Еврей үг нь `Елохим` бөгөөд `Хүчэрхэгүүд` гэсэн утгыг илэрхийлж Тэнгэр элч нарыг хэлж байна. Тэнгэр элч нар биднийг санаандаа буулгасан баримтаас үзэхэд тэд гадна талдаа бидэнтэй адил төрхтэйг харуулж байна. Тиймээс тэд Бурхантай нэгэн адил шинжтэй маш бодит, тодорхой, биет нэгэн юм.

`Шинж чанар` гэдэг нь энэ утгаараа энд хэн нэгэн биет бүтэцээрээ юутай үндсээрээ ижил болохыг илэрхийлж байна. Библид хоёр `мөн чанар` байдаг бөгөөд уг үгийн утга санааны хувьд тэдгээрийг нэгэд дор авч үзэж болохгүй юм.

Бурханы Шинж Чанар / бурханлаг мөн чанар /

Нүгэл хийж чадахгүй /төгөс төгөлдөр/ /Ром. 9:14;
6:23 ср. Дуулал 90:2, Мафф. 5:48; Якоб. 1:13/
Үхэж чадахгүй, өөрөөр хэлбэл мөнх /1Тим. 6:16/

10 БУРХАН

Эрч хүч, чадалаар дүүрэн /Ис. 40:28/

Энэ нь Бурхан ба Тэнгэр Элч нарын шинж чанар бөгөөд үүнийг Иесусыг дахин амилахад өгсөн юм/Үйлс 13:34; Илч. 1:8; Евр. 1:3/. Энэ шинж чанарыг бидэнд амалсан билээ /Лук. 20:35; 2 Пет. 1:4; Ис.40:28 ср. Иш. 31/.

Хүний Шинж Чанар

Нүгэл хийдэг /Иаков. 1:13-15/ нь төрөлхийн бузар санаанаас болдог /Иер. 17:9; 7:12,-23/

Үхэх үйлтэй. Өөрөөр хэлбэл мөнх бус. /Ром. 5:12,17; 1 Кор.15:22/

Оюун санаа болоод /Иер. 10:23/ бие бялдарын хувьд эрч хүч, чадал маш хязгаартай /Ис.40:30/.

Хүн сайн ч муу ч бүгд ийм шинж чанартай байдаг. Энэ шинж чанарын төгсгөл нь үхэл юм /Ром. 6:23/. Иесус мөнхийн амьдралынхаа явцад ийм л шинж чанартай байсан юм /Евр. 2:14-18; Ром. 8:3; Иох.2:25; Мат.10:18/ .

`Nature` хэмээх англи үгний утга нилээд бүдэг байдаг нь тун тусгүй. Бид энэ үгийг “Жон өгөөмөр шижтэй. Тэрээр харамч байх тийм шинж байхгүй. Харин тэрээр хүний шинжтэй машинаараа бахархаж болох байхаа” ” гэсэн өгүүлбэрт хэрэглэж болно. Харин бид эдгээр хичээлээрээ “шинж” гэдэг энэ үгийг ийм маягаар хэрэглэхгүй юм.

Тэнгэр Элчийн Дүр Төрх

Тэнгэр Элч нар Бурханы мөн чанартай болохоороо нүгэлгүй бөгөөд нүгэл хилэнц үхлийг авчирдаг учраас /Ром. 6:23/ тэд үхэхгүй юм /Ром. 6:23/. Тэд биетээр, бодитоор оршин тогтнох ёстой. Ийм л учраас Тэнгэр Элч нар дэлхийрүү ирэхдээ ердийн хүн шиг харагддаг.

Тэнгэр Элч нар Абрахамд Бурханы үгийг хэлэхээр иржээ. Тэднийг “гурван эрс” гэж тодорхойлсон ба Абрахам тэднийг хүн дүрстэй болохоор нь анх тэдэнтэй хүн хэмээн харьцаж “Жаахан ус авчируулж та нар хөлөө угааж энэ модны дор амарна уу?” хэмээжээ /Эхлэл 18:4/.

--Тэдгээр Тэнгэр Элчийн хоёр нь Содом хотын Лотруу очив. Тэднийг Лот ба Содомын хүмүүс бас л хүн гэж үзэв. “Хоёр Тэнгэр Элч Содомруу ирж” Лот тэднийг хонохыг урьжээ. Гэтэл Содомын

эрчүүл Лотын гэрлүү ирж “Энэ шөнө чам дээр ирсэн хүмүүс хаана байна?” гэж заналхийлэх маягаар асуув. Лот тэгэхэд нь “эдгээр эрс буруу юм юу ч хийгээгүй шүү дээ” гэж гуйжээ. Тэднийг түүхэнд үнэнхээр “эрчүүл” гэж нэрлэжээ. “Эрчүүл /Тэнгэр Элч нар/ гараа сунган ” Лотыг аварсан байна. “ Тэгээд тэр эрчүүл Лотод хандан ...Бурхан энэ газрыг /Содом/ устгуулахаар биднийг илгээсэн” гэж хэлжээ.

--Шинэ Гэрээнд энэ үйл явдлыг өгүүлснээс үзэхэд Тэнгэр Элч нар хүний дүрстэй байдаг аж. “Харь хүмүүсийг дайлахыг битгий март гэснээр зарим нь /жишээ нь Лот ба Абрахам/ Тэнгэр Элч нарыг мэдэлгүй дайлжээ” /Ев. 13:2/

--Иаков гадны хүнтэй шөнөжин барилдав /Эхлэл 32:24/. Хожим нь тэр нь Тэнгэр Элч байсныг бидэнд хэлсэн юм /Хос. 12:4/.

--Гялтганасан цагаан хувцастай хоёр хүн Иесусыг дахин амилаж /Лук. 24:4/ тэнгэрт хөөрхөд /Үйлс 1:10/ дэргэд байжээ. Тэд Тэнгэр Элч нар байсан нь илт.

--“Хүний хэмжээс, өөрөөр хэлбэл Тэнгэр Элчийн хэмжээс” гэсний утгыг авч үз /Илч. 21:17/.

Тэнгэр Элч нар Нүгэл Хийдэггүй

Тэнгэр элч нар Бурханы мөн чанартай учир үхэж чадахгүй. Үүнгээс үүдэн нүгэл үхлийг авчирдаг учир тэд нүгэл үйлдэхгүй гэсэн үг юм. “Тэнгэр Элч”ийг грек ба еврейгээр анх орчуулсан нь “Элч” гэсэн утгатай байлаа. Тэнгэр Элч нар бол Бурханы үгийг дагагч, элч, зарц нар учраас тэднийг нүгэлтэй гэж бодохын аргагүй юм. Иймээс “Тэнгэр Элч” гэж орчуулагдсан “аггелос” хэмээх грек үгийг хүнтэй, өөрөөр хэлбэл усны ёслол үйлдэгч Йоханнес /Мафф. 11:10/ ба түүний элч нар /Лук.7:27/, Иесусын элч нар /Лук. 9:52/ ба Жериког тагнасан хүмүүстэй /Иаков 2:25/ холбож ярихад “ элч” гэж бас орчуулжээ. *Хүний элч* гэсэн утгаар илэрхийлэгдэх `тэнгэр элч` нар мэдээж нүгэл үйлдэх магадлалтай юм Бүх тэнгэр элч нар / зарим нэг нь бус/ төрөлхөөсөө Эзэнд дуулгавартай явдаг учир нүгэл үйлддэггүй гэдгийг доорхи ишлэлүүдээс харж болно:

“ ЭЗЭН Өөрийн сэнтийг тэнгэрт залсан бөгөөд
Түүний хаанчлал бүхнийг захирдаг.
Түүний үгийн дууг даган
Түүний үгийг биелүүлдэг, хүч чадалтай,

12 БУРХАН

Түүний тэнгэр элч нар аа, ЭЗЭНийг магтагун.
Түүний хүслийг биелүүлэн
Түүнд үйлчилдэг
Түүний түмэн цэргүүд ээ,
Та нар ЭЗЭНийг магтагун” /Дуулал 103:19-21/

“Түүний бүх тэнгэр элч нар аа, Түүнийг магтагун.
Түүний бүх цэргүүд ээ, Түүнийг магтагун.” /Дуулал 148:2/

“Харин Тэр тэнгэр элч нарын алинд нь хэзээ
“Дайснуудыг чинь Би Чиний хөлийн гишгүүр болгох хүртэл
МИний баруун гарт залрагун” гэж айлдсан бэ?
Тэд бүгдээрээ авралыг өвлөх хүмүүсийн төлөөх үйлчлэлд
илгээгдсэн үйлчлэгч сүнснүүд биш үү? / Еврей 1:13,14/

“Бүх” хэмээх үгийг удаа дараа хэрэглэсэн нь Тэнгэр элч нар сайн ба муу /нүгэлтэй/ гэж хоёр хуваагддаггүйг харуулж байна. Тэнгэр элч нарын жинхэнэ мөн чанарыг зөв зүйтэй ойлгож авснаар тэдний жинхэнэ итгэлийг олж мэдэхэд их тустай юм: “Харин тэрхүү үе хийгээд үхэгсдээс амилалтад хүрэх зохистой гэж тооцогдсон хүмүүс нь эхнэр ч авахгүй, нөхөрт ч гарахгүй. Тэд тэнгэр элч нартай адил тул цаашид үхэж чадахгүй бөгөөд амилалтын хөвгүүд тул Бурханы хөвгүүд юм.” /Лук 20:35,36/. Үүнийг ойлгох нь нэн чухал. Тэнгэр элч нар үхэж чадахгүй: “ Үхэл ... Тэнгэр элч нарыг авч одохгүй”. Хэрэв тэнгэр элч нар нүгэл үйлддэг байсан бол Эзэнийг дахин амилах үед итгэлийг нь олж авсан тэнгэр элч нар үргэлжлүүлэн нүнэл үйлдэх чадвартай хэвээр байх ёстой. Харин нүглийн хөлс бол үхэл гэдгийг “Учир нь нүглийн хөлс бол үхэл, харин Бурханы бэлэг бол бидний Эзэн Есус доторхи мөнх амь мөн” /Ром 6:23/ гэж хэлсэн байгаа учраас тэнгэр элч нар мөнх амьгүй байх байсан. Хэрэв бид нүгэл үйлдэж л байгаа бол үхэх нь дамжиггүй гэсэн үг юм. Ийм учраас Тэнгэр элч нар нүгэл үйлдэж чадна гэж хэлэх нь мөнх амь олгоно гэсэн ЭЗЭНий амлалтыг учир утгагүй болгож байна. /Лук 20:35,36/д тэнгэр элч нарын тухай өгүүлсэн нь Тэнгэр элч нарыг сайн муу гэж ангилдаггүй, тэнгэр элч нар цөм нэг ангилалд багтдагийг харуулж байна.

Хэрэв Тэнгэр элч нар нүгэл үйлдэж чаддаг байсан бол ЭЗЭН дэлхий ертөнцийн хэрэг явдал болон та бидний амьдралд зөв дүгнэлт гаргах чадваргүй байх байсан, учир нь Тэр /Дуулал 103:19-21/т Тэнгэр элч нараар дамжуулан ажилладгаа

тунхагласан билээ. /Дуулал104:4/д дурдсанчлан “Тэрээр салхийг Өөрийн элч, Галын дөлийг Өөрийн үйлчлэгч болгодог”. Ингэхээр тэнгэр элч нар ЭЗЭНд дуулгаваргүй хандах ямар ч үндэсгүй юм. Христч хүн, Эзэний Хаант улсыг дэлхий дээр залран ирж, Эзэний хүсэл бодол диваажинд байгаа лугаа адил биелээсэй, “Таны хаанчлал ирэх болтугай” /Мат.6:10/ хэмээн өдөр болгон залбирах учиртай. Хэрэв Эзэний тэнгэр элч нар диваажинд нүгэлт муу тэнгэр элч нартай өрсөлдөх болбоос Эзэний хүсэл бодол энд төгс биелж чадахгүй, түүнчлэн Эзэний хэтийн Хаант улсад мөн ийм байдал нүүрлэхэд хүрнэ. Дэлхий ертөнцөд мөнх амьдралыг өнгөрөөнө гэдэг нь нүгэл, дуулгаварт журам хоёрын хоорон дахь мөнхийн тэмцэл болно гэсэн үг. Энэ нь хэдийгээр таатай биш ч гэлээ, мэдээж, энэ гол асуудал маань биш билээ.

Гэхдээ ... ?

Олонхи “христч” сүм Тэнгэр элч нар нүгэл үйлдэж чадна, дэлхий ертөнц дээрхи нүгэл болон элдэв саад бэрхшээлийг өдөөдөг муу Тэнгэр элч нар байсаар байгаа гэж үздэг. Бид энэхүү ташаа ойлголтыг 6 дугаар хичээлээр илүү дэлгэрэнгүй үзнэ. Энэ удаа бид доорхи дүгнэлтийг хийнэ:

- Биднийг бүтээгдэхээс өмнө, өөрөөр хэлбэл Эхлэл 1т зааснаас бүр өмнө өөр нэгэн бүтээл бүтээгдсэн байж болох юм. Мөн /Эхлэл 3:5/д Та нар түүнээс идсэн тэр өдөртөө л нүд чинь нээгдэн, Бурхан шиг болж, сайн мууг мэдэх болно гэдгийг Бурхан мэддэг билээ гэжээ” гэдэгчлэн одоогийн байгаа Тэнгэр элч нар “ сайн ба муу үйлийн” ялгааг таньж мэдэхээр ирсэн байж болох юм. Тэр үед амьдарч асан бодит хүмүүсийн зарим нь нүгэл үйлдэж байсан нь хөдөлшгүй баримт. гэвч энэ бол хүмүүс дураараа дургих дуртайг харуулсан дам яриа. Нүгэл үйлддэг Тэнгэр элч гэж байдаггүй гэх өнөөгийн онолын талаар бид юу мэдвэл зохихыг Библид : Бүх Тэнгэр элч ЭЗЭНий үгийг дагадаг хэмээн сургажээ.
- /Хабаук1:13/т “ Таны мэлмий бузар мууг зөвшөөрч чадахааргүй дэндүү ариун юм” гэдэгчлэн Диваажинд бузар зүйл оршин тогтнож чадахгүй. Мөн Дуулалын 5:4,5д “ Учир нь Та бол хорон мууг таашаадаг Бурхан биш ээ. Ямар ч муу муухай нь Тантай хамт оршдоггүй ээ. Онгирон сагсуурагчид Таны мэлмийн өмнө зогсож чадахгүй Гэм

14 БУРХАН

нүгэл үйлдэгч бүгдийг Та үзэн яддаг.” Гэсэн байдаг. Диваажинд нүгэлт муу тэнгэр элч нар Эзэнтэй тэрсэлддэг гэсэн үзлийг энэхүү дуулал бүрэн үгүйсгэж байна.

- “Тэнгэр элч” хэмээн орчуулагдсан Грек үг нь “элч, төлөөлөгч” гэсэн утгатай бөгөөд бидний дээр дурьдсанчлан, бодотоор оршин тогтногч хүмүүст хамаатай байж болно. Ийм хүн “ элч, төлөөлөгч” нар, мэдээж хэрэг, нүгэл үйлдэж чадна.
- Амьдралд тохиолдох хамаг муу муухай, бузар бүхний бурууг бид муу үйл, нүгэлт оршил гээч рүү чихдэг бөгөөд энэ нь паганизм буюу онгон шүтэх ёсонд нэн түгээмэл тархсан итгэл үнэмшлийн нэг юм.

Христч үзлийн талаар онгон шүтэх ёсонд тусгагдсан зарим санаа Христийн ёсонд нэвтэрсэн нь илт ажиглагддаг.

- Нүгэлт муу Тэнгэр элч нар өнөөг хүртэл оршин тогтносоор байдаг гэж ташаа ойлгож болохоор ишлэл Библид маш их тааралддаг. Жишээлбэл, “Муу сүсний эрэлд” хэсгийг ийнхүү ташаа ойлгож болох юм. Иймэрхүү ишлэл нь бидний дэлгэн үзүүлсэн Библийн баялаг сургаалийг үгүйсгэж чадахгүй билээ.

ХИЧЭЭЛ 1: Асуултууд

1. Бурханд итгэх итгэлээ нэмэгдүүлэхэд бидэнд юу хамгийн их хэрэг болох вэ?
 - А. Сүмд явах
 - Б. Библи судрыг судлах
 - В. Христч хүмүүстэй ярилцах
 - Г. Байгалийг ажиглах

2. Доорхи тодорхойлолтуудын аль нь БУРХАНЫ хамгийн зөв тодорхойлсон байна вэ?
 - А. Оюун ухаан дахь санаа төдий
 - Б. Агаар мандаол дахь Сүнсний өчүүхэн хэсэг
 - В. Эзэн гэж байдаггүй
 - Г. Жинхэнэ, бодит хүн

3. Бурхан бол
 - А. Эв нэгдэл
 - Б. Гурвалсан холбоо
 - В. Олон бурхан нэгдсэн нэг цогц
 - Г. ямар ч аргаар тодорхойлох боломжгүй

4. “Яхвэ Елохим” хэмээх Бурханы нэр ямар учиртай вэ?
 - А. Тэр байх болно.
 - Б. Хүчирхэг хүмүүсийн дотроос илчлэгдэх болно
 - В. Агуу их нэгэн
 - Г. хүч чадал

5. “Тэнгэр элч” гэж юу гэсэн үг вэ?
 - А. Хүнтэй адилхан
 - Б. Далавчтай
 - В. Элч, зарлага
 - Г. туслах

6. Тэнгэр элч нүгэл үйлдэж чадах уу?
 - А. Тийм
 - Б. Үгүй

2.1 Тодорхойлолт

Бурхан гэж үнэнээсээ байдаг бөгөөд Тэр хүнтэй адил мэдэрч, сэтгэлийн хөөрөлд автдаг учир өөрийн үр хүүхдүүд болох бидэнтэй хүсэл зориг, сэтгэл санаагаа хуваалцаж, бидний амьдралд өөрийн шинж чанартай тохирсон арга замаар үйл ажиллагаагаа явуулж байдаг. Бурхан бүх зүйлээ Өөрийн “Ариун Сүнсээр” дамжуулж хийдэг юм. Хэрэв бид Бурханыг мэдэж, Түүнтэй идэвхтэй харилцаа тогтооё гэвэл энэнхүү “Ариун Сүнс” гэж юу болох, тэр нь хэрхэн үйлчилж байдгийг мэдэж авах хэрэгтэй.

“Ариун сүнс” гэдэг үгийг яг тодорхойлох нь амар биш юм. Хэрэв бид хуриман дээр очсон бол тэнд бүх зүйл үнэхээр ариун сайхан байлаа гэж хэлэх жишээтэй. Энэ нь хуриманд дээрх уур амьсгал нэг л сайхан байсан, тэнд бүх хүн сайхан хувцас өмссөн байх ба өөр хоорондоо эелдэг найрсагаар харилцан ярилцаж, мөн хоол унд нь элбэг дэлбэг сайхан, бэргэн нь сайхан харагдаж байсан гэх мэтчилэн санааг илэрхийлж байгаа юм. Энэ бүгд нийлээд хуримын уур амьсгалыг бүрдүүлэгч ариун сүнс нь болж байдаг. Яг үүнтэй адил Бурханы “Ариун Сүнс” нь Түүний бүхий л зүйлийг багтааж байгаа юм. Хуучин Гэрээнд “ариун сүнс”-г хөврүүлсэн Еврей үг нь “амьсгал” буюу “хүч чадал” гэсэн утгатай. Тиймээс Бурханы ариун сүнс бол түүний Түүний “амьсгал” бөгөөд Түүний оюун ухааныг тусгагч Бурханы жинхэнэ мөн чанар мөн. Бид хэн нэгний оюун ухаан болон санаа санаа сэтгэлийн талаар “ариун сүнс” хэмээх үгийг хэрхэн хэрэглэхийн жишээнүүдийг хичээл 4.3-т үзэх болно. Ариун сүнс хэмээх ойлголт нь дан ганц хүчийг илэрхийлсэн үг биш болох нь Ром 15:19-“Ариун Сүнсний Хүч” гэснээс тодорхой байна.

Хүн яаж бодно тэр нь үйл хөдлөлөөр нь илэрхийлэгдэж байдгийг Библи сургасан байдаг (Сургаалт үгс 23.7; Мат.12:34). Үүнийг батлахад бид өөрсдийнхөө үйл явдалыг жаахан бодоход л хангалттай. Бид ямар нэг юм бодоод түүнийгээ хийдэг. Үүнээс илүү яруу алдартай Бурханы сүнс мөн л адил. Тэрээр өөрийнхөө мөн чанар, Өөрийн зан чанар болон зорилгыг хүчээрээ харуулдаг юм. Бурхан боддог учир юмсийг хийдэг: “Үнэхээр Миний бодсон хэрэг биелж, Миний төлөвлөсөн ёсоор үйл бүтнэ ” . Иса (14:24).

Бурханы Хүч

Олон ишлэлүүдэд Бурханы ариун сүнсийг Түүний Хүч чадалтай хамтатган үзсэн байна. Ертөнцийг бүтээхийн тулд “Бурханы сүнс усан мандал дээгүүр элин хальж байлаа. Тэгээд Бурхан -Гэрэл бий болог! гэхэд гэрэл бий болов” (эхлэл 1:2,3) гэсэн байдаг.

Бурханы ариун сүнсийн хүчээр гэрэл гэх мэт ертөнцийн бүх л юмс бүтээгджээ. “ Түүний Сүнсээр Тэнгэр цэлмэв”, “Өөрийн мутраар тэр зугтагч могойг цоо хатгав” (Иов 26:13), “Эзэний үгээр тэнгэрүүд, амных нь амьсгалаар Тэнгэрийн бүх эрхэс бүтээгдсэн” (Дуулал 33:6) гэсэн байдаг. Тиймээс Бурханы ариун сүнсийг

Түүний амьсгал
Түүний үг
Түүний мутар

хэмээн тодорхойлдог юм.

Бурхан тиймээс өөрийн хүч чадлаараа хамаг зүйлийг бүтээдэг ажгуу. Тиймээс итгэгчид бурханы хүслээр дахин төрөв (Иох. 3:3-5) Итгэгчдийг Бурхан ариун сүнсээрээ бүтээв (Иох. 3:3-5).

Бурханы хүсэл нь ариун сүнсээр дамжиж хэрэгжидэг. Бүх л бүтэн бодит бүтээлийн тухай ярихдаа бид “ Та Өөрийн Сүнсийг илгээхэд тэд бүтээгддэг. Тэгээд Та газрын өнгө төрхийг шинэчлэдэг” (Дуулал 33:6) гэж уншдаг. Энэхүү ариун сүнс/хүч чадал нь бүх зүйлийг хадгалагч бөгөөд тэднийг бүтээх арга зам юм. Энэ эмгэнэлт амьдрал Бурханы ариун сүнсийн идэвхтэй оролцоогүйгээр бүдэрнэ гэж бодоход хялбар юм. Энэ амьдралаас залхсан Иовд өөр нэгэн сургаал айлдагч энэ тухай сануулж хэлжээ:“Хэрэв Тэрээр (Бурхан) Өөр уруугаа Өөрийн сүнс, Өөрийн амьсгалыг цуглуулсан бөгөөд хэрэв ийн үйлдэхээр шийдсэн бол, бүх бие махбодь хамтдаа үхэж, хүн шороонд буцах байсан” (Иов 34:14,15).

Биднийг болоод бүтээгдсэн бүх зүйлсэд өгөдсөн сүнс л бидний амьдралыг тэтгэгч зүйл болохыг хичээл 4.3-аас харах болно. Бидэн дотор “сүнсний амьсгаа” байдаг бөгөөд (Эхлэл 7:22) түүнийг төрөхөд маань Бурхан бидэнд өгсөн (Дуулал 104:30, Эхлэл 2:7) гэжээ. Тийм ч учир “Бүх махан биеийн сүнснүүдийн

18 БУРХАН

Бурхан Эзэн"-ийг бий болгодог (Тооллого 27:16, Еврей 12:9). Бүх бүтээгдсэн зүйлсийг тэтгэн хадгалагч нь Бурхан учир Түүний ариун сүнс нь газар сайгүй байдаг. Давидыг хаа ч явсан Бурхан Ариун сүнсээрээ дамжуулан түүнтэй ямагт хамт байсан ба тэр ариун сүнс/хүчээр дамжуулан Тэрээр Давидын бодол санаа бүрийг мэдэж чадаж байсанг Давид хүлээж зөвшөөрдөг. Ийм учир Бурхан өөрийн ариун сүнсээрээ дамжин газар сайгүй байдаг бөгөөд, өөрийн бодит бие нь тэнгэрт оршдог ажгуу.

“Миний сууж, босохыг ч хүртэл Та мэддэг. Та хаа холоос миний санаа бодлуудыг ойлгодог... Таны сүнснээс би хаашаа одож чадах вэ? Эсвэл таны оршихуйгаас би хаашаа зугтаж чадах вэ? Хэрэв би далайнх амгийн алсын хэсэгт суувал...тэнд ч Таны баруун мутар (өөрөөр хэлбэл ариун сүнсээр дамжуулан) надаас зуурах болно”(Дуулал 139:2,7,9,10)

Ариун Сүнс

Бурханы сүнс нь өргөн дэлгэр ухагдахуун болохыг бид олж мэдлээ. Энэ бол Түүний оюун санаа, зан суртахуун бөгөөд бодлоо үйл хөдлөлөөр болгож хэрэгжүүлдэг хүч нь юм. Тийм ч учир “Бүх махан биеийн сүнснүүдийн Бурхан Эзэн” (Тооллого 27:16, Еврей 12:9), хүн зүрхээрээ боддог шиг тэр ч мөн адил (Сургаал үгс 23:7), тиймээс Бурхан бол Түүний бодол учир Бурхан бол сүнс (Иохан 4:24) гэх зэргээр өгүүлсэн байдаг. Гэхдээ энэ нь Бурхан бол хүн бус гэсэн үг биш билээ. Бурханы сүнс хэмээх энэхүү өргөн их ойлголтын тухай биднийг илүү ухаарахад туслахын үүднээс бид “Ариун Сүнс ” гэсэн хэллэгтэй дайралдаг.

“Ариун Сүнс ” гэсэн томъёог бараг зөвхөн Шинэ Гэрээнд л байдаг. Библийн судруудын америк хувилбарт түүнийг голдуу Ариун Хий Үзэгдэл хэмээн хэрэглэсэн байдаг боловч ямагт Ариун Сүнс хэмээн ойлгож байвал зохилтой. Сүүлийн үеийн библүүдэд энэ утгаар нь авч хэрэглэсэн байдаг билээ. Энэ хэллэг нь Хуучин Гэрээн дэх Бурханы Сүнс буюу Эзний Сүнс гэсэнтэй адил утгатай юм. Энэ нь Пентекостын байрын өдөр Христийн дагалдагч нарт Ариун Сүнс асгарч ирсэн тухай Үйлс-2-ын мөрнүүдээс харахад илэрхий байдаг. Үүнийг Жоелийн айлдсан эш үзүүллэгийн биелэлт хэмээн Петер тайлбарласан бөгөөд түүнд “Өөрийн (Бурханы) Сүнс (Үйлс 2:7) асгарах” хэмээн тодорхойлсон байдаг юм. Мөн Лук 4:1-т “Ариун Сүнсээр дүүрсэн” Христ Иорданаас буцаж ирсэн гэдгийг өгүүлдэг. Хожим нь мөн бүлэгт Есүс “Эзэн Бурханы Сүнс миний дээр байна” хэмээн Исана

61-н биелэлтийн тухай ярьдаг. Энэ хоёр тохиолдлын хоёуланд нь (мөн өөр бусад хэсэгт ч гардаг) Ариун Сүнс хэмээх ойлголтыг Бурханы Сүнс гэдэгтэй адил утгаар хэрэглэсэн байдаг юм.

Ариун Сүнсийг Бурханы хүч чадалтай адилтгасан байдаг дараах мөрнүүдийг ч гэсэн анхааралтай ажиглана уу:

-“Ариун Сүнс чам дээр ирж хамгийн дээдийн хүч чамайг бүрхэнэ” (Лук 1:35)

-“Ариун Сүнсний хүчээр та нар...тэмдгүүд болон гайхамшгийг ариун сүнсний хүч дотор авчирсан юм”. (Ром 15:13,19)

-“Бидний сайн мэдээ...хүч ба Ариун сүнс дотод очсон юм” (1 Тес. 1:5)

-Шавь нарт Ариун Сүнс өгөх тухай “дээрээс ирэх хүчийг өмстлөө” (Лук 24:49) гэжээ.

-Христийг өөрийг нь “Ариун Сүнс ба Хүч чадлаар тосолсон” (Үйлс 10:38)

-Паул өөрийн тунхаглалыг Бурханы няцаагдашгүй хүч чадлаар тайлбарлахдаа “Миний үг болоод миний тунхаглал бол...сүнс болон хүч чадлын илрэл байсан” (1 Коринт 2:4)

2.2 Онгод

Бид Бурханы Сүнснийг Түүний Хүч чадал, бодол, зан чанар хэмээн тодорхойллоо. Тэрээр үүнийгээ сүнсээрээ хийх үйл ажиллагаанд харуулдаг. Өмнөх хэсэгт бид Бурханы сүнс хэрхэн түүний бүтээлүүдэд үйлчилж байгаа нь харагддагийг дурдсан билээ. “Түүний сүнсээр тэнгэр цэлмэсэн” (Иов 26:13) буюу өнөөгийн хүн болоод юм бүхнийг бүтээхийн тулд Бурханы Сүнс усан мандал дээгүүр элэн хальж байлаа (Эхлэл 1:2). Үүний зэрэгцээгээр бид мөн “Эзний үгээр ” гариг дэлхий бүтээгдсэн хэмээх (Дуулал 33:6) мөрүүдтэй дайралддаг ба юмс бүхэн бүтээгднэ гэж “Бурхан айлдсан” нь ёсоор болж байсанг Эхлэлд

20 БУРХАН

өгүүлсэн нт үүний жишээ юм. Тиймээс Бурханы Сүнс нь Түүний үгэнд тод томруун туссан байдаг бөгөөд энэ бид дотоод бодрол, хүсэл бодол буюу жинхэнэ “өөрсдийгээ” үгээр маш нямбай илэрхийлдэгтэй яг адил юм. “Зүрхний бялхлалаас ам ярьдаг (Матай 12:34)” хэмээн Есүс тун ухаалгаар хэлсэн байдаг. Тэгэхээр хэрэв бид үгээ цэные гэвэл эхлээд бодол дээрээ ажиллах ёстой юм. Тиймээс Бурханы үг бол Түүний сүнс буюу бодлын тусгал юм. Библи сударт Бурханы үгийг бичиж тэмдэглэж, бидэнд Бурханы сүнс болон бодлыг ойлгох боломж олгосон байдаг нь асар их ивээл юм. Тэгвэл Бурхан Өөрийн сүнсийг бичигдсэн үгээр илэрхийлэх энэ ид шидийг бусдын ОНГОДЫН үйл явцаар олж авсан юм. Энэ үг “сүнс” хэмээх үгийг тойрон суурилжээ.

12 IN-SPIRIT-ATION

“Сүнс” нь “амьсгаа” буюу амьсгалах гэсэн утгатай бөгөөд “онгод” гэдэг нь “ амьсгал дотор” гэсэн үг юм. Тиймээс Бурханы “онгод”- онд орохдоо хүмүүсийн бичсэн үгнүүд нь Бурханы Сүнсний үгүүд байсан гэсэн үг юм. Библийн талаархи мэдлэгтээ хөтлөгдөн, Бурханы талаар бүх үнэн мэдлэг олж авахад бидний хэрэгцээтэй бүхнийг хангаж байдаг нь Бурханы Сүнсний үгүүд болохыг мартажгүй байхыг Паул Тимофейд сануулсан байдаг:

“Христ Есүст итгэх итгэлээр дамжуулан авралд хүрэх мэргэн ухааныг чамд өгөх чадалтай Ариун Бичээсүүдийг чи бага наснаасаа мэдэх болсон. Судар бүр Бурханы амьсгалснаар байгаа бөгөөд заахад, зэмлэхэд, залруулахад, зөвт байдал дотор чиглүүлэхэд тустай. Энэ нь Бурханы хүн аливаа сайн үйлд бүрэн бэлтгэгдсэн байхын тулд юм” (2 Тимот 3:15-17)

Хэрэв гайхамшигт Судрууд үнэхээр цогц мэдлэгийг олгож чадах ахул Бурханы талаар үнэнийг харуулахад бидэнд ямар нэг “дотоод гэрэл ” хэрэггүй юм. Хүмүүс өөрсдийнхөө сэтгэл санаа болонтуулж өнгөрүүлж байгаа зүйлээ Бурханы мэдлэгийн талаарх эх сурвалж гэж хүмүүс хэчнээн их ярьдаг билээ! Хэрэв Бурханы онгодын үгэнд итгэх итгэлийг хүлээж авах нь хэн нэгэнийг Христичийн амьдралаар амьдрахад хангалттай гэвэл зөв зүйлийн аливаа хүч байх хэрэггүй юм. Хэрэв тийм хэрэгцээ байх аваас Бурханы үгс бидний хэрэгцээг бүрэн хангаагүй . Гэтэл Паул яваандаа Библи бидний сэтгэл зүрхийг дүүргэнэ хэмээн хэлсэн байдаг. Библийн хөлгөн судрыг гартаа бариад Бурханы Үгс юм шүү гэж жинхэнээсээ итгэхэд тун их итгэл

шаардлагатай. Еврей нар Бурханы Үгсийг танин мэдэх сонирхолтой байсаныг үгүйсгэж боломгүй бөгөөд өнөөгийн “Христчүүд” мөн адил тийм хүсэлтэй байна. Бид бүгдээрээ Еврей 4:2-г анхааран уншвал зохилтой.

“Учир нь сайн мэдээ бидэнд тунхаглагдсны адил тэдэнд ч бас тунхаглагдсан юм (Израйль эзгүй тал нутаг байхад). Гэтэл тэдний сонссон үгс тэдэнд тус болсонгүй. Яагаад гэвэл тэр үг сонсогчдын дотор итгэлээр холбогдоогүй ажээ.”

Бидэнд уламжилж ирсэн Бурханы сүнс/үгийн хүчинд бүрэн итгэхээсээ илүү итгэл үнэмшэлд дөт замаар очих нь илүү сонирхолтой байдаг байна. Өөрөөр хэлбэл Бурханы үгийг даган, тэгснээр Түүний сүнсийг өөрсдийнхөө зүрх сэтгэлд жинхэнээр нөлөөлэхэд амьдралаа аваачихаар зовлон туулахын оронд Бурханыг хүлээн зөвшөөрүүлэх зөв сайны хүч гэнэт бидэнд ирсэн нь илүү тааламжтай гэсэн үг юм.

Бурханы үгсэд оршдог сүнсний асар их хүч чадлыг хүлээж авахаас хойрогшсон энэхүү байдал нь олон “Христичүүдэд” бүх Сударуудад Бурханы онгод дүүрэн эсэхэд эргэлзэхэд хүргэжээ. Библийн судард бичсэн зүйлсийн ихэнх нь мэргэн буурал хүний хувийн үзэл бодол хэмээн тэд санацгаадаг болжээ. Ийм өрөөсгөл тайлбарыг Петер тун чадамгайгаар няцаасан байдаг.

“Бид илүү баттай болгогдсон эш үзүүллэгийн үгтэй. Үүр цайж, үүрийн цолмон зүхэнд тань гийх хүртэл, харанхуй газарт гэрэлтэж буй дэнлүүг анхаарах мэт та нар түүнд анхаарал тавихдаа сайн байдаг. Судрын нэг ч эш үзүүллэг эш үгүүлэгчийн өөрийнх нь тайлбараар ирээгүйг юуны түрүүнд мэдэгтүн. Учир нь нэг ч эш үзүүллэг хэзээ ч хүний хүслээр хийгдсэнгүй, харин Ариун Сүнсээр хөндөгдсөн хүмүүс бурхнаас айлджээ” (2 Петер 1:19-21).

Бид Библийн үгс Бурхны үгс гэдгийг “юунаас түрүүнд” ойлгох ёстой.

22 БУРХАН

Библийг туурвисад

Ариун Судруудын бүрэн онгодод итгэх нь амин чухал юм. Библийг туурвисан хүмүүсийг сүнсэнд хөдөлшгүйгээр хөтлөгдсөн байсан учир бичсэн үгс нь тэдний өөрсдийн үгс биш байлаа. Бурханы Үг бол үнэн (Иохан 17:17) бөгөөд зэмлэж, залруулж (2 Тимот 3:16,17) байдаг тул үнэнд эмзэглэдэг хүмүүс хүлээж авдаггүй нь гайхалтай зүйл биш ажээ. Дагалдагч Эш үзүүлэгч Иеремиа Бурханаас онгодуулсан үгсийг ярьсаныхаа төлөө ихээхэн зовлон амссан учир дамжуулсан үгсийг тэмдэглэж, тараахгүй байхаар шийддэг. Гэвч Бурханы Үгсийг бичих нь хүний хүслээс илүүтэйгээр Бурханы Хүслийн үр дүн тул тэр “Ариун Сүнс хөтлүүлснээр” түүнд өөр сонголтгүйх аргагүй болсон юм. “ Би бүх өдрийн турш доог тохуу болов. Хүн бүр намайг тохуурхасан юм. Харин хэрэв би “Би түүнийг дурсахгүй. Түүний нэрээр ярихгүй” гэвэл энэ нь миний сэтгэл зүрхэнд ясаар минь хаагдан хүрээлэгдсэн шатаж буй гал мэт болно. Би түүнийг дотроо хадгалахаас залхаж, би түүнийг тэсвэрлэж үл чадна” (Иеремиа 20:7-9).

Хэрэв энэ хүмүүс онгодыг дутуу хүртсэн бол бид Бурханы жинхэнэ үнэн Үг буюу Сүнсэнд хүрч чадахгүй байхсан. Хэрэв тэдний бичсэн зүйлс үнэхээр Бурханы Үг байсан ахул тэд онгодын үедээ Бурханы Сүнсэнд бүрэн эзэмдүүлдсэн байх ёстой байв. Хэрэв тийм биш бол бүтээгдэхүүн нь цэвэр Бурханы Үг байх ёсгүй билээ. Бурханы Үгийг бүрэн Түүнийх гэдгийг хүлээн авах нь биднийг илүү ихийг уншиж, түүнийг дагах эрмэлзэлтэй болгоно. “Таны үг бол маш цэвэр тунгалаг байна. Тиймээс таны зарц түүнийг хайрладаг юм (Дуулал. 119:140)”.

Ийм учир Библийн хөлгөн судар нь ямар нэг хүмүүсийн туурвисан уран зохиол биш харин Өөрийн сүнсээрээ дамжуулан хийсэн Бурханы бүтээл юм. Үүний үнэн гэдгийг Шинэ Гэрээ, Хуучин Гэрээнд өгүүлсэнийг дурьдсан байдгийг бодож үзэхэд харагдана:-

- Матай 2:5 –д хэрхэн “эш үзүүлэгчээр дамжуулан бичиж” - Бурхан тэднээр дамжуулан бичсэнийг өгүүлдэг.
- “Ариун Сүнс Давидын амаар урьдаас хэлсэн...” (Үйлс 1:6, Петер ингэж Дуулалаас иш татсан байдаг. Еврей 3:7)

Ийм учраас Библийн хүмүүн зохиогчид эхэн үеийн Христэд итгэгчдэд харьцангуй чухал биш байсан. Харин тэдний үгс Бурханы Сүнсээр онгодуулсан байсан нь чухал юм.

Бурханы Үгийн Хүч

Бурханы сүнс нь зөвхөн түүний оюун санаа/зан суртахуунтай холбоотой төдийгүй Өөрийн бодлоо илэрхийлж байдаг Түүний Хүчтэй холбоотой байдаг билээ. Тиймээс түүний сүнс-үгс нь зөвхөн Түүний оюун санааг илэрхийлээд зогсохгүй тэр үг өөртөө эрчимт хүчийг агуулж байдаг юм.

Тэр хүчийг үнэнээсээ үнэлэх нь түүнийг хэрэглэх хүслийг бидэнд төрүүлдэг. Бурханы үгийг даган биширвэл биднийг амьдралын аар саар зүйлд эзэмдүүлэхээс хурдан зайлсхийж, авралд хүрэхэд шаардлагатай хүчийг өгдөг гэсэн мэдлэгээрээ бид дээрхтэй хобоотой гардаг эвгүй, тавгүй байдлыг давж гарах юм. Үүнийг үзэж мэдсэн Паул:

“Би Христийн сайн мэдээнээс ичихгүй. Энэ бол авралд хүргэх Бурханы хүч мөн (Ром 1:16)”

Лук 1:37-д үүнтэй ижил санаагаар “Бурханд боломжгүй зүйл гэж нэг ч байхгүй” гэжээ.

Библийг судлан шинжилж, түүнийг өөрсдийнхээ амьдралд нэвтрүүлэх нь тиймээс их эрч хүч мөн. Энэ нь цөөн хэдэн өгүүлбрийг товчхон иш татдаг, тэдгээрийг ойлгох, хэрэгжүүлэх талаар чармайлт гаргадаггүй шашин судлаачдын хүйтэн хөндий, шинжлэх ухааны аргачлал юмуу олон сүмийн “тавтай байгаа” христийн шүтлэгтэй огт холбоогүй юм. “Бурханы Үг шаламгай (бодитой) бөгөөд үнэн”, “Түүний (Бурханы) хүчний үг” (Еврей 4:12, 1:3). “Бурханы захисан үг...итгэдэг та нарын дотор бас ажлаа хийдэг” (1 Тесалоник 2:13). Бурхан Үгээр дамжуулан жинхэнэ итгэгчдийн оюун санаанд өдөр бүр, цаг мөч тутамд өөрийн ажиллаж байдаг ажээ.

Тиймээс таны суралцаж байгаа Христийн Сайн Мэдээний гол санаа нь Бурханы үнэн хүч юм. Хэрэв та түүнийг сонсвол энэ нь таныг Бурханы хүүхэд болгож чадна. Бурханы сүнс/оюун санааг энэ амьдралд ямар нэг хэмжээгээр харуулж, Христийг эргэн ирэхэд болох Бурханы сүнслэг шинж чанар уруу өөрчилөгдөхөд

24 БУРХАН

таныг бэлтгэнэ (2 Петр 1:4). Паулын номлол нь “ Сүнсний ба хүчний илэрлээр байсан” (1 Корин 2:4) юм.

Хэдийгээр Христэд үнэнч гэж хэдийгээр өөрсдийгөө хэлж байгаа боловч Библийг Бурханы Үг хэмээн хагас итгэдэг хүмүүс БИДНИЙ эргэн тойронд байна. Тэд Бурханд итгэдэг гэдэг мөртлөө Түүнийг бодитой хүн гэдгийг хүлээж авдаггүй. Тэд Судрууд бүрэн төгс онгод оруулдаг ба бидний хувь хүний сэтгэл, итгэлийн дээр байдаг гэдгийг няцааснаараа Бурхан хүчийг няцааж байгаа хэрэг юм. Үүнтэй холбогдуулан 2 Тимот 3:5 гэсэн ишлэлийг дурдвал “бурханлаг байдлын дүртэй байх боловч түүний хүчийг үгүйсгэдэг” хэмээсэн нь Христийн Сайн Мэдээг хамруулсан хэрэг юм.

Манай фунтаантилизмыг (шашны журмыг туйлбартай дагах) нь бидний дэлхийдахин дооголдог. (“Чи арай ингэж итгэдэг юм биш биз?” гэх зэргээр илэрдэг). Тэрчлэн Паул болон түүний номлогчдыг ч мөн тэгсэн: “Загалмайд мөргөн бишрэх нь тэдний хувьд тэнэглэл боловч аврагдсан бидэнд Бурханы хүч юм” (1 Корин 1:18) гэсэн байдаг.

Энэ бүхнийг анхааралдаа авч бид бүгдээрээ Библийг агуу хүндэтгэлтэйгээр гартаа барин, урьд урьдынхаас илүү хичээл зүтгэл гарган, түүнийг ойлгож, дагахын тулд улам шаргуу уншиж болохгүй гэж үү.

Бурханы Дэлхийд Түүний Хүмүүсийн Хандах Хандлага

Библид бичигдснийг нарийвчлан уншвал Библийг бичигчид зөвхөн өөрсдийгээ төдийгүй бусад Библийг бичигсдийг ч онгод авсанаар хандаж байжээ.Эзэн Есүс хэн бүхнээс илүү юм. Есүс Давидын дуулалаас иш татахдаа үүнийг үгээр илэрхийлсэн байдаг. “Давид сүнсээрээ” гэж хэлснээрээ Давидын Бурханы үгийг дамжуулж байсныг мэдэж байснаа харуулсан юм (Матай 22:43). Мөн Есүс Мосегийн “бичээс”-ийн (Сургаалт Үгс 5:45-47)талаар ярьж байхдаа Мосег **Пентатюхыг** бичсэнг итгэж байгаа харуулсан юм. “Илүү өндөр шүүмжлэгч” хэмээн нэрлэгддэг Христичүүд Мосег бичсэн гэдэгт эргэлздэг боловч Есүсын хандлага тэдний буруу гэдгийг харуулдаг билээ. Тэрбээр Мосегийн бичээсүүдийг “Бурханы хуулиад” хэмээн нэрлэсэн байдаг (Марк 7:8,9). Шударга бус, эргэлзэгчдийн бүлэг Хуучин Гэрээний ихэнхийг домог хэмээн хэлж боловч Есүс эсвэл Паул

нар ханддаггүй юм. Есүс Өмнөдийн Хатан Хааныг түүхийн хүлээн зөвшөөрөгдсөн баримт гэж ярьсан (Матай 12:42). Гэхдээ тэр “Өмнөдийн Хатан Хааны түүх ингэж үргэлжилдэг” гэж хэлээгүй билээ.

Есүсийн Дагалдагч нарын хандлага Эзэнийхтэйгээ төстөй байсныг Петр “Есүсийн үгийг сонсоход ‘илүү баттай болгогдсон эш үзүүлэгийн үг’ (2 Петр 1:19-21) халхалж байна” гэж хэлсэнээрээ харуулсан. Паулын захианууд “Судрууд”ын адил “Судар” байсанд Петр итгэж байжээ. “Бусад Судрууд” нь Хуучин гэрээний бичээсийг ийн нэрлэж байжээ.Тиймээс Петрийн хувьд Паулын захидлууд Хуучин Гэрээний шиг даган мөрдвөл зохих сургаал байв.

Есүсийн Сайн Мэдээний талаар шууд бусаар илэрхийлсэн зүйлс Үйлс, Ефес, Илчлэлт зэрэгт олонтой дурдагдсан байдаг (Үйлс 13:51, Матай 10:14). Тэдгээр нь бүгд “нэг сүнс”ээр онгод орж байсан төдийгүй Шинэ Гэрээг бичигчид нь Сайн мэдээнд бичигдсэн зүйлүүдийг нь урамшуулан зоригжуулж байсан гэж үздэг. 1 Тимот 5:18 –д Паул Дэд Хууль 25:4 (Хуучин Гэрээнд) болон Лук 10:7-г “Судар” гэсэн байдаг. Паул хэлсэн үгээ өөрийнх нь биш Бурханы Үг гэдгийг дахин дахин сануулдаг байв (Галат 1:11.12; 1 Кор. 2:13; 11:23; 15:3). Үүнийг бусад шавь нар ч хүлээн зөвшөөрсөн байдаг бөгөөд тийм ч учир Иаков 4:5–д Паулын Галат 5:17-д хэлснийг иш татан “Судар” хэмээсэн байдаг.

Бурхан Христээр дамжуулан бидэнтэй “ярьжээ”. Тиймээс цаашид дахин өөр илчлэлт хэрэггүй (Еврей 1:2) хэмээсэн байдаг. Библид өнөөгийн бидэнд байхгүй байгаа ирээгүй бусад бичээсүүдийг онгодоор бичигдсэн гэдгийг дурдсан байдаг нь ажиглагддаг.(жишээ нь Яширын ном, Натан, Илиах, Паулаас нараас Коринтод бичсэн зүйлүүд мөн Иоханы гуравдугаар захиа зэрэг нь диотрефис дагахаас татгалзсан сүм уруу Иоханы захиа бичсэн боловч тэр нь хадаглагдаагүйг харуулдаг). Яагаад эдгээр захиа бидэнд уламжлагдаж ирсэнгүй вэ? Яагаад гэвэл тэд бидэнд нэг их хамаагүй байсан бололтой. Тийм учир Бурхан бидэнд хэрэгтэй бүх Судруудыг уламжлан ирүүлсэн хэмээн сэтгэл амар байж болох юм.

Шинэ Гэрээний номнуудыг онгод хүртсэн гэдгийг аажимдаа хүлээж авсан гэж заримдаа ярьдаг. Гэтэл Христийн дагалдагч нар нэг нэгнийхээ бичсэн захидлыг Бурханы үг гэж үздэг байсан

26 БУРХАН

нь энэ ойлголтыг няцааж байгаа юм. Эдгээр захидлууд болон үгсийг үнэхээр онгод хүртсэн үү үгүй юу гэдгийг шалгах Сүнсний гайхамшигтай бэлэг байсан юм (1 Кор. 14:37; 1 Иоh. 4:1; Илчлэлт. 2:2). Эдгээр онгодтой захидлуудыг тэр даруйд нь онгодтой хэмээн хүлээж авсан . Хэрэв Библид ямар ч захиргаагүйгээр хүний сонголт юморсон бол энэ ном нь ямар ч эрх мэдэлгүй байх байсан.

2.3 Ариун Сүнсний бэлгүүд

Янз бүрийн үед Бурхан хүмүүстэй харилцахдаа Өөрийн хүчийг (“Ариун Сүнсийг”) эрчүүлд хэрэглүүлэхээр шилжүүлж байжээ. Гэхдээ энэ нь хүнд юу дуртайгаа хийг гэж “хоосон чек”-ийн хэлбэрээр бус харин энэ Ариун сүнсээ ямагт тусгай зорилготой хэрэглүүлэхээр өгч байжээ. Ариун сүнсний бэлгийг тэр зорилго биеллэгц татаж авдаг. Бурханы сүнс Бурхан оюун санаанд буй зорилгыг тулсахын тулд ажилладаг гэдгийг бид мартаж болохгүй. Түний алс хэтийн зорилгыг биелүүлэхийн тулд хүмүүсийн амьдралд богино хугацаанд зовж шаналах явдал тохиолддог (Хичээл 6.1-ийг үз). Тиймээс Түүний Ариун Сүнс нь энэ дэлхийн зовлон шаналалыг арилгахад тэр бүр зориулагддаггүй гэж ойлговол зохино. Хэрэв энэхүү зовлон шаналалаас үнэхээр арилгавал Бурхан бидэнд санаагаа илтгэх илүү өндөр зорилт байсан цагт л тохиолдоно.

Энэ нь өнөөдөр Ариун Сүнсэнд Христичдийн нийтлэг ханддаг хандлагатай зөрчилддөг. Учир нь тэд Христэд итгэснээр өвчинөөс эдгэрэх зэрэг Ариун Сүнс өгнө гэж боддог биет ашиг тусын төлөө Христэд итгэдэг гэсэн сэтгэгдэл төрж байгаа юм. Уганда зэрэг хямрал зөрчилдөөнд идэгдсэн улс орнуудад өвчин анагаах Сүнсний бэлэг эзэмшсэн гэх хүмүүс үй олноороо гардгийн учир шалтгаан нь энэ юм. Түүхийн үүднээс ийм ярианууд хүмүүсийн хэрэгцээ маш их байгаа үетэй давхцдаг. Энэ нь сүнсний бэлгийг эзэмшсэн тухай одооны яриаг эргээд эргэлзээтэй болгож байгаа юм. Хэрэв хүн одооны хүний зовлон гамшгийг давах ямар нэгэн аргыг хайж байгаа бол тэрэнд тохирсон арга оллоо гэж хэлэхэд амархан юм.

“Христийн” сүнсний ивээлийг хүртсэн гэх олон Христичүүд байдаг хэдий ч тэднээс уг ивээлийн зорилго юунд оршиж буйг асуухад

мэдэхгүй байдаг нь олонтой. Бурхан ямагт тусгай, тодорхой зорилгоор Өөрийн сүнсээ зориулж иржээ. Ийм учраас тэрхүү Сүнсний бэлгийг жинхэнээрээ хүртсэн хүмүүс түүнийг юунд зориулахаа яг мэдэж байсан учир амжилт нь хангалтгүй байдаггүй. Гэтэл энэ нь өнөөдөр хүнийг анагаах сүнсний бэлгийг хүртсэн гэх хүмүүс заримдаа нөгөө хүнээ бүрэн эдгээж чадахгүй, эсвэл хагас хугас эмчиливч байгаа явдалтай харшилж байна.

Сүнсний бэлгийн цаана тусгай шалтгаан, зорилго агуулагдаж байдгийг дараах жишээнүүд харуулж өгнө. Эдгээр сүнсний бэлгийг хүртсэн явдалтай холбоотой ямар ч хувь хүний шинж байхгүй ба тэр бэлгийг хүртсэн гэх боловч тэдгээрийг дуртай үедээ хэрэглэж чадах тийм ч хүмүүс байгаагүй.

Бид Бурханы сүнсний талаар ярьж байгаа учир, түүний зорилгыг хүн өөрчилнө гэдэг байж боломжгүй. Учир нь сүнсний бэлгүүд нь зөвхөн Бурханы хүсэл зоригийг биелүүлэхэд зориулагдсан болохоос түр зуур хэрэглэсэн хүмүүст өгөгдсөн байдаг. (Иса. 40:13).

-Эртний Израйлийн түүхэнд хүмүүст шүтээн гэх мэт ариун эд зүйлсийг хадгалах зориулалттай асар барих тушаал өгсөн тухай гардаг. Улмаар Бурханыг шүтэн бишрэхэд шаардлагатай эд зүйл бүрийг хэрхэн бүтээх талаар зааварчилгааг хамт өгчээ. Үүний тулд Бурхан Өөрийн сүнсээ тодорхой хэдэн хүмүүст хүртээжээ. Тэд “Аароны хувцас хийх мэргэн ухааны сүнсээр дүүрсэн” хүмүүс байв. (Египетээс гарсан нь 28:3)

-Тэр хүмүүсийн нэг болох Безалел “мэргэн ухаан, мэдлэг, бүх талын ур чадварт Бурханы сүнсээр дүүрсэн нь алт мэтсээр уран хийцтэй зүйлсийг хийлгэж суулгах чулуунуудыг засуулах...зэрэг бүх талын ур чадвараар ажиллуулах”(Египетээс гарсан нь 31:3-5) болжээ.

- Тооллого 11:14-17 –д Мосед тулгарсан дарамт шахалтыг нимгэлэхийн тулд хүмүүсийн гомдлыг зөв шүүлгэх зорилгоор Мосет оногдуулсан байсан сүнс/хүчний заримыг Израйлийн ахмадуудад өгсөн тухай гардаг. Мосег үхэхийн өмнөхөн Иошуад шилжин орсоноор тэр Бурханы хүмүүсийг зөв зохистой

28 БУРХАН

удирдуулахын тулд түүний сүнсний бэлгийг түүнд өгсөн юм. (Дэд хууль 34:9).

- Израйлчууд өөрсдийн газар уруугаа орсон цагаас анхны хааныг (Саул) тодрох хүртлэх хугацаанд тэднийг шүүгчид хэмээн нэрлэгддэг хүмүүс захирдаг байжээ. Энэ зуур тэднийг дайснууд нь байнга даралж байсан бөгөөд энэ үед Израйлыг гайхамшигтайгаар эзлэн түрэмгийлэгчдийн дороос гаргах зорилгоор Бурханы Сүнс хэрхэн шүүгчид нарын зарим дээр бууж ирсэн тухай шүүгчидийн тэмдэглэлд бичигдсэн байдаг. Отнейл (Иуда. 3:10), Гидеон (Иуда. 6:34) болон Иефтан (Иуда.11.29) зэрэг нь үүний жишээ юм.

- Шүүгчидийн нэг болох Самсонд арслан бар (Иуда. 14:5,6) болон 30 хүн (Иуда 14:19) алж, өөрийг нь уясан хүлээсийг тас татах (Иуда 15:14) сүнсний хүчийг

- хайрласан байдаг. Эндээс харахад Самсон "Ариун Сүнс"-ийг байнга эзэмшдэг байгаагүй нь харагдаж байна- тэр тусгай зорилгоор түүнд дээр ирж дараа нь буцан явдаг байжээ.

Энэ бүгдээс үндэслэн үзэхэд Бурханы сүнсийг тодорхой зорилгод хэрэлэхээр хүлээж авах нь:-

- Авралын баталгаа биш
- Хүний амьдралын туршид хадгалагддаг зүйл биш
- Тэдэн доторх нууцлаг хүч биш
- 'Хүний амьдралын баяр баясгалант мөчид орж ирдэг зүйл ажээ.

Ариун Сүнсийг хүнд яагаад илгээдгийг хүмүүс тун бүрхэг тайлбарладгийг энд тэмдэглэх ёстой юм. 'Ариун Сүнсийг хүлээж авсан' гэж хүмүүс хэлдэг. Сайн Мэдээний Танхимд нэлээдэд нь сургаал айлдагч "Есүсийг хүлээж авах" талаар бодож байгаа. Хүмүүсийн өмнө "сүнсний бэлгүүдийг хүлээж авах"-ын лууванг (өгөөш) харуулдаг. Гэвч аль бэлгүүд? гэсэн асуултыг шаргуу асуух ёстой. Хүмүүс ямар бэлгийг хүртсэнээ өөрсдөө мэддэггүй байна гэдэг нь ойлгомжгүй. Самсонд арсланг алах сүнсний

хүчийг бэлэглэн өгсөн (Иуда. 14:5,6) бөгөөд тэрбээр архиран дайрах арслантай тулгарах мөчдөө чухам ямар сүнс өгөдснийг мэдсэн байх учиртай. Түүний оюун санаад эргэлзээ байхгүй байсан байх. Энэ нь Ариун Сүнснийг хүлээн авсан гэж өнөөдөр ярьж явдаг мөртлөө тусгай зүйлсийг хийж чаддаггүй, эсвэл өөрсдөд нь ямар бэлэг өгсөнийг мэддэггүй хүмүүсийн яриатай зөрчилдөж байна.

1-ээр зууны бэлэгүүдийн шалтгаан

Есүсийн өөрийн дагалдагч нартаа сүүлчийн тушаалаа өгчээ. Тэднийг дэлхийг тойрон явж, Сайхан Мэдээг дуулгахыг хүсчээ. (Марк 16:15, 16) Тэд энэ хүслийг ёсоор болгохдоо Христийн үхэл, ялангуяа түүний дахин амилах мэдээг түгээжээ. Гэвч энэ үед Шинэ Гэрээ байгаагүйг анхаарах хэрэгтэй. Тэд зах зээл, сүм хийдийн газар зогсож, Назарын Есүс хэмээх хүний тухай ярьж байлаа. Бүх талаараа төгс төгөлдөр Израйлийн нэгэн дархан үхээд дараа нь Хуучин Гэрээний эш үзүүлэлийн нарийн биелэлтээр дахин амилагдаж, одоо хүмүүсийг баптисм хүртэж түүний жишээгээр дагахыг хүсч байгаа тухай яриа хүмүүст хачин этгээд сонсогдсон бизээ.

Тэр үед өөр итгэл бишрэл төрүүлж, хүмүүсийг дагуулах гэсэн хүмүүс олон байжээ. Христидийн тунхагласан мэдээг умарт Израйлийн загасчдын

гаргасан гүн ухаан биш харин Бурханаас Өөрөөс нь ирсэн гэдгийг дэлхийд нотлох ямар нэг зам байх ёстой байлаа.

Өдгөө цагт бидний хэлсэн үг Бурханаас ирсэн гэдгийг харуулахын тулд Шинэ Гэрээнд өгүүлсэн Есүстийн ажил үйлс, сургаалийн талаар ишлэл авдаг. Гэтэл ийм зүйл бичигдээгүй байсан тэр цаг үед номлогчдын ярьж байсан зүйлийг үнэн гэдгийг харуулах зорилгоор Бурхан Өөрийнхээ Ариун Сүнснийг ашиглахыг зөвшөөрчээ. Энэ нь түүний өгсөн бэлгийн цаад зорилго байлаа. Шинэ Гэрээ байхгүй бол шинээр итгэгчдийг итгэл бишрэлд нь гүнзгийрүүлэхэд бэрхшээл учруулах байв. Тэдний өмнө тоо томшгүй олон бэрхшээл тохиолдож байсан тул тэдэнд Христэд итгэх итгэлдээ лавшран ороход нь зааж чиглүүлэх зүйл хэрэгтэй байлаа. Ийм л учир шалтгаанаар Бурхан Ариун Сүнснийн бэлгийг ишлэлүүдээр дамжуулан өгч тэднийг Шинэ Гэрээнд эдгээр

30 БУРХАН

ишлэлүүд болон Есүсийн сургаалийг бичиж тэмдэглэлтэл эхэн үеийн итгэгчдэд өгч байжээ.

Ариун Сүнсний өгөх болсон шалтгааныг хангалттай тайлбарласан байдаг:-

- Тэрээр (Есүс) “өндөрт дээш (тэнгэрт) гарахдаа... хүмүүст бэлгүүд өгсөн...эдгээр нь ариун хүмүүсийн үйлчлэлийн /номлолын\ ажилд бэлтгэж, Христийн биеийг байгуулахын тулд юм”, өөрөөр хэлбэл итгэгчдэд. (Ефес 4:8:12).

- Ингэхээр Паул Ром дахь итгэгчдэд “...Та нарыг бат болгохын тулд сүнслэг зарим бэлгийг та нартай хуваалцах гэсэндээ би та нарыг харахыг ихэд хүсдэг” (Ром 1:11) хэмээн бичжээ..

Сайн Мэдээг түгээхийг баттай болгохыг тулд бэлэг хэрэглэх талаар бид дараах зүйлсээс уншдаг :-

- “Бидний Сайн Мэдээ та нарт зөвхөн үгээр очоогүй, мөн хүч ба ариун сүнс дотор бүрэн баталгаагаар очсон юм”. Энэ нь гайхамшигаар дамжуулан хийгджээ. /1 Тес. 1:5ь, Кор. 1:5,6/

- “Христийн надаар дамжуулан харь үндэстнүүдийг дуулгавартай байдалд үгээр /ид шидэт/ болон үйлээр минь тэмдгүүд болон гайхамшигийн хүч дотор Арин Сүнсний хүч дотор авчирсан юм” (Ром 15:18:19) тухай Пол ярьжээ.

- Сайн Мэдээг түгээгчидийн тухайд бол “Бурхан өөрийн хүслийн дагуу тэмдэг хийгээд гайхамшигаар, Ариун Сүнсний бэлгүүдээр дамжуулан тэдний хамт гэрчилсэн билээ” хэмээн бид уншдаг. (Еврей 2:4).

- Кипрт Сайн Мэдээг түгээх явдал гайхамшигаар тэтгэсэн бөгөөд ингэснээр “Болсон явдлыг харсан мөнөөх захирагч тэдний сургаальд гайхширан итгэжээ” (Үйлс 14:12).

Ийнхүү гайхамшиг мөнөөх айлдаж байсан номлолуудад итгэхэд хүргэжээ. Икониумд мөн “Эзэнд...өөрийн нигүүслийн үгээ гэрчлэн, тэдний гараар дамжуулан гайхамшиг, тэмдгүүдийг соёрхож байлаа” (Үйлс 14:3).

Энэ бүгдийг номлол хийх зарилагийг дагасан элч нарын талаар өгүүлэхдээ нэгтгэж хэлсэн байдаг: “Тэд явж, газар сайгүй тунхаглажээ. Эзэн тэдэнтэй хамт ажиллаж, үгийг дагалдах тэмдгүүдээр баталж өгчээ” (Марк 16:20).

Тодорхой Цагт Тодорхой Зүйлс

Ийнхүү сүнсний энэ бэлгүүдийг тодорхой зүйлсийг тодорхой цагт хийлгүүлэхээр өгөгдсөн байна. Энэ нь бэлгийг гайхамшигтайгаар эзэмшсэн нь насан туршид байх юм гэж ярих нь алдаа гэдгийг харуулж байна. Петр болон Элч нар Есүстийг тэнгэрт хальсаны дараахан Пентекостийн найран дээр “Ариун Сүнсээр дүүрч”ээ (Үйлс 2:4). Тийм учраас л тэд Христийн Сайн Мэдээг онцгой арга замаар номлохын тулд гадаад хэлүүдээр ярьж чаддаг байлаа. Эрх дархтнууд тэднийг нухчин дарахыг оролдоход “Петр Ариун Сүнсээр дүүрч”, тэдэнд итгэлтэйгээр хариулсан байдаг (Үйлс 4:13). Шоронгоос суллагдсаны дараа өөсрдөд нь өгсөн бэлгийн ачаар тэд номлолоо үргэлжлүүлэх боломжтой болжээ- “Тэд бүгд Бурханы Ариун Сүнсээр дүүрч, Бурханы үгийг зоригтойгоор ярьж эхлэв” (Үйлс 4:31).

Гярхай уншигч үүнийг уншаад “сүнсээр аль хэдий нь дүүрсэн байсан тэд” хэмээн хэлэхгүй байгааг анхаарах буй заа. Тэднээр тодорхой үйлс хийлгэхийн тулд тэднийг сүнсээр дүүрэгсэн ба гэхдээ Бурханы төлөвлөгөөнд байгаа дараагийн зорилгыг биелүүлэхийн тулд дахин сүнсээр дүүрэх ёстой байлаа. Паул баптисмынхаа үед мөн адил “Ариун Сүнсээр дүүрсэн” байсан боловч түүнээс олон жил өнгөрсөн хойно муу санаат хүнийг сохор болгож шийтгэхийн тулд дахин “Ариун Сүнсээр дүүрэх” ёстой байлаа (Үйлс 9:17:13:9).

Паул гайхамшигт бэлгүүдийн талаар ярихдаа эхэн үеийн итгэгчид “Христийн бэлгийн хэмжээгээр” (Ефес 4:7) түүнийг эзэмшдэг байсан хэмээн бичсэн байдаг. Грек хэлэнд “хэмжээ” гэдэг нь “хязгаартай хэсэн буюу хэмжээ”/ гэсэн утгыг илэрхийлдэг ажээ (Хүчний Зохицол). Зөвхөн Есүсийн бэлгийн хэмжээ л хязгааргүй

32 БУРХАН

байжээ. Өөрөөр хэлбэл Тэр хүссэн хэмжээгээрээ хэрэглэх эрхтэй байжээ (Жон 3:34).

Бид дараагийн хэсэгтээ 1-р зуунд хүмүүст олгож байсан гэж тэмдгэлэгдсэн сүнсний бэлгүүдийг тодорхойлох болно.

1-Р ЗУУНЫ СҮНСНИЙ БЭЛГҮҮД

ЭШ ҮЗҮҮЛЭХ

“Эш үзүүлэгч” хэмээх Грек үг нь Бурханы үгийг урьдчилан хэлдэг хүнийг хэлдэг. Өөрөөр хэлбэл Бурханы үгийг хэлэх онгод орсон аливаа хүнийг хэлэх бөгөөд тэд заримдаа ирээдүйд тохиолдох зүйлийг урьдаас хэлдэг (2 Петер 1:19-21). Тиймээс “эш үзүүлэгчид” буюу эш үзүүлэх бэлэг бүхий хүмүүс “Иерусалимаас Антиох руу иржээ. Тэдний нэг Агаб гэгч босож, Сүнсээр зааварчлагдан-Бүх газрыг хамарсан их өлсгөлөн болно гэж хэлэв. Энэ өлсгөлөн Клаудийн хаанчлалын үед болжээ. Тэгээд ах дүү нартаа дагалдагч бүр өөр өөрсдийн хэр чадлаар тусламж илгээхээр шийдэв” (Үйлс 11:27-29). Цөөн жилийн дотор биелэлээ олдог ийм нарийн тодорхой эш үзүүлэлт нь эш үзүүлэх бэлэг эзэмшсэн гэж яриах өнөөгийн хүмүүсийн дотор огт гардаггүй юм. Эрт цагийн сүм үнэнхээр ийм бэлэг эзэмшсэн хүмүүс тэдний дотор байсан ба тэд эш үзүүлэгчидийн урьдчилан хэлсэн зовлон зүдүүрийг зайлуулахын тулд цаг мөнгөө зориулсан гэж баттайгаар хэлж байлаа. “Сүнсээр дүүрсэн” гэх өнөөгийн сүмүүд дотор ийм жишээ цөөхөн гарах болов уу.

АНАГААХУЙ

Бурханы төгс төгөлдөр Хаанчлал энэ дэлхийд ирэх тухай сайн мэдээг (Gospel) элч нар номлож байснаас үзэхэд тэд түүнийг батлахын тулд, “Сохрын нүд нээгдэж дүлийгийн чих нь онгойно. Тэгээд доглон хүн буга мэт дүүлнэ...” (Исана 35:5,6) гэж заасанчилан урьдчилан мэдрүүлэх тийм гайхамшгийг үзүүлэх нь зохистой хэрэг байлаа. Бурханы Хаанчлалын талаар нэмж мэдье гэвэл Хичээл 5-ыг үзээрэй. Бурханы Хаанчлал дэлхий дээр бий байгуулагдахад энэ мэтийн амлалтуудыг хагас хугас биелүүлэхгүй бөгөөд Хаанчлал энд байна уу үгүй юу гэж эргэлзэхээргүй тод томруун байна. Тэрхүү Хаанчлалын талаархи мэдээг Бурхан гайхамшигаар нь шийдэмгий, тодорхой

бөгөөд няцаагдашгүй хэлбрээр нотолсон байна. Ийм учраас дээр үеийн итгэгчид өвчнийг эдгээх гайхмшигт үйлдлүүдийг олны нүдэн дээр хийдэг байжээ.

Үүний сонгодог жишээг өглөө бүр сүмийн үүдэн дээр хэвтдэг байсан доголон гуйлгачинг Петр хэрхэн эдгээснээс харж болно. Түүнийг олонд танил болгохын тулд сүмийн үүдэнд өдөр бүр хэргээр аваачдаг байсныг Үйлс 3:2-оос харж болно. Петрийн сүнсний бэлгийн ачаар тэр эдэгмэгцээ “үсрэн цэх зогсоод алхалж эхлэв. Тэр цовхчин Бурханыг магтан тэдний хамт сүмд явж орлоо. Бурханыг магтан алхалж буй түүнийг бүх хүмүүс хараад сүмний үзэсгэлэнт дааман хаалганы дэргэд гуйлга гуйхаар суудаг байсан нэгэн болохыг таньж, түүнд юу тохиолдсоныг үзээд гайхаж хоцорсон байлаа. Өнөөх хүн Петр...хамт байхт зуур гайхаж хоцорсон хүмүүс бүгд гүйлдэн ...танхимын орчимд цугларчээ” (Үйлс 3:7-11).

Петр тэр даруй Христийн дахин амилах тухай гадаа ярьж эхэлжээ. Өвчнөөс анагаагдсан гуйлгачин эргэлзэшгүй, няцашгүй баримт гэрч болон тэдний өмнө байсан учир тэд Петрийн үгийг Бурханы үг хэмээн итгэсэн гэдэгт бидэнд эргэлзэх юм алга. “Залбиралын цагаар” сүмийн хаалга Бямба гаригийн өглөөний зах зээл шиг хүмүүсээр дүүрсэн байсан байж таарна. Бурхан үгээ тийм ил тод гайхамшигаар батлахын тулд ийм газруудыг сонгодог байв. Үүнтэй адилаар Үйлс 5:12-т “элч нарын гараар ард олны дунд олон тэмдэг болон гайхамшиг бүтээгдэж байв” гэсэн байдаг. “Пентакостал”-н анагаагчдын яриа нь гудамжинд бус гудамжны арын сүмд, өр зүрх хатуутай нийтлэг олон түмний өмнө биш “гайхамшиг” болно гэж горьдсон хүлээсэн “итгэгчдийн” өмнө болсон явдлуудын тухай байдаг.

Энэхүү бүтээлийг зохиогч бээр сүнс эзэмшсэн гэх, мөн сүнс эзэмдсэн хүмүүсийг харсан гэх чамгүй олон тооны хүмүүстэй эдгээр асуудлыг хэлэлцэж, сүнс эзэмшсэн гэх олон хүний яриа сонсож явсан хэдий ч боловч хүмүүсийг бүрэн “эдгээгээгүй” буюу их л сайндаа хагас хугас эдгээсэн байдлуудыг олж үзсэн “хувийн гэрчилэлтийг” нарийвчлан тайлбарлах хэрэгцээгүй юм. Иймэрхүү зүйлс олон байдгийг сүмийн үнэнч гишүүд хүлээн зөвшөөрөх буйзаа. Би өөрийн Пентекостын сайн санаат найз нартаа “Та нарт ийм агуу их хүч байж болно гэдэгт итгэхийг хүсэхгүй байгаа юм биш.

34 БУРХАН

Гэвч Бурхан Өөрийнх нь хүч хэнд байгаа хэнд байхгүй гэдгийг ямагт тов тодорхой харуулж ирсэн. Тийм учир би та нарыг баримтыг надад харуулж өгөөч гэж асуухад болохгүй юм байхгүй. Тэгсэний дараа, одоогоор Судартай нийцүүлж чадахгүй байгаа та нарын тэр номлолын байр суурийг тань хүлээж авах хандлага надад илүү болж магадгүй” гэж олон удаа хэлсэн билээ. Надад “сүнс ба хүчийг тодорхой харуулсан” тохиолдол гараагүй байна.

Христчид Бурханы гайхамшигт сүнсний бэлгийг эзэмшсэн байж болохыг 1-р зууны Еврейн ортодокс шүтлэгтнүүд үл ойшоож байсан нь миний хандлагатай зөрчилдаж байгаа юм. Гэсэн хэдий ч тэд хүртэл “Энэ хүн олон зүйлийг үйлдэж байна (Иохан 11:47)”. “Тэдний үйлдсэн гайхамшигт тэмдэг нь Иерусалимд оршин суудаг бүхэнд нэгэнт тодорхой тул бид түүнийг үгүйсгэж чадахгүй” (Үйлс 4:16) гэдгийг хүлээн зөвшөөрөхөөс араггүй болсон юм. Үүнчлэн, хэлээр ярьж байсан Элч нарыг сонссон хүмүүс “гайхжээ” (Үйлс 2:6). Пентекосталын чалчаа ярианы хариуд ийм явдал гардаггүй юм. Орчин үеийн “Пентекосталуудад” илүү найрсаг ханддаг хүмүүс тэднийг үнэхээр гайхамшигт хүрдэг гэдгийг ухаалгаар няцааж чадах баримт нь энэ маргаанд чухал зүйл болж байгаа нь мэдээж. Хэрэв ганц гайхамшиг Иерусалим даяар шуугиан тарьсан юм бол Лондоны Трафальгарын тайлбай буюу Найробийн Няаруру Паркт жинхэнэ гайхамшиг боллоо гэхэд Бурханы гайхамшигт сүнслэг бэлгүүдийг өнөөдөр ч гэсэн эзэмшсэн гэдгийг дэлхий дахинд хүлээн зөвшөөрнө гэж үзэх нь ухаалаг бус гэж үү.

Пентекосталийн “анагаах” үйлдэл нь Бурханы Сүнсний шууд ажиллагаа биш сэтгэл санааны болон сэтгэцийн нөхцөл байдлын үр дүн юм. Гэтэл гудамжинд хэвтэж байсан хүмүүсийг эмчилэхэд Петр гайхамшигийн жинхэнэ бэлгийг ашиглаж чадсан юм. (Үйлс 5:15). Паулын гайхамшигт бэлгийг хэрэглэснийг засгийн газрын үл итгэгч сайд болон Листра (Үйлс 14:8-13) хотод суугч шүтлэгтэн бус олон хүмүүс нүдээр харсан юм. Сүнслэг бэлгүүдийн зорилго ба шинж чанарын шаардлагын дагуу эдгээр зүйлсийг нийтийн өмнө хийж байсан ба Бурханы хүчийг Түүний зарц нар ил тод харуулсан гэдгийг хүлээн зөвшөөрөхөөс өөрөөр тайлбарлах аргагүй байлаа. Христийн анагаах увидасуудын нэгнийх нь нөлөө мөн үүнтэй адил байв. “Хүмүүс (түүнийг харсан) мэл гайхаж үүнтэй адил зүйл бид хэзээ ч үзсэнгүй гэж Бурханыг алдаршууллаа” (Марк 2:12).

ХЭЛҮҮД

Номлогчид болон итгэгчийн дүр үзүүлэгч номлогчид бүх дэлхийгээр явж, сайн мэдээг бүх бүтээлд тунхаглах агуу үүрэг хүлээж авчээ. /Марк 16:15,16/. Үүнийг сонсонгуут тэд эн түрүүнд “Гэвч би харь хэл мэдэхгүй шүү дээ” хэмээн уулга алдсан нь болов уу. Тэдний хувьд энэ нь “Би сургуульд байхдаа хэлний хичээлд тун тааруу байж билээ ” гэх мэтээр сургуульд суралцаагүйдээ гэмшин харамсах явдал байсангүй. Иймэрхүү асуудал үүсэхэд тэдний бүгдийн нь царайд “тэд бол эрдэм номгүй, боловсролгүй” хүмүүс гэдэг нь илт бичээтэй байлаа /Үйлс 4:13/. Тэр ч байтугай, Паул гэх мэтийн илүү өндөр боловсрол эзэмшсэн номлогчдын хувьд хүртэл ер бусын хэлний бэрхшээл гэдэг давж гарахад бэрх асуудал хэвээр байжээ. Хүмүүс Бурханд итгэлээ өгч сүнслэг болон хувирахад даатгахад номлогчид сэнхрүүлэхэд шаардагдах итгэл үнэмшил гэдэг нь /бичмэл Шинэ гэрээ байхгүй тохиолдолд/ нэг нэгнийхээ ер бусын хэлийг ойлгохгүй байх нь зүй ёсны асуудал гэжээ.

Үүнийг давж гарахын тул, харь хэлээр ярих авьяас /"ер бусын хэл"/ болон харь хэлээр ярьж хэлэлцэхийг ойлгох чадварыг нэвтрүүлжээ. “Ер бусын хэлний ” тухай энэхүү үзэл болон учир нь үл олдох дуу чимээ гарган баяр бахадлаа илэрхийлснээ “ер бусын хэл” хэмээн үздэг “ахин төрсөн” олон Христчид хоёр хоорондоо эрс зөрөлддөг. Библи сударт “ер бусын хэл” гэдэг үгийг “гадаад хэл” хэмээн тодорхойлсон байдгийг харуулснаар энэхүү төөрөгдлийг арилгаж болох юм.

Иудейчүүдийн Дээгүүр өнгөрөх баярын үеэр, Христийг мөнхийн улс руу одсоны дараахан номлогчид “ бүгд Ариун Сүнсээр дүүрч, мөнөөх Сүнсээр дамжуулан өгөгдсөнийг харь хэлээр ярьж эхлэв. ... энэхүү дуу чимээнээр үй олон хүмүүс цугларч, өөрсдийнх нь төрөлх хэлээр тэдний ярихыг сонсоод ихэд гайхжээ. Гайхаж алмайрсан тэд: Энэ ярьж байгаа хүмүүс чинь галилчууд биш үү? Гэтэл бид бүгдээрээ өөрсдийн төрөлх хэлээрээ тэдний ярихыг сонсож байх нь юу вэ? Партчууд, медечүүд, ... бид Бурханы агуу үйлсийн тухай тэдний яриаг өөрсдийн төрөлх хэлээр сонсоцгоолоо гэв. Тэд бүгд гайхшран алмайрчээ.” /Үйлс -:4-12/. Өнөө цагт өөрснийгээ харь хэлээр ярих авьяастай гэх зарим хүний учир нь үл ойлгогдох хэлийг сонссон хүмүүс гайхаж бахдах нь юу бол. Энэ нь Үйлсийн 2т гардаг шиг яригдсан үгсийн утгыг

36 БУРХАН

ойлгон багдахын оронд харин ч шалихгүй ёжлол, аль эсвэл хайхраймжгүй байдал бий болгодог.

Үйлсийн 2:4-11т “харь хэл” болон “төрөлх хэлийн” хоорон дахь ялгааг тод томруун харуулснаас гадна “харь хэлүүд” нь Шинэ Гэрээний бусад хэсэгт “төрөлх хэлүүд”ийг харуулахын тулд тун баримт нотолгоотой хэрэглэгдсэн. “үндэстэн, ард түмэн, хэлтэн” гэх хэлц үгүүд дэлхий дахины бүх ард түмний тухай Илчлэлд 5 удаа хэрэглэгджээ. /Илчлэл 7:9, 10:11, 11:9, 13:7, 17:15/. “Харь хэл” хэмээх Грек үг нь Хуучин гэрээний грек хувилбарт хэл яриа гэсэн утгаар орсон байдаг / Эхл. 10:5, Дэд хууль 28:49, Дан. 1:4/.

1 Кор. 14 т ер бусын хэлний авьяасыг ашиглах талаархи тушаалуудыг жагсаасан байдаг, бол Ис. 28:11 т энэхүү бэлгийг Иудэйн эсрэг гэрчлэхэд хэрэглэх тухайд “ Үнэхээр тэр энэ ард түмэнд хандаж шулгасан уруул, харь хэлээр дамжуулан ярих болно.” Гэжээ. Ис. 28:11 нь үндсэндээ Израилийн түрэмгийлэн эзлэгч нар Иудейчүүдтэй тэдний мэдэхгүй хэлээр ярьж байгаа тухай өгүүлсэн юм. “Харь хэл” болон “уруул” хоёрыг хооронд нь зааглаж өгсөн нь “харь хэл” бол гадаадын хэл гэдгийг харуулж байна. 1 Кор. 14т “харь хэлүүд” нь гадны хэлүүдтэй холбоотой болохыг харуулсан өөр олон жишээ дурдаж болно. Энэхүү бүлэгт Паул эртний сүм цуглаанд бэлгийг зүй бусаар ашиглаж байгааг шүүмжилж, ингэснээрээ харь хэл болон мэргийн бэлгийн мөн чанарын талаар олон сургаал дэвшүүлжээ. Бид үүнийг одоо товчхон тайлбарлахыг зорьё. Ишлэл 37 гийн гол санаа нь :

“Хэрэв хэн нэг нь өөрийгээ эш үзүүлэгч,
эсвэл сүнслэг гэж боддог бол
тэр хүн миний та нарт бичсэн
энэ зүйлс нь Эзэний тушаал
гэдгийг мэдэж аваг”.

Хэрэв хэн нэг хүн өөрийгээ сүнсний бэлэг авсан гэх юм бол тэр Эзний хайрласан бэлгийг хэрхэн хэрэглэх талаар өмнөх тушаалуудыг хүлээж авах ёстой. Өнөөдөр тэрхүү тушаалуудыг зөрчсөн хэн боловч тэд Эзний үгийг үл ойшоосноо илэн далангүй хүлээн зөвшөөрдөг. Ишлэл 11 – 17:

“Иймээс хэрэв би тухайн аялганы
утгыг мэдэхгүй бол ярилцагч
хүнийхээ хувьд би харь хүн болж,

миний хувьд ярилцагч маань
харь хүн болно.

Тэрчлэн та нар сүнслэг зүйлсэд
хүсэн тэмүүлдэг хүмүүс учир
чуулганы босгон байгуулалтын
төлөө тэдгээрийн бялхалтыг эрж хай.

Тиймд хэлээр яригч хүн тайлбарлахын тулд залбираг.

Учир нь хэрэв би хэлээр залбирвал миний сүнс
залбирдаг бөгөөд харин миний
ухаанд үр жимс үгүй юм.

Тэгвэл яах вэ? Би сүнсээр залбирах болно.
Би бас ухаанаар залбирах болно.
Би сүнсээр дуулах болно.
Би бас ухаанаар дуулах болно.

Эс бөгөөс хэрэв та нар сүнс дотор ерөөвөл
билэг авьяасгүй нэг чинь та нарын
талархалд “Амен” гэж яаж хэлэх вэ?
Та нарын юу хэлснийг чинь ч тэр мэдэхгүй.

Учир нь чи талархлаа сайн илэрхийлдэг
байж болох ч бусад нь байгуулагдахгүй.”

Цуглаан мөргөлд оролцогсодтой тэдний ойлгохгүй хэлээр ярих нь иймээс ямар ч утгагүй юм. “Үл ойлгогдох хэлээр” ярихыг тооцдоггүй юм гэхэд “залбирлын” эцэст хэрхэн үнэн сэтгэлээсээ үл ойлгогдох хэлээр “Амен” гэх вэ? “Амен” гэдэг бол “Болтугай” гэсэн утгатай, өөрөөр хэлбэл, “би энэ залбиралд хэлсэн бүх зүйлтэй санал нийлж байна” гэсэн үг юм. Ахан дүүстэйгээ тэдний үл ойлгох хэлээр ярилцахад тэднийг сэнхрүүлж үл чадна гэж Паул хэлжээ.

Ишлэл 19:

“ Чуулган дотор хэлээр түмэн үг хэлснээс
бусдыг ч мөн сургахын тулд чуулган дотор ухаанаараа
таван үг хэлэхийг би хүсдэг.”

38 БУРХАН

Энэ бол ойлгомжтой. Над хэдэн цагаар харийн хэлээр юм уу, аль эсвэл ямар нэг “үл ойлгогдох хэлээр” ном айлдсанаас англиар Христийн тухай товчхон өгүүлбэр хэлэх нь миний хувьд хавьгүй дээр.

Ишлэл 22:

“Тиймээс хэлүүд нь итгэдэг хүмүүсийн төлөө бус,
харин итгэдэггүй хүмүүсийн төлөөх тэмдэг болдог аж.
Харин эш үзүүллэг нь итгэдэггүй хүмүүсийн төлөө бус,
харин итгэдэг хүмүүсийн төлөө байдаг.”

Иймээс харь хэлүүдийг голдуу Сайн мэдээг гадуур явж номлоход ашигладаг байна. Өнөөдөр “итгэгчид” хэсэг бүлгээрээ, аль эсвэл дор дороо “харь хэлийг” эзэмших эрмэлзэлтэй байна. Сайн мэдээг олонд түгээхийн тулд гадны хэлээр гайхалтай сайн ярьдаг хүмүүс аль эрт цагаас ямагт хомс байсан. 1990 ээд оны эхээр зүүн Европт Христийг номлох үүд хаалга нээгдсэн хэдий ч “эвангелийн” сүмүүд хэлний бэрхшээлээс шалтгаалан судар номоо англи хэлээр тараах хэрэгтэй болсон юм. Хэрэв харь хэлийн бэлэг авьяасаар дүүрсэн байсан бол бэлэг авьяасыг хэрэглэх байсан биш үү?

Ишлэл 23:

“Тиймээс хэрэв чуулган бүрэн бүтнээрээ хамтдаа
цуглаад, бүгд хэлүүдээр яривал бэлэг авьяасгүй
хүн, эсвэл итгэдэггүй хүмүүс орж ирвэл
тэд та нарыг галзуу гэж хэлэхгүй гэж үү?”

Энэ бол чухам жинхэнэ болсон явдал юм. Лал болон шашинд үл итгэгч атеистууд Баруун Африк даяар харь хэлүүдийн бэлэг авьяастай гэх хүмүүсийн жигтэй ааш араншинг элэглэн дооглодог байжээ. Тэр ч байтугай, Дээгүүр өнгөрөх баяр Пентекостын чуулганд буугаа төлөв түвшин Христч хүн хүртэл өөрийн эрхгүй тэдгээр гишүүнийг галзуурсан гэж бодно.

Ишлэл 27:

“ Хэрэв хэн нэгэн хүн хэлээр яривал,
нэг удаа хоёроос илүүгүй аль эсвэл
хамгийн ихдээ гурван хүн ээлжлэн ярьж,
нэг нь тайлбарлаг.”

Ямарваа цуглаан залбирлын үеэр ердөө хоёр юм уу, гурван хүн л харь хэлээр ярих шаардлагатай байдаг байлаа. Сонсогчид гурваас дээш харь хэлээр ярих нь юу бол. Үг хэлэгчийн өгүүлбэр болгон нь хоёроос дээш удаа давтагдаад байвал цуглааны хамаг учир утга удалгүй алдагдана. Лондонгийн төвд Англи хүмүүс болон франц, германаар бага зэрэг ярьдаг жуулчид ирдэг чуулганд харь хэлийн бэлэг авьяасаар дүүрсэн байх юм бол Үг хэлэгч ийнхүү эхэлж мэдэх юм:

ПАСТОР: Good evening. /англи/
 ХЭЛЭЭР ЯРИГЧ 1: Bon soir /франц/
 ХЭЛЭЭР ЯРИГЧ 2: Guten abend /герман/

Гэвч тэд “ээлж дараагаараа” ярих ёстой. Бүгд нэгэн зэрэг яриад унах юм бол үл ойлголцол үүснэ. “Харв хэлээр яригчийн” сэтгэл хөдлөлийн мөн чанарын улмаас олон хүн нэгэн зэрэг ярихад гоц байдал үүснэ. Нэг хүн яриад эхлэхэд бусад нь тэр дороо мөн ярихыг тэмүүлдэг болохыг би өөрийн биеэр ажигласан юм.

Эзэний дамжуулсан мэдээг ярилцагчийн үл мэдэх хэлээр дамжуулдгаараа Харь хэлийн бэлэг авьяас нь зөнтэй холбоотой ашиглагддаг. Хоёр бэлэг авьяасыг ийм маягаар ашигласан жишээг Үйлсийн 19:6 гаас харж болно. Гэсэн хэдий ч, Лондонд болдог Англи хүмүүсийн ирдэг чуулганд олон франц жуулчид ирсэн бол Пастор францаар ярихад тэнд байлцсан Англи хүмүүс “үл гэгээрнэ”. Иймээс, хүн болгонд нэг бүрчлэн ойлгуулахын тулд харь хэлийг тайлбарлах бэлэг авьяас заавал байх ёстой бөгөөд саяын дурдсан тохиолдолд Францаас Англи руу хөрвүүлэх шаардлагатай. Хэдийгээр Пастор өөрөө ч мэдэхгүйгээр Францаар ярих бэлэг авьяас хүлээн авсан байсан ч Франц байлцагсдын хэн нэг нь асуулт асуухад Пастор бусдын тусламжгүй түүний яриаг ойлгохгүй. Иймээс үүнд дэм болохын үүднээс хөрвүүлэх бэлэг авьяас заавал байх хэрэгтэй.

Шаардлагатай үед хөрвүүлэх бэлэг авьяас үгүй бол харь хэлийн бэлэг авьяас ашиглагдахгүй. “ ... ээлжлэн ярьж, нэг нь тайлбарлаг. Хэрэв тайлбарлах хүн байхгүй бол тэр хүн чуулган дунд чимээгүй байж, өөртөө болон Бурханд яриг” /1 Кор. 14:27,28/. Одоо цагт өөрснийгээ “харь хэлтэн” гэж горилогч олон хүн хэний ч үл ойлгох “хэл”ээр ярьж, хэн нэгнээр тайлбарлуулахгүй байгаа нь эдгээр тушаалыг үг дуугүй зөрчиж байгаа хэрэг мөн.

40 БУРХАН

Ишлэл 32, 33:

“Эш үзүүлэгчдийн сүнс эш үзүүлэгчдэд захирагддаг. Учир нь Бурхан бол самуурлын Бурхан бус, харин амар амгалангийн Бурхан мөн.”

Ариун Сүнсээр дүүрэх бэлэг авьяас гэдэг бол хэвийн ухаан санааны хүрээнээс хэн нэг хүн гарах явдал биш, сүнс гэдэг бол хүмүүсийг хүчээр албадлагаар хийхэд хүргэдэг бус харин биеэ захирдаг болно гэсэн үг. “Аврагдаагүй” хүмүүсийг буг чөтгөр эзэмддэг, /Хичээл 6.3 аас үз./ харин итгэгчдийг Ариун Сүнс дүүргэдэг гэж буруу ярьцгаадаг.

Харин 1 Кор. 14:32т дурдсан Сүнсний хүч чадал нь өвөрмөц төгсгөлөөр өндөрлүүлэх дүүргэгчийн эрх мэдэлд захирагддаг. Энэ нь хүний хүрээнд байдаг сайн зүйлийн эрч хүчийг муу сүнсний хүчтэй харшуулсан хэрэг биш юм. Тэгээд ч, Ариун сүнс номлогчидтой цуг цаг ямагт оршдоггүй, харин тодорхой цагт онцгой зүйлүүдийг үйлдүүлэхийн тулд л ирж байсныг бид дээр өгүүлсэн билээ.

Ишлэл 34:

“Ариун хүмүүсийн бүх чуулганы адил чуулгануудад эмэгтэйчүүд чимээгүй байг. Учир нь тэдэнд ярихыг зөвшөөрдөггүй. Харин Хууль юу хэлдэг шиг тэд захирагдаж байг”.

Сүнслэг бэлэг авьяасыг ашиглах тухайд, эм хүн сүмийн чуулганы үеэр бэлэг авьяасыг хэрэглэх ёсгүй болохыг тууштай тэмдэглэжээ. Хэрэв “үл ойлгогдох хэлээр” ярих гоц үзэгдлийг үзэгчдийн дунд нэг хүнээс нөгөөд шилжиж буй сэтгэлийн хөдлөлөөр тайлбарлаж болох бол энэ тушаалыг үл тоомсорлож буй хэрэг мөн. Эрмэлзэгч оюун санаатай эмс, хүүхдүүд, ер хэн ч байсан ийнхүү уруу татагдаж, үүний улмаас “харь хэлээр” илэрхийлэгдэх хэлээр бахдан ярьдаг.

Орчин үеийн сүмүүдэд “харь хэлээр ярих” болон “эш үзүүлэхэд” эмэгтэйчүүдийн нэр алдар энэхүү ишлэлийн тов тодорхой тушаалуудтай эвлэрэх боломжгүй юм. Паулыг эмэгтэй хүнийг үзэн яддаг байсан гэх хачин жигтэй, арга ядсан баримтыг хэдхэн

ишлэлийн хойно няцаасан байдаг: “ Хэрэв хэн нэг нь өөрийгээ эш үзүүлэгч, эсвэл сүнслэг гэж боддог бол тэр хүн миний та нарт бичсэн энэ зүйлс нь Эзний тушаал гэдгийг мэдэж аваг” /1 Кор. 14:37/ гэж байдаг нь энэ нь түүний өөрийн нь үг биш болохыг харуулж байна.

2.4. Бэлэг авьяасыг өгөх нь

Христийг буцаж ирсний хойно өнөөгийн дэлхий ертөнцийг Бурханы хаант улсад хувиргахын тул итгэгчид Бурханы сүнсийн гайхамшигт бэлэг авьяасуудыг дахин хэрэглэх болдог. Иймээс бэлэг авьяасыг “ирэх үеийн хүчүүдийг амссан” / Евр. 6:4,5/ гэх бөгөөд Иоелийн 2:26 - 29т Израильчуудыг гэмшсэний хойно тэнгэрлэг бэлгүүдийг цутгахыг дүрсэлсэн байдаг. Христийг буцаж ирэхээр эдгээр тэнгэрлэг бэлгийг итгэгчдэд цутгана гэдэг нь итгэмжит үг бөгөөд Судар болон дэлхийн дахины үйл явдлыг ажиг буй, Их Эзэний буцаж ирэхийг хүлээж буй ямар ч итгэгчид тэнгэрлэг бэлгүүдийг цутгах мөч тун удахгүй ирнэ. /Хавсралт 3 ыг үз./

Тэнгэрлэг бэлгүүдийг цутгасан нэгдүгээр зуун болон хоёр дахь ирэлтийн завсар хооронд тэнгэрлэг бэлгүүдийг өгөх тухайд Библи сударт маш тодорхой эш үзүүлсэн байдаг.

“Хайр хэзээ ч дуусдаггүй. Харин эш үзүүлж байгаа бол, тэдгээр нь үгүй болно. Хэрэв олон янзын хэлүүд байгаа бол тэд болих болно. Хэрэв мэдлэг байгаа бол энэ ч үгүй болно. Учир нь бид хэсэгхэнийг мэддэг, хэсэгхэнийг эш үзүүлдэг. Харин төгс юм нь ирэх үед хэсэгхэн гэдэг нь үгүй болно” /1 Кор. 13:8-10/.
Тэнгэрлэг бэлгүүд нь “цаг зуурын”.

Нэгдүгээр зуунд дүүрсэн тэнгэрлэг бэлгүүд “ онцгой цаг үе нь болоход” өгөгддөг. Энэ нь Христийн хоёр дахь ирэлт байж таарахгүй, учир нь тэнгэрлэг бэлгүүдийг дахин өгөгдөж буйг харах болно. “Төгс” хэмээн хөрвүүлэгдсэн Грек үг нь “ дүүрэн, туйлын ” гэсэн утга агуулсан бөгөөд энэ нь заавал “ гэмгүй ” гэсэн утга агуулах албагүй.

42 БУРХАН

Энэхүү төгс зүйл нь эртний Христчдийн эш үзүүлэх тэнгэрлэг бэлгийн дүнд олж авсан мэдлэгийг орлох юм. Эш үзүүлэх гэдэг нь Бурханы гэгээрсэн үгүүдийг хэлэх тэнгэрлэг бэлэг авьяас гэдгийг санах хэрэгтэй, энэ нь ийм үгүүдийг бичмэлээр буулгасан хэрэг бөгөөд энэ нь Библи судрыг бүрдүүлдэг билээ.

Нэгдүгээр зуунд, дундаж итгэгч хүн Шинэ Гэрээний хэсгээс л мэддэг байсныг бид мэднэ. Тэрбээр янз бүрийн асуудлуудын тухайд сүмийнхээ ахмад хүмүүсийн эш үзүүлэлтийн үгүүдээс олж сонсох бөгөөд Есүсийн амьдралын тоймыг олж мэдэж, Паулын захианаас нэг, хоёрыг олж уншиж мэдэх юм. Харин энэхүү эш үзүүлэлтийн үгүүдийг бичмэлээр төгс бүрэн буулгасан тохиолдолд эш үзүүлэх тэнгэрлэг бэлгээр дүүрэхийг хүлээх шаардлагагүй болж байгаа юм. Энэхүү төгс боловсорсон бичмэл нь тэнгэрлэг бэлгийн санваартны байрыг эзэлж, улмаар Шинэ Гэрээг төгс болгожээ.

“Судар бүр Бурханы амьсгалснаар байгаа бөгөөд
заахад, зэмлэхэд, залруулахад, зөвт байдал
дотор чиглүүлэхэд тустай. Энэ нь Бурханы хүн аливаа
сайн үйлд бүрэн бэлтгэгдсэн байхын
тулд юм” /2 Тим. 3:16,17/.

“Судар” бол төгс бүрэн бөгөөд “судрыг” гэгээрүүлж бичмэлээр буулгасны хойно “тэрхүү төгс” ирж, гайхамшигт тэнгэрлэг бэлгүүд өгөгддөг.

Ефесийн 4:8 - 14т улам төгс болгохын тулд дараах байдлаар үг нөхөж блох юм:

“Тиймээс “Өндөрт /диваажинд/ дээш гарахдаа,
Тэр /Есүс/ олон хоригдол олзлов.
Тэр хүмүүст бэлгүүд өгсөн” гэж хэлдэг. ...
Бид бүгд итгэл /нэгдсэн итгэл/ хийгээд Бурханы хүүг
мэдэх мэдлэгийн нэгдэл хүртэл, төлөвшсөн хүн болтол,
Христийн дүүрэн байдлын чанарын хэмжээнд хүртэл
ингэх ажээ.
Үүний үр дүнд бид цаашид хүүхэд байхаа больж,
давалгаанд энд тэнд шидэгдэн, аливаа номлолын
салхи, хүмүүсийн ов мэх болон зальхай хуйвалдааны
башир аргад туугдалгүй өсөх ёстой” .

Хүнийг төгс бүрэн боловсрох хүртэл нэгдүгээр зууны тэнгэрлэг бэлгүүдийг өгсөн бөгөөд 2 Тим. 3:16,17д хэдийгээр “судрын” чиглүүлэлтийг хүлээн зөвшөөрсөн хэдий ч “ Бурханы хүн бүрэн бэлтгэгдсэн ” гэж хэлдэг. Кол. 1:28д мөн “бүрэн байдал” нь Бурханы үгийн хариултаас ирдэг гэж сургадаг. Судар нийтдээ дүүрч гэгээрэхэд янз бүрийн сүмүүдийн санал болгосон үй олон хоосон номлолтой зууралдах шаардлагагүй болдог. Библи судар цорын ганц бөгөөд “ Таны үг бол үнэн мөн ” /Иох. 17:17/. Үүнийг хуудас хуудсаар нь судалсны эцэст бид Ефес 4:13 т өгүүлдэг “ нэгдсэн итгэлийг” олж авах болно. Иймээс Христчид тэрхүү итгэлээр дүүрэх бөгөөд энэ ч утгаараа тэд Бурханы бичмэл төгс Үгийн үр дүнд төгс /”бүрэн”/ юм.

Энэ зуур, Ефес 4: 14т гайхамшигт тэнгэрлэг бэлгүүдийн санваартан болон сүнслэг хүүхэд насыг хэрхэн харьцуулсан болон эш үзүүлэлт, мөн гайхамшигт тэнгэрлэг бэлгүүд хэрхэн өгөгддөг болохыг ажигла. 1 Кор. 13:11 т ч мөн адил зүйлийг өгүүлсэн байгаа. Энэхүү үгүүдийг уншсан хэнд ч болов ямар ахиц ажиглагдах вэ гэхээр Бурханы бичмэл үгүүдийг илүү гүнзгий танин мэдэж, Бурхан та бидэнд өөрийгээ бүрэн Илчилсэнд баясан бахдаж, Бурханы үгүүдэд төлөв дуулгавартай ханддаг болох юм.

ХИЧЭЭЛ 2: Асуултууд

1. Доорхи үгсийн аль нь “Сүнс” гэдэг үгийн утга вэ?
А/ хүч чадал
Б/ Ариун
В/ амьсгал
Г/ тоос
2. Ариун Сүнс гэж юу вэ?
А/ хүн
Б/ хүч чадал
В/ Бурханы хүч чадал
Г/ Эцэг, Хүү, Ариун Сүнс гурвын холбоо
3. Библи судрыг хэрхэн бичсэн бэ?
А/ хүмүүс өөрсний санааг цаасанд буулгасан
Б/ Хүмүүс Бурхан хэлсэн гэж бодсон зүйлүүдээ цаасан дээр буулгасан
В/ Бурханы Сүнсээр, хүмүүсийг гэгээрүүлэх замаар
Г/ зарим нь гэгээрч, зарим нь гэгээрээгүй
4. Доор дурдсан шалтгаануудын чухам алинаас нь болж Сүнсний гайхамшигт тэнгэрлэг бэлгүүд өгөгдөх болсон бэ?
А/ Сайн мэдээг үгээр номлоход туслах
Б/ эртний сүмийг хөгжүүлэхийн тулд
В/ хүмүүсийг зөв шударга байхыг албадах
Г/ номлогчдыг хувийн нь саад бэрхшээлээс аврах
5. Бид Бурханы үнэнийг хаанаас судалж болох вэ?
А/ хагасыг нь Библиээс, хагасыг нь өөрсдийн санаа бодлоос
Б/ Библи уншихаас гадна Ариун сүнс бидний юу хийхийг шууд удирдана
В/ Зөвхөн Библиээс
Г/ шашны санваартнаас

3.1. Оршил

Энэ тухайд бид өмнөх хичээлүүдээс Бурхан гэж хэн болох, хэрхэн үйл ажиллагаа явуулдаг тухай өргөн мэдлэг олж авсан билээ. Үүний зэрэгцээ бид нийтлэг тархсан хэд хэдэн ташаа ойлголт байдгийг тодруулсан. Энэ удаа бид Түүний тушаалуудыг сахих /Иохан 14:25/ замаар “ Эзэн өөрийг нь хайрлагсдад амласан” /Иаков 1:12, 2:5/. Зүйлүүдийн тухайд гүнзгийрүүлэн авч үзэхийг зорьсон юм.

Хуучин Гэрээнд дурдсан Бурханы амлалтууд л чухам жинхэнэ христч итгэл үнэмшлийг бүрдүүлдэг. Паул амь өрссөн сорилтод орохдоо ирээдүйд өөрт нь оногдох шан харамжийн төлөө хамаг юмаа зориулахад бэлэн байгаагаа “ Харин би одоо манай эцэг өвгөдөд Бурханы өгсөн амлалтын найдвараас болж шүүгдэж байна. ” /Үйлс 26:6,7/ гэжээ. Тэрээр ихэнх насаа “Бид эцэг өвгөдөд амлагдсан тэрхүү сайн мэдээг л та нарт тунхаглаж байна. ... Есүсийг амилуулснаар Бурхан амлалтаа бидний хүүхдүүдэд биелүүлж өгсөн юм. ”/ Үйлс 13:32,33/ хэмээн номлосоор өнгөрүүлжээ. Паул эдгээр амлалтад итгэвэл нас барсны хойно дахин амилна гэх найдвар үүсдэг /Үйлс 26:6-8/, Есүсийн хоёр дахь ирэлтийн тухай болон Бурханы Хаанчлалын /Үйлс 24:25, 28:20,31/ тухай мэдлэгийг тайлбарлажээ.

Энэ бүхэн нь Хуучин Гэрээ бол мөнхийн амийн тухай үл өгүүлэх Израилийн тухай авцалдаа холбоогүй түүх юм гэх үлгэр домгийг үгүйсгэж байна. Бурхан 2 000 жилийн тэртээ гэв гэнэт Есүсээр дамжуулан бид бүхэнд мөнхийн амь өгөхөөр шийдсэн хэрэг биш. Тэр анхнаасаа ийм зорилго агуулсаар ирсэн.

“ Тэр нь мэхэлдэггүй Бурханы мөнх цагаас
өмнө амласан мөнх амийн найдварт
үндэслэсэн юм. Бурхан зохистой цагт
Өөрийн үгийг бидний Аврагч Бурханы тушаалаар над даалгасан
тунхаглалаар илэрхийлжээ ” / Тит 1:2,3/.

“ Тэрхүү амь нь илэрхийлэгдсэн. Эцэгтэй хамт
байсан бөгөөд бидэнд илэрхийлэгдсэн мөнх
амийг бид үзсэн, мөн та нарт гэрчилж,
тунхаглаж байна ” / 1Иох. 1:2/.

46 БУРХАН

Бурхан өөрийн хүмүүстээ мөнхийн амь өгөхийг анхнаасаа зорьдог байсан учир Тэр Хуучин Гэрээнд дурдагдсан хүмүүстэй байх 4 000 жилийн туршид чимээгүй байгаагүй нь мэдээж. Үнэндээ, Хуучин Гэрээ нь эш үзүүлэлт, амлалтуудаар дүүрэн бөгөөд эд тус бүр Бурханы Өөрийн хүмүүстээ бэлдсэн итгэл найдварын тухай илүү нарийн ширийн зүйлүүдийг агуулж байдаг.

Бидний аврагдахад Иудейн эцгүүдэд хандаж Бурханы хэлсэн амлалтуудыг ойлгох нь амин чухал учраас, Паул Эфест итгэгчдийг ийм зүйлийг мэдэхээс нь өмнө урьчилан сануулж, хэдийгээр тэдгээр итгэгчийн урьд өмнөх атеист итгэл үнэмшил нь Бурханы тухай ямар нэг итгэл үнэмшил төрүүлж байсан байж таарах хэдий ч “ Тэр үед та нар Христээс тусгаарлагдсан байв. Та нар Израилийн нийгмээс гадна, амлалтын гэрээнүүдийн хувьд харь хүмүүс байв. Та нар ямар ч найдваргүй, ертөнцөд Бурхангүй байлаа” /Ефес 2:12/ гэжээ. Харин энэ нь Хуучин Гэрээн дахь Бурханы амлалтуудыг мэддэггүйн харгай юм, үнэн хэрэгтээ бол “ ямар ч итгэл үнэмшил, Бурхан тэнгэргүй ” байжээ. Паул Христч итгэлийг тодорхойлохдоо “ манай эцэг өвгөдөд Бурханы өгсөн амлалтын найдвар ” / Үйлс 26:6/ гэж хэлснийг мартаж болохгүй.

Хуучин Гэрээний эдгээр хэсэгт илүүтэй ач холбогдол өгөх учиртай ч ингэдэг сүм хийд харамсалтай нь цөөхөн байдаг. “Христч үзэл” нь Шинэ Гэрээн дээр суурилсан шашин болж уруудсан – тэр ч бүү хэл, түүн дотроос хэдхэн ишлэл авч хэрэглэх хандлагатай болсон. Есүс зөв арга замыг маш тодорхой хэлсэн:

“ Харин тэр түүнд “ Хэрэв тэд Мосе болон
Эш үзүүлэгчдийг сонсдоггүй юм бол
үхэгсдээс хэн нэг нь амилсан ч
тэд үнэмшихгүй биз дээ” гэжээ гэв ” / Лук 16:31/.

Есүс байгаа гэдэгт итгээгүй яваа ердийн хүмүүс бол Есүс дахин амилсан гэхэд итгэх нь хангалттай гэж үзэж болох юм, гэвч Хуучин гэрээг итгэл үнэмшилтэй ойлгохгүйгээр энэ нь бүрэн дүүрэн болж чадахгүй гэж Есүс хэлжээ.

Есүс Загалмайд хадагдсаныхаа дараа элч дагалдагчид нь Хуучин Гэрээг анхаарч үздэггүй байсныхаа балгаар итгэл үнэмшилгүй байсныг олж мэджээ.

“ Есүс – Мунхаг хүмүүс ээ. Эш үзүүлэгчдийн хэлсэн бүхэнд итгэхдээ хойрго сэтгэлтэнгүүд ээ. Христ энэ бүх зовлонг эдлэн, тэгээд Өөрийн сүр жавхланд орох ёстой байсан биш үү, гэв. Тэгээд Тэр Мосегээс эхлэн бүх эш үзүүлэгчид, бүх Судар Өөрийнх нь тухай юу хэлснийг тэдэнд тайлбарлав ” /Лук 24:25 - 27/.

Хуучин Гэрээ *тэр чигээрээ* Түүний тухай хэрхэн өгүүлж байгааг анхаар. Энэ бол элч дагалдагсад нь Хуучин Гэрээг огт уншдаггүй байсан, аль эсвэл Хуучин Гэрээ гэж үг огт сонсоогүй байсан хэрэг огт биш, гэвч тэд хуучин гэрээний үгсийг зохих ёсоор нь ойлгодоггүй байсан учир үнэн голоосоо итгэж үнэмшиж чаддаггүй байсан ажээ. Тэгэхээр Бурханы үгсийг зүгээр нэг уншаад байлгүй зөв тунгааж ойлгох нь жинхэнэ итгэл үнэмшил төрүүлэхэд зайлшгүй шаардлагатай байдаг юм. Иудэйчүүд Хуучин гэрээг уншихдаа хэт улайран биширдэг байсан /Үйлс 15:21/ боловч тэд юмс ба Есүс, Түүний Сайн Мэдээний хоорондын уялдаа холбоог ойлгоогүйн улмаас жинхэнэ итгэл үнэмшил төрүүлж чадаагүй, иймээс Есүс тэдэнд хандан:

“ Хэрэв та нар Мосед итгэсэн юм бол Надад итгэх байсан. Учир нь тэр Миний тухай бичсэн юм. Харин та нар түүний бичээст итгэхгүй бол яаж Миний үгэнд итгэх билээ? Гэж айлдлаа. ” /Иох. 5:46,47/

Библи судрыг унших ийм сул хэв маягаас гадна тэд өөрснийгээ баталгаатай аврагдсан гэж итгэх дуртай хэрнээ Есүсийн тухай жинхэнэ мэдээг олж харахгүй байжээ. Есүс тэдэнд ингэж хэлэх хэрэгтэй болжээ:

“ Та нар Судруудыг судалдаг. Учир нь тэдгээрийн дотор мөнх амь бий гэж та нар боддог. Тэдгээр нь Намайг гэрчилдэг билээ. ” /Иох. 5:39/

Тэгэхээр Хуучин Гэрээний сургаалууд болон түүнд гардаг зарим үйл явдлыг мэдэх олон хүнд мөн ийм явдал тохиолдож мэдэх юм: энэ бол ердөө тохиолдлоор олж авсан мэдлэг юм. Христийн гайхамшигт мэдээнүүд болон Бурханы хаанчлалын Сайн мэдээ ийм хүмүүсээс далдлагдсаар байдаг. Хуучин Гэрээний гол амлалтуудын жинхэнэ утга агуулгыг харуулах замаар та нарыг мөн ийм байдлаас гаргахад л энэ хичээлийн маань зорилго оршиж байгаа билээ:

48 БУРХАН

- Едений цэцэрлэгт
- Ноахад
- Абрахамд
- Давидад

Эдний тухай мэдээллийг Мосегийн бичсэн Библийн эхний таван судар болон Хуучин Гэрээний эш үзүүлэлтүүдээс олж болно. Христч Сайн Мэдээний бүх элементүүдийг энд дурдсан байгаа. Паул энэхүү Сайн Мэдээг номлох тухай өгүүлэхдээ:

“ Ийнхүү Бурханы тусламжийг хүртсэнээр өдгөөг хүртэл би их, бага хүмүүст гэрчлэн зогсохдоо эш үзүүлэгчид болон Мосегийн хэлсэн нь биелэх ёстой гэдгээс өөр юуг ч ярьж байгаагүй. Энэ бол Христ зовлон эдэлж, үхэгсдээс анх түрүүн амилснаараа энэ ард түмэнд болон Харь үндэстнүүдэд гэрлийг

тунхаглана гэсэн үг юм . ” /Үйлс 26:22,23/, гэсэн бөгөөд мөн түүний эцсийн өдрүүдэд ч энэ дуун хэвээр үлдэж: “ Ингээд тэд түүнтэй өдөр болзож, түүний байсан газар олуулаа цуглахад Паул өглөөнөөс үдэш болтол тэдэнд Бурханы хаанчлалын тухай гэрчлэн, Есүсийн тухай тэдэнд итгүүлэхийг хичээж, Мосегийн Хуулиас болон эш үзүүлэгчдийн номоос ярьж тайлбарлав. ”/Үйлс 28:23/

Паул хамгийн дээд Христч хүн бид бүхнийг өдөөн уриалах итгэл найдвар байх ёстой гэж үздэг байсан бөгөөд энэ нь түүний амьдралын хонгилын үзүүрт гялалзах хурц гэрэл нь байсан тул жинхэнээс итгэгч Христ бүхэн үүнийг санаж явах ёстой. Энэхүү “өдөөлт уриалгаар” дүүрсэн бид одоо Сударыг судалж эхлэх боломжтой боллоо.

3.2 Едений цэцэрлэг дэхь амлалт

Хүн төрөлхтөн Бурханаас холдсон тухай сэтгэл шимшрүүлсэн түүх нь Эхлэлийн 3 дугаар бүлэгтэй холбоотой. Могойг Бурханы үгийг буруу иш татаж, Еваг Бурханы үгийг зөрчихэд хүргэсэн гэж харааж зүхдэг. Эр эм хоёул Бурханы үгэнд ороогүйнхээ төлөө шийтгэл хүлээдэг. Харин Бурхан могойд хандаж доорхи үгсийг хэлэхэд харанхуйн дүр зураг дундаас итгэл найдварын бяцхан туяа зурсхийдэг:

“ Би чамайг тэр эмэгтэйтэй өс хонзонтой, Бас чиний үр хүүхдийг тэр эмэгтэйн үр хүүхэдтэй өс хонзонтой болгох болно. Тэр эмэгтэйн үр хүүхэд чиний толгойг няцалж, чи түүний өсгийг няцлах болно. ” / Эхл. 3:15/

Энэ ишлэл нэн баялаг юм: бид үүнтэй холбоотой янз бүрийн юмсыг анхааралтай тодорхойлох хэрэгтэй. “үр” гэдэг нь үр удам, аль эсвэл хүүхэд боловч зарим талаар мөн тодорхой “үр”тэй холбоо бүхий хүмүүсийг хэлсэн байж болно. Абрахамын “үр ” нь Есүс /Гал. 3:16/ болох тухай хожим үзэх боловч хэрэв бид баптисм хүртэн “Есүст” орсон бол бид ч мөн үр мөн /Гал. 3:27-29/. “Үр” гэдэг нь мөн үл устах үрийг хэлэх тул жинхэнэ үр бол эцгийнхээ зан чанарыг агуулсан байх ёстой.

Иймээс могойн үр нь могойн төрөл ангитай төс бүхий төрөлтөнд хамрах болно:

- Бурханы үгийг гуйвуулсан
- Худал хэлсэн
- Бусдаар нүгэл хийлгүүлсэн

Энэ бүхнийг нэг бүрчлэн хийх хүн байдаггүй тухай бид 6 дугаар хичээлээс үзэх боловч бидний дунд:

- “ бидний хуучин хүн ” / Ром. 6:6/
- “ төрөлх хүн ” / 1 Кор. 2:14/
- “ заль мэхийн тачаалын дагуу ялзарч
буй хуучин хүн ” / Ефес 4:22/
- “ хуучин хүнээ бузар муу зуршилтай нь ” / Кол. 3:9/
гэж байдаг.

Бидний дунд байгаа нүгэлтэй хүнийг Библид “муу сүнс” могойн үр гэдэг.

Эмэгтэйн үр нь онцгой хувь хүн байх учиртай- “ чи түүний өсгийг няцлах болно ” /Эхл. 3:15/. Энэ хүн нь ямагт могойн үрийг няцлах бөгөөд өөрөөр хэлбэл нүгэл - “чиний толгойг няцална”. Могойн

50 БУРХАН

толгой руу цохих нь үхлийн дохио – учир нь тархи нь толгойдоо байдаг. Эмэгтэйн үр байж таарах нэр дэвшигч бол гарцаагүй Их Эзэн Есүс юм.

“ Харин эдүгээ энэ нь бидний Аврагч Христ Есүсийн үзэгдсэнээр илчлэгджээ. Тэр үхлийг устган, амь ба үхэшгүй байдлыг сайн мэдээгээр дамжуулан гэрэлд авчирсан ”. /2 Тим. 1:10/

“ Махан бие мөхөс болохоор Хуулийн хийж чадаагүйг Бурхан хийсэн юм. Тэр Өөрийн Хүүг нүгэлт махан биетэй адил байдалд нүглийн тулд илгээж, махан биеийн дотор нүглийг шийтгэв. ” / Ром 8 : 3/

“ Нүглүүдийг зайлуулахын тулд Тэр үзэгдсэн гэдгийг та нар мэднэ. Түүнд ямар ч нүгэл байхгүй. ” / 1 Иох. 3:5/

“ Түүнийг Хүү төрүүлэхэд, чи Түүнийг Есүс гэж нэрлэ. Учир нь тэр Өөрийн ард түмнийг нүглээс нь аварна гэж хэлэв. ” / Мат. 1:21/

Хэдийгээр Бурхан Түүний Эцэг байсан боловч Есүс “ эмэгтэй хүнээс ” /Гал. 4:4/, Марийн хүү болж төрсөн юм. Энэ утгаараа ч тэр, хэдийгээр өөр ямар ч эрэгтэй байгаагүй атал Бурханы тааллаар өгөгдсөн эмэгтэйн үр юм. Эмэгтэйн энэхүү үрийг могойн үр “чи түүний өсгийг няцлах болно” /Эхл. 3:15/ түр зуур шархдуулна. Өсгийгээ могойд хазуулах нь могойг толгойд нь

цохисонтой харьцуулахад түр зуурын шарх юм. Ярианы олон үг хэлд Библийн суурь үндэс агуулагдаж байдаг: “ толгой руу нь цохь ” / өөрөөр хэлбэл ямар нэг юмыг бүрмөсөн зогсоох, эцэс болгох/ гэдэг хэллэг нь Есүс могойн толгой руу цохисон эшлэлд суурилсан байж таарна.

Гэмийг буруушаалт, могойн үр ийг үндсэндээ Христийг загалмайд цовдлогдсоноор харуулдаг - ишлэлүүдэд Христ гэмийг ялан дийлснийг өнгөрсөн цагт хэрхэн иш татдагийг анхааралтай унш. Иймээс Есүс өсгөйдээ түр зуурын шарх авч шаналсан нь түүний 3 өдрийн үхэлтэй холбоотой. Тэр үхлээс дахин амилснаараа Түүний гэмд өгсөн үхлийн цохилтыг бодвол энэ нь түр зуурын шарх байсан гэдгийг баталдаг. Библийн бус түүхийн бичээсүүдэд цовдлуулсан хохирогсод өсгийгээгээрээ модонд хадагддаг

байсан гэж заасан нь сонирхол татаж байгаа юм. Иймд Есүс Түүний үхлээр “өсгийдээ шархаджээ”. Исаи. 53:4,5т Христийг загалмай дээрхи үхлээрээ дамжуулан Бурханаар хэрхэн “няцлагдан яллагдсаныг” дүрсэлсэн байдаг. Энэ нь цаад утгаараа Христ могойн үрээр няцлагдах болно гэдэг Эхл. 3:15ийн эшийг үзүүлж байна. Гэсэн хэдий ч Бурхан Христтэй тулгарсан муу ёрын сүнсээр дамжуулан төгс ажиллаж, Түүний хүүг өвтгөн няцалж байгаа муу ёрын сүнснүүдийн хүчүүдийг хянах замаар няцлалт яллалтыг Тэр хийсэн /Ис. 53:10/ хэмээжээ. Бурхан Түүний хүүхэд болгоны муу ёрын сүнсүүдийн ажиллагааг ийнхүү удирддаг ажээ.

Өнөөгийн мөргөлдөөн

Харин таны толгойд ийм асуулт гарч ирж мэдэх юм: “ Хэрэв Есүс гэм ба нүглийг /Могойн үр/ устгасан юм бол яагаад эдгээр зүйл нь өнөөг болтол байсаар байгаа юм бэ? ”. Үүний хариулт гэвэл Есүс загалмай дээр байхдаа өөртөө байгаа гэмийн хүч чадлыг устгасан, Эхл. 3:15 ийн эш үзүүлэлт нь бүхэлдээ Есүс болон түүний гэм хоорондын зөрчилдөөнийг харуулсан байдаг. Энэ нь юу гэсэн үг вэ гэхээр Тэр биднийг Түүний ялалтыг хуваалцахыг урьсан учир бид ч бас гэм ба үхлийг даван дийлж чадах юм. Түүний ялалтыг хуваалцахаар уригдаагүй хүмүүс, аль эсвэл ийм саналыг хүлээж авдаггүй хүмүүс мэдээж хэрэг гэм ба үхэлтэй тулгарсаар байх болно. Хэдийгээр усан баптисм хүртэн Христэд ирэгч эмэгтэйн үртэй уялдаатайгаар жинхэнэ итгэгчид ч гэсэн мөн гэм ба нүгэлтэй тулгардаг ч гэсэн тэдний гэм өршөөгддөг, ийм ч учраас нүглийн үр болох үхлээс аврагддаг. Хэдийгээр Мянганы эцэс гэхэд хүмүүс үхэхээ болих хүртэл Бурханы төлөвлөгөө биелэх болоогүй ч энэ утгаараа Есүс загалмай дээр “үхлийг устгасан” /2 Тим. 1:10/. – Дэлхий ертөнцөд үхэл гээч юм үгүй болоход :

“ Учир нь Тэр бүх дайснуудаа Өөрийн хөл дороо оруулах хүртэл ноёрхох ёстой.
Эцэст нь устгагдах дайсан бол үхэл мөн ” /1Кор. 15: 25,26/.

Бид хэрэв “ баптисм хүртэн Христэд” орсон бол Есүсийн тухай амлалтууд Эхл. 3.15 д өгүүлдэг шиг бидний хувьд амин хувийн амлалтууд болж өгдөг, өөрөөр хэлбэл амлалтууд Библи судрын зүгээр нэг сонирхолтой хэсгүүд төдий байхаа больж, шууд бидэнд зориулагдсан эш үзүүлэлт амлалтууд болж хувирдаг. Эмэгтэйн үрийн тухайд ч мөн адил, бид гэмийг богино хугацаанд

52 БУРХАН

ялан дийлж байгаагаа мэдрэх болно. Их Эзэнийг буцаж ирэх хүртэл бид ч мөн Есүсийн нэгэн адил өсгөйдээ хатгагдаж, мөн үхэх болно. Харин бид эмэгтэйн жинхэнэ үр мөн бол тэрхүү “шарх” зөвхөн түр зуурынх байх болно. Усан дор жинхэнэ ёсоор баптисм хүртэж, Христэд очигсод өөрснийгээ Түүний үхэл ба дахин амилахтай холбож, /Ром. 6:3-5/ уснаас дээшлэхээр бэлэгджээ.

Бид хэрэв эмэгтэйн жинхэнэ үр мөн бол Эхл. 3:15 д дурдагддаг үгс бидний амьдралд мөн тусгалаа олно – бидний дунд зөв ба буруугийн хоорон дахь зөрчил бий болдог. Агуу номлогч Паул /Ром 7:14-25/ түүний дотор түүнийг зовоосон гэм ба өөрийн нь мөн чанар хоёрын хоорондын зөрчилдөөнийг дүрсэлсэн байдаг.

Баптисм хүртэн Христэд орсны дараа бидний дотор агуулагдах гэмийн зөрчилдөөн улам бүр ихэсч, энэ нь бидэнтэй цуг ямагт хамт байх болно. Гэмийн хүч чадал их тул энэ нь нэг бодлын хэцүү юм. Гэвч нөгөө талаар, хэцүү биш, учир нь бид энэ зөрчилдөөнийг туулж, давсан Христийн дотор байгаа билээ. Итгэгчдийг Ефес 5:23-32г эмэгтэй хүн мэтээр хэрхэн дүрсэлснийг анхааралтай унш, үүнд эмэгтэйн үр байснаараа бид мөн эмэгтэй болсон мэт дүрсэлсэн байдаг.

Эмэгтэйн үр зарим талаар Есүс болон Түүний зан чанарыг эзэмшихийг оролдогсдыг аль алийг нь төлөөлдөг болохоор могойн үр гэм болон гэм, могойн зан чанарыг харуулагсдын аль алийг нь хэлж байгаа хэрэг. Ийм хүмүүс Бурханы үгийг үл ойшоож, аль эсвэл гажуудуулж, улмаар Адам Ева нарт тохиолдсон шиг шившигт гэм үйлдэж, Бурханаас холддог. Иудейчүүд Бурханыг үхэлд хүргэсэн, өөрөө хэлбэл, эмэгтэйн үрийг өсгөйд нь хатгасан, тул тэд могойн үрийн тод томируун жишээ юм. Үүнийг баптист Жон ба Есүс ийнхүү нотолжээ:

“ Харин фарисайчууд болон садукайчуудаас олон хүн баптисм хүртэхээр ирж буйг тэр

/Жон/ хараад, тэдэнд – Хорт могойн удам аа, ирэх уур хилэнгээс зугт гэж хэн та нарт сануулсан юм бэ? ” /Мат. 3:7/.

“ Есүс тэдний бодлыг мэдээд, тэдэнд хандан, -Аливаа хаанчлал дотроо хуваагдвал сүйрнэ.

Аливаа хот, эсвэл гэр дотроо хуваагдвал оршин тогтнохгүй. Хорт могойн удам аа, та нар өөдгүй хорон атлаа сайныг ярьж яаж чадна вэ? Учир нь зүрхний бялхлаас ам ярьдаг.” /Мат. 12:25, 34/

Дэлхий ертөнц, тэр бүү хэл, шашны ертөнц хүртэл ийм могойн ааш араншинг агуулж байдаг. Усан баптисм хүртэн Христэд нэгдсэн хүмүүс л гагцхүү эмэгтэйн үртэй холбогддог, харин бусад хүмүүс могойн үртэй их бага янз бүрийн хэмжээгээр холбогдсон байдаг юм. Есүс могойн үртэй холбогдсон хүмүүстэй хэрхэн харьцаж байсан нь бидний дүр зурагтай яг тохирох юм:

- Тэр хайр болон жинхэнэ халамжийн сүнсээр тэдэнд номлодог .
- Тэр тэдний ааш авир болон бодлыг Түүнд нөлөөлөхийг зөвшөөрөхгүй байсан.
- Тэр тэдэнд Түүний амьдралаар дамжуулан Бурханы хайрлах зан чанарыг харуулсан.

Гэвч энэ бүхний нь төлөө тэд Түүнийг үзэн ядаж байв. Тэр өөрөө Бурханы үгийг дагах гэж эрмэлздэг байсанд нь тэд атаархаж байжээ. Тэр ч бүү хэл, Түүний гэр бүл /Иох. 7:5, Марк. 3:21/ болон дотны нөхөд /Иох. 6:66/ нь хүртэл саад болж, зарим нэг нь түүнээс биеийн хувьд холджээ. Паул нэгэн цагт өөрийг нь түшиж тулж явсан хүмүүсээ халаглахдаа яг ийм зүйлийг мэдэрчээ.

“Тиймээс би та нарт үнэнийг хэлснээрээ би та нарын дайсан болсон хэрэг үү?” /Гал. 4:14-16/

Үнэн бол хэзээ ч хялбар бус бөгөөд үнэнийг таньж мэдэж, үнэнээр амьдрахад ямагт бэрхшээл үүсч тэр ч байтугай хавчилтад өртдөг.

“ Харин тэр үед махан биеэр төрсөн нь Сүнсээр төрснийгээ хавчсантай адил түүнчлэн эдүгээ мөн тэгж байна /Бурханы амьд, оршин буй үгээр – 1 Петр 1:23/ ” /Гал. 4:29/

Бид үнэхээр Христтэй жинхэнээсээ нэгдсэн бол бид Түүний зовж шаналсныг бас мэдрэх ёстой, мөн Түүний тэнгэрлэг шагналыг мөн адил хүртэх ёстой. Паул энэ тухайд юутай ч харьцууламгүй үнэт жишээ хэлжээ:

- өөрөөр хэлбэл, бид Есүсийн нэрээр баптисм хүртэцгээсэн. /Үйлс 2:38, 8:16/
Иймэрхүү ишлэлүүдтэй тулгарахад, “эмэгтэйн үр, Есүстэй холбогдоход ийм юм дагалдах бол би Түүнд орохоо болилоо” гэж бодоход хүргэж магадгүй. Гэвч мэдээж хэрэг бид өөрсний давж гарч үл чадах тийм зүйлийг хэзээ ч гэтлэхгүй билээ. Өөрснийгээ Христтэй бүрэн бүтэн нэгтгэхийн тулд юун түрүүнд өөрийгээ золиослох шаардлагатайн дээр Түүнтэй нэгдсэнийхээ дүнд гайхамшигт шагнал хүлээн авч “бидний дотор илчлэгдэх тэр гайхамшигийн хажууд бидний өнөө цагт амсаж буй зовлон бэрхшээл юу ч биш юм”. Тэр ч бүү хэл, одоо цагт хүртэл амьдралын зовлон зүдгүүрийг гэтэлж гарч, Бурхантай хамт хүчирхэг байх боломжийг Түүний золиос бидэнд олгодог. Үүн дээр Христдөлийн олон Библид нэн чухалчилж авч үздэг дараах баясгалант баталгааг нэмье:

“Та нарт учирсан сорилт нь хүнд тохиолддог л зүйл юм. Бурхан итгэмжит билээ. Тэр та нарыг хэрээс чинь хэтэрсэн зүйлээр соригдохыг зөвшөөрдөггүй, харин сорилтыг тэсвэрлэж чадахын тулд сорилттой хамт мөн гарах замыг ч өгдөг юм” /1 Кор. 10:13/.

“Миний дотор та нарыг амар амгалан байг гэж Би та нарт эдгээр зүйлсийг хэллээ. Ертөнцөд та нар зовлонтой байна. Гэвч зоригтой байгун. Би ертөнцийг ялсан гэж айлдлаа” /Иох. 16:33/.

“Тэгвэл бид эдгээр зүйлийн тухайд юу хэлэх вэ? Хэрэв Бурхан бидний талд юм бол, хэн биднийг эсэргүүцэх вэ?” /Ром. 8:31/.

3:3 Ноад Өгсөн Амлалт

Адам, Эва хоёрын үеэс хойш хүний түүх ургашлахын сацуу хүний чанар улам бүр муудаж байлаа. Хүн төрлөхтөн ёс суртахууны юмс тийнхүү доройтолд орсон үед Бурхан тэр юмсын системийг устгахаар шийдсэн юм. Чингэхдээ Ноа ба түүний гэр бүлийг л үлдээжээ. Тэгээд дэлхийг үерээр устгах үед Ноа өөрөө болон бүр төрлийн амьтадын төлөөлөгчид амьдрах том завь босгохыг тушаажээ. Дашрамд, Сударт тодорхой өгүүлсэн хэдий ч их

хэмжээний үер үнэнхээр болсоныг илтгэх шинжлэх ухааны баттай шалтгаан байгаа юм. Харин газар /манай энэ ертөнц/ сөнөөгүй бөгөөд гагцхүү түүн дээр байсан хорон муу хүнийг устгасан гэдгийг анхаарагтун: “газар дэлхий дээр хөдлөгч хамаг амьтан үхжээ” /Эхлэл 7:21/. Есүс /Матай 24:37/ ба Петр /2Петр 3:6-12/ хоёул Ноагийн дэлхийн явдлыг Христийн хоёрдахь ирэлтийн үетэй адил байхыг харсан юм. Тиймээс Ноагийн үеийн хүний хорт муу чанар Христийг эргэж ирэхэ үед шийтгэгдэхээ хүлээн буй бидний ертөнцийн өнөөгийн үетэй тохирч байгаа юм.

Хүний аймшигт гэм нүгэл болоод энэ ертөнц өөрөө өөрийгөө хөнөөх хөтөлбөртэй байгаа нь энэ газар дэлхий устгагдана гэсэн итгэл Христич дунд хүртэл гарч иржээ. Энэ санаа нь, Бурхан энэ ертөнцийн үйл хэргийн талаар идэвхтэй санаа тавьдаг бөгөөд энэ газар дэлхийд Бурханы хаанчлалыг тогтоохоор Есүс Христ удахгүй ирнэ гэсэн Библийн үндсэн мэдээг огт ойшоохгүй байгааг тодорхой харуулж байна. Хэрвээ хүнээр энэ ертөнцийг устгуулах юм бол эдгээр амлалтыг хэрхэн биелүүлэх билээ. Бурханы Хаанчлал газар дэлхий дээр тогтоно гэдгийг батлах чухал нотолгоонууд Хичээл 4.7 ба Хичээл 5-д бий. Энэ сацуу, газар дэлхий ба нарны систем устгагдахгүй гэдгийг дараах зүйл хангалттай нотлоно:-

-“Тэр өөрийн газрыг мөнхөд бий болгосон” /Дуулал 78:69/

-“Дэлхий ертөнц л үүрд оршин үлддэг” /Есс. 1:4/

-“Нар ба сар...гэрэлт бүх одод...хамгийн дээд тэнгэрүүд....тэд Түүний тушаалаар бүтээгдсэн билээ. Тэрээр хэзээ ч өнгөрөн одохгүй зарилгийг гаргасан юм” /Дуулал 148:3-"6/

-“Далай усаар дүүрдэг шиг дэлхий ЭЗЭНий мэдлэгээр бялхана” /Ис. 11:9, Тооллого 14:21/ Хэрвээ Бурхан газар дэлхийг өөрөөр нь устгуулах юм бод хэцүү. Энэ амлалтыг хараахан гүйцэтгээгүй байгаа юм.

-“ Бурхан газрыг бий болгосон юм. Тэр газрыг хий дэмий бүтээгээгүй бөгөөд хүмүүсийг оршин суулгахын тулд бүтээсэн юм.” /Ис. 45:18/ Хэрвээ Бурхан газар дэлхийг зөвхөн устгуулахын тулд бүтээсэн бол Түүний ажил хий дэмий зүйл байхсан.

56 БУРХАН

Гэвч аль түүнд, Эхлэлд Бурхан энэ бүхнийг Ноад амалсан. Ноа үерээр бүтээгдсэн шинэ ертөнцөд дахин амьдарч эхлэхдээ дахиад л бүрэн хэмжээний устгал болох байх гэж айсан байж магадгүй юм. Үерийн дараа бороо орж эхлэх тоолонд ийм бодол түүний толгойд орж ирж байсан нь гарцаагүй. Тэрээр ийм юм хэзээ ч болохгүй гэж гэрээ /хэд хэдэн амлалт/ хийжээ. Үүнд:

“Би Өөрийнхөө гэрээг та нартай ...байгуулана /”Би” гэснийг анхаарна уу. Бурхан мөнх бус хүнд амлалт өгсөн нь гайхалтай! Хамаг амьтаныг дахин хэзээ ч үерийн усанд устгахгүй. Газар дэлхийг сүйрүүлэх үер дахин хэзээ ч болохгүй” /Эхлэл 9:9-12/.

Энэ гэрээг солонго нотлов.

“Намайг газар дээр үүл /бороо/ хуралдуулахад, тэр үүлэн дээр солонго харагдахад, Би Миний болон та нарын, мах цустай бүх амьтаны хооронд байгуулсан мөнхийн гэрээгээ санан дурсах болно. ...Энэ /солонго/ бол тэр гэрээний тэмдэг болно” /Эхлэл 9:13-17/.

Энэ нь Бурхан ба газар дээрхи хүн, амьтаны хоорондын мөнхийн гэрээ учир газар дэлхийд хүн, амьтан мөнхөд орших ёсон буй. Бурханы хаанчилал тэнгэрт бус газар дэлхийд байх болно гэдгийн нотолгоо энэ юм.

Иймээс Ноад өгсөн амлалт бол Хаанчлалын Сайн Мэдээний суурь үндэс юм. Энэ нь Бурханы анхаарал хэрхэн энэ ертөнцөд төвлөрдөг болон хэрхэн Тэрээр үүнтэй мөнхийн зорилготой болохыг харуулж байна. Тэрээр ууралж хилгэнэсэн ч өршөөлийг санадаг /Хаб.3:2/. Түүний хайр тийм байсан ба Тэрээр Өөрийн бүтээсэн амьтдаа ч халамжилдаг /1Кор. 9:9, Иона 4:11/

3.4. Абрахамд өгсөн Амлалт

Есүс болон Эш Үзүүлэгчидийн сургасан Сайн Мэдээ нь Абрахамын ойлгосноос үндсээрээ өөр байлаа. Бурхан Судраар дамжуулан, “Абрахамд Сайн Мэдээг урьдчилан тунхаглажээ.”

/Гал. 3:8/. Тиймээс Петр Сайн Мэдээ тунхаглахаа эхлэх, дуусгахдаа Эш татсанд тэдгээр амлалтууд тун чухал юм /Үйлс 3:13,25/. Абрахамд юу сургасаныг бид ойлгох юм бол Христосын Сайн Мэдээний үндсэн ойлголтыг авах болно. “Сайн Мэдээ” Есүсын үед бий болсон юм биш гэдгийг харуулсан зүйлс байна:

-“Бид /еврей/ эцэг, өвөгдөд амлагдсан амлалтын тэрхүү сайн мэдээг л та нарт тунхаглаж байна...Бурхан амлалтаа ...биелүүлж өгсөн юм” /Үйлс 13:32,33/.

-“Бурхан Эш үзүүлэгчидээрээ /Абрахам, Эхэлэл 20:7/ дамжуулан Ариун Судруудад урьдаас амалсан тэрхүү сайн мэдээ /Ром 1:1,2/.

-“ Энэ зорилгын үүднээс сайн мэдээ үхэгсдэд ч хүртэл тунхаглагдсан юм / 1Петр 4:6/. Өөрөөр хэлбэл 1-р зуунаас өмнө амьдарч байгаад үхсэн итгэгчид.

-“Сайн мэдээ бидэнд тунхаглагдсаны адил тэдэнд ч бас тунхаглагдсан юм /Еврей 4:2/. Өөрөөр хэлбэл зэрлэгэд орших Израил.

Абрахамд өгсөн амлалтууд 2 үндсэн сэдэвтэй:

1/ Абрахамын үрийн /тусгай үр удам/ тухай юмс ба

2/ Абрахамд амалсан газрын тухай юмс.

Эдгээр амлалтуудыг Шинэ Гэрээнд тайлбарласан ба Библийг өөрөө өөрийгөө тайлбарлана гэсэн бодлогыг бид баримталж, Абрахамтай хийсэн гэрээний талаар бүрэн ойлголттой болохын тулд Гэрээнүүдийг бид хослуулж заах болно.

Абрахам уул нь цэцэглэн хөгжсөн Ур хотод амьдарч байжээ. Тэр нь одоогын Ирак ажгуу. Абрахамын үед иргэншлийн өндөр түвшинд хүрсэн байсан нь археологийн өнөө үеийн судалгаанаас харагддаг. Банкны систем, улсын алба, холбогдох дэд бүтэцтэй байжээ. Өөрөөр байдгийг үл мэдэгч Абрахам бидний мэдэж буйгаар дэлхийн хүн болон энэ хотод амьдарч байв. Гэтэл түүнийг энэ хөгжилтэй амьдралаас явж амалсан газарлуу зорин хөдөл гэсэн Бурханы ер бусын дуудлага түүнд иржээ. Чухам хаашаа очих, юу хийх нь тодорхой мэдэгдэхгүй байлаа. Үндсэндээ энэ нь 1500 милийн аялал байжээ. Хүрэх газар нь Канаан байлаа. Энэ нь орчин үеийн Израил юм.

58 БУРХАН

Хаяа Абрахамын амьдралд Бурхан гарч ирж түүнд амалсан амлалтуудаа давтан хэлж, өргөжүүлж байлаа. Тэдгээр амлалтууд нь Христийн Сайн Мэдээний үндэс бөгөөд мөн энэ амьдралын түр зуурын юмсыг орхиж, итгэл бишрэлийн амьдралд урагшилж, Бурханы амлалтуудыг байгаагаар нь авч, Түүний Үгээр амьдрах тэр дуудлага нь Абрахамд хүрч байсан шиг, Христичийн хувьд бидэнд үнэн ирдэг. Абрахам аялах явцдаа амлалтуудыг хэрхэн цэгнэж бодсон нь тодорхой. “Итгэлээр Абрахам /Ураас/ дуудагдахдаа өв болгон хүлээн авах гэж байсан /Канаан/ хэмээх нутагруу явснаар дуулгавартай дагав. Тэр хаашаа явж байгаага ч мэдэлгүй гарч явав” /Еврей 11:8/.

Бид Бурханы амлалтуудыг анх удаагаа авч үзвэл Бурханы Хаанчлалын амалсан газар нь чухам ямар байхыг бид ч бас мэдэхгүй. Гэвч Бурханы Үгэнд бид итгэнэ гэдэг нь түүнийг уриалгахан дагана гэсэн үг юм.

Абрахам бол эдгээр амлалтууд дээр азаа туршихаас өөр хийх юмгүй тэнүүлч нүүдэлчин хүн биш юм. Түүний гарвал, үүсэл, байр байдал нь үндсэн үг хэллэгээр илэрхийлэхэд биднийхтэй төстэй юм. Бид Бурханы амлалтуудыг хүлээн авч тэдгээрийн дагуу явах уу яахав гэж эрэгцүүлэх үедээ Абрахамтай учирсан бэрх, төвөгтэй шийдвэр гаргах тэр мөчтэй тулгарч болох юм. Бизнесийн холбоотнууд чинь хачин жигтэй хараад л, хөршүүд чинь сэмхэн /"Тэр шашинтай болсон!"/ нүднийхээ булангаар хараад л, энэ бүхэн Абрахамд учирсан л байж таарна. Абрахамд энэ бүхний дундуур туулаад гарахад агуу их зүйл хүч өгсөн байж таарна. Түүний урт удаан аялсан жилүүдэд тэр зүйлийг өгсөн ганц юм нь амлалтыг үг байсан. Тэрээр тэдгээр үгийг цээжилж, өөрт нь үнэнхээр учир утгатайг өдөр тутам эрэгцүүлэн бодсон байж таарна.

Бид итгэлээ харуулж, түүгээр үйлдлээ явуулснаар Абрахам шиг Бурханы найз /Иса. 41:8/ хэмээгдэх нэр төрийг олж, Бурханы тухай олж мэдэх /Эхлэл 18:17/ эрхтэй болж Хаагчлалд мөнхийн амьдрал олж авах бат найдвартай болох боломжтой. Христийн Сайн Мэдээ бол Абрахамд өгсөн эдгээр амлалтууд дээр тулгууралсан гэдгийг бид дахин онцлон тэмдэглэе. Бид Христич мэдээлэлд жинхэнээр итгэхийн тулд Абрахамд өгсөн амлалтуудыг мэдэх ёстой. Тэдгээргүйгээр бидний итгэл, итгэл биш болно. Иймээс бид Бурхан ба Абрахамын хоорондын яриаг ахин дахин унших нь зүйтэй.

ГАЗАР

1/ “Чи төрсөн нутагаа...орхиж миний чамд зааж өгөх газарлуу яв” /Эхлэл 12:1/.

2/ Абрахам “...Бетел хүртэл аялаж /Төв Израилын нутаг/...Эзэн Абрахамд хэлэв: Чи хараагаа өргөн, одоо байгаа газраасаа хойд, урд, баруун, зүүн зүг руу харагтун. Чамд харагдаж байгаа тэр бүх газар нутгийг би чамд болон чиний үр хүүхдүүдэд үүрд өгнө...Босоод, энэ газар нутгаар хөндлөн гулд явж үз....Би түүнийг чамд өгнө” /Эхлэл 13:3, 14-17/.

3/ “Эзэн Абрахамтай гэрээ байгуулж – Би энэ газрыг Египет мөрнөөс их мөрөн Евфраг хүртэл чиний үр удамынханд өгсөн билээ гэв” /Эхлэл 15:18/.

4/ “Би одоо чиний харийн хүн мэт амьдран сууж байгаа энэ нутаг буюу Канааны бүх газар нутгийг чамд болон чиний үр удмынханд үүрдийн өмч болгон өгнө” /Эхлэл 17:8/.

5/ “Түүнийг /Абрахамыг/ Ертөнцийн өв залгамжилагч болно гэсэн амлалт” /Ром 4:13/.

Энд бид Абрахамд хийсэн удаа дараагын илчлэлүүдийг харж байна.

1. ‘Чамайг би очуулмаар нэг газар байна’.
2. ‘Чи одоо тус бүс нутагт хүрч очоод байна. Чи болоод чиний хүүхдүүд энд мөнхөд амьдрах болно’. Мөнхийн амьдралын талаархи энэ амлалт нэг их сүр дуулиан, тодотголгүй тэмдэглэгдэн үлдсэнийг анзаарагтун: Хүн үүнийг зохиосон бол гарцаагүй чаминаар гоёчлон, уран сайхнаар өгүүлэх байсан.
3. Амалсан газар нутгийг илүү нарийн тодорхойлжээ.
4. Абрахам амлалтыг энэ амьдралд хүлээж авна гэж бодох ёсгүй юм. Тэрээр энэ газарт “харийн хүн” байх ёстой юм. Гэхдээ хожим нь тэрээр тэндээ үүрд амьдрах болно. Үүний утга санаа нь юув гэвэл тэрээр үхэх бөгөөд харин хожим дахин амилалт болж энэ амлалтаа хүлээж авах юм.
5. Ариун сүнсээр удирдуулсан Паул, Абрахамд өгсөн амлалтуудыг бүх л газар дэлхийг өвлөн авах утгатай гэж үзсэн бололтой.

60 БУРХАН

Абрахам амлалтуудаа биелэхийг амьдралынхаа хугацаанд хүлээж аваагүй өнгөрсөнийг Судар Судар бидэнд зориуд сануулсан юм.

“Итгэлээр тэр амлалтын газарт харийн хүн мэт сууж /амьдралын түр хэв маяг/, харийн нутагт байгаа мэт майханд нутаглаж амьдарсан” /Евр. 11:9/

Тэрээр тус газарт гадны хүн шиг амьдарч байсан ба сэтгэл санаа нь, аюулгүй биш байдалд байгаагаа ямагт санан, хүнийрхэн эвгүйрхэн байдаг дүрвэгсэдийнх шиг байсан болов уу. Тэрээр өөрийн газарт үртэйгээ амьдарч байгаагүй болов уу. Тэрээр үр удам болох Исаак, Якоб нартайгаа /тэдэнд амлалтуудыг давтан хэлсэн/ “...амлалтуудыг хүлээж авалгүй, харин холоос тэдгээрийг харж, амлалтуудад ятгагдаж, баяр хүргэж, өөрсдийгөө дэлхийд харь хүмүүс хийгээд цөлөгдөгсөд гэдгийг хүлээн зөвшөөрөн итгэл дотроо нас барсан билээ” /Еврей 11:13/. 4 шат байгааг анзаарна уу:

--Энэ хичээлийг үзэх явцдаа амлалтуудыг мэдэх.

--“тэдэнд ятгагдах” – Хэрэв Абрахамыг ятгах үйл явц байсан бол бидэнд мөн хир зэрэг ийм үйл явц орох вэ?

--Христруу баптисм хүртснээр тэдгээрт баяр хүргэх. /Гал.3:27:29/

--Энэ ертөнц бол манай жинхэнэ гэр биш. Гэхдээ бид газар дэлхийд тэр ирээдүйн үе ирнэ гэж найдан амьдарч байна гэдгээ өөрсдийн амьдралын хэв маягаар дэлхийд хүлээн зөвшөөрөх.

Хэрвээ бид эдгээр зүйлсийг сайшаан хүлээн авах юм бол Абрахам манай агуу их баатар ба үлгэх жишээ болж байна. Амлалтуудын биелэлт нь хожим ирнэ гэдгийг ядарсан өвгөн эхнэрээ үхэхэд л эцэст нь ухаардаг. Тэрээр үнэн хэрэгтээ эхнэрээ оршуулах хэсэг газрыг амлагдсан газраас худалдан авах болдог. /Үйлс 7:16/. Үнэнхээр Бурхан “ганц алхам газрыг ч түүнд өмчөөр өгөөгүй хэдий ч түүнийг үр хүүхэдгүй байхад нь хүртэл энэ нутгийг түүнд болон түүний дараа үр удамд нь өмч болгон өгөхөөр тэр амалсан юм” /Үйлс 7:5/. Абрахамын одоогийн үр нь газар дэлхийд өөрсдөд нь өмчлүүлж

мөнхөд өвлүүлэхээр амлагдсан газар дээрээ өмч худалдан авах буюу түрээслэхдээ мөн л тийм нийцтэй бус явдлыг мэдэрч болох юм!

Гэвч Бурхан амлалтуудаа биелүүлдэг. Абрахам ба өөр бусад бүгдэд амалсан тэдгээр амлалтуудаар шагнах өдөр ирэх ёстой. Еврей 11:13, 39, 40-д яг үүнийг өгүүлж байна:

“Тэд бүгд амлалтуудыг хүлээж авалгүй итгэл дотроо нас барсан юм. Бурхан бидний төлөө илүү дээр ямар нэгэн юмыг урьдаас харж байсан. Ингэснээр тэд бидэнгүйгээр төгс болгогдох ёсгүй” гэжээ.

Иймээс жинхэнэ бүх итгэгчидийг цагаа болохоор яг л ижил цэгт, өөрөөр хэлбэл сүүлчийн өдөр шүүлтийн суудал дээр шагнах юм. /2 Тим. 4:18, Матт. 25:31-34, 1 Петр 5:4/. Шүүхийн өмнөхөн тэдгээр амлалтуудыг дахин амилуулах ёстойг мэдэх Абрахам ба бусад нь шүүгдэхийн тулд орших ёстой болжээ. Хэрвээ тэд тэдгээр амлалтыг хүлээж аваагүй ба Христийг эргэж ирэхэд дахин амилж, шүүгдсэний дараа л тэдгээрийг авах юм бол Абрахам мэт нь ухамсарлалгүйгээр Христийн ирэхийг хүлээн байна гэдгийг хүлээн зөвшөөрөхөөс өөр хувилбар байхгүй юм. Гэвч Европ даяарх сүмүүдэд буй өнгөт шилэн шигтгээнүүд Абрахамыг одоо итгэлийн амьдралын амалсан шагналыг хүртэн Тэнгэрт байгаагаар дүрсэлдэг нь нийтэд илэрхий билээ. Мянга мянган хүн шашины хувьд тийм санаануудыг хүлээн зөвшөөрч хэдэн зуун жилээр тэдгээр зургийн дэрэгдүүр өнгөрсөөр ирсэн билээ. Тэр шугамаас хазайх, Библьд суурилсан эр зориг танд байх уу?

ҮР

Хичээл 3:2-д тайлбарласанчилан үрийн талаархи амлалт гол нь Есүст хамаарах бөгөөд, хоёрдугаарт, “Христэд” байдаг тэдэнд хамаарах учир Абрахамын үр гэж бас тооцогдоно:-

1/”Би чамайг аугаа их үндэстэн болгож, чамайг ерөөн....газар дэлхий дээрх бүх үндэстэн чамаар дамжуулан ерөөгдөнө” /Эхлэл 12:2,3/.

2/ “Чамд харагдаж байгаа тэр бүх газар нутгийг би чамд болон чиний үр хүүхдүүдэд үүрд өгнө. Би бол чиний үр хүүхдийг газар

62 БУРХАН

шороо мэт болгоно. Хэрэв хүн газар шороог тоолж чаддаг бол чиний үр хүүхдүүдийг ч тоолж чадмуй” /Эхлэл 12:2,3/.

3/ “Чи тэнгэр өөд хар, хэрэв оддыг тоолж чадваас тоол... Чиний үр удам ийм олон болно....Энэ газрыг Би чиний үр удамынханд өгсөн билээ” /Эхлэл 15:5,18/.

4/ “Би Канааны бүх газар нутгийг...чиний үр удмынханд үүрдийн өмч болгож өгөөд Би тэдний Бурхан нь болно” /Эхлэл 17:8/

5/ “Би үнэнхээр чамайг ерөөж, чиний үрсийг тэнгэрийн одод, далайн эргийн элс мэт асар олон болгоно. Чиний үрс дайснуудынхаа үүд хаалгыг эзлэн авах болно. Бас чи Миний үгийг дуулгавартай дагасан учир газар дэлхийн бүх үндэстэн чиний үрсээр дамжуулан ерөөгдөх болно” /Эхлэл 22:17,18/.

Дахин хэлэхэд, “үр”ийг ойлгох Абрахамын ойлголт удаа дараалан өргөжсөн юм:-

1/ Юуны өмнө, түүнийг ямар нэг учирлаар ер бусын олон үр удамтай болж, түүний “үр”ээр дамжуулан бүхэл газар дэлхий ивээгдэнэ гэж түүнд хэлжээ.

2/ Түүнийг олон хүн оролцуулсан үртэй болно гэж түүнд хожим хэлжээ. Тэдгээр хүмүүс түүний хүрэлцэн ирсэн газарт, өөрөөр хэлбэл Канаанд түүнтэй хамт мөнхийн амьдралаар амьдрах юм.

3/ Түүний үрийг тэнгэр дэх од шиг олон болно гэж түүнд хэлжээ. Энэ нь, тэр олон сүнслэг үр удам /тэнгэр дэх одод/ ба олон ердийн үр удам /”газрын тоос” мэт/ тай болох юм гэж бодогдуулсан байж болох юм.

4/ Үрийн хэсэг болох олон хүн Бурхантай биечлэн харилцаатай байж болох юм гэсэн нэмэлт итгэлийг түрүүчийн амлалтуудыг өгөхдөө онцлон тэмдэглэжээ.

5/ Үр түүний дайснуудын эсрэг ялалт байгуулана.

Үр нь дэлхий дахины бүх хүмүүст хүртээлтэй “ивээл”ийг авчирах ёстой гэдгийг анзаар. Библид ивээлийн санаа, гэм нүглийг өршөөхтэй ямагт холбогддог юм. Эцсийн эцэст энэ нь Бурханд хайртай хэн нэгэн хүсэх хамгийн том ивээл юм.

Иймээс дараах зүйлсийг бид уншина: “Алдаа зөрчил нь уучилагдсан нэгэн юутай ерөөлтэй вэ?” /Дуулал 32:1/; “Ерөөлийн аяга” /1 Кор. 10:16/. Христийн цусыг төлөөлөх аяга дарсыг ийнхүү дүрсэлж буй бөгөөд үүгээр дамжуулан уучилах бололмжтой болдог.

Дэлхийд уучилалыг авчирсан Абрахамын цорын ганц үр удам бол мэдээж Есүс бөгөөд Абрахамд өгсөн амлалтуудын талаархи Шинэ Гэрээний тайлбар үүнийг хатуу баталж байна:-

“Тэр /Бурхан/ “Үрст” гэж олны талаар хэлээгүй, харин ганцын тухай “Чиний үрд” гэж айлдсан. Тэр бол Христ юм” /Галат 3:16/

“...Чиний үрээр дэлхийн бүх өрх айлууд ивээгдэх болно хэмээн Абрахамд айлдан, эцэг өвгөдтэй чинь Бурханы байгуулсан гэрээний хөвгүүд юм. Бурхан эхлээд Өөрийн хүү Есүсийг /үрийг/ өсгөн. Түүнийг та нарын нэг бүрийг хорон муу замаас нь эргүүлж ивээхийн тулд илгээсэн юм” /Үйлс 3:25,26/

Эхлэл 22:18-ийг Петр хэрхэн Эш татан хөрвүүлснийг анзаар:-

Үр = Есүс

Ивээл = нүгэлийг уучилах

Нүгэл бол Бурханы хүмүүсийн хамгийн том дайсан учраас мөн Есүсын хамгийн том дайсан мөн ба түүнийг Есүс дарна гэдэгтэй, Үр болох Есүс дайсныгаа дарна гэсэн амлалтыг холбож үзвэл зөв байраа эзэлж байгаа нь тэр.

Үрд Нэгдэх нь

Христич Сайн Мэдээний үндсэн зүйлүүдийг Абрахам ойлгосон гэдэг нь одоо тодорхой болох ёстой. Харин эдгээр чухал амлалтууд нь Абрахам ба түүний үр Есүст зориулагдсан юм. Өөр бусдыг яахав? Абрахамын махан биеийн үр удам хүртэл өөрөө аяндаа тэрхүү тусгай үрийн хэсэг болохгүй юм /Иохан 8:39, Ром 9:7/. Гэхдээ үрт өгсөн амлалтуудыг бидэнтэй бас хуваахын тулд

64 БУРХАН

бид Есүсын дотны хэсэг болох ёстой. Энэ нь Христийн Есүсруу баптисм хүртснээр /Ром 6:3-5/ ихэвчлэн бид түүний нэрээр баптисм хүртдэг /Үйлс 2:38, 8:16, 10:48, 19:5/ Үүнийг Гал. 3:27-29-аас өөрөөр хэрхэн илүү тод өгүүлэх билээ:-

“Христруу баптисм хүртсэн та нар бүгдээрээ /зөвхөн бүгдээрээ/ Христийг өмссөн юм. Иудей гэж байхгүй, грек ч гэж байхгүй, боол ч гэж байхгүй, эр ч гэж байхгүй, эм ч гэж байхгүй. Учир нь Учир нь та нар Христийн Есүс дотор нэг болой. /баптисмаар/ Хэрэв та нар Христийнх юм бол /түүнрүү баптисм хүртсэн/ та нар Абрахамын үр бөгөөд амлалтын дагуу өв залгамжилагчид юм”.

–Есүсээр дамжуулан уучилалын “ивээл” /ерөөл/ хүртснээр газар дэлхийд мөнхөд амьдрах амлалт. Христруу баптисм хүртснээр бид түүнд өгсөн амлалтыг хуваан эдэлж байгаа юм. Тиймээс Ром 8:17-д биднийг “Христийн хамтран залгамжилагчид” хэмээн нэрэлдэг.

Ивээл /ерөөл/ үрээр дамжин дэлхийн өнцөг булан бүрийн хүнд ирэх ёстой бөгөөд үр нь эргийн элс, тэнгэрийн одод мэт дэлхий дахины хүмүүсийн бүлэг болох ёстой гэдгийг санагтун. Үүнээс үзэхэд тэд эхлээд ивээл /ерөөл/ хүртэж байж үр болж болох юм. Тиймээс /ганц/ үр “үе дамжин ЭЗЭНд захирагдана” /өөрөөр хэлбэл олон хүн. Дуулал 22:30/.

Абрахамд өгсөн амлалтуудын хэлхээг бид ингэж дүгнэж болох юм:

(1) Газар

Абрахам ба түүний үр Есүс, Түүн доторхи хүмүүс Канааны газар нутгийг өвлөх ба бүр өрөгжүүлж бүх л дэлхийг өвлөж тэндээ үүрд амьдрана. Тэд түүнийг энэ амьдралдаа хүлээж амахгүй бөгөөд харин Есүс эргэж ирэх сүүлчийн өдөр авна.

(2) Үр

Энэ нь гол нь Есүс байсан. Хүн төрлөхтний нүгэлүүд /”дайснууд”/-ийг Түүгээр дамжуулан дарж уучилалын ивээл дэлхий дахинд түгээмэл хүртээмжтэй болно.

Есүсын нэрлүү баптисм хүртснээр бид үрийн хэсэг болдог. Эдгээр хоёр хэлхээ Шинэ Гэрээний номлолд дайралддаг ба хүмүүст тэдгээрийг заахад дараа нь баптисм хүртдэг гэсэн мэдээлэлүүд байгаа нь гайхалтай биш юм. Ийм л замаар эдгээр амлалтуудыг хийж байсан ба хийж ч болох юм.

Нэгэн өвгөн үхэлтэй тулгарахад /63/ яагаад Паул түүний найдварыг “Израилын найдвар” /Үйлс 28:20/ хэмээн тодорхойлсон нь одоо бидэнд ойлгомжтой байж болох юм. Жинхэнэ Христич найдвар бол Еврейн уугуул найдвар юм. “Аврал еврейчүүдээс гарна” /Иохан 4:22/ гэж Христийн хэлсэн нь ариун сүнсний Еврейчүүд болох хэрэгтэй гэдэгтэй холбоотой байх ёстой юм. Яагаад гэвэл Еврей эцэг нарт өгсөн авралын амлалтуудаас бид Христээр дамжин хүртэж болох билээ.

Эртний Христичид ингэж номолсоныг бид уншдаг:-

1/ “ Бурханы Хаанчлал ба

2/ Есүс Христийн нэртэй холбоотой юмс” /Үйлс 8:12/.

Эдгээр нь арай өөр гарчиг дор Абрахамд тайлбарласан хоёр зүйл юм:-

1/ Газрын талаархи амлалтууд ба

2/ Үрийн талаархи амлалтууд.

Хаанчлал ба Есүсын тухай “юмс” /олон тоон дээр/-ийг “Христийг номлох” /Үйлс 8:5 / хэмээн дүгэнсэнийг дашрамд анзаар. Энэ нь ихэвчлэн “Есүс чамд хайртай! Тэр чиний төлөө үхсэн гэдэгт итгэж байна гээд л хэлчих. Тэгэхээр чи аврагдаж байгаа хэрэг!” гэсэн утгатай байдаг. Гэвч “Христ” гэсэн хэллэг түүний тухай болон түүний ирээдүйн Хаанчлалын тухай номлолыг тодорхой дүгнэж байгаа юм. Абрахамд номолсон энэ Хаанчлалын тухай сайн мэдээ нь эхэн үед Сайн Мэдээг номлоход томоохон үүрэг гүйцэтгэсэн юм.

Коринтод, Паул “3 сарын турш Бурханы Хаанчлалын тухай сургамжлан, ятгаж зоригтой ярьж байв /Үйлс 19:8/; Ефесэд тэрээр “Бурханы Хаанчлалыг Номлон” /Үйлс 20:25/ явсан ба Ром дахь түүний хунгийн дуу мөн адил байлаа. “ Бурханы Хаанчлалын тухай гэрчлэн, Есүсын тухай тэдэнд итгүүлэхийг

66 БУРХАН

хичээж...Хуулиас...Эш Үзүүлэгчидийн номоос сургаж байв” / Үйлс 28:23,31/. Ярих юм ихтэй байсан нь Хаанчлал ба Есүсын тадаархи үндсэн Сайн Мэдээ нь “Есүс дээр Итгэ” гэж хэлэхийн төдий зүйл биш байлаа. Абрахамд хийсэн Бурханы илчлэл түүнээс ч илүү дэлгэрэнгүй байсан ба түүнд амалсан зүйлүүд жинхэнэ Христич Сайн Мэдээний үндэс юм.

Есүсруу баптисм хүртэх нь биднийг үрийн хэсэг болгож өгч байгаа ба тэгснээр амлалтуудыг өвлөх боломжтой болгож байгаа юм /Галат 3:27-29/.

Гэвч бид амалсан авралыг олж хүртэхэд баптисм дангаараа хангалттай биш. Хэрвээ бид үрлүү өгсөн амлалтуудыг хүлээж авахаар бол /64/ бид үрд, Христэд үлдэх ёстой. Тиймээс Баптисм бол дөнгөж эхлэл. Бид уралдааны гараанд гарч байгаа хэрэг бөгөөд цаашид гүйгээд байх хэрэгтэй болно. Абрахамын үр болчихсноор л Бурхан биднийг хүлээн авчихлаа гэж бодож болохгүй. Израильчууд бол зарим талаар Абрахамын үр мөн боловч баптисм хүртэлгүйгээр, Христрүү амьдралаа захируулалгүйгээр, Абрахамын жишээг дагалгүйгээр аврагдана гэсэн үг бишээ /Ром 9:7,8, 4:13,14/. Есүс Еврей нарт “Та нар Абрахамын үр удам мөн гэдгийг Би мэднэ: Гэвч та нар намайг алахыг оролдож байна....Хэрэв та нар Абрахамын хүүхдүүд байсан бол Абрахамын хийснийг үйлдэхсэн” /Иохан 8:37,39/ гэж хэлсэн бөгөөд энэ нь Бурхан ба амлагдсан үр болох Христэд итгэх амьдралаар амьдрах ёстойг өгүүлжээ.

“Үр” нь дээдсийнхээ шинж төлөвийг агуулсан байх ёстой. Хэрвээ бид Абрахамын жинхэнэ үр байа гэвэл зөвхөн баптисм хүртээд зогсохгүй түүнтэй адил Бурханы амлалтуудад жинхэнээр итгэсэн байх ёстой юм. Тиймээс түүнийг “итгэх бүх хүмүүсийн эцэг...бидний эцэг Абрахамд байсан итгэлийн мөрөөр мөшигөгч хүмүүсийн эцэг...” /Ром 4:11,12/ хэмээн нэрлэжээ.”Итгэлийн хүмүүс нь тэгэхээр Абрахамын хөвгүүд юм гэдгийг мэдэж ав /өөрөөр хэлбэл зүрхэндээ шингээ! /Гал. 3:7/.

Жинхэнэ итгэл нь зарим үйлдэлд харагдаж байх ёстой. Эс тэгвээс, Бурханы нүдэнд бол, тэр нь итгэл биш юм /Иоков 2:17/. Бид суралцаж авсан эдгээр амлалтуудад итгэж байгаагаа эхлээд баптисм хүртснээр харуулах бөгөөд ингэснээр тэдгээр нь бидэнд биечлэн хүртэхээр ирнэ /Гал. 3:17-19/. Тэгэхээр та Бурханы амлалтуудад нээрээ итгэж байна уу? Бид

амьдралынхаа туршид энэ асуултыг өөрөөсөө зогсоо зайгүй асууж байх ёстой юм.

Хуучин ба Шинэ Гэрээ

Абрахамд өгсөн амлалтууд Христийн Сайн Мэдээг дүгнэж байгаа нь одоо илт болсон байх ёстой. Бурханы хийсэн амлалтуудын өөр нэг том хэсэг бол Мосегийн хуулийн утгаар Еврейчүүдтэй хийсэн амлалтууд юм. Хэрвээ еврейчүүд энэ хуулийг дагах юм бол тэд энэ амьдралдаа биетээр ивээгдэнэ /ерөөгдөнө/ гэж тэдгээр амлалт өгүүлжээ/Дэд хууль 28/ Эдгээр амлалтуудад буюу “гэрээнд” мөнхийн амьдралын талаар шууд амалсан зүйл байхгүй юм:-

1/ Христ буцаж ирэхэд Бурханы Хаанчлалд уучилал ба мөнхийн амьдралыг Абрахам ба түүний үрд амалсан. Энэ амлалтыг мөн Еденд ба Давидад хийсэн.

2/ Мосегийн үеийн Еврей хүмүүст хэрэв тэд Бурханы Мосед өгсөн хуулийг даган мөрдвөл одоогийн амьдралд нь энх амгалан, баяр жаргалыг амалсан.

Бурхан Абрахамд Хаанчлалд уучилал ба мөнхийн амьдрал амалсан. Гэвч энэ нь зөвхөн Есүсын золиосолоор л боломжтой болсон юм. Ийм шатлгаанаар, загалмай дээрх Христын үхэл Абрахамд өгсөн амлалтуудыг нотолсон /Гал. 3:17, Ром. 15:8, Дан. 9:27, Кор. 1:20/ учраас Түүний цусыг “шинэ гэрээний цус” /Гэрээ, Матай 26:28/ гэж нэрэлсэн хэмээн бид уншдаг. Үүнийг бид санаж байхын тулд, бидэнд эдгээр зүйлийг сануулахын тулд Есүс биднийг Өөрийнхөө цусыг бэлэгдсэн аяга дарсыг тогтмол хүртэж байхыг хэлсэн /1 Кор. 11:25-ыг үз/. “Миний цусаар тогтоох шинэ гэрээ юм” / Лук 22:20/. Бид эдгээр зүйлийг ойлгохгүй юм бол Есүс болон түүний бүтээлийн дурсгал болгож “талх хуваах” хэрэггүй юм.

Есүсын золиосол Бурханы Хаанчлалд уучилал ба мөнхийн амьдралыг байх боломжтой болгосон юм. Тиймээс тэрээр Абрахамд өгсөн амлалтуудыг баттай болгосон юм; тэрээр “илүү сайн гэрээний батлан даагч” байв /Евр. 7:22/. Еврей 10:9-д Есүсыг “Тэр хоёрдахийг нь тогтоохын тулд анхныхыг нь зайлуулдаг. Энэ нь, Есүс Абрахамд амлалтуудаа нотлохдоо өөр нэг гэрээг зайлуулдагийг харуулж байна. Тэр нь Мосегоор дамжуулж өгсөн гэрээ юм. Есүс шинэ гэрээг үхлээрээ нотолсоныг

68 БУРХАН

иш татсан шүлгүүд нь түүний алга хийсэн хуучин гэрээ байсныг илтгэнэ /Евр. 8:13/.

Энэ нь юу гэсэн үг вэ гэхээр Христтэй холбоотой гэрээг эхэл хийсэн хэдий ч түүнийн үххээс өмнө энэ гэрээ бүрэн ажиллагаанд ороогүй байсан учир “шинэ” гэрээ гэж нэрлэгджээ. Мосегоор дамжуулж хийсэн “хуучин” гэрээний зорилго бол Есүсын бүтээлрүү анхааралыг чиглүүлж Христтэй холбоотой амлалтуудад итгэх итгэлийг чухалыг онцлон харуулах явдал байсан /Гал. 3:19,21/. Нөгөө төлөөр, Христэд итгэх итгэл Мосед өгсөн хуулийн үнэнийг нотолж байгаа юм /Ром. 3:31/. Паул үүнийг ер бусаар дүгнэхдээ: “Бид итгэлээр зөвтгөгдөхийн тулд бидний хувьд хууль нь биднийг Христруу хандуулж зааварчлагч болов” /Гал. 3:24/. Мосегоор дамжуулсан хууль чухам энэ зорилгоор хадгалагдсан ба үүнийг одоо ч суралцахад бидэнд ашигтай.

Эдгээр зүйлийг анхны уншилтаар ойлгоход амар биш: бид дараах байдлаар дүгнэж болно:-

Абрахамд хийсэн Христтэй холбоотой амлалтууд –
Шинэ Гэрээ.

Мосед өгсөн хуультай холбоотой Израильд хандсан амлалтууд -
Хуучин Гэрээ.

Хрисийн үхэл. Хуучин Гэрээ дууссан /Кол. 2:14-17/. Шинэ Гэрээ ажиллагаанд орсон.

Энэ шалтгаанаар аравны нэг, Саббат өдрийг сахих гэх мэт Хуучин Гэрээний хэсэг байсан зүйлүүд одоо шаардлагатай биш юм– Хичээл 9.5-ыг үз. Шинэ Гэрээг жинхэнэ Израилыг гэмшиж, Христийг хүлээн авсан үед Шинэ Гэрээ хийгдэх юм /Иер. 31:31,32, Ром 9:26,27, Езе. 16:62, 37:26/. Мэдээж одоо гэмшиж, Христийг хүлээн авч, Есүсруу баптисм хүртсэн ямар Еврей хүн ч тэр даруй Шинэ Гэрээнд орж болно /Түүнд Еврей мөн бишийн ялгаа байхгүй – Гал. 3:27,29/.

Эдгээр зүйлийг үнэнхээр хүндэлж үзнэ гэдэг нь биднийг Бурханы амлалтууд баттай гэдгийг ухаарахад хүргэж байна. Үл итгэгч үзэлтнүүд эртний Христич номлогчидыг эерэг өөдрөг мэдээ өгсөнгүй гэж шудрага бусаар буруушааж байсан юм. Паул үүнд хариу өгөхдөө, Бурхан амлалтуудаа Христ үхэж байж хэрэгжинэ

гэж нотолсон учир тэдний ярьж байсан найдвар бол тэр дороо болчих зүйлийн тухай биш, харин бүрэн баттай саналын тухай юм."Бурхан үнэн учир та нарт хандах бидний /номлолын/ үг *за юмуу үгүй* биш байсан. Биднээр та нарын дунд тунхаглагдсан Бурханы Хүү Христ Есүс нь *за* ба *үгүй* байгаагүй . Харин Түүний дотор *За* байгаа юм. Учир нь Бурханы бүх амлалт Түүний дотор *За* гэдэг. Тиймд бид Бурханы алдрын тулд Түүгээр дамжуулан *Амен* гэдэг/ 2 Кор. 1:17-20/. Энэ нь мэдээж "энэ бүхэнд зарим нэг үнэн *байгаа байлгүй дээ...*?" гэсэн хандлагыг няцааж байгаа юм.

3.5 Давидад хийсэн Амлалт

Давид нь Бурханы амлалтууд хүлээж авсан Абрахам мэтийн олон хүний адил хялбархан амьдралтай байсангүй. Тэрээр олон хүүхэдтэй айлын хамгийн бага хүү байсан бөгөөд манай эринээс өмнөх 1000 оны Израильд энэ нь хонь хургаа хариулах, эзэрхүү ах нартаа зарагдаж гүйнэ гэсэн үг /1 Сам. 15-17/. Тухайн үед тэрээр Бурханд итгэх өндөр түвшинд хүрсэн ба түүнээс хойш тэр түвшинд хүрсэн хүн цөөхөн юм.

Израильд түрэмгий хөрш Филистинчүүдийн зүгээс заналхийлэлтэй тулгарах өдөр иржээ. Филистины аврага хүн болох Голиаттай нэг хүнээ тулалдуулах шаардлагатай болов. Тэдний хэн ялсан нь ялагдсанаа захирах ёстой байлаа.

Давид дүүгүүр хэрэглэн Бурханы тусламжтайгаар Голиатыг ялсан нь түүнд хаан /Саул/-аас илүү нэр хүндийг авчирчээ. Саул Давидыг дараагын 20 жил өмнөт Израилийн эзгүй хээр газраар хулгана мэт мөшгин мөрдсөөр байсан нь "Хор шар бол Үхэгсдийн орон мэт хатуу ширүүн" /Соломоны Дуун. 8:6/ гэсэн үгсийн үнэн болохыг нотлов.

Яваандаа Давид хаан болсон ба түүний зэрлэгшсэн амьдралын хугацаанд Бурханы түүнд үзүүлсэн хайрыг үнэлэн хүндэтгэж байгаагаа харуулахын тулд Бурханд зориулж сүм барихаар шийджээ. Бурханы үүнд хариу болгож, Давидын хүү Соломон сүм барих ба Бурхан Давидад гэр бий болгох хүсэлтэй байгаа мэдэгджээ /2 Сам. 7:4-13/. Дараа нь дэлгэрэнгүй амлалт ирж тэр

70 БУРХАН

нь Абрахамд хэлсэнтэй ижил байсан бөгөөд бусад зүйлийг дэлгэрүүлэв:-

“Чиний өдрүүд дуусаж, чи эцэг өвгөдийнхөө хамт нойрсох үед Би чамаас гарах үрийг чинь чиний дараа босгож, түүний хаанчлалыг тогтооно. Тэр Миний нэрийн төлөө өргөө босгож, Би түүний хаанчлалын суудлыг мөнхөд тогтооно. Би түүний эцэг болж, тэр Миний хөвгүүн болно. Тэр гэм бурууг үйлдвэл, Би хүний таяг, хүний хөвгүүний ташуураар түүнийг засан хүмүүжүүлнэ. Гэвч чиний өмнөөс Миний зайлуулж өгсөн Саулаас Би хайр энэрэлээ авсаны адил Миний хайр энэрэл түүнээс салахгүй. Чиний гэр болон чиний хаанчлал Миний өмнө мөнхөд үргэлжилж, чиний хаан ширээ мөнхөд тогтоно гэв” /1 Сам. 7:12-16/.

Түрүүчийн манай хичээлүүдээс “үр”ийг Есүс гэж бид бодох байх. Түүнийг Бурханы хүү /2 Сам. 7:14/ хэмээн дүрсэлсэн нь үүнийг нотолж байгаа ба Библийн бусад хэсэгт ч байгаа бусад ишлэлүүд бас нотлоно:-

-“Би бол Давидын ...үндэс” гэж Есүс хэлэв /Илчлэлт 22:16/.

-“ тэр нь /Есүс/ махан биеэр Давидын үр удмаас төрсөн” /Ром. 1:3/

-“Бурхан амласаныхаа дагуу чухамхүү энэ хүний удмаас Аврагч Есүсийг Израильд авчирсан” /Үйлс 13:23/

-Авралын элч онгон Марид хүү Есүсынх нь тухай ийнхүү хэлжээ:
“Тэр Хүү агуу Нэгэн болох ба Хамгийн Дээдийн Хүү гэж дуудагдана. Эзэн Бурхан Түүнд өвөг Давидынх нь хаан ширээг өгөх болно....Түүний хаанчлалд төгсгөл байхгүй /Лук 1:32,33/. Энэ нь 2 Сам. 7:13-д дурьсан, Давидын үр Есүст өгсөн амлалтанд хамаарч байна.

Үрийг Есүс хэмээн нэгэнт тогтсон тул хэд хэдэн дэлгэрэнгүй зүйл чухал болж байна:-

-1/ Үр

“Чиний үр....чмнмй хэвлийнээс гарч...Би түүний эцэг болно, тэр миний хүү болно.” “Чиний биеийн үр жимснээс Би чиний сэнтийнд зална /2 Сам. 7:12,14, Дуулал 132:10,12/. Үр болох Есүс нь шууд

утгаараа Давидын биет ур удам байх ёстой ба гэсэн ч Бурхан түүний Эцэг байх ёстой байлаа. Үүнд Шинэ Гэрээнд дүрсэлснээр зөвхөн онгон төрөлтөөр хүрч болох байсан. Есүсын эх нь Давидын үр удам болох Мари байв /Лук 1:32/, гэхдээ түүнд хүн эцэг байгаагүй. Бурхан Мари Есүсыг олохын тулд Бурхан Марийн умайд Ариун Сүнсний ид шидээр үйлчилсэн бөгөөд үүнд Тэнгэр Элч “Тиймээс төрөх ариун нэгэн нь Бурханы Хүү гэж дуудагдах болно” гэж хэлжээ/Лук 1:35/. Давидад өгсөн амлалтыг гагцхүү “онгон төрөлт”өөр хэрэгжүүлэхээс өөр аргагүй байлаа.

-2/ Өргөө

“Тэр миний нэрийн төлөө өргөө босгоно” /2 Сам. 7-13/ гэсэн нь шууд утгаар ч, ариун сүнсний утгаар ч Есүс Бурханд зориулж сүм барина гэдгийг харуулж байна. Хэрхэн Мянганд /Есүс дэлхийд эргэж ирсний дараах Бурханы Хаанчлалын эхний 1000 жил/ нэгэн сүм Иерусалимд баригдахыг Езекиел 40-48-д өгүүлдэг. Бурханы “Өргөө” гэдэг нь Түүний дуртайя амьдрах газар бөгөөд Исаиа 66:1,2 –т Бурхан өөрийнх нь үгэд дуулгавартай хүмүүс дунд амьдрахаар ирнэ гэсэн байдаг. Тиймээс Есүс Бурханы амьдрах, жинхэнэ итгэгчидээс бүрдсэн ариун сүм босгож байгаа юм. Есүсыг Бурханы сүмийн ба Христичидын суурь чулуу /1 Петр 2:4-8/ гэж дүрсэлсэн ба одоо сүмийн чулуунууд байрандаа ороод байгаа билээ.

-3/ Хаан Ширээ

“Би түүний /Хрисийн/ хаанчлалын суудлыг мөнхөд тогтооно... “Чиний /Давидын/ гэр болон чиний хаанчлал Миний өмнө мөнхөд үргэлжилж, чиний хаан ширээ мөнхөд тогтоно” /2 Сам. 7:13,16, Иас. 9:6,7/. Иймээс Христийн хаанчлал Израил дахь Давтдын хаанчлалд суурилагдана. Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл Бурханы ирж буй хаанчлал Израилын хаанчлалыг дахин тогтооно гэсэн үг. Энэ талаар илүү ихийг Хичээл 5.3-аас үз. Энэхүү амлалтыг биелүүлэхийн тулд Христ Давидын “хаан ширээн”-д буюу засаглалын газарт залрах ёстой юм. Энэ нь шууд утгаар Иерусалим байлаа. Энэ нь, эдгээр амлалтуудыг биелүүлэхийн тулд хаанчлал энэ дэлхийд тогтох ёстойг нотолж байгаа өөр нэг нотолгоо юм.

72 БУРХАН

-4/ Хаанчлал

“Чиний гэр болон чиний хаанчлал Миний өмнө мөнхөд үргэлжилж, чиний хаан ширээ мөнхөд тогтоно” /2 Сам. 7:16/ гэдэг нь Давид Христийн мөнхийн хаанчлал тогтохыг харна гэсэн үг юм. Тэгэхээр энэ нь, хаанчлалыг дэлхий дахинд тогтож Есүс Иерусалимаас захиран суухыг Давидад өөрийн нүдээр харах боломж олгохын тулд Христийг эргэж ирэхэд түүнийг дахин амилуулана гэсэн шууд бус амлалт байлаа.

Давидад амалсан эдгээр зүйлсийг ойлгох нь зайлшгүй чухал. Давид эдгээр зүйлийн талаар баяртай ярьж “...үүрд мөнхийн гэрээ...энэ бол миний хамаг аврал, хамаг хүсэл” /2 Сам. 23:5/ гэжээ. Эдгээр зүйл манай авралд ч бас холбогдоно. Тэдгээрт баярлах нь мөн л бидний хүсэл билээ. Ингэхээр эдгээр номлол чухал гэдгийг дахин харуулж байна. Христосын ертөнц дараах гайхамшигт үнэнтэй шууд зөрчилдөж байгаа нь эмэгнэл юм. Үүнд:-

- Хэрвээ Есүс махь бодийн хувьд бодитоор “урьдчилан оршиж” байсан бол, өөрөөр хэлбэл тэр төрөхөөсөө өмнө оршиж байсан бол Есүс Давидын “үр” буюу үр удам болно гэсэн эдгээр амлалтуудыг утгагүй болгож байна.

- Хэрвээ Бурханы хаанчлал тэнгэрт байх юм бол Есүс Давидын Израил дахь хаанчлалыг дахин тогтоож чадахгүй ба Давидын “хаан ширээ” буюу засаглалын газарт ч захиран сууж чадахгүй юм. Эдгээр зүйл шууд утгаараа газар дэлхийд байсан учраас тэднийг дахин байгуулах нь тэр л газартаа болох ёстой.

БИЕЛҮҮЛЭХ НЬ СОЛОМОН УУ?

Давидын биет /бодит/ хүү Соломон Давидад амалсан амлалтуудын зарим хэсгийг биелүүлжээ. Тэрээр шууд утгаар Бурханд зориулж сүм босгосон /Хаадын Дээд 10/ ба тэрээр ихэд цэцэглэсэн хаант улстай байлаа. Дэлхий дахины улс үнтэстэнүүд Соломонд хүндэтгэл үзүүлэхээр төлөөлөгчидөө илгээдэг байсан ба энэ сүмийг хэрэглэснээр агуу их ариун ивээл ирж байв. Тиймээс Соломоны хаанчлал нь Давидад өгсөн амлалтууд улам ихээр биелэгдэхийг зааж байгаа бөгөөд тэр нь Христийн хаанчлалд харагдах юм.

Давидад өгсөн амлалтуудыг Соломон бүрэн биелүүлсэн гэж зарим нь үздэг. Гэтэл үүнийг дараах зүйл няцааж байна:--

- Шинэ Гэрээний баялаг баримтууд “үр”ийг Соломон биш Христ гэж гэрчилсэн байдаг.
- Давид өөрт нь Бурханы хийсэн амлалтуудыг Абрахамд хийсэн амлалтуудтай холбосон бололтой байдаг /Шастирын дээд 17:27 = Эхлэл 22:17,18/.
- “Үр”ийн хаанчлал үүрд мөнх орших ёстой – Соломоных бол үгүй.
- Амлалтууд мөнхийн амьдралтай холбоотой ба энэ нь түүний одоогынх нь гэр бүлд хамаарахгүй гэдгийг Давид хүлээн зөвшөөрсөн. “...Үүрд мөнхийн гэрээг Тэр надтай байгуулсан учир миний гэр Бурханы хувьд ч төн ийм бус гэж үү” /2 Сам. 23:5/.
- Давидын үр бол нүгэлээс аврах Аврал /Иса. 9:6,7, 22:22, Иер. 33:5,6,15, Иохон 7:42/. Гэвч хожим нь Соломон Израилын найдвараас гадуурх хүмүүстэй гэрэлснээр Бурханаас буруулсан юм /Хаадын дээд 11:1-13, Иех. 13:26/.

ХИЧЭЭЛ 3: Асуултууд

1. Бурханы ямар амлалтууд нь нүгэл ба зөв шудрагын хоорондын байнгын тэмцлийг урьдчлан хэлдэг вэ?
а/ Ноад өгсөн амлалт
б/ Еденд хийсэн амлалт
в/ Давидад өгсөн амлалт
г/ Абрахамд өгсөн амлалт
2. Еденд хийсэн амлалттай холбоотойгоор дараах мэдэгдлийн аль нь үнэн бэ?
а/ Хорт могойн үр бол Лусифер
б/ Христ ба зөв шудрага бол эмэгтэй хүний үр.
в/ Хорт могойн үрийг Христ түр зуур шархдуулсан
г/ Эмэгтэй хүний үр Христийн үхлээр гэмтсэн
3. Абрахамын үр хаана үүр мөнх амьдрах вэ?
а/ Тэнгэрт
б/ Иерусалимд
в/ Газар дэлхийд
г/ Зарим нь Тэнгэрт зарим нь газарт
4. Дараачын алыг нь Давидад амалсан бэ?
а/ Түүний агуу их үр удам үүрд мөнх хаанчлан сууна.
б/ Түүний 'үр' Тэнгэрт Хаанчлалтай байна.
в/ Үр нь Бурханы хүү болно.
г/ Түүний үр Есүс газарт төрөхийн өмнө Тэнгэрт амьдрах болно.

4.1 Хүний төрөлхийн шинж

Хүн төрөлхтөний ихэнх нь үхлийн тухай юмуу үхлийн үндсэн шалтгаан болох өөрсдийн төрөлх шинжийн талаар нэг их боддоггүй байна. Өөрийгөө иншгэ шинжлэн дүгнэдэггүй нь өөрийгөө ухаарах сөхөө өгдөггүй учраас хүн өөрсдийн төрөлх шинжээс гарсан хүслээр шийдвэрээ гаргадаг. Амьдрал маш богинохон бөгөөд төгсгөл болох үхэл бидэн дээр эцэст нь ирнэ гэдэг тун нууцлагдмал байдаг амьдралын баримтыг хүлээн зөвшөөрөхөйг татгалзсан сэтгэл дотор нь байдаг. “Амьдрал тань юунд зориулагдах юм бэ?? Та нар хэсэг зуур үзэгдээд дараа нь алга болох уур манан шүү дээ Бид үхэх нь гарцаагүй бөгөөд газарт асгагдаад, дахин цуглуулж үл чадах устай адил юм. Өглөө тэд шинэр соёолон буй өвс мэт байдаг. Өглөө нь тэр нь цэцэглэж шинээр соёолдог. Үдэш дөхөхөд тэр нь хагдран хатдаг.” /Иаков4 :14; 2 Самуел14:14; Дуулал 90:5.6/

Үнэнхүү бодлоготой хүн болох Мосе үүнийг хүлээн зөвшөөрсөн ба Бурханаас “Бид таньд мэргэн зүрхийг өргөхийн тулд өөрсдийнхөө өдрүүдийг тоолохыг бидэнд зааж өгөөч”/Эхлэл 2:17/ гэж гуйжээ. Тиймээс амьдралын богино болохыг харгалзан бид жинхэнэ мэргэн ухаан эзэмшихийг эн тэргүүний зорилт болгох хэрэгтэй.

Үхлээр төгсөх асуудалд хүн янз бүрээр ханддаг. Зарим үндэстэн гарз, төгсгөлийн мэдрэмжийг багасгах зорилгоор үхэл ба оршуулгат амьдралын хэсэг болох гэж оролджээ. “Христич” хэмээх нэр зүүгчдийн ихэнх нь дараа нь ямар нэг газар уруу шагнал юмуу шийтгэл хүлээхээр явж үхлийг даван гарах “мөхөшгүй сүнстэй” буюу өөртөө мөхөшгүйн зарим шинжийг агуулдаг гэсэн дүгнэлт хийжээ. Үхэл хүний амьдралын гол үндсэн асуудал, эмгэнэл болохын учир хүний ухаан, оюун санааны нөлөөгөө бууруулах чиглэлээр ажиллаж ирсэн гэж үзэж болох юм. Тиймээс үхэл ба хүний төрөлх шинжийн талаар худал онолууд олноор гарчээ. Энэ чухал сэдвийн талаар жинхэнэ үнэнийг олохын тулд тэдгээрийг ямагт Библиетэй харьцуулан шалгаж байх ёстой юм. Библид тэмдэглэгдсэн анхны худал зүйл бол Едены цэцэрлэг дэх хорт могой гэдгийг санах хэрэгтэй. Хүн нүгэл үйлдсэн бол “үхэх нь зүйтэй” /Эхлэл 2:12/ гэсэн Бурханы ердийн мэдэгдлийн эсрэг “Чи үхэхгүй.” гэж хорт могой хэлдэг. /Эхлэл 3:4/ Хүний төгсгөл ба үхлийг ор тас үгүйсгэх оролдлого нь бүх худал шашны шинж чанар болсон юм. Энэ салбарт ялангуяа

76 БУРХАН

нэг худал номлолоос нөгөө нэг худал номлол гарах түүнээс өөр нэг худал номлол гарах гэх мэтчилэн цуван гарах нь илт. үүнчлэн нэг үнэнээс өөр нэг үнэн гардгийг 1Кор 15:13-17-д өгүүлсэн байдаг. Үүнд Паул нэг үнэнээс нөгөө үнэн үрүү орсон байдаг юм. /"Хэрвээ...хэрвээ...хэрвээ..." гэдгийг анхаарах./

Өөрсдийнхөө үнэн шинж чанарыг ойлгохын тулд хүнийг бүтээсэн талаар Библид юу гэснийг бид авч үзэх хэрэгтэй. Бичигдэж хоцрогдсон зүйлийг энгийн хэлээр өгүүлсэн байх ба үүнийг шууд утгаар авч үзвэл бид шинж чанараараа яг юу болох талаар ямар ч эргэлзээ байхгүй болно. /Эхлэлийн жинхэнэ утгын талаар **Гажилт** (Digression)18-г үз/ "Эзэн бурхан тоос шорооноос хүнийг бүтээж..чамайг /Адамыг/ газар шорооноос авсан. Чи тоос шороо тул тоос шороондоо буцаж очих болно" /Эхлэл 2:7, 3:19./ Хүн төрөлхөөсөө мөнх байх ямар ч тэмдэг энд байхгүй бөгөөд үхлийн дараа түүнээс юу ч эс амьдарна.

Хүн бүр үндсээрээ хумхын тоосноос бүрдсэн гэсэн баримтыг библид тэмдэглэсэн байдаг. "Бид шавар" /Иса 64:8/ "Хүн нь газрын хөрснөөс юм" /1 Кор15:47/ "Үндэс суурь нь шороонд байдаг" /Иов 4:19/ "Хүн шороонд буцах байсан."/Иов 34:14,15/ "Тоос шороо мэт өчүүхэн амьтан."/Эхлэл 18:27/ . Бурханы зарлигийг Еденд үл дагасан тэр даруйд бурхан "хүнийг хөөж гаргаад...тэр одоо гараа сунган бас алимны модны жимснээс авч идээд мөнх наслах вий" /Эхлэл 3:24, 22/ Хүн дотор угаасаа үүрд мөнхийн шинж байсан бол ингэх хэрэгцээгүй байх байсан юм.

Болзмол Мөнх Амь

Хүн Христийнбүтээлээр дамжуулж мөнхийн амьдрал ба мөнх амь олж авах замыг олж болох юм гэж Сайн Мэдээ үргэлжид давтан өгүүлдэг. Энэ нь Библийн ярьж буй ганц төрлийн мөнх амь учраас буруу зүйл хийсний төлөө ухамсартай зовох нь үүрд мөнх байна гэсэн санааг Библийн зүгээс дэмждэггүй. Мөнхийн амийг олох ганц зам бол Бурханы сургаалыг дагах явдал юм. дуулгаавартай дагагч нар мөнхийн байдлыг төгс төгөлдөр нөхцөлд өнгөрөөх болно. Энэ нь зөв зүйл хийсний шагнал юм. Энэ мөнхийн амь нь бидний аяндаа эзэмшиж авдаг зүйл биш бөгөөд тусгай нөхцөлтэй гэдгийн нотолгоо нь дараах өгүүлбэрүүд байх ёстой юм:-

-**"Христ...амь ба үхэшгүй байдлыг сайн мэдээгээр дамжуулан гэрэлд анивчсан."** /2Тим1:10,1Иох1:2/

-“мөнх амь” Иох 6:53, 54. Иоханын бүлэг 6-д бүхэлд нь Христ өөрийгөө “амьдралын талх” ба түүнд зөв хандаж байж л мөнх амь аливаа найдвар байж болох юм. /Иох 6:47, 50, 51, 57, 58/

-“Бурхан бидэнд мөнх амийг өгсөн бөгөөд энэхүү амь нь түүний Хүүгийн дотор байна.” /1 Иох 5:11/ “Христ” дотор байдаггүй хүмүүст мөнх амь байх найдвар байж болохгүй. Зөвхөн Христээр дамжуулж л мөнх амь боломжтой болов. Тэрээр “мөнхийн амийн зохиолч” /Үйлс 3:15 A.V mg/ -“Өөрт нь дуулгавартай бүх хүмүүст мөнх авралын үндэс нь болсон” /Еврей 5:9/ Тиймээс хүнд мөнх амь байх нь Христийн бүтээлээр дамжуулж үүсчээ.

- жинхэнэ итгэгч мөнх амийг эрэлхийлдэг ба үүнийхээ төлөө өөрөө төрөлхөөсөө эзэмшдэггүй мөнхийн амьдралын бэлгээр шагнагдах болно./Ром 2:7, 6:23, Иох10:28 /. Бидний мөнхийн бус бие Христийг эргэж ирэхэд “үхэшгүйг өмсөн ёстой” /1 Кор15:53/ . Иймээс үхэшгүй мөнх нь одоо эзэмшиж байгаа зүйл биш амлаж байгаа зүйл юм. /Иох 2:25/

- гагцхүү бурхан л залгамжлагдах үхэшгүй мөнхийг эзэмшдэг. /1Тим 6:16/

4.2 Сэтгэл

Дээр дурдснаас үзэхэд хүнд төрөлхөөс нь “үхэшгүй мөнх сэтгэл” буюу өөр аливаа мөнх шинж байх нь байж болшгүй зүйл юм. одоо бид “Сэтгэл” хэмээх үгийг тойрсон төөрөлдөөнтэй зүйлийг тодотгохыг оролдоё. Библид “Сэтгэл” хэмээн орчуулагдсан Еврей ба Грек үгүүд /”Нефеш” ба “Псүше”/ дараах маягаар орчуулагдаж байна.

Бие	Амьсгаа
Амьтан .	Зүрх

78 БУРХАН

Оюун ухаан

Хүн

Өөрөө

“Сэтгэл” нь тиймээс хүн, бие буюу өөрт хамаарах аж. Алдартай “Бидний Сэтгэлийг Авар” /SOS/ хэмээх дохио нь “Биднийг үхлээс авар” гэсэн үг нь тодорхой. Тиймээс “Сэтгэл” нь “та” буюу хүнийг бүрдүүлэгч бүх зүйлсийн товчлол юм. Библийн орчин үеийн хувилбаруудад /жишээлбэл NIV буюу олон улсын шинэ хувилбар/ (цаашид ОУШХ) ‘Сэтгэл’ гэдгийг ховор хэрэглэх ба оронд нь ‘та’ буюу ‘хүн’ гэдэг үгс хэрэглэдэг. Бурханы бүтээсэн амьдатыг “хөлхөн хөдлөгч аливаа амьдат” (Эхлэл 1:20, 21) гэж нэрлэгдэнэ. ‘Амьтан’ хэмээн орчуулагдсан Еврей үг энд ‘нефеш’ гэх ба энэ нь бас ‘Сэтгэл’ гэж орчуулагджээ. Жишээ нь Эхлэлийн 2:7-д “...хүн амьд оршигч сэтгэл” гэжээ. Тэгэхээр хүн ч, амьтан ч “Сэтгэл” ажээ. Хүн амьтан хоёрын ялгаа нь хүн амьтнаас ухааны хувьд давуу юм. Хүн бол Бурханы бие махбодийн дүр төрх болон бүтээгдсэн (Эхлэл 1:26, Хичээл 1,2-г үз.) Зарим хүн Сайн Мэдээг мэдэх ёстойгоор заяагдсан тэдэнд үхэшгүй мөнх нээгджээ (2 Тим. 1:10). Үндсэн шинж чанар ба бидний үхлийн шинж чанарын хувьд хүн амьтан хоёрын хувьд ялгаа байхгүй юм:-

“Хүний хөвгүүдийн хувь тавилан адгуусны хувь тавилантай адил бөгөөд нэг нь үхдгийн адил нөгөөдөх нь ч бас үхэх аж...Хүнд адгууснаас дээрдээд байх юм алга...Бүгд л /хүн ба амьдат нэг л газар уруу явцгаана.Бүгд л шорооноос гарсан тэгээд бүгд шороондоо буцна.” (Номлогчийн үгс 3:19, 20). Экклесиастийн “Хүн гэгч өөрсдөө адгуус юм гэдгээ танихуйц.”/ Номлогчийн үгс 3:18/ гэсэн баримтыг хүнийг мэдэхэд нь Бурхан туслаасай гэж Экклесиастийн онгод орсон зохиолч мөргөжээ. Иймээс ийм баримтыг олон хүн хүлээж авахад хэцүү байх нь ээ. Нээрээ ч бид өөрсдийгөө хадгалах төрөлхийн авьяастай, хамгийн хатуужилтай нь амь зуух, үр төлөө өгөх зэрэг төрөлхийн шинж чанараараа амьтан гэдгээ хүлээн зөвшөөрөхөд гутамшигтай байж болох юм. ОУШХ дахь Номлогчийн үгс 3:18-н орчуулганд, Бурхан хүнийг ердөө л амьтан гэдгийг харуулж “шалгадаг” гэжээ. Өөрөөр хэлбэл Түүний жинхэнэ хүмүүс болж чадсан даруухан хүмүүс үүний үнэнийг ойлгох ба харин тийм биш нь энэ “шалгалтыг” давахгүй. Хүмүүнлэгийн онол буюу хүн бол дээд зэргийн чухал, үнэ цэнэтэй юм гэсэн санаа, хорьдугаар зууны явцад чимээгүйхэн дэлгэрсэн юм. Хүмүүнлэгийн нөлөөний талаархи бодлоо бид тодотгох нь том зорилт юм. Дуулал 39:5-н энгийн үгс болох “...Хүн бүр өөрийн

хамгийн сайн үедээ зүгээр л нэг амьсгал юм.”өөрийн алхамаа чиглүүлэхээр алхадаг хүнд ч байдаггүй” (Иеремиа 10:23).

Бидний мэддэг хамгийн гол зүйлсийн нэг бол бүх хүн , түүнчлэн бүх “амьтай амьтан” яваандаа үхнэ гэдэг явдал юм. Тиймээс ‘Сэтгэл’ үхдэг. Энэ нв үхэхгүй мөнхийн яг эсрэг зүйл юм. Библид орчуулагдаж орсон ‘сэтгэл’ хэмээх үгийн орчуулагуудын бүх хэрэглээний гуравны нэг орчим нь үхэл ба сэтгэл устахтай холбоотой байгаа нь гайхалтай биш юм. ‘Сэтгэл ’ гэдэг үгийг ийм замаар хэрэглэж байгаа баримт нь энэ нь устахгүй, үхэшгүй мөнх зүйл биш байж болохгүй гэдгийг харуулж байна.

- “Нүглийг үйлдэгч сэтгэл нь үхэх болно.”(Езе. 18:4)
- “Бурхан сэтгэлийг устгаж чадна” (Мат.10:28) Сэтгэл устгагдаж байгаа дурдагдсан бусад зүйлс: Езе.22:27, Сургаалт үгс 6:32, Лев.23:30.
- Хазор хот дотор байсан бүх “сэтгэлийг ” сэлмээр хөнөөв. /Иош.11:11, Иош.10:30-39/
- “Амьд юм бүхэн үхэв.” (Илчлэлт 16:3, Дуулал 78:50)
- Тодорхой хуулийг үл дагасан аливаа ‘сэтгэл’ –ийг алахыг Мосегийн хуулинд ихэвчлэн заадаг байв. (Жишээ нь Тооллого 15:17-31)
- Сэтгэлийг боомилон гэх буюу урхидав гэж байвал түүнийг сэтгэл үхэж болно гэж ойлговол утга учиртай болно.(Сургаалт үгс 18:7, 22:25, Иов 7:15).
- “Өөрсдийн сэтгэлийг амьд хадгалж чаддаггүй.”/Дуулал 22:29/
- “Өөрийн амийг үхэл уруу асгаж...” /Иса.53:10,12/

“Сэтгэл” гэдэг нь бидэн доторхи үхэшгүй мөнхийн гэрэл биш харин хүн буюу биенд холбогдоно гэдгийг энэ үг гардаг шүлгүүдийн ихэнх нь харуулдаг. Зарим илэрхий жишээнүүд нь:

-“Амин цус” /Иер.2:34/.

80 БУРХАН

-“Хэрэв гэрчил гэсэн шаардлагыг сонссон атлаа хэлэлгүй нүгэл үйлдвэл...хэрэв тэр үүнийгээ мэдээгүй байсан...хэрэв амаараа бодлогогүйгээр тангараглавал ” /Левит 5:1-4/

- “Өө Сэтгэл минь ээ...дотор нь байгаа бүхэн ч...Эзэнийг магтаж, Сэтгэл минь ээ...чиний хүслийг сайн зүйлсээр хангана.” /Дуулал 103:1,2,5/

- “Хэн өөрийн амийг аврахыг хүснэ тэр хүн түүнийг алдана. Харин хэн Миний төлөө, Сайн мэдээний төлөө өөрийн амийг алдана тэр хүн түүнийг аврана” /Марк 8:35/

Энэ нь сэтгэлийг хүн доторхи аливаа сүнслэг шинжтэй холбоогүй гэдгийг нотолж байна; энд ‘сэтгэл’/Грекээр ‘псуше’/ гэдэгт нь орчуулагдсанаар зөвхөн хэн нэгний бие махбодийн амьдралыг ойлгох юм.

- Тооллого 21:4-т үзүүлснээр бүлэг хүмүүс нэг ‘сэтгэл’-тэй байж болох юм. ‘Сэтгэл’ нь тэгэхээр бидний хүн тус бүр доторхи хувийн үхэшгүй байдлын илэрхийлэл юм.

4.3 Хүний сүнс

Ихэнх хүмүүсийн оюун ухаанд сүнс ба сэтгэл хоёрыг ялгахад төвөгтэй байдаг. Үүнийг зарим хэл болон Библийн орчуулганд ‘сүнс’ ба ‘сэтгэл’ гэсэн англи үгс нь зөвхөн ганц тэнцэх үгтэй байдаг нь улам дордуулж байна. Хүний бүх бүрэлдэхүүн хэсэгтэй холбоотой ‘сэтгэл’ нь заримдаа сүнстэй ч холбогдож болох юм. Гэвч Библид “сэтгэл” ба “сүнс” хэрэглэгдэхдээ утга санааны хувьд ялгаатай. Сэтгэл ба сүнс “салтал нэвтрэн ордог”(Еврей 4:12)

“Сүнс” хэмээх Еврей ба Грек үгнүүд нь (‘Руач’ ‘Пнема’) дараах замаар орчуулагдана:-

Амьдрал Сүнс

Оюун ухаан Салхи

Амьсгал

Бид “сүнс”-ний санааг Хичээл 2.1-д үзсэн. Бурхан Өөрийн Сүнсээ хүн хийгээд байгалийн бүтээлээ хадгалахын тулд хэрэглэдэг. Хүний доторхи Бурханы сүнс тэгэхээр түүний доторхи амьдралын хүч юм. “Сүнсгүй бие үхмэл байдаг” /Иаков 2:26/ “Эзэн Бурхан амин амьсгалыг /Адамын хамраар нь / үлээж оруулахад хүн амьд /оршигч/болов.” (Эхлэл 2:7). Иов “Бурханы Сүнсийг ” “миний хамар дотор” байгаа гэж ярьдаг. (Иов 27:3, Исаиа2:22) .

Тиймээс бидэн дотор байгаа амьдралын сүнсийг төрөхөд өгсөн бөгөөд бидний бие амьд байх хугацаанд тэндээ байх юм. Бурханы сүнс ямар ч зүйлээс гарахад тэр дороо алга болдог-Сүнс бол амьдралын хүч юм. Хэрвээ Бурхан “...өөр уруугаа Өөрийн сүнс, Өөрийн амьсгалыг цуглуулсан бөгөөд хэрэв ийм үйлдэхээр шийдсэн бол бүх бие махбодь хамтдаа үхэж хүн шороонд буцах байсан.Харин ухаан байвал үүнийг сонс...” (Иов 34:14-16) Хүн өөрийнхөө жинхэнэ шинж чанарыг ийнхүү нээгдэж байгаатай эвлэрэхэд маш хэцүү гэдгийг сүүлчийн өгүүлбэр харуулж байна.

Биднийг үхэхэд Бурхан Өөрийн сүнсээ авахаар зөвхөн бидний бие үхээд зогсохгүй бидний ухаан санаа бүхлээрээ оршин тогтнохоо болино. Давид үүнийг сайшаасан нь түүнийг хүн шиг сул дорой амьтанаас илүү Бурханд итгэх итгэл рүү хөтлөсөн юм. Дуулал 146:3-5 нь хүмүүнлэгийн тухай яриануудаас эсрэг юм: “Ноёдод бүү итгэ. Авралгүй хүний үгэнд ч бүү итгэ. Түүний сүнс гарч явдаг бөгөөд тэрээр газар шороо руу буцдаг. (Бидний бүтээсэн газар шороо).Яг тэр өдөр түүний бодлууд мөхдөг. Иаковын Бурханыг өөрийн тусламж болгосон хүн юутай ерөөлтөй вэ”.

Үхэхэд “тоос нь урьд байсан газар шороондоо буцаж, сүнс нь түүнийг өгсөн Бурхандаа буцах ажгуу” (Номлогчийн үгс 12:7). Бурхан өөрийн сүнсээр дамжуулж газар сайгүй байдаг гэдгийг бид түрүүнд тайлбарласан. Энэ утгаар “Бурхан бол сүнс” (Иохан 4:24). Бид үхэхээр бидний доторхи Бурханы сүнс биднээс явдаг учир бид “сүүлчийнхээ амьсгалыг амьсгалдаг”. Тэрхүү сүнс бидний эргэн тойрон байгаа Бурханы сүнс уруу шингэдэг. Тиймээс үхэхээр “сүнс Бурхан уруу эргэн очино”.

82 БУРХАН

Бурханы сүнс бүх бүтээн бий болгогсодоос Бурханы сүнс үлддэг учир бүх амьтадад мөн адил үхлийн явц болно. Хүн ба амьтад өөрсдийн дотроо ижил сүнстэй буюу амьдралын хүчтэй байдаг. “Хүний хувь тавилан адгуусны хувь тавилантай адил бөгөөд нэг нь үхдгийн адил нөгөөдөх нь ч бас үхэх аж. Үнэндээ аль аль нь л ижилхэн амьсгалтай байх бөлгөө. Хүнд адгууснаас дээрдээд байх юм алга.” (Номлогчийн үгс 3:19) Хүн ба амьтаны сүнс хаашаа явдагт тодорхой ялгаа байхгүй гэдгийг зохиогч цааш нь хэлж байна. (Номлогчийн үгс 3:21). Хүн ба амьтан адил сүнстэй байж ба адилхан үхлээр үхдгийг ийнхүү дүрсэлсэн нь Бурханаас сүнс авдаг хүн ба амьтаны аль аль нь цусан дээрээ адилхан үхлээр устгагдагийг дахин харуулж байна /Эхлэл 2:7, 7:15: “Газар дэлхий дээрх хөдлөгч хамаг амьтан, жигүүртэн шувууд, мал адгуус, ан араатан, газраар мөлхөгч бүхэн хийгээд бүх хүн төрөлхтөн: хамартай амин сүнсний амьсгаатай бүхэн үхэж...газар дээрх хамаг амьтан

газрын хөрснөөс нь арчигджээ” (Эхлэл 7:21-23) Дашрамд Дуулал 90:5-д үхлийг цустай адилтгаж байгааг анзаар. Хүн бол “бүх мах цус...бүх амьд зүйлс”-тэй нэг зэрэглэлд байдгийг Эхлэл 7-н бичээс тодорхой харуулж байна. Энэ нь хүн тэдгээртэй адилхан амьдралын сүнстэй учраас тэр юм.

4.4 Үхэл бол ухамсаргүй

Одоог хүртэл сэтгэл ба сүнсний талаар бидний мэдэж авсан зүйлээс үзэхэд үхсэн хүн бүрэн ухамсаргүй болдог гэж үзэж болно. Бурханд хариуцлага хүлээсэн хүмүүсийн үйл ажиллагааг Тэрээр санахын сацуу (Малай 3:16, Илчлэлт 20:12, Еврей 6:10) биднийг үхэх байдалд орсон үедээ ухамсартай байдаг гэсэн зүйл Библид алга байна. Үүнтэй холбогдуулан дараах тодорхой мэдэгдэлүүдтэй маргахад амар биш юм:-

-“Түүний /хүний/ сүнс гарч явдаг бөгөөд тэр өдрөө /цаг мөчид/ тэрээр газар шороо уруу буцдаг.”(Дуулал 146:4)

-“Үхдэлүүд юу ч мэддэггүй...тэдний хайр хорсол атаа, жетөө хэдийнээ мөхжээ” (Номлогчийн үгс 9:5,6)
“Үхэгсэдийн оронд мэргэн ухаан” байхгүй (Номлогчийн

үгс 9:10)-бодох санах ч юм байхгүй учир ухамсар байхгүй.

- Үхлийн талаар Иов хэлэхдээ “ерөөсөө байгаагүй юм шиг” (Иов 10:18) болно гэжээ. Тэрээр үхлийг бидэнд төрөхөөс өмнө байсан шиг ямар ч мэдрэх юм, ухамсар орших ёсон огт байхгүй зүйл гэжээ.

- “Хүн адгуус амьтадын адил үхдэг” (Номлогчийн үгс 3:18). Хэрвээ хүн хаа нэг газар үхлийг даван гардаг бол тэд тэгэх л ёстой. Гэвч Судар болон шинжлэх ухаанд энэ тухай өгүүлсэн зүйл алга.

- Бурхан “бид бол тоос шороо юм гэдгийг санаж байдаг. Хүний хувьд гэвэл түүний өдрүүд өвс ногоо шиг байдаг. Хээрийн цэцэг шиг өсөн хөгждөг... Тэр үгүй болдог. Түүний газар нь ч түүнийг таньдаггүй” (Дуулал 103:14-16).

Үхэл бол зөв сайн хүний хувьд хүртэл үнэхээр ухамсаргүй зүйл гэдэг нь Бурханы зарц нар амьдралаа уртсгахыг дахин дахин гуйдагаар харагдаж байна. Яагаад гэвэл тэд үхэл бол ухамсаргүйн байдалд ордог гэдгийг ойлгож үхсэний дараа Бурханыг магтан алдаршуулж чадахгүй юм гэдгээ мэдсэн байна. Хезекиа (Иса. 38:17-19) ба Давид (Дуулал 6:4,5, 30:9, 39:13, 115:17) нар үүний сайхан жишээ юм. Үхлийг зөв сайн хүн, хорт муу хүн аль алинд нь нойрсох буюу амрах хэмээн удаа дараа тодорхойлжээ.(Иов 3:11,13,17, Дан.12:13)

Зөв сайн нь үхснийхээ дараа шууд диваажингийн жаргалд очиж шалгуулна гэсэн алдартай ойлголт Библид огт байхгүй гэж бид шууд хэлэх хангалттай баримттай танилцлаа. Үхэл ба хүний шинж чанарын тухай номлол энх амгалангийн талаар их ухагдахууныг өгч байна.Хүний олон нугачааг зовлон зүдгүүрт амьдралынхаа дараа ор тас мэдэрхүйгүй газар бол булш юм. Бурханы шаардлагуудыг мэдэлгүй өнгөрсөн хүмүүст үл мэдрэхүй мөнхөд оршино. Хүний амьдралын энэ эмгэнэлт үл гүйцэлдсэн амьдралын хуучин тооцоо хэзээ ч сөхөгдөхгүй. Хүний төрөлх оюун ухааны хий хоосон найдвар айдас хэрэгжихгүй ба ийм аюул занал болохгүй.

84 БУРХАН

Библийг сурахад үнэний систем илрэн гарна. Гэвч харамсалтай нь Библийг сайн анхаараагүйгээс болж хүний бодол санаанд алдааны систем бас гардаг. Хүн үхлээр дуусна гэдэгт өөрийгөө тайтгаруулах гэж ихэд хичээн оролдсоноор өөрийгөө “үхэшгүй мөнх сэтгэл”-тэй гэж итгэхэд хүргэдэг. Ийм үхэшгүй мөнх шинж хүний дотор оршдог гэж бодсон учраас энэ нь үхлийн дараа хаа нэгтэй явах ёстой гэж бодоход хүргэдэг. Тэгсэнээр үхэхэд зөв сайн хүн, хорт муу хүн хоёрын хувь тавиланд ялгаа байх ёстой гэж үзэхэд хүргэнэ. Үүнийгээ батжуулахын тулд “өнө мөнхийн сайн сэтгэлүүд” Диваажин (Тэнгэр) хэмээх газар байх ёстой, “өнө мөнхийн муу сэтгэлүүд” очих “там” хэмээх газар байх ёстой хэмээн дүгнэжээ. Библиээр бол “өнө мөнхийн сэтгэл” байхгүй гэж бид өмнө нь тайлбарласан. Түгээмэл ийм тайлбарын өөр хуурамч санаануудад одоо дүн шинжилгээ хийе.-

1. Биднийг үхэхэд “мөнхийн сэтгэл”-ийн хэлбэрээр өгсөн амьдралын маань шагнал бол түүнийг (сэтгэлийг) тодорхой газарт томилох.
2. Зөв сайн ба хорт муу хүмүүсийг үхэхэд нь хооронд нь ялгаж салгадаг.
3. Зөв сайн хүмүүс диваажинд явж шагнагдана.
4. Хүн бүхэн “мөнхийн сэтгэлтэй” юм бол хүн бүхэн нэг бол диваажин, нэг бол тамд явах ёстой.
5. Муу “сэтгэлүүд” там хэмээх газарт явж шийтгэл хүлээнэ.

Бидний дүн шинжилгээний зөвхөн үгүйсгэх зорилготой биш юм. Эдгээр зүйлсийг нарийвчлан авч үзсэнээр хүний шинж чанартай холбоотой жинхэнэ дүр зургын чухал хэсэг болсон Библийн үнэний олон элментүүдийг бид илэрхийлэх болно гэж үзэж байна.

4.5 Дахин амилах

Зөв сайнуудыг шагнах нь дахин амилахад, Христийг ирэх үед болох юм гэдгийг Библид цохон тэмдэглэж байна. (1Тес. 4:16). Хариуцлагатай үхлийн дахин амилалт нь (Хичээл 4:8-г үз.)

Христийн энэ тэргүүний хийх зүйл юм. Үүний дараа шүүлт болно. Хэрвээ “сэтгэл” үхэхдээ тэнгэр лүү явсан бол дахин амилах шаардлага байхгүй юм. Хэрвээ дахин амилалт байхгүй бол Бурханд дуулгавартай байя гэсэн бүх хүчин чармайлт утгагүй болно гэж Паул хэлжээ.(1Кор.15:32). Хэрвээ Паул үхэхдээ ‘сэтгэл’ нь тэнгэр рүү явж шагнагдана гэж үзэж байсан бол ийм тайлбар хийхгүй байх байсан болов уу?. Үүний утга санаа нь бие дахин амилах нь шагналын ганц хэлбэр мөн гэж Паул үзсэнд оршино. Одоо үнэнчээр амьдрахын урамшил нь “дахин амилахад” ирнэ гэж Христ биднийг урамшуулан найдвар төрүүлдэг. (Лук 14:14)

Библи биений хэлбэрээс өөр орших ямарваа хэлбэр байдаг тухай сургадаггүйг дахин онцлон тэмдэглэе. Энэ нь Бурханд, Христ, тэнгэр элч мөн хүмүүст хамаарна. Христ эргэн ирэхдээ “бидний дорд биеийг өөрийнхөө цог жавхланта биетэй адил болгон өөрчилнө” (Фил.3:20,21). Одоо тэрээр шууд утгаараа биеийн хэлбэртэй ба цусаар бус, Сүнсээр хүч авч байдаг учир бид ч мөн адил шагналыг хуваан эдэлнэ. Шүүлт дээр бид хэрхэн энэ амьдралдаа биеийн хэлбэрээр амьдарсныхаа төлөө шангаа хүртэнэ. (2Кор.5:10). Махан биеийн амьдралаар амьдрагсад нь одоогийн мөнх бус биетэй байх ба тэр нь дараа нь хумхын тоос болон буцаж хувирна. Тэгвэл амьдралдаа махан биеийн оюун ухааныг сүнсээр даван туулах гэж оролдогсод сүнсээр дүүрсэн биеийн хэлбэрээр “сүнснээс мөнх амийг хурааж авна.”(Галат 6:8)

Зөв сайнуудыг биеийн хэлбэрээр шагнах тухай нэлээн баримтууд бий. Нэгэнт үүнийг хүлээн зөвшөөрмөгц дахин амилах нь маш чухал болох тодорхой болно. Бидний одоогийн бие үхэхэд оршин тогтнохоо зогсоно. Хэрвээ бид мөнхийн амьдрал ба үхэшгүй мөнхийг биеийн хэлбэрээр эдлэж болдог бол бидний биеийг дахин бүтээж дараа нь Бурханы шинж чанарыг өгөх цаг иртэл үхэл гэдэг нь ухамсаргүйн байдал болох ёстой юм.

1 Коринтын 15 нь бүхэлдээ дахин амилалтыг дэлгэрэнгүй өгүүлсэн байдаг.

Түүнийг анхааралтай унших нь ямагт хэрэг болно. 1 Кор 15:35-44 хэсэгт Бурханаар бие өгүүлэхийн тулд үрийг хэрхэн суулгаж, тэр нь дараа нь газраас урган гарч ирдэгийг тайлбарладаг. Ингэхээр үхэгсэд биеэр шагнагдахын тулд босч ирэх болно. Христ булшнаасаа босч ирж мөнх бус биеэ үхэшгүй мөнхийн бие болгон хувиргасан шиг жинхэнэ итгэгч түүний шагналыг хувааж хүртэнэ.(Фил.3:21) Баптисмаар дамжуулан бид өөрсдийгөө

86 БУРХАН

Христийн үхэл ба амилалттай холбодог ба бид ч гэсэн амилалтаар нь дамжуулан Түүний хүлээж авсан шагналыг хуваалцана гэж итгэдэгээ харуулдаг.(Ром 6:3-5). Бид түүний зовлонг одоо хуваалцах замаар түүний шагналыг хуваалцаж байгаа юм. “Бид биедээ Есүсийн үхлийг үргэлж тээж явдаг. Ингэвэл Есүсийн амь мөн бидний бие дотор илэрхийлэгдэх юм.” (2Кор.4:10). “Үхэгсэдээс Есүсийг амилуулсан Нэгэний Сүнс та нарын дотор оршвоос, Өөрийн сүнсээр дамжуулан үхлийн биесд чинь амь өгнө”(Ром 8:11). Бид ийм найдвартайгаар тэр биеийг үхэшгүй мөнхийн болгосноор дамжуулан “бидний биеийн солилт”-ыг (Ром 8:23) хүлээж байна.

Жинхэнээр биеэр шагнана гэсэн энэ найдварыг Бурханы хүмүүс эрт үеэс ойлгож иржээ. Абрахам хөндлөн гулд явж үзсэн Канааны газар нутгийг мөнхөд өвдөж авна гэсэн амлалтыг хувьдаа авсан юм. (Эхлэл 13:17, Хичээл 3:4-г үз). Тэрээр энэхүү амлалтад итгэхийн тулд ирээдүйн нэгэн цагт түүний бие ямар нэг замаар сэргээгдэж үхэшгүй мөнх болно гэж итгэхээс зайлшгүй явдал болсон юм. Ингэснээр энэ нь боломжтой болно.

Иов бие нь булш дотор өтөнд идэгдэх хэдий ч шагналаа биеийн хэлбэрээр хэрхэн хүртэхийг ойлгож байгаагаа тодорхой илэрхийлсэн: “Миний хувьд гэвэл Миний золигч амьд...эцэст Тэрээр дэлхий дээр байр сууриа эзэлнэ гэлгийг би мэднэ /арьс минь устгагдсан хойно ч / би махан биеэрээ бурханыг харах болой. Түүнийг би өөрөө харах бөгөөд Түүнийг, өөр хэнийг ч биш миний нүд үзэх болно.Миний зүрх дотор үүнийг хүсэн хүлээж байна. ” (Иов 19:25-27). Исаиагийн найдвар мөн үүнтэй төстөй юм: “Миний үхсэн бие амилна.”(Иса.26:19).

Есүсийн дотны анд Лазарын үхлийн тухай өгүүлсэн зүйлд дээрхтэй маш адилхан үгс бий. Эзэн Есүс түүний сэтгэлийг тэнгэр рүү явсан гэж эгч дүү нарыг нь тайтгаруулахын оронд дахин амилах өдрийн тухай ярьжээ.”Чиний ах дахин босч ирнэ” гэжээ. Үүнд Лазарын дүү Марта даруй хариу болгож

өгүүлсэн зүйл нь эрт үеийн Хористичүүд үүнийг хэр зэрэг их сайшааж байсныг харуулдаг. “Марта түүнд Эцсийн өдрийн амилалтад тэр амилна гэдгийг би мэднэ гэв” (Иохан 11:23,24). Тэрээр Иовтой адилхан үхлийг диваажин дахь жаргалын амьдралд хүрэх үүд хаалга мэтээр ойлгоогүй бөгөөд түүний оронд дахин амилахыг “эцсийн өдөр” хэмээн хүлээн суужээ.

(Иовын “сүүлчийн өдөр”). “Эцгээс сонсож сурсан хүн бүр над уруу ирдэг...тэр хүнийг би эцсийн өдөр амилуулна.” (Иох.6:44,45) гэж Эзэн амилдаг.

4.6 Шүүлт

Шүүлтийн талаар Библид сургадаг зүйл нь нэг итгэлийн гол зарчимуудын нэг бөгөөд үүнийг баптисмын өмнө тодорхой ойлгосон байх ёстой. (Үйлс 24:25, Еврей 6:2). Сударт “шүүлтийн өдөр”-ийг удаа дараа өгүүлсэн байх бөгөөд (жишээ нь: 2 Пет.2:9, 3:7,1 Иох.4:17, Иуда 6) энэ нь Бурханы мэдлэг өгөгдсөнүүд нь шагналаа хүлээж авах цаг үе юм. Тэд бүгд “Бурханы шүүх ширээний өмнө зогсох болно”(Ром 14:10), бид амьдралынхаа төлөө биеийн хэлбэрээр хаиу шангаа хүртэхээр “Христийн шүүх суудлын өмнө гарч ирэх ёстой” (2 Кор 5:10).

Христийн хоёр дахь ирэлтийн тухай Даниел нь шүүлтийн ширээг хаан ширээний хэлбэрээр зөгнөсөн байдаг (Дан.7:9-14). Сургаалт үлгэр нь үүнийг улам дэлгэрэнгүй тусгажээ. Нэг үлгэр нь зарц боол нартаа мөнгө үлдээн явж тэрхүү мөнгийг хэрхэн юунд зарцуулсныг мэдэхээр дуудаж шалгадаг эзэнг эргэж ирсэнтэй зүйрлүүлж үзсэн байдаг(Матай 25:14-29). Загасчины тухай үлгэр нь сайн мэдээний ирсэнг бүх төрлийн хүмүүсийг цуглуулсан загсны тортой зүйрлүүлсэн ба хүмүүс тэгээд сууж (шүүлтийн суудал) сайн загсныг муугаас нь ялгажээ (Матай 13:37-49). Үүний утга санаа нь тодорхой юм:

“Энэ үеийн төгсгөлд Тэнгэр элч нар ирж, зөвт хүмүүсийн дундаас муу хүмүүсийг ялгана”.

Одоогоор бидний үзсэн зүйлээс дүгнэвэл Эзнийг эргэн ирж дахин амилсны дараа Сайн мэдээнд тодорхой нэг газар тодорхой нэг цагт дуудагдсан бүх хүмүүс цуглаж, Христтэй уулзана гэж үзвэл шударга болох юм. Тэд тайлан тавьж, Христ Хаанчлалд орох шагнал авах эсэхийг шийднэ. Зөвхөн энэ үед л зөв сайнууд шагналаа хүлээж авна.Энэ бүхнийг хонь, ямааны тухай үлгэрт бүхэлд нь өгүүлдэг.“Хүний Хүү алдраа дуурсган бүх тэнгэр элч нарынхаа хамт ирж Өөрийн сүр жавхланта сэнтийндээ залрах болно.(Иерусалим дахь

88 БУРХАН

Давидын сэнтий, Лук 1:32,33): Тэр бүх үндэстнүүдийг өмнөө цуглуулж (бүх үндэстнээс иргэн хүмүүс Матай 28:19): хоньчин хонио ямаанаас тусгаарладаг шиг Тэр тэднийг нэг нэгнээс нь тусгаарлаад хонио Өөрийн баруунтайд, ямааг зүүнтэйд байлгана. Тэгээд Хаан Өөрийн баруунтайд байгсдад хандан хэлэх нь Миний ерөөгдөгсөд өө, та нар нааш ир. Ертөнцийн сууриас та нарт бэлтгэсэн хаанчлалыг өвлөн авсугай” (Матай 25:31-34).

Бурханы Хаанчлалыг өвлөх болон энэ талаар Абрахамд өгсөн амлалтуудыг хүлээн авах нь зөв сайн хүмүүст өгөх шагнал болох юм. Гэхдээ үүнийг Христийг эргэж ирэхэд болох шүүлтийн дараа л хийнэ. Тиймээс Христийг буцаж ирэхээс өмнө үхэшгүй мөнх биеийг шагнал болгоно гэсэн амлалтыг хүлээж авах боломжгүй юм. Иймээс биегүйгээр ямар ч хэлбэрээр оршин амьдрах боломжгүй нь харагдаж байгаа учир үхлээс дахин амилах хүртэлх хугацаанд итгэгч ухамсарын хувьд оршин тогтнол огт байхгүй.

Христ эргэн ирж шагналыг өгөх бөгөөд түүнээс нааш энэ явдал болохгүй гэсэн нь удаа дараа давтагддаг Библийн нэг зарчим юм.

- “Ахлах хоньчинг үзэгдэхэд та нар алдрын гандашгүй титмийг хүлээн авна.”(1Петр 5:4,1:13).
- “Есүс Христ түүний үзэгдэлт ба хаанчлалаар амьд ба үхэгсэдийг шүүнэ...зөв шударга шүүгч болох Эзэн ирээдүйд зөвт байдлын титмээр тэр өдөр шагхан болно.”(2Тим.4:1,8)
- Эцсийн өдрүүдэд Месайн эргэн ирэлтээр “Газрын шороонд булагдсан нойрсогчдоос олон нь (Эхлэл 3:19) сэрг, нэг хэсэг нь мөнх амь уруу харин нөгөө хэсэг нь ичгүүр болон мөнхийн жигшил рүү явна” (Дан.12:2)
- Шүүлт дээр Христ ирэхэд тэдгээр “булшинд байгсад...ирчихээд байна:сайн үйлийг үйлдсэн хүмүүс нь амийн амилалт уруу муу үйлийг шйлдсэн хүмүүс нь ялын амилалт уруу гарч ирнэ” (Иох.5:25-29)
- “Би удахгүй ирнэ. Хүн бүрд үйлдсэнийх нь дагуу буцаан төлөхийн тулд Миний шагнал надтай хамт байгаа” (Илчлэлт 22:12) Бид тэнгэр уруу шагналаа авах гэж явахгүй-харин Христ тэнгэрээс түүнийг бидэнд авчирна.

Есүс шагналаа авчирна гэдэг нь түүнийгээ тэнгэрт бэлдсэн гэсэн үг бөгөөд хоёр дахь ирэлтээрээ түүнийг газар дэлхий дээр авчирч өгнө. Абрахамд амласан газрыг бид “өвлөх” гэдэг нь энэ утгаар “та нарын төлөө тэнгэрт хадгалагдсан, (Христийн ирэх) эцсийн үед илэрхийлэгдэхэд бэлэн буй авралын төлөө та нар итгэлээр Бурханы хүчээр хамгаалагдсан” (1 Петр1:4,5).

Үүнийг үнэлж үзэх нь Иохан 14:2,3 дугаар хэсэгт хэлсэн үл ойлгогдох зүйлийг зөвөөр тусгахад бидэнд тустай: “Би /Есүс/ та нарт орон байр бэлдэхээр явна. Хэрэв би явж та нарт орон байр (“тэнгэрт хадгалагдсан ” шагнал) бэлдвэл дахин ирж та нарыг өөртөө авна. Би хаана байна та нар мөн тэнд байх болно”. Өөр газарт Есүс хэлэхдээ тэрээр дахин ирж бидний шагналыг өгнө (Илчлэлт 22:12) гэжээ. Түүнийгээ шүүлтийн ширээнд өгнө гэдгийг бид мэдсэн. Тэрээр Иерусалисдахь Давидын хаан ширээнд “үүрд” залрах юм. (Лук 1:32,33). Есүс газар дэлхийд үүрд мөнх байж Бурханы Хаачлалд, хаана ч байсан тэнд нь бид байх болно. Иймээс “Чамайг өөртөө авна” гэсэн түүний амлалтыг биднийг шүүлт дээр хүлээж авч байгаагын илэрхийлэл гэж үзэж болно. “Чамайг өөртөө авна” гэсэн грек хэллэг нь Иосеф Мариг эхнэрээ болгож “өөр уруугаа авна” гэсэнтэй холбогдуулан Мат.1:20-д дайралдана. Тийм учраас энэ нь Есүс уруу бие махбодийн хувьд хөдөлнө гэсэн санаа биш.

Шагналыг зөвхөн Христийн эргэж ирэх шүүлтэн дээр өгөх учраас зөв сайн болон хорт муучууд үхэхээрээ нэг л газар өөрөөр хэлбэл булш уруу очих юм. Тэднийг үхэхэд ямар ч ялгаа хийгдэхгүй. Үүнийг дараах зүйлүүд батална:

- Ионатан зөв сайн байсан бөгөөд Саул хорт муу байсан. Гэвч “үхэхдээ ч салаагүй” (2 Сам.1:23) .
- Саул ,Ионатан, Самуел үхэхдээ бүгд нэг газар очсон. (1 Сам.28:19).
- Зөв сайн Абрахамыг үхэхэд “өөрийнх нь хүмүүстэй нь /буюу өвөг дээдэстэй нь/ нийлүүлсэн. Тэд шүтлэгтэнгүүд байсан. (Эхлэл 25:8, Иошуа 24:2)
- Мэргэд тэнэгүүдийн адил үхэцгээнэ (Номлогчийн үгс 2:15,16).

Энэ бүхэн нийтлэг ‘Христын шүтлэг’ –сургаалуудтай эрс зөрчилддөг. Зөв сайн хүн үхэхдээ шууд тэнгэр уруу явдаг гэж тэд

90 БУРХАН

сургадаг нь дахин амилах буюу шүүх хэрэгцээг үгүй болгож байна. Гэсэн хэдий ч эдгээр нь Бурханы аврах төлөвлөгөөний чухал үйл явдалууд бөгөөд тиймээс сайн мэдээний хувьд ч мөн адил чухал. Зөв сайн хүн үхэхэд тэнгэрт очих шагналаар шагнагдах ба дараагийн өдөр, дараагийн сар, дараагийн жил бусад нь араас нь очино гэсэн санаа нийтлэг байдаг. Энэ нь бүх зөв сайн хүмүүс нэгэн цагт хамтдаа шагнагдана гэсэн Библийн сургаалтай эрс зөрчилдөнө:

- Шүүлт дээр хонийг ямаанаас нэг нэгээр нь салгана. Шүүлт нэгэнт дуусахад Христ баруун гарт цугларсан бүх хонинд хандан:
- “Миний Эцгээр ерөөгдөгсөд өө, та нар нааш ир. Ертөнцийн сууриас танарт бэлтгэсэн хаанчлалыг өвлөн авсугай” (Мат.25:34). Ингэснээр бүх хонь хаанчлалыг нэгэн цагт өвлөн авна.(1 Кор.15:52)
- Христийн эргэж ирэх болон шүүлтийн “ургац” дээр сайн мэдээнд хөдөлмөрлөсөн бүгд “хамт баярлах” болно. (Иох:4:35,36, Мат.13:39)
- Илчлэлт 11:18-д Бурхан “Таны боолууд болон эш үзүүлэгчид...ариун хүмүүс...таны нэрээс эмээгч хүмүүст”-өөрөөр хэлбэл бүх шүтэгчдэд хамтад нь шагнал өгөх үед “үхэгсэдийг шүүх цаг ирнэ ” хэмээн тодорхойлжээ.
- Еврей 11-д Хуучин Гэрээний зөв сайн хүмүүсийн нэлээдийг нэрлэсэн байдаг.13-р ишлэлд Бурханы хаанчлалд орох замаар аврагдах тухай Абрахамд хийсэн амлалтуудыг “тэд бүгд хүлээж авалгүй итгэл дор нас барсан юм.” (Еврей 11:8-12). Үүнээс үзэхэд эдгээр хүмүүс үхэхдээ тэнгэр уруу шагнал авахаар нэг нэгээрээ яваагүй байна. Үүний шалтгааныг 39,40-р ишлэлүүдэд тайлбарласан байна. Тэд “амлагдсныг хүлээж аваагүй. Бурхан битдний төлөө илүү дээр ямар нэгэн юмыг урьдаас харж байсан. Тэд ингэснээр тэд бидэнгүйгээр төгс болгогдох ёсгүй.” Тэдэнд амлагдсан шагналыг олгох асуудал саатарсны шалтгаан нь бүх үнэнч үүдийг нэгэн зэрэг нэгэн цагт “төгс болгогдох” ёстой гэсэн Бурханы

төлөвлөгөө байсных юм. Энэ нь шүүлтүүр дээр Христийг эргэж ирэхэд тохионо.

4.7 Шагналын газар: Тэнгэр үү, Газар уу?

Дээрх шалтгаануудыг үл харгалзан Бурханы хаанчлал, өөрөөр хэлбэл амлагдсан шагнал нь тэнгэр биш газарт байх юм гэж одоо ч бодсоор байгаа хүмүүс дараах зүйлүүдийг тайлбарлах хэрэгцээтэй болно:

- ‘Эзэний Залбирал’ Бурханы хаанчлалыг ирэхийг гуйдаг (өөрөөр хэлбэл Христийг эргэж ирэхийг залбирах), гэтэл Бурханы хүсэл одоо тэнгэрт хийгдэж байгаатай адил газарт мөн хийгдэх юм. (Матай 6:10). Иймд бид Бурханы Хаанчлалыг газарт ирэхийн төлөө залбирч байна. Мянга мянган хүмүүс Бурханы Хаанчлалыг одоо тэнгэрт хэдийнээ хийгдсэн тул газар дэлхий сөнөнө гэж итгэн өдөр бүр бодлогогүйгээр мөргөдөг нь эмгэнэлтэй.
- “Дөлгөөн хүмүүс ерөөлтэй еэ! Учир нь тэд дэлхийг өвлөн авах болно.” (Матай 5:5) –‘тэдний сэтгэл нь тэнгэр уруу явна’ гэдэгт биш юм. Үүнтэй холбогдон Дуулал 37 бүхэлдээ зөв сайн хүмүүсийн эцсийн шагнал газар дээр байхыг онцлон тэмдэглэсэн байдаг: Хорт муу хүмүүс түр зуур өөрсдийнхөө ноёрхолыг тогтоосон яг тэр газарт зөв сайн хүмүүс мөнхийн амьдралаар шагнагдаж тэрхүү газрыг эзэмших болно.(Дуулал 37:34,35). “Харин даруу хүн газар нутгийг өвлөж...түүгээр ерөөгдөгсөд газар нутгийг өвлөж...зөв шударга хүн газар нутгийг өвлөж түүнд мөнхөд оршин суух болно” (Дуулал 37:11,22,29). Газар дэлхий/амлагдсан газар дээр мөнхөд амьдрах гэдэг нь тэнгэр дэх мөнхийн амьдралыг биелэгдэшгүй болгоно.
- “Давид ...үхэж оршуулагдсан. Давид тэнгэрт гарсан нь биш” (Үйлс 2:29,34). Харин ч Петр тайлбарлахдаа түүний найдвар нь Христийн эргэн ирэхэд үхлээс дахин амилагдах явдал байв. (Үйлс 2:22-36).

92 БУРХАН

- Газар дэлхий нь Бурханы хүн төрөлхтөндөө үйлдэх үйл ажиллагааны талбар юм. “Тэнгэрүүд бол Эзэний тэнгэрүүд билээ. Харин газар дэлхийг Тэрээр хүний хөвгүүдэд өгсөн” (Дуулал 115:116).
- Илчлэлт 5:9,10-т зөв сайн хүмүүсийг шүүлтийн ширээнд хүлээж авахад тэд юу гэж хэлэхийг урьдчилан зөгнөжээ: “(Христ) биднийг Бурханы төлөөх хаанчлал ба тахилчаар болгосон. Бид дэлхий дээр хаанчлах болно” Газар дээр байгаа Бурханы Хаанчлалд захирах энэ дүр зураг нь бид ‘жаргалыг’ тэнгэрт хаа нэгтээ эдлэнэ гэсэн бүдэг бадаг ухагдахуунаас маш хол юм.
- Даниелын 2 ба 7-р бүлгүүд дэх эш үзүүлэлэг нь Христийн эргэн ирэх үе дэх эцсийн эцэст Бурханы хаанчлалаар захирагдах улс төрийн эрх мэдлийг үзүүлсэн байдаг. Хаанчлалын эрх мэдэл “бүхэл тэнгэрийн *дор*” байж,

“хамаг *дэлхийг*” дүүргэнэ (Даниел 7:27; 2:35, 44). Мөнхийн Хаанчлал нь “Дээдийн Дээд Нэгэний ариун хүмүүсийн ард түмэнд өгөгдөх болно” (Дан.7:27). Тиймээс тэдний шагнал нь тэнгэрийн *дор*, газар дээр орших энэхүү Хаанчлал дахь мөнхийн амьдрал юм.

4.8 Бурханы өмнө хариуцах үүрэг

Хэрвээ хүн төрөлхөөсөө ‘мөнхийн сэтгэл’-тэй байдаг бол хаа нэгтэй, шагналын юмуу шийтгэлийн газрын аль нэгэнд мөнхийн хувь тавилантай байх албатай болно. Энэ нь хүн бүр Бурханы өмнө үүрэгтэй гэсэн үг юм. Нөгөөтэйгүүр хүн төрөлхийн мөнх бус, амьтантай адил шинжтэй гэдгийг Библид хэрхэн заадгийг бид харуулсан. Гэвч Бурханы хаанчлалд мөнхийн амьдралтай болох саналыг зарим хүмүүст тавьсан. Хүний амьдралаар амьдарсан хүн бүр дахин амилахгүй нь илэрхий. Хүн амьтантай адилхан амьдраад үхээд, хумхын шороо болон бутрана. Гэвч хүмүүсийг шүүж заримыг нь буруушааж заримыг нь мөнхийн амьдралаар шагнах учраас хүн төрөлхтөн дотроос шүүгдэж шагнагдахын тулд дахин амилах тусгай зэрэглэл тогтоогдох юм.

Хэн нэгэн нь дахин амилах үгүй нь шүүлтийн өмнө хариуцлага хүлээх эсэхээс нь хамаарна. Биднийг Бурханы үгийн талаар өөрсдийн мэдлэгт хэрхэн хандахаар нь үндэс болгон шүүнэ. Христ тайлбарлахдаа “Намайг голж миний үгийг хүлээж авдаггүй хүнийг шүүх шүүгч бий. Миний хэлсэн үг эцсийн өдөрт түүнийг шүүнэ.”(Иохан 12:48). Христийн үгийг мэдэхгүй буюу ойлгоогүй байснаас түүнийг хүлээж авах буюу үл хүлээж авах боломж олдоогүй хүмүүс шүүлтэд хамаарахгүй. “Хуульгүйгээр (Бурханых гэдгийг мэдэхгүйгээр) нүгэл үйлдсэн бүх хүн Хуульгүйгээр мөхөх болно. Хуулийн

дор нүгэл үйлдсэн бүх хүн Хуулиар шийтгэгдэх болно.”(Ром 2:12). Ингэхээр Бурханы шаардлагуудыг мэдээгүйчүүд нь амьтан мэт алга болно. Мэдсээр байж Бурханы хуулийг зөрчигсөдийг шүүх хэрэгцээтэй учраас тэднийг шүүхээр дахин амилуулна. Бурханы харснаар “Хууль байхгүй үед нүглийг хүлээлгэхгүй.”, “нүгэл бол (Бурханы) хуулийг зөрчсөн хэрэг юм.”,”Хуулиар нүглийн мэдлэг ирдэг” (Ром 5:13, 1Иох.3:4, Ром3:20). Бурханы үгэнд илэрхийлснээр Бурханы хуулиудыг мэдэхгүй бол хүнд “нүглийг тулгахгүй”. Тиймээс тэднийг шүүхгүй ба дахин амилуулахгүй. Иймээс Бурханы Үгийг мэдэхгүйчүүд нь амьтан ургамалтай адил байрлалд байгаагаа харна. Тэдэн лугаа адил үхмэл хэвээр үлдэнэ. “Ухааралгүй хүн мөхөх адгуустай адил юм”(Дуулал 19:20).”Тэд хонь шиг үхэгсэдийн оронд аваачигдахаар товлогдсон”(Дуулал 49:14).

Бурханы замуудыг мэдсэнээр бид үйл ажиллагааныхаа төлөө Түүний өмнө үүрэг хүлээх ёстой болж байгаа бөгөөд тиймээс дахин амилж шүүлтийн ширээнд гарч ирэх шаардлагатай болно. Учир иймд зөвхөн зөв сайн буюу баптисм хүртэгч нэгэнүүд дахин амилаад зогсохгүй Бурханыг мэддэг шалтгаанаар Түүний өмнө үүрэг хүлээгч бүгд дахин амилах юм. Энэ нь Сударт байнга давтагддаг сэдэв юм:

- Иохан 15:22-т Үгийн тухай мэдлэг нь хариуцлагат авчирна.”Хэрэв би (Есүс) ирж тэдэнд хэлээгүйсэн бол тэд гэм буруугүй байх байсан. Харинодоо тэд өөрсдийн нүгэлд шалтаг (‘уучлал’) байхгүй болно “. Ром 1:20-21 –т Бурханы тухай мэдсэн хүмүүс “уучлалгүй ” үлдэнэ.

94 БУРХАН

- “Эцгээс сонсож, сурсан хүн бүр над уруу ирдэг...Би (Христ) тэр хүнийг эцсийн өдөрт амилуулна.” (Иохан 6:44,45)
- Бурханы замуудыг үнэхээр үл тоогчдын үйл ажиллагааг Тэрээр “мэдээгүй юм шиг өнгөрөөдөг”. Түүний замыг мэддэгүүдтйг Бурхан ажиглаж хариу үйлдэл тэднээс хүлээдэг.(Үйлс 17:30).
- “Эзнийхээ хүслийг мэдсэн хэрнээ хүслийнх нь дагуу биелүүлээгүй, бэлэн байгаагүй. Тэр боол ташуурын амт хатуухан хүртэнэ. Харин үүнийг мэдээгүй бөгөөд ташуурын амт хүртэх хэрэг үйлдсэн нэг нь багахан хүртэнэ. (жишээ нь
- үхэж үлдэх) Хэнд их нь даалгагдсан байна түүнээс ихийг шаардана.”(Лук 1:-47,48)-тэгвэл Бурхан хир илүүг шаардах вэ?
- “Тийм учир зөв юмыг үйлдэхийг мэддэг хэрнээ үл үйлддэн хүнд энэ нь нүгэл юм” (Иаков 4:17).
- Бурхан Израильд Өөртэйгөө холбогдуулан хийсэн илчлэлтээс хамаарч тэд Бурханы өмнө тусгай үүрэг хүлээнэ(Амос 3:2).
- Үүрэг хариуцлагын энэ номлолоос болж “зөв байдлын замыг мэдээд, өөрсдөд нь өгөгдсөн ариун тушаалуудаас нүүр буруулан эргсэнээс энэ замыг мэдээгүй байсан нь тэдэнд дээр байх байсан (2 Петр 2:21). Үүнтэй холбоотой бусад зүйлс нь: Иохан 4:41, 3:19, 1 Тим. 3:13, Хос. 4:14, Дэд Хууль 1:39 болно.

Бурханы тухай мэдлэг бидэнд шүүлтийн сэнтийн өмнө үүрэг оногдуулж байгаа учраас ийм мэдлэггүй нь шүүгдэх хэрэгцээгүй учир дахин амилахгүй ба тэд мэдлэг байхгүй учраас “мөхөх адгуустай адил” болж байгаа юм (Дуулал 49:20). Амьдарсан хүн бүр дахин амилахгүй гэдгийг харуулсан зүйлүүд олон байна:

-Вавилоны эртний үндэстний ард түмэн үнэн Бурханыг үл ойшоосон учраас үхсэнийхээ дараа “дахин өндийхгүй” (Иер. 51:39, Ис. 43:17).

-Исаиа өөрийгөө урамшуулан: “Аяа, Бидний (Израилын) Бурхан Эзэн, таниас өөр эзэд биднийг захирсан боловч (Филистин ба Вавилон)...тэд үхсэн, амьдрахгүй (дахин);салан одсон сүнсүүд босохгүй...Тэдний аливаа дурсамжийг арилгасан. (Исаиа 26:13,14). Тэдний дахин амилахгүй талаархи гурвалсан санаа бий: “(дахин) амьдрахгүй...сэргэхгүй...бүх дурсамж нь арилна”. Нөгөө талаар Израел нь үнэн Бурханы тухай өөрсдийн мэдлэгт тулгуурлан дахин амилалтын үзэлтэй байсан. “Таны (Израелын) үхэгсэд миний үхсэн биетэй хамт амилж, тэдний цогцос босно.” (Исаиа 26:10).

- Бурханы хүмүүс Израелын тухай ярих нь бидэнд Христийн эргэн ирэхийг хэлдэг, “газрын шороонд булагдсан нойрсогчдоос ихэнх нь сэрж, нэг хэсэг нь мөнх амь уруу нөгөө хэсэг нь ичгүүр болон мөнхийн жигшил уруу явна” (Даниел 12:2). Иймд харин Еврей нарын бүгд биш “олон” нь дахин амилах ба Бурханы

- өмнө тэд Өөрийн сонгосон хүмүүсийн адил хариуцлага хүлээнэ. Өөрсдийн үнэн Бурханыг бүрэн үл ойшоогчид “унаж , дахин хэзээ ч маргахгүй” бөгөөд тэд “Эзэний үг”-ийг (Амос 8:12,14) олох чадваргүй болно.

Бид одоогоор дараах зүйлсийг үзээд байна:

1. **Бурханы үгийн тухай мэдлэг Түүний өмнө хариуцлагыг бий болгоно.**
2. **Зөвхөн хариуцлагатангууд дахин амилж, шүүгдэнэ.**
3. **Үнэн Бурханыг үл мэдэгчид амьтадын адил үхэж үлдэнэ.**

Эдгээр дүгнэлтийн утга санаа нь хүний бардам сэтгэл болон бидний итгэхийг ихээхэн эрмэлздэг тэр зүйлд хүнд цохилт болж байна: Түүхийн явцад, одоо ч жинхэнэ Сайн Мэдээг үл ойшоон ирсэн олон сая хүмүүс, Библийн мэдээг ойлгох чадваргүй сэтгэл мэдрэлийн хүнд өвчтөнгүүд, Сайн мэдээг мэдэх эрийн цээнд хүрч чадалгүй нас барсан нялх болон балчир хүүхдүүд зэрэг эдгээр бүлэг хүмүүс Бурханы талаар жинхэнэ мэдлэггүй ба тиймээс Түүний өмнө хариуцлага хүлээхгүй гэсэн зэрэглэлд орно. Энэ нь

96 БУРХАН

юу гэсэн үг вэ гэхээр тэд эцэг эхийн сүсэг бишрэлээс үл хамааран дахин амилахгүй юм. Энэ нь хүмүүнлэгийн үр ба манай төрөлх хүсэл эрмэлзэл, санаа сэтгэлтэй эрс тэс зөрчилддөг. Гэсэн хэдий ч эцсийн үнэний тухай Бурханы үгэнд даруухан хандан, бид өөрсдийн шинж чанарын талаар даруухан үзэр баримтлалтай байх юм бол биднийг үүний үнэнийг хүлээж авахад хүргэнэ. Хүний туулж өнгөрүүлдэг зүйлсийн баримтыг судрыг баримтлалгүйгээр ч гэсэн шударгаар шалгаж үзвэл дээр дурьдсан бүлэг хүмүүст ирээдүйн амьдрал байх найдвар байхгүй болов уу гэсэн дүгнэлтэд мөн хүргэнэ.

Эдгээр явдалд дахь Бурханы замыг бид эргэлзэнэ гэвэл зүйд огт үл нийцнэ. “Бурханы эсрэг хариу хэлдэг хүн чи хэн бэ?” (Ром 9:20). Бид дутуу ойлгож байж болно гэдгээ хүлээн зөвшөөрч болно. Харин бид Бурханыг шударга бус буюу буруу юм хийлээ гэж хэзээ ч буруутгаж болохгүй. Бурханыг ямар нэг талаар хйаргүй байна хэмээх буюу алдаа гаргаж байна гэж бодвол бүхнээс хүчтэй Бурхан, Өөрсдийн амьтдаа ухаалаг бус, шударга бус замаар хандаж байгаа Эцэг, Бүтээгч гэсэн аймшигт төлөв бий болох юм.

Давид хаан хялх хүүхдээ алдсан гэж бичсэнийг унших нь ач холбогдолтой зүйл юм: 2Сам.12:15-24-т хэрхэн Давид хүүхдийг амьд байх үед нь түүний төлөө маш ихээр залбирсан боловч үхсэн гэдгийг нь бодиттойгоор хүлээж авсан байна. “Хүүг амьд байх үед би мацаг барьж уйлж байсан нь “Эзэн намайг нигүүслэж, хүүг амьдруулах магад” хэмээн санасны учир юм. Гэвч одоо хүүхэд нас барчихлаа. Би юундаа мацаг барих ёстой билээ?... тэр над дээр эргэж ирэхгүй...”. Дараа нь Давид эхнэрээ тайтгаруулж удалгүй өөр хүүхэдтэй болжээ.

Эцэст нь, Бурханы өмнө хариуцлага хүлээх зарчмыг мэдсэн олон хүмүүс Түүний өмнө хариуцлага хүлээж шүүгдэх тохиолдолд Түүний тухай дахин илүү мэдлэгийг олж авахыг хүсэхгүй болдог гэж яригддаг. Тэгвэл эдгээр хүмүүс Бурханы өмнө хэдийнээ хариуцлага хүлээсэн бөгөөд Бурханы Үгийн тухай өөрсдийнх нь мэдлэг нь тэднийг Бурхан тэдний амьдралд байж Өөртэйгээ жинхэнэ харилцаа тогтоох саналаас айлгаж байгаа юм. Иймд “Бурхан бол хайр” бөгөөд Тэр “хэнийг ч мөхүүлэхийг хүсдэггүй” бас “Тэр цорын ганц хүүгээ өгсөн. Ингэснээр Хүүд итгэх хэн ч мөхөхгүй, харин мөнх амьтай болох юм.” (1Иохан 4:8, 2Петр3:9, Иохан 3:16) гэдгийг санах хэрэгтэй.

Ийм шагнал, эрх дарх нь хариуцлага дагуулах нь гарцаагүй. Гэсэн ч эдгээр нь бидэнд тийм их хэцүү, хүнд байхаар зориулагдаагүй; хэрэв бид Бурханд үнэхээр хайртай бол бид Түүний авралын санал нь тодорхой ажлын төлөө өгч буй бэлэн шагнал бус харин Өөрийн хүүхдүүдэд аз жаргалын мөнхийн амьдралыг Өөрийн гайхамшигт чанарыг нь бишрэх сэтгэлээр нь дамжуулан өгөхийн тулд юу чадахаа хийх хайрын сэтгэл юм гэдгийг ойлгон баярлах бахдах болно.

Бид Бурханы дуудлагыг Түүний Үгээр дамжуулан сонсож бишрэдэг тул бид .

Бид хүмүүсийн дунд явж байхдаа Бурхан биднийг өөрсдийн хариуцлагаа үл ойшоон амьдрахыг хүлээн суух биш харин биднийг онцгой эрчимтэйгээр харж Түүний хайрд үзүүлэх бидний хариуг уриалгаханаар эрэлхийлж байдгийг анзаардаг. Хэзээ ч биднээс хайрын харцаа салгахгүй; бид ч хэзээ ч Бурханы хариуцлагаас чөлөөлөгдөн махан биеэ хэт анхаарахын тулд Түүний тухай мэдлэгээ мартаж чадахгүй. Харин ч бид Бурхантай онцгой ойрхон байдагтаа баярлан Түүний хайр аугаа гэдэгт итгэн Түүний тухай бага биш илүү их мэдэхийг эрэлхийлж чадна, тэгэх ч хэрэгтэй. Бурханы зам болон таалалын бидний хайр тэдгээрийг мэдэхэд чиглэгддэг, иймд бид Түүнийг улам илүү дуурайж чадах ба Түүний дээдийн дээд ариун байдлаас төрөлхөөсөө эмээх явдлыг даван туулна.

4.9 Там

Тамын тухай нийтлэг үзэл баримтлал нь түүнийг хорт муу 'үхэшгүй сэтгэлүүд'-эд үхлийн дараа оногдуулж буй шийтгэл буюу шүүлт дээр буруутагсдад зориулсан өвчин зовлонгийн газар гэж тодорхойлдог. Библийн сургаснаар бид там нь бүх хүмүүсийн үхсэнийхээ дараа очих үхэгсэдийн орон гэж үзэх хэрэгтэй.

Үгийн хувьд 'там' нь 'шеол' гэсэн Еврей үгнээс гаралтай бөгөөд орчуулвал 'далдлагдсан газар' гэсэн утгатай. 'Там' нь 'шеол'-н Англи хэл рүү буулгасан хувилбар юм; иймд бид 'там'-ын тухай уншихад төгс бүрэн орчуулагдсан үгийг уншиж буй хэрэг биш. 'helmet' буюу 'хуяг' гэдэг үг нь толгойдоо өмсдөг өмсгөл бөгөөд үгийн хувьд 'hell-met' гэсэн гаралтай. Библийн хувьд

98 БУРХАН

‘далдлагдсан газар’ буюу ‘там’ нь үхэгсэдийн орон юм. ‘Шеол’ гэсэн үндсэн үгийг ‘үхэгсэдийн орон’ гэж орчуулсан нэлээн хэдэн жишээ бий. Гэхдээ зарим орчин үеийн Библийн хувилбарт ‘там’ гэсэн үгийг ‘үхэгсэдийн орон’ гэж илүү тохиромжтойгоор орчуулж хэрэглэж байна. ‘Шеол’ гэсэн үгийг ‘үхэгсэдийн орон’ гэж орчуулсан цөөн хэдэн жишээ нь тамыг гал авалзсан газар болон хорт муучуудын тарчлах газар гэсэн нийтлэг үзлийг сулруулдаг:-

- “Хорон муу хүмүүсийг...үхэгсэдийн орны эрхшээлээс аварна” (шеол [Дуулал 49:15])- тэд тарчлаандаа орилж хашгирахаа болино.
- “Бурхан миний сэтгэлийг үхэгсэдийн орны эрхшээлээс аварна” (шеол [Дуулал 49:15])-өөрөөр хэлбэл Давидын сэтгэл буюу бие нь үхэгсэдийн орон, ‘там’-аас дахин амилсан.

Тамыг хорон муучуудын аврагдаж гарч үл чадах шийтгэлийн газар ; зөвсэйн хүн там (үхэгсэдийн орон) уруу ороод дахин гарч ирж чадна. Хос 13:14-т “Би тэднийг (Бурханы хүмүүс) Үхэгсэдийн орны (шеол) хүчээс золих уу? Би тэднийг үхлээс золих уу?” гэсэн байдаг. Энэ нь мөн 1Кор 15:55-д тэмдэглэгдсэн ба Христийн эргэн ирэх үеийн дахин амилалтыг өгүүлсэн. Хорё дахь амилалтыг зөгнөсөнтөй адил (Хичээл 5.5-г үз) “Үхэл ба Үхэгсэдийн орон өөрсдийн үхэгсэдийг гаргаж өгөв” (Илчлэлт 20:13) гэжээ. Үхэл өөрөөр хэлбэл үхэгсэдийн орон ба там хоёрын уялдаа холбоог анхаар. (Дуулал 6:5-г үз).

1 Самуел 2:6 дахь Ханнагийн үгс тун тодорхой. “Эзэн үхүүлдэг бас амьдруулдаг (дахин амилалтаар): Тэр үхэгсэдийн оронд (шеол) унагадаг бас босгодог”.

‘Там’ бол үхэгсэдийн орон юм гэж үзснээр зөв сайнууд өөрсдийн дахин амилалтаар мөнхийн амьдралд орж аврагдах болно гэсэн ойлголтыг төрүүлнэ. Иймд энэ нь ‘там’ буюу үхэгсэдийн оронд орох боломжтой мөн дахин амилалтаар түүнийг орхин гарч болно гэсэн үг. Есүс хамгийн дээд жишээ юм: түүний “сэтгэл үхэгсэдийн оронд орхигдсонгүй. Түүний махан бие ч ялзралыг үзсэнгүй” (Үйлс 2:31). Учир нь тэр амилсан юм. Христийн ‘сэтгэл’ болон ‘махан бие’ буюу бие махбодь хоёрын уялдааг анхаар. Түүний бие “ттамд үлдээгүй” гэдэг нь тэр тэнд хэсэг хугацаанд өөрөөр хэлбэл үхэгсэдийн оронд гурав хоног байжээ. Христ ‘там’ уруу явсан нь тэнд зөвхөн хорон муучууд очдоггүйн хангалттай баталгаа юм.

Сайн, муу хүмүүс аль аль нь 'там' уруу буюу үхэгсэдийн орон уруу явдаг. Иймд Есүс "өөрийн булшийг нүгэлт хүмүүсийн хамт" байлгасан. (Иса.53:9). Үүнтэй хамт зөв шударга хүн там уруу өөрөөр хэлбэл үхэгсэдийн орон уруу явдаг тухай бусад жишээнүүд бий. Иаков өөрийн хүү Иосефын төлөө "гашуудсаар өөр ертөнцөд .. хүрч очдог" (Эхлэл 37:35).

Нүглийн төлөө оногдуулах шийтгэл нь үхэл гэсэн Бурханы нэг зарчим бий: (Ром 6:23; 8:13; Иаков 1:15). Бид өмнө нь үхэл нь бүрэн ухамсаргүйн газар гэж үзсэн. Нүгэл нь мөнхийн тарчлаан биш харин дээд сүйтгэлийн үр дагавар ба (Матай 21:21;22:7; Марк 12:9 Иаков 4:12) хүмүүс Үерт дайрагдан устаж (Лук 17:27,29) Израйлчууд зэрлэг байдалд үхэцгээсэн (1Кор.10:10). Аль ч тохиолдолд нүгэлтэнгүүд мөнхөд тарчлаагдахаасаа илүү *үхэцгээдэг*. Тиймийн учир хорон муучууд ухамсарын тарчлаан болон зовлонгийн мөнх байдлаар шийтгэгдэх боломжгүй.

Бид мөн Бурхан Хэрэв бид Түүний үгийг үл ойшоовол нүглийг нүгэл гэхгүй ба нүглийг тулгадаггүй гэдгийг үзсэн. (Ром 5:13). Ийм нөхцөлд буй хүмүүс үхдэл хэвээр үлдэнэ. Бурханы шаардлагыг мэдсэн хүмүүсийг Христийн эргэн ирэхэд амилуулж шүүнэ. Хэрэв хорон муу нүгэлт бол хүлээх шийтгэл нь үхэл юм. Учир нь энэ нь нүгэлд оногдуулах шүүлт юм. Иймд Христийн шүүлтийн сэнтийний өмнө ирсэн хойно үүрд мөнх үхдэл хэвээр байхаар дахин үхнэ. Энэ нь Илчлэлт 2:11; 20:6 –д өгүүлсэн "хоёр дахь үхэл" болно. Эдгээр хүмүүс нэг л удаа үхнэ, үхэл нь бүрэн ухамсаргүй юм. Тэд Христийг эргэн ирэхэд дахин амилж, шүүгдэж эхний үхэлтэйгээ адилхан бүрэн ухамсаргүй хоёр дахь үхлээр шийтгэгдэнэ.

Энэ нь нүглийн төлөө оногдуулах шийтгэл нь 'үүрдийн' байх ба тэдний үхэлд төгсгөл байхгүй. Үүрд үхдэл хэвээр байх гэдэг нь үүрд мөнхийн шийтгэл юм. Үүний илэрхийлэлийг Библи хэрэглэсэн жишээг Дэд хууль 11:4-с харж болно. Үүнд Бурхан Улаан далайд Фараоны цэргийг үүрд устгаж улмаар тэрхүү цэргүүд дахин хэзээ ч Израйлийг зовоохгүй болгосонг дүрсэлсэн. "Тэр тэднийг Улаан тэнгисийн усанд живүүлж...Эзэн тэднийг бүрмөсөн устгасан"

Хуучин Гэрээний үеийн эрт цагт хүртэл итгэгч нар хорон муучуудыг үхэгсэдийн орон уруу буцаах хариуцлага бүхий эцсийн өдөрт дахин амилалт болно гэдгийг ойлгож байсан. Иов 21:30,32-

100 БУРХАН

т тун тодоор “Хорон муу хүн сүйрлийн өдөрт аваачигдана (өөрөөр хэлбэл дахин амилж)...түүнийг (дараа нь) булшинд хийнэ” гэжээ. Христийн эргэн ирэлт мөн шүүлтийн тухай үлгэрт түүний өмнө хорон муучууд ‘алагдсан’ тухай өгүүлдэг. (Лук 19:27). Энэ нь хорон муу хүн үүрд мөнх ухамсарт газарт үргэлж тарчлаан амсаж байдаг гэсэн үзэлтэй тохирохгүй. Аливаа тохиолдолд энэ нь бодлогогүй шийтгэл- 70 жилийн хугацаатай *мөнхийн* тарчлаан болох юм. Бурханы хувьд хорон муу хүмүүсийг шийтгэх нь зугаа цэнгэл биш; ийм учраас Тэрээр тэдэнд мөнхийн шийтгэлийг оногдуулдаггүй. (Езе. 18:23, 32; 33:11 мөн 2 Петр 3:9).

Шүтлэг бишрэлээ орхисон Христичид ‘тамыг’ гал буюу тарчлан зовоох гэсэн санаатай холбож үздэг. Энэ нь там (үхэгсэдийн орон) –ын талаар Библийн сургаалтай эрс зөрчилдөж байгаа юм. “Тэд хонь шиг Үхэгсэдийн оронд аваачигдахаар товлогдсон. Үхэл тэдний хоньчин болно” (Дуулал 49:14). Энэ нь тэрхүү үхэгсэдийн орныг энх амгалан юуг ч үл мэдрэх газар гэсэн утгатай. Христийн сэтгэл буюу бие тамд гурван өдөр болоход ялзралыг үзсэнгүй (Үйлс 2:31). Хэрвээ там галын орон байсан бол ийм байх боломжгүй байсан. Езекиел 32:26-30 нь үхэгсэдийн оронд тайван хэвтэх эргэн тойрон дох дайчдын зураглалыг гаргасан байдаг. “Тэд бүгд айдсыг төрүүлж байсан...дайтах зэвсэгтэйгээ үхэгсэдийн орон уруу явсан. Толгойнх нь дор илднүүд нь тавигдсан...тэд алагдагсадтайгаа хамт хэвтсэн” Энэ нь дайчдыг зэвсэгтэй нь оршуулж толгойг нь сэлмэн дээр тавьдаг тэрхүү ёсаншлыг өгүүлж байна. Гэсэн ч энэ нь “там-булшны” дүрслэл юм. Эдгээр хүчирхэг хүмүүс тамдаа (өөрөөр хэлбэл булшиндаа) хэвтэж буй эдгээр хүчирхэг эрчүүл тамыг галын орон гэсэн санааг дэмжихгүй нь лавтай. Биет зүйлс (өөрөөр хэлбэл сэлмүүд) ‘там’ уруу хүмүүстэй хамт явж байгаа нь там бол

сүнслэг тарчлааны талбар биш юм гэдгийг харуулж байна. Ингэхэд Петр хорон муу хүнд “Мөнгө чинь чамтай хамт мөхөг” (Үйлс 8:20) гэж хэлсэн байдаг.

Иоханы туулж өнгөрүүлсэн түүх үүний эсрэг байдаг. Аврага том загасанд амьдаараа залгиулсан . “Иона загасны гэдэс дотроос өөрийн Бурхан Эзэнд залбирсан. Тэр Эзнийг дуудан Үхэгсэдийн орны гэдэснээс гаргаж өгөөч гэж би хашхирч байсан ” (Иона 2:1,2). Энэ нь “тамын гэдэс” гэдгийг халимныхтай зүйрлэсэн хэрэг юм. Халимны гэдэс бол үнэхээр “далдлагдсан газар” байсан бөгөөд энэ нь ‘шеол’ буюу орчуулбал ‘там ’ гэсэн үгний үндсэн утга юм. Мэдээж энэ нь галын газар биш байсан бөгөөд халим

Ионаг бөөлжөөд гаргачихаар тэрээр “тамын гэдэснээс” гарч ирсэн юм. Энэ нь Христийг ‘там’ (булш)-ас дахин амилахыг зааж байгаа хэрэг. Матай 12:40-г хар.

Галын дам утга

Библид Бурхан нүгэлд уурлаж үүний үр дүнд нүгэлтэнг булшинд бүрэн устгахыг төлөөлүүлж мөнхийн гал хэмээх үгийг олонтой хэрэглэдэг. Содомыг ‘мөнхийн гал’-р шийтгэсэн ба (Иуда 6.7), өөрөөр хэлбэл оршин суугчид нь хорон муу байснаас түүнийг бүрэн устгасан байна. Өнөөдөр уг хот үнсэн товрог болж мөхсөн тэнгисийн усны дор оржээ. Хэрэв бид ‘мөнхийн галыг’ шууд утгаар нь ойлговол энэ хот гал түймэрт авагдсан зүйл огт алга. Үүнчлэн Израйлын хийсэн нүгэлд Бурхан уурлан Иерусламыг мөнхийн галаар шатаана хэмээн айлгажээ. “Би хаалган дээр нь гал ноцоох бөгөөд тэр нь Иерусламын орднуудыг залгиж унтраагдахгүй” (Иеремиа 17:27). Иерусалимыг ирээдүйн хаанчлалын нийслэл болон хэмээн урьдчилан хэлсэн боловч (Иса.2:2-4, Дуулал 48:2) Бурхан үүнийг бид нараар шууд утгаар нь уншуулна гэсэн үг биш. Иерусалимын том байшингуудыг галдан шатаажээ (Хаадын Дэд 25:9). Гэвч тэр түймэр нь мөнхөд үргэлжлээгүй.

Энэчлэн Бурхан Иедумагийн газрыг түймрээр шатааж тэр нь “өдөр ч шөнө ч унтрахгүй, утаа нь мөнхөд суунаглана. Энэ нь үеийн үед эзгүйрэн ...тэнд шар шувуу, хэрээ үүрлэнэ...бэхлэгдсэн цамхагууд болон хотуудынх нь дотор үүргэний бут, өргөст халгай ургана.” (Исаиа 34:9-15). Иедумягийн сүйдсэн газарт амьтад болон ургамлууд орших ёстой байсан учраас мөнхийн гал гэдэг хэллэг нь Бурханы уур хилэн, газар нутгийг бүрэн устгахтай холбоотой болохоос биш түүнийг шууд утгаар авч үзэх нь утгагүй.

‘Үүрд’ гэж орчуулагдах Еврей ба Грек үгүүд шууд “үеийн үед” гэсэн утгатай юм. Заримдаа энэ нь шууд утгаараа хязгааргүй үргэлжлэх зүйлийг илтгэнэ.

Жишээлбэл Хаанчлалын орших хугацаа байна. Гэхдээ дандаа ийм бус. Ез.32:14,15 бол үүний жишээ юм: “Сүнс бидэн дээр асгарах хүртэл хэрэм ба цамхагууд ямагт үүр байх болно.” Энэ нь ‘мөнхийн галын’ ‘мөнх байхыг’ ойлгох нэг зам юм. Иерусалим ба Израйлын нүгэлд уурласан Бурханы уурыг галтай адилтгах

102 БУРХАН

явдал байн байн тохиолдоно. “Миний уур ба хилэн энэ газар дээр (Иерусалим)...шатах бөгөөд унтраагдахгүй” (Иеремиа 7:20, бусад жишээ Лам7:11, Хааны Дэд 22:17).

Мөн гал нь ялангуяа Христийг эргэн ирэхэд нүглийг Бурхан шүүх явдалтай холбож үздэг. “Учир нь харагтун, зуух мэт шатаж буй өдөр ирж байна. Омог бардам тэднийг түймэрдэх болно” (Малахи 4:1). Өвсний ёзоор буюу тэр байтугай хүний бие галд шатахад хумхын тоос болон хувирна. Ямарваа бодис ялангуяа хүний мах шөрмөсийг шууд утгаар мөнхөд шатаж байх ямар ч боломж байхгүй. Иймээс ‘мөнхийн гал’ гэдэг үг шууд утгаараа мөнхийн тарчлаан гэж үзэж болохгүй. Шатах ямар ч зүйл байхгүй бол гал мөнхөд үргэлжлэх боломжгүй. “Там” “галт нуурт хаягдлаа” (Илчлэлт 20:14) гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Энэ там ‘галын нуур’-тай ижил биш болохыг харуулна. Энэ нь бүрэн сүйрлийг төлөөлж байгаа юм. Мянганы төгсгөлд үхэл гэж байхаа болих учраас булшыг бүрэн үгүй хийх ёстой гэж бидэнд Илчлэлт номын билэг тэмдэгийн чанартай өгүүлж байна.

Жехенна

Шинэ гэрээнд ‘там’ хэмээх үгийг орчуулсан хоёр грек үг байна. ‘Хадес’ гэдэг нь бидний өмнө дурдсан еврейн ‘шеол’-той адил юм. ‘Жеханна’ гэдэг нь Иерусалим хотын гадна талд орших хогын цэгийн нэр бөгөөд хотын хогыг тэнд шатаадаг байжээ. Хогын иймэрхүү цэгүүд өнөөгийн хөгжиж буй орнуудын олон хотуудад байдаг нийтлэг зүйл юм. (Жишээлбэл Филлипини улсын Манила хотын гадна талд “Утаат уул” гэж бий.). Оноосон нэр үг буюу өөрөөр хэлбэл тодорхой газрын нэрийн хувьд үүнийг ‘там’ гэж орчуулсанд орвол ‘жехенна’ гэж орчуулалгүй үлдээсэн нь дээр байсан. ‘Жехенна’ нь еврейн ‘Же-бен-Хиннон’ гэсэн арамайк хувилбар юм. Энэ нь Иерусламын ойролцоо байсан (Иош.15:8) бөгөөд Христийн үед хотын хог хаягдалын газар байжээ. Ямагт гал шатаж байсан учраас тэнд гэмт хэрэгтэнүүдийн цогцосуудыг хаяж, улмаар жехенна нь бүрэн сүйтгэл, сүйрлийн билэг тэмдэг болжээ.

Тэр галд хаяж байсан зүйлүүд тэндээ мөнхөд үлдээгүй, цогцосууд хумхын тоос болон хувирсан гэдгийг дахин тэмдэглүүштэй. Шүүлтийн өдөрт “Бидний Бурхан шатаах гал (байх болно) юм” (Еврей 12:29); Нүгэлд хилэгнэсэн

Түүний уурын гал нүгэл үйлдэгчдийг нүгэлт байдалд нь амьд чигээр нь орхихгүй харин сүйрүүлэх болно. Бурхан, Вавилоны гарт байсан Израйлын гарт байсан өөрийн хүмүүсийг шүүсэн өмнөх шүүлтийн үеэр жехенна нь Бурханы хүмүүсийн дундах нүгэл үйлдэгчдийн үхсэн биесээр дүүрсэн байлаа. (Иер.7:32,37)

Эзэн Есүс 'жехенна' үгийг хэрэглэхдээ хуучин гэрээний бүх санаануудыг Өөрийн чадварлаг аргаар нэгтгэнсэн юм. Бурхан эргэж ирэхдээ шүүлтийн ширээнд гологдсон хүмүүс нь "Унтрашгүй галтай Жеханнад (өөрөөр хэлбэл 'там') өт хорхой нь үхэхгүй, гал нь унтрахгүй" газар руу явна(Марк 9:43-44). Жехенна нь еврей нарын толгойд биеийн гологдол ба сүйрлийн санааг төрүүлсэн нь дамжиггүй. Бид нүглийн эсрэг Бурханы хилэгнэл болон нүгэл үйлдэгчдийг үхлээр дамжуулан бүрэн устгадаг гэсэн санааг мөнхийн галаар төлөөлүүлэн үздэг болохыг мэдлээ.

"Өт нь үхдэггүй" тэр газар бүрэн сүйрлийн энэ өвөрмөц хэллэгийн нэг хэсэг нь юм. Хэзээ ч үхэшгүй өт байх нь боломжгүй хэрэг. Жехенна нь Бурханы хүмүүсийн дундаас хорон муу хүмүүсийг түүрүүнд нь шийтгэдэг газар байсан баримт нь Жехенныг Христ цаашид хэрэглэх хандлагатай болсныг харуулж байна.

ХИЧЭЭЛ 4: Асуултууд

1. Үхлийн дараа юу болох вэ?
 - a) Сэтгэл Тэнгэр уруу явна.
 - b) Бид ухамсаргүй болно.
 - c) Сэтгэл шүүлт болтол хаа нэг газар хадгалагдна.
 - d) Хорон муу сэтгэлүүд там уруу явж сайнууд нь Тэнгэр уруу очно.

2. Сэтгэл гэж юу вэ?
 - a) Бидний оршин байхын үхэшгүй хэсэг.
 - b) 'бие, хүн, бүтээл' гэсэн утгатай үг.
 - c) Сүнс гэдэгтэй яг адил утгатай.
 - d) Үхлийн дараа Тэнгэр уруу эсвэл там уруу очдог ямар нэг зүйл.

3. Үхэл нь ухамсаргүйн орон мөн үү?
 - a) Тийм.
 - b) Үгүй

4. Там гэж юу вэ?
 - a) Хорон муу хүмүүсийн байх газар.
 - b) Энэ амьдралын зовлон.
 - c) Үхэгсэдийн орон.

5.1 Хаанчлалыг тодорхойлох нь

Бидний өмнөх хичээлүүд нь Христийг эргэн ирэхэд Өөрийн үнэнч хүмүүсээ мөнхийн амьдралаар шагнах нь Бурханы зорилго болохыг харуулж байна. Мөнхийн амьдралыг газар дэлхий дээр эдэлнэ; Бурхан удаа дараа давтсан амлалтууд үнэнч хүмүүс тэнгэр уруу явах тухай санаа байгаагүй. “Бурханы хаанчлалын сайн мэдээ” (Матай 4:23)-т Абрахамд газар дэлхий дээрх мөнхийн амьдралын талаархи Бурханы амлалтуудтай холбоотой ирсэн (Гал.3:8). Хэдийгээр Бурхан Өөрийн бүхий л бүтээлүүдийн Хаан нь одоо ч хэвээрээ боловч Тэр хүнд дэлхийг мөн өөрийн амьдралаа хүссэнээрээ удирдах эрхийг өгсөн. Энэ нь өнөө үед дэлхий “хүн төрөлхтөний хаанчлал” (Дан. 4:17) гэсэн утгыг илэрхийлнэ.

Христийн эргэн ирээд “ертөнцийн хаанчлал нь бидний Эзэний болон Түүний Христийн хаанчлал болсон. Тэр үеийн үед хаанчилна” (Илчлэлт 11:15). Тэгээд Бурханы хүсэл болон таалал дэлхий дээр бүрэн нээлттэйгээр хэрэгжинэ. Иймд Есүс бидэнд мөргөх тушаал өгсөн: “Таны хаанчлал ирэх болтугай. Хүсэл тань тэнгэрт шигээ газар дээр биелэгдэх болтугай” (Матай 6:10). Иймийн учир “Бурханы хаанчлал” гэсэн үг нь “Тэнгэрийн хаанчлал” (Матай 13:11, Марк 4:11) гэсэнтэй уялдаа холбоотой. Бид хэзээ ч “тэнгэр дэх хаанчлал” гэж уншиж байгаагүй. Энэ нь Христийг эргэж ирэхэд газар дээр түүний байгуулах тэнгэрийн хаанчлал юм. Бурханы хүслийг тэнгэр элч нар тэнгэрт бүрэн даган биелүүлдэг (Дуулал 103:19-21) тул энэ нь ирээдүйн Бурханы хаанчлалд мөн биелж, газар дэлхий зөвхөн зөв сайнуудад өвлөгдөхөд тэд “тэнгэрийн элч нартай адил” байх болно. (Лук 20:36)

Христийг эргэн ирэхэд Бурханы хаанчлалд орох нь энэ амьдралын бүх Христич нарын зорилгын эцсийн үр дүн юм. (Матай 25:34; Үйлс 14:22); Мөн энэ тухай зөв ойлголттой байх нь туйлын чухал юм. Филлиппойн “Христ”-н номлол “Бурханы хаанчлал ба Есүс Христын нэрийн тухай зүйлс” (Үйлс 8:5,12) – гзаасан хичээл гэж тодорхойлогддог. Ишлэл ишлэлээрээ энэ нь “Бурханы хаанчлал ” хэрхэн Паулын номлолын гол санаа зовоосон зүйл байсанг санагдуулна. (Үйлс 19:8; 20:25; 28:23,31). Иймд Бурханы хаанчлалын тухай үзлийг бид бүрэн төгс

106 БУРХАН

ойлгохын ач холбогдол нь Сайн мэдээний гол хэсгүүдийг бүрдүүлнэ.

“Бид олон зовлон туулж байж Бурханы хаанчлалд орох ёстой” (Үйлс 14:22). Энэ нь амьдралын хонгилын үзүүр дэх гэрэл учраас жинхэнэ Христич амьдралд хамаарах золиосуудыг бий болгох хүчин зүйл болно. Вавилоны хаан Небухаднезар дэлхийн ирээдүйг мэдэхийг хүсдэг байжээ. (Дан.2). Тэрээр янз бүрийн металл бодисоор хийсэн аугаа хөшөөг зүүдлэв. Даниел алтан толгойг Вавилоны хаан юм гэж буулгаж хэлжээ. (Дан 2:38). Түүний дараа Израйлыг тойроод гол гол эзэн хаадуудын үе залгамжлагчид ирэх ба нөхцөл байдлыг дүгнэхэд “хөлийн хуруунуудын нэг хэсэг нь төмөр, нөгөө хэсэг нь шавар байсны адил тэр хаанчлалын зарим хэсэг нь хүчтэй байх атал нөгөө хэсэг нь хэврэг байх болно” (Дан. 2:42).

Өнөөгийн дэлхий дээрх эрх мэдлийн хуваарилалт олон үндэстнүүдийн дунд тархсан ба зарим нь хүчтэй зарим нь сул дорой байна. Даниел хөлөн дээр цохисон жижиг чулууг харсан бөгөөд энэ чулуу нь бүх л дэлхийг дүүргэх аугаа том уул болон өсөх аж. (Дан. 2:34,35). Энэ чулуу нь Есүсийг дүрсэлжээ. (Матай 21:42; Үйлс 4:11; Ефес 2:20; 1Петр 2:4-8). Түүний газар дэлхийг бүрхэхээр бүтээх “уул” нь хоёр дахь ирэлтээрээ байгуулах үүрд мөнхийн Бурханы хаанчлал юм. Энэ эш үзүүлэлэг нь хаанчлал тэнгэрт бус газарт байхыг нотолсон хэрэг юм.

Хаанчлал нь Христийн эргэн ирэх үед л бүрэн дүүрэн бодиттой байгуулагдахыг бусад ишлэлүүдэд өгүүлсэн. Паул Есүсийг “Бурханы хаанчлал, түүний үзэгдэлт”-эд (2 Тим.4:1) үхсэн хийгээд амьд болгоныг шүүх тухай ярьдаг. Мика 4:1 нь Бурханы хаанчлалыг том уул байхтай адилтгасан Даниелын санааг “Эцсийн өдрүүдэд Эзэний өргөөний уул нь уулсын тэргүүнээр тохоогдон толгодын дээгүүр өргөгдөнө.” гэж дараа нь энэхүү хаанчлал газар дэлхий дээр ямар байхыг дүрсэлсэн дүрслэл байдаг. (Мика 4:1-4). Бурхан Есүст Иерусалим хотод Давидын ширээг өгнө: “Тэр үүрд хаанчлах бөгөөд Түүний хаанчлалд төгсгөл байхгүй” (Лук 1:32,33). Энэ нь Есүс Давидын сэнтийнд заларч эхлэх ба Түүний хаанчлал эхлэх тийм тодорхой цаг үе бий гэдэг нь зайлшгүй. Энэ үе нь Христийн эргэж ирэх үе юм. “Түүний хаанчлалд төгсгөл байхгүй” гэсэн нь (Дан. 2:44)-н “ Тэнгэрийн Бурхан хаадын үед хэзээ ч усташгүй нэг хаанчлалыг байгуулах бөгөөд тэр хаанчлалын эрх мэдэл нь бусад ард түмний гарт

орохгүй” –тэй холбогдоно. Илчлэлт 11:15 нь хэрхэн хоёр дахь ирэлтийг дүрслэхдээ адилхан хэлийг хэрэглэсэн: “Ертөнцийн хаанчлал нь бидний Эзэний болон Түүний Христийн хаанчлал болсон. Тэр үеийн үед хаанчилна”. Дахин дурдахад Христийн хаанчлал болон ноёрхол газар дэлхий дээр ирэх тодорхой цаг байгаа: тэр нь Түүний эргэх ирэлт юм.

5.2 Хаанчлал одоогоор байгуулагдаагүй байгаа

Бурханы хаанчлал нь одоогийн итгэгч нар- ‘сүм’ –ээр бүрдэж бүрэн оршин тогтнож байна гэсэн ойлголт өргөн дэлгэр байна. Жинхэнэ итгэгч нар ‘аврагдаж’ Хаанчлалд чухал байр суурьтай болсон байхад Христ түүнийг байгуулахаар хараахан эргэж ирээгүй байгаа учир бид Хаанчлалд бүрэн орж чадаагүй гэдэг талаар эргэлзэх юм байхгүй.

Одоогоор бидний суралцаад байгаа зүйлээс “махан бие ба цус Бурханы хаанчлалыг өвлөж чадаагүй” (1 Кор.15:50) нь тодорхой болсон бизээ. Баптисм бид нарыг Абрахамд өгсөн амлалтуудыг өвлөн авагч болгосон учир бид нар “өөрийг нь хайрлагсдад амласан хаанчлалыг өвлөгчид” (Иаков 2:5). Абрахамд өгсөн амлалтууд нь хаанчлалын гол Сайн мэдээг хамарч байгаа юм. (Мат.4:23, Гал.3:8, 27-29). Иймээс Абрахамд өгсөн амлалтуудыг биелүүлэх үед Христийг эргэн ирэхэд хаанчлалыг өвлөн авна гэсэн амлалтууд нийтлэг гарч байна. (Мат.25:34;1Кор 6:9,10; 15:50, Гал.5:21, Ефес 5:5). Ирээдүйн өвлөлтийн тухай хэлийг хэрэглэсэн нь :хаанчлал бол -итгэгчдийн одоогийн эзэмшил биш гэдгийг харуулж байна.

“Бурханы хаанчлал тэр даруй бий болгох ёстой” гэж бодож байгаа хүмүүсийг Есүс засахын тулд нэгэн сургаалт зүйлрлэл хэлжээ.“Нэгэн сурвалжит хүн хаанчлалыг хүлээж аваад буцаж ирэхээр алс холын оронг зорьжээ. Тэр хугацаанд тэрээр ажил хэргээ албат нартаа даалган үлдээжээ. Мөнөөх хүн хаанчлалаа хүлээж авсны дараа буцаж ирэв. Тэгээд мөнгө өгсөн боолууд нь ямар ажил эрхлэн явуулсныг мэдэхээр дуудуулж гэнэ”(Лук 19:11-27).

108 БУРХАН

Тэрхүү сурвалжит хүн нь тэнгэрийн 'алс хол орон' уруу хаанчлалыг хүлээж авахаар явж хаанчлалтай шүүлтийн цагт өөрөөр хэлбэл хоёр дахь ирэлтээр эргэн ирэх Христийг төлөөлж буй юм. Тэгэхээр "албат боол" нар Эзнээ эзгүй үед одоо хаанчлалыг өмчлөх боломжгүй юм.

Үүний нотолгоо нь дараах болно:-

- "Миний хаанчлал бол энэ ертөнцийнх бишээ" гэж Есүс тодорхой хэлсэн (Иохан 18:36). Гэвч тухайн үед хүртэл Тэр "Би Хаан байна" (Иохан 18:37) гэж хэлж чадаж байсан. Энэ
- нь Христийн одоогийн "хаанчлал" нь түүний хаанчлалыг тогтоосон гэсэн үг биш юм. Тэр ч байтугай 1-р зууны үнэнч хүмүүс "Бурханы хаанчлалыг" (Мика 15:43) ХҮЛЭЭСЭЭР байгаагаар дүрслэгддэг.
- Христ өөрийн дагалдагч нартаа Тэрээр дахин хэзээ ч "Эцгийнхээ хаанчлалд дахин шинээр уух өдрийг хүртэл" (Матай 26:29) дарс уухгүй гэж хэлсэн. Энэ нь ба хүмүүс хэрхэн Христийн "Бурханы хаанчлалын сайхан зүйлсийн (өөрөөр хэлбэл дээд тунхаглал) "(Лук 8:1) тухай номлолыг ойлгож байгаагаар хаанчлал ирээдүйд байхыг тодорхой харуулж байна. "Бурханы хаанчлалд (ирээдүйд) талх идэх хүн бүр ерөөлтөй өө" (Лук 14:15) нь тэдний тайлбар байв.
- Лук 22:29,30 –д энэ сэдвийг үргэлжлүүлсэн: "Би та нарт хаанчлалыг өгнө, та нар миний хаанчлалд миний ширээнээ идэж ууна".
- Есүс өөрийн хоёр дахь ирэлтийн шинжийг зөгнөсөн тэмдэгийг тайлбарлан дүгнэхдээ "Та нар ч гэсэн эдгээр зүйлс болохыг хараад Бурханы хаанчлал ойрхон байгааг мэдэгтүн" (Лук 21:31) гэжээ. Хэрэв хаанчлал түүний хоёр дахь ирэлтээс өмнө оршвол утга учиргүй юм.
- "Бид олон зовлон туулж байж Бурханы хаанчлалд орох ёстой" (Үйлс 14:22). Зовон шаналагч итгэгч бүр хаанчлалыг ирэхийг үнэн сэтгэлээсээ мөргөдөг нь гайхах зүйлгүй (Матай 6:10).
- Бурхан "Өөрийнхөө хаанчлалд дууддаг"(1Тес.2:12); хариуд нь бид тэрхүү хаанчлалд орох үүдийг одоо

сүнслэг амьдралаар *эрэлхийлэн хайх* хэрэгтэй.(Матай 6:33).

5.3 Өнгөрсөн үе дэх Бурханы хаанчлал

Бурханы Хаанчлал бол ирээдүйд итгэгчидэд өгөх шагнал юм. Байдал иймийн учир тэд үүнийг хүртэхийн тулд Христийн үлгэр жишээг дагасан амьдралаар амьдрах учиртай. Энэ нь богино хугацаанд зовох, тавгүй байдалдтай учирана гэсэн үг юм. Иймээс тэрхүү ирээдүй цагийн гайхамшигийг улам гүнзгий ойлгох гэсэн тэдний хүсэл бүх л өдрүүдэд нь улам л нэмэгдсээр байх учиртай билээ. Энэ нь тэдний сүнслэг эрмэлзлэлийн хураангуй, өөрсдийн Эцэг хэмээн хайрлаж ирсэн Бурханыг бүрэн тунхагласан хэрэг болно.

Хаанчлал ямар байхыг Сударт дэлгэрэнгүй өгүүлдэг. Та амьдралынхаа хугацаанд түүнээс цөөхөн хэдийг л олж мэдэж амжина. Энэхүү ирээдүйн Хааачлалын гол зарчимуудын заримыг ойлгох нэг зам бол Бурханы Хаанчлал өнгөрсөн үед, Израиль үндэстний хэлбрээр оршиж байсан гэдгийг хүлээн зөвшөөрсөн явдал юм. Энэ Хаанчлал Христийн эргэж ирэхэд дахин тогтох ёстой юм. Бурханы ирээдүйн Хаанчлал хэрхэн зохион байгуулагдах талаар бидэнд ерөн хэмжээний ойлголт өгөхийн тулд Библийн нилээд хэсэгт Израиль үндэстний талаар мэдээлэл өгдөг.

Бурханыг ихэвчлэн “Израильын Хаан” хэмээн дүрсэлсэн байдаг /Иса. 44:6, Иса.41:27, 43:15, Дуулал 48:2, 89:18, 149:2/. Ингэхээр Израильын хүмүүс нь Түүний хаанчлал байжээ. Тэд Египтээс Улаан Тэнгисээр дамжин зугтан гарсаныхаа дараахан Бурхантай Синай Ууланд гэрээ байгуулах замаар Бурханы Хаанчлал болж эхэлсэн юм. Тэд энэ гэрээг хадгалах дуртай байсны хариу болгож тэд “хаанчлалд байж...ариун үндэстэн байж” болох болов /Египтээс гарсан нь 19:5,6/. Ингэхээр “Израил Египтээс гарахад...Израиль ч түүний эзэмшил болсон билээ” /Дуулал 114:1,2/.

Израиль энэ гэрээнд орсон дараа Синайн зэрлэг нутгаар аялаж амлагдсан Канааны газарт суурьштв. Бурхан тэдний Хаан байсан учир тэднийг хаад биш “Шүүгчид” /өөрөөр хэлбэл Гидеон, Саисон нар/ захиран суужээ. Эдгээр шүүгчид хаад биш байсан ба бүхэл

110 БУРХАН

бүтэн газрыг захирхаасаа илүүтэй улс орны тодорхой хэсгийг захирсан, Тэнгэрээр залуулсан захирагчид байлаа. Тэднийг Бурхан тусгай зорилгоор, өөрөөр хэлбэл Израильыг гэмшихэд хүргэж тэднийг дайснуудаас аврахын тулд буй болгожээ. Израильчууд шүүгч Гидеоныг хаанаа болохыг хүсэхэд тэрээр: “Би та нарыг захирахгүй...ЭЗЭН та нарыг захирана” гэж хэлжээ /Шүүгчид 8:23/.

Сүүлчийн шүүгч Самуел байлаа. Түүний үед Израильчууд эргэн тойрон дахь улс үндэстэнтэй адил байхын тулд хүнэн хаан гүйжээ. Түүхийн явцад Бурханы жинхэнэ хүмүүс Бурхантай ойр дотно харилцаатай байснаа дутуу үнэлэж, үүнийгээ өөрсдийн эргэн тойрон дахь дэлхийтэй ижил төстэй хаарагдахын төлөө золиослоход хүрч байв. Толгой иймэрхүүгээр эргэх явдал манай өнөөгийн дэлхийд хамгийн их хурцаар илэрч байна. Бурхан Самуелд харамсан өгүүлсэн нь: “Тэр өөрсдийг нь захирах хаан байхаас намайг эсэргүүцэж байгаа” гэжээ /1 Сам. 8:7/. Гэлээ ч гэсэн Бурхан тэдэнд хорон муу Саулаас эхлээд хаалыг өгчээ. Түүний дараагаар зөв сайн Давид хаан болж түүнээс хаадын бүхэл бүтэн үе гарч ирсэн юм. Илүү их сүнслэг оюун ухаантай хаад Бурханы хаанчлалыг эсэргүүцэж байсан ч Израиль Бурханы хаанчлал хэвээрээ гэдгийг ухаарчээ. Тэгэхээр тэд Израилийг өөрийн эрхийн дагуу биш Бурханын эрийн өмнөөс зарич байгааг мэджээ.

Энэ зарчмыг ойлгох нь Давидын хүү Соломоныг “Таны Бурхан Эзэний төлөө хаан байхын тулд /Бурханы/ сэнтийд” заларсаныг дүрсэлний утга санааг бидэнд тодорхой болгож байна /Шастирын дэд 9:8, Шастирын дээд. 28:5, 29:23/. Соломоны захиргааны үед агуу их энх амгалан, хөгжил цэцэглэлтэд хүрсэн нь ирээдүйн Бурханы Хаанчлал ийм болно /буюу “тийм төрлийн”/ гэснийг заасан хэрэг буюу. Тиймээс Соломоныг Бурханы өмнөөс Израилийн хаан байсныг онцлон тэмдэглэдэг. Үүнчлэн Есус Бурханы төлөө Израилийн Хаан болж Бурханы сэнтийд залрах болно /Матт 27:37,42, Иохан 1:49, 12:13/.

Бурханы Шүүлт

Соломон санаагаа хувиргасаны дараа Израилийн хаанчлал хоёр хэсэгт хуяагджээ: Соломоны хүү Рэхобоам Иуда, Бенжамин, Манассегийн овгийн хагасыг захирч, Жеробоам бусад арван омгийг захирчээ. Энэ арван овгийн хаанчлалыг Израиль, буюу

Ефраим хэмээн нэрлэж, хоёр овгийнхоныг Иуда хэмээн нэрэлжээ. Эдгээр бүх овгийн хүмүүс ихэнхдээ Соломоны муу жишээг дагаж, өөрсдийгөө жинхэнэ Бурханд итгэдэг гэжээ. Тэгсэн хирнээ эргэн тойрон дахь үндэстнүүдийн онгоныг шүтжээ. Бурхан зөнч хүмүүсээр дамжуулан тэднийг гэмшихийг удаа дараа гүйсан боловс тусыг олсонгүй. Үүнээс болж Бурхан тэднийг Израилийн хаанчлалаас хөөж тэдний дайснуудын газарлуу илгээж шийтгэл үзүүлэв. Үүнийг Ассириан ба Вавилонуудаар Израилийг эзлүүлж, амьдаар нь бариулах замаар гүйцэтгэв. ”” Харин та тэднийг олон жил хүлцэж, өөрийн сүнсээр, өөрийн эш үзүүлэгчидээхр дамжуулан ятгасан ч тэд чих тавьсангүй. Тиймийн учир та тэднийг /эргэн тойроны/ газрын ард түмнүүдийг гарт өгөв /Нех. 9:30/.

Израилийн арван овгийн хаанчлалд сайн хаан огт байсангүй. Жеробоам, Ахаб, Жехоахаз гэх мэт нь Хаадын номонд онгон-шүтэгчид гэж бичигдэн үлджээ. Тэдний сүүлчийн хаан Хошеа байсан ба түүний захиргааны үеэр Израиль Ассириад ялагдаж арван омог олзлогджээ /2 Хаад 17/. Тэд тэндээс хэзээч эргэж ирээгүй юм.

Иудагийн хоёр овогийн хаанчлал зарим нэг сайн хаантай байлаа / жишээлбэл Хезекиа ба Иосиа/. Гэхдээ ихэнх нь хорон муу байлаа. Хүмүүс нүгэлийг давтан хийж байсан тул Бурхан Иудаг тэдний сүүлчийн хаан Зедекиагийн захиргаанд Өөрийн хаанчлал болгон шилжүүлэв. Энэ нь тэднийг Вавилончуудаар эзлүүлэн ийм байдалд хүргэв. Вавилончууд тэднийг Вавилонруу олзлон аваачив /Хаадын дэд 25/. Тэд Вавилонд 70н жил болж, дараа нь зарим нь Израильруу Езра ба Нехемиагийн удирдлага дор эргэн иржээ. Тэд Вавилон, Грек,

Ромчуудад захриагдан хэзээ ч дахиж өөрсдийн хаантай болоогүй юм. Есус Ромын захиргааны үед төржээ. Израиль Есусыг хүлээж аваагүй учир Ромчууд тэднийг манай эрины 70 онд эзлэн авч дэлхий дахинаар тараажээ. Дөнгөж өнгөрсөн 100 жилд л тэд буцан ирж эхэлсэн нь Христийн эргэж ирэхийн тэмдэг болсон юм.

Езекиел 21:25-27 Бурханы Хаанчлалын энэ төгсгөлийг Израиль үндэстэнд харснаар зөгнөн хэлсэн юм: “Өдөр нь ирсэн Израилийн ноён болох хорон муу нэгэн, алагдсан нэгэн чи /өөрөөр хэлбэл Зедекиа/ ... Эзэн Бурхан ийнхүү айлдаж байна.

112 БУРХАН

Малгайг авч титмийг тайл. /өөрөөр хэлбэл Зедекиа хаан биш болно/. Энэ нь цаашид урьдынх шигээ байхгүй. ...Би түүнийг балгас, балгас, балгас болгоно. Үүнийг эзэмших эрхтэй нэгнийг ирэх хүртэл, тэр нь хойшид байхгүй бөгөөд Би түүнийг түүнд өгнө /Хос. 10:3, Иеремиагийн гашуудал 5:16, Иер. 14:21, Дан. 8:12-14/.

Ез. 21:25-27 –ийн гурван удаагийн түлхэн унагалт бол Вавилоны хаан Небухаднезар гурван удаа эзэлснийг хэлж байна. Ажигламтгай оюутнууд эдгээр ишлэлээс Бурханы хаанчлал ба түүний хаанд хэрхэн адил хандахын жишээг харах болно. Зедекиаг авч хаясан нь Бурханы хаанчлалыг авч хаясан хэрэг байлаа /5:2 Хэсгийг үг/. Ийнхүү Израиль үндэстэн дэх Бурханы хаанчлал төгөөв: “Би Израилийн гэрийн хаанчлалыг төгсгөх болно” /Хос. 1:4/. “...иртэл тэр нь хойшид байхгүй байх болно...” гэдэг нь “үүнийг эзэмших эрхтэй нэгэн ирнэ, тэгээд /Бурхан/ түүнд түүнийг өгнө” гэсэн утгатай юм /Лук. 1:32,33/. Энэ нт хаанчлалыг сэргээн босгох амлалтыг биелүүлэх үед болох юм.

Израилийг сэргээх

Бурхан хаанчлал *Аврагчыг буцаж ирэхэд сэргэх* талаар Хуучин Гэрээнд зөнчид маш ихээр өгүүлсэн байдаг. Христийн дагалдагчид үүнд сайн бэлтгэлтэй байгаа.”Тэгээд цуглагсад түүнээс ЭЗЭН энэ цагт Та Израильд хаанчлалыг мэргээх үү?” гэж асуув. “Езекиел одоо биелэгдэх үү?” Есүс хариулахдаа, түүний хоёрдахь ирэлтийг тэд хэзээ ч мэдэхгүй гэж айлдав. Гэвч түүнийг нэгэн үед эргэж ирнэ гэж тэр дараад нь авралын элч нар хүмүүст хэлжээ /Үйлс 1:6-11/.

Ингэхээр Бурхан/Израилийн хаанчлалыг хоёрдахь ирэлтэн дээр сэргээх юм. Ийнхүү Бурхан Есүс Христийг илгээнэ гэж Петер гэж номлож, “Та нарын төлөө томилогдсон Христ болох Есүсийг Тэр илгээх болно. Бурхан өөрийнхөө ариун иш үзүүлэгчидийн амаар эрт цагаас айлдсанчлан бүхнийг сэргээх үе хүртэл Түүнийг тэнгэр хүлээн авах ёстой юм” хэмээжээ/ Үйлс 3:20,21/. Хоёрдахт ирэлтээр Бурханы хаанчлалыг дахин тогтоож Израилийн Бурханы хаанчлалыг сэргээх нь “бүх /Бурханы/ ариун эш үзүүлэгчидийн жинхэнэ сэдэв юм.

- “Энэрэл хайраар нэгэн сэнтий босгогдож, Давидын майханд /хоёрдахь ирэлтээрээ/ шудрагаар шүүгч тэнд

сууна/Лук 1:32,33/. Тэр /Есүс/ шудрага үнэнийг хайж, зөв явдалд алгуурлахгүй /Иса. 16:5/.

- “Тэр өдөр Давидын /Лукын 1:32,33-ын Давидын сэнтий/ нурж унасан бүхээгийг Би босгож, түүний цөмөрхийнүүдийг шаван битүүлнэ. Мөн Би түүний балгасануудыг босгож, түүнийг эртний өдрүүдийнх шиг нь дахин байгуулна /Амос 9:11/. Сүүлчийн өгүүлбэр бол сэргээхийг ярьж байгаа нь илт.
- “Тэдний хүүхдүүд бас урьдынх шигээ байж, тэдний цуглаан миний өмнө тогтоогдох болно” /Иер. 30:20/.
- “Эзэн Иерусалимыг дахин сонгоно” /Зех. 2:12/. Тэгээд түүнийг дэлхий дахины Өөрийн хаанчлалын нийслэл болгоно.
- “Би Иуда болон Израилийн сайн сайхныг сэргээж, анх байсан шиг нь тэднийг дахин барьж босгоно...Дахин энэ газарт баяр хөөрийн дуу сонсогдоно. Би анх байсан шиг нь газар нутгийн сайн сайхныг сэргээнэ. ...энэ газарт /Иерусалим/...хоньчдын газар бий болно....мал сүргүүд дахин өнгөрөх болно /Иер. 33:17-20/.

Энэ Хаанчлалыг байгуулахаар Христ эргэн ирэх нь үнэнхээр “Израилийн найдвар” бөгөөд түүнд бид баптисмаар холбогдох ёстой.

5:4 Ирээдүйд Байх Бурханы Хаанчлал

Ирээдүйд ямаршүү Хаанчлал байхтай холбоотой нилээд мэдээлэл энэ хичээлийн 1,3-р хэсэгт бий. Абрахамд түүний Үрээр дамжуулж дэлхийн өнцөг булан бүрийн хүмүүс ивээгдэнэ гэж амалсаныг бид мэднэ. Ром 4:13-д энэ санааг өргөжүүлж бүх газар дэлхийг Абрахамын Үрэнд, өөрөөр хэлбэл Христ дэх хүмүүс өвлөн авна гэсэн утгыг гаргажээ. Дан 2 –т дүр төрхийн талаархи эш үзүүлэлтэд Христ хэрхэн жижигхэн чулуу болон эргэн ирж тэгээд хаанчлал аажимдаа дэлхий дахинд дэлгэрэх тухай тайлбарладаг /Дуулал 72:8/. Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл зарим нь ярьдагчилан Бурханы Хаанчлал зөвхөн Иерусалимд буюу

114 БУРХАН

Израилын газарт байрлахгүй юм. Гэхдээ эдгээр газар нутаг түүний төв хэсэг байх нь мэдээж.

Энэ амьдралдаа Христийг дагагчид “хаан ба тахилчид” болж “бид дэлхий дээр хаанчлах болно” /Илчлэлт 5:10/. Бид янз бүрийн хэмжээтэй, янз бүрийн

тоотой суурингуудыг захирах болно. Нэг нь 10 гаруй хот, нөгөө нь 5-аас тлүү хотыг захирана /Лук 19:17/. Христ дэлхийн хаанчлалаа бидэнтэй хуваах болно /Илч. 2:27, 2 Тим. 2:12/. “Хаан нь үнэн зөвөөр хаанчлал, ноёд нь /итгэгчид/ шудрагаар захирана” /Иса. 32:1, Дуулал 45:16/.

Христ нь Давидын дахин тогтоогдсон хаан ширээнд үүрд суух ёстой /Лук 1:32,33/. Өөрөөр хэлбэл Тэрээр Иерусалимд байсан Давидын хаанчлалын газар, байр суурийг авах юм. Нэгэнт Христ Иерусалимаас захиргаагаа явуулах учир энэ нь ирээдүйн Хаанчлалын нийслэл болох юм. Чухам энэ нутаг дэвсгэрт сүм баригдах юм /Езе. 40-48/. Дэлхий дахинд янз бүрийн газарт хүмүүс Бурханыг магтан байх зуур /Мат. 1:11/ энэ сүм нь дэлхийн мөргөлийн гол газар болох юм. “Бүх үндэстнүүдийн үлдсэн болгон нь түмэн цэргийн эзэн болох хаанд мөргөхөөр, майхан Баярыг тэмдэглэхээр жилээс жилд ирэх болно” /Зех. 14:16/.

Иерусалимд хийх жил бүрийн энэ мөргөлийг Иса. 2:2,3-т эш үзүүлэн өгүүлэхдээ: “ Эцсийн өдрүүдэд Эзний өргөөний уул нь / Даниел 2:35,44-д хаанчлал / уулсын тэргүүнээр тохогдон / өөрөөр хэлбэл Бурханы хаанчлал ба сүм нь хүн төрлөхтний хаанчлалын дээр сүндэрлэнэ/...Бүх үндэстнүүд түүн уруу цутгана. Олон ард түмнүүд ирээд ‘Нааширцгаа, ЭЗЭН-ий уулруу, Иаковын Бурханы өргөөрүү явцгаая. Тэрээр бидэнд Өөрийн замыг зааж өгнө...Учир нь хууль Сионоос гарч, ЭЗЭН-ий үг Иерусалимаас гарна” гэжээ. Энэ нь Хаанчлалын эртний өдрүүдийн зураглал болж буй хүмүүс Христийн хаанчлалын талаар мэдээг бусдад тарааж тэд Бурханы Хаанчлалын “уул” өөд мацах ба энэ хаанчлал аажмаар дэлхийд түгэх болно. Энд шашин шүтлэгт жинхэнэ сонирхож буйн зураглал харагдаж байна.

Манай үеийн хүмүүсийн хамгийн том эмэгнэлүүдийн нэг бол ихэнх хүмүүс Бурханыг өөрсдийн Эцэг, Бүтээгч гэж жинхэнэ ойлгосоны үндсэн дээр биш, улс төр, нийгэм, соёл, сэтгэлийн

хөдөлгөөн зэрэг шалтгаанаар шүтдэг. Хаанчлалд Бурханы замуудыг мэдэх сонирхол дэлхий дахинаар гарч ирнэ. Хүмүүс Бурханы талаар илүү мэдлэг авах гэсэн хүсэл эрмэлзлэлдээ хөтлөгдөн дэлхийн өнцөг булан бүрээс Иерусалимруу аялах болно.

Хүний хуулийн системүүд болон шүүхийн засаглалаас үүсэх, будлиантай, шудрага бус явдлуудын оронд Иерусалимаас Христийн тунхаглах “хууль” ба ЭЗЭН гэдэг хууль зүйн нэг журам дэлхий дахинд буй болно. Сургааль номлолд зааж байгаа “Бүх үндэстэн түүн уруу урсана” гэдгийн учир утга нь гэвэл, Бурханы талаар жинхэнэ мэдлэг олж авах гэсэн нийтээр эрмэлзэх нь энэ амьдралдаа ийм мэдлэг олж авахын төлөө тэиүүлэгч хувь хүмүүсийн зөрчилдөөнийг багасгадаг шиг үндэстнүүдийн хоорон дахь төрлөхийн сөргөлдөөнийг багасгана гэсэн үг юм.

Бүх үндэстнийг Иерусалимруу урсаж байгаагаар дүрсэлсэн нь Еврей нар Еврей бус хүмүүстэй Иерусалимд Бурханд мөргөхөөр “хамтран урсаж” явна гэж Иса. 60:5-д өгүүлсэнтэй ижил юм. Энэ нь Зех. 8:20-23-дахь Хаанчлалын тухай зөгнөн хэлсэнтэй сайн таарч байгаа билээ.

“Ард түмнүүд, тэр ч байтугай олон хотуудын оршин суугчид ирнэ. Нэгнийх нь оршин суугчид нөгөөдөө очиж `ЭЗЭН-ий тааллыг гуйхаар, түмэн цэргийн ЭЗЭН-ийг хайхаар бүгд хамт тасралтгүй / Зех. 14:16-д `жилээс жилд` гэжээ/ явцгаая. Би бас явна` гэнэ. Асар олон ард түмнүүд, хүчирхэг үндэстнүүд Иерусалимд түмэн цэргийн ЭЗЭН-ийг хайхаар ЭЗЭН-ий тааллыг гуйхаар ирнэ...бүх үндэстэнүүдээс арван хүн нэг иудей хүний хувцаснаас зууран `Биднийг өөртэйгөө хамт явуулаач. Бурхан чамтай хамт байгааг бид сонслоо` гэх болно”.

Энэ нь Еврей хүмүүсийг гэмшиж, дуулгавартай болсонд үндэстнүүдийн “толгой ба сүүл” болгосон тухай зураглалыг буй болгож байна Дэд хууль 28:13/. Авралын талаархи Бурханы төлөвлөгөөг ингэхэд хүн бүр ойлгох болно. Орчин үеийн Христич дундахь үйл ойшоох байдлыг огцом төгсгөх болно. Хүмүүс тэгэхээр эдгээр юмсыг хэлэлцэхдээ урамтай байх бөгөөд тэгээд Еврей нарт “Бурхан та нартай гэдгийг сонссон” гэж хэлэх юм. Хүмүүс тэгээд дэлхийн одоогийн бодлыг дүүргэж буй үл бүтэх хий үзэгдлийн тухай биш сүнслэг юмсын тухай ярих болно.

116 БУРХАН

Бурханд ихээр үнэнч байгаа нөхцөлд Христ "...үндэстнүүдийн хоорондохийг шүүж...тэд илдээ анжисны хошуу, жадаа хадуур болгон давтана. Үндэстэн үндэстнийхээ эсрэг илд далайхгүй бөгөөд дахин хэзээ ч тэд дайтахад суралцахгүй" /Иса. 2:4/ гэсэнд гайхах явдалгүй юм. Христийн туйлын их эрх мэдэл, маргааныг бүрэн шудрага шүүсний ачаар үндэстнүүд уриалгахан гэгч нь хүнд зэвсгээ хөдөө аж ахуйн машин техник болгон хувиргаж цэргийн бүх сургуулилтаа орхих юм. "Түүний өдрүүдэд зөв шудрага хүн цэцэглэж" /Дуулал 72:7/ тэгээд сүнслэг чанарыг дээдэлж, Бурханы хайр, ивээл, шудрага ёс, гэм мэт шинж чанаруудыг тусгасан хүмүүст хүндэтгэл ирэх

болно. Бардам загнах, биеэ тоох, амиа бодон илүүг хүсэх зэргийг дээгүүр тавьж байгаа одоогийн байдал дээрхийн эсрэг зүйл юм. "Илдээ анжис болгон" давтах явдал энэ дэлхийд ирээдүйд болох хөдөө аж ахуйн агуу их өөрчилөлтүүдийн нэг хэсэг нь болох юм. Адамын нүгэл үйлдсэнд түүний өөрийнх нь төлөө газрыг хараасан /Эхлэл 3:17-19/ учраас одоо тэндээс хоол хүнс олж авахын тулд их хүч чармайлт гаргах хэрэгтэй болжээ. Хаанчлалд " /Нэгэн цагт үр шимгүй байсан/ Уулын оргил дээрх газарт үр тариа элбэг дэлбэг байх болтугай. Түүний үр жимс Ливан /Ливаны үр тариа/ шиг найгана" /Дуулал 72:16/. "Газар хагалагч нь хураагч хүнд, усан үзмийн худалдаачин үр таригч хүнд ойртох үед уулс амтат дарсыг дуслуулж, бүх толгод алга болно /Амос 9:13/. Газрын сайжирсан үржил шим тийм болох бөгөөд Еденд газарт хэлсэн хараал багасах юм.

Хөдөө аж ахуйн ийм агуу их үйлдвэрлэлд олон хүн оролцоно. Хаанчлалын эш үзүүлэлтүүдээс хүмүүс хөдөө аж ахуйн бие даасан хэв шинжрүү буцаж орно гэдэг сэтгэгдэл төрж байна.:-

"Өөрсдийг нь айлгах ямар ч хүнгүйгээр тэдний хүн тус бүр нь өөрийн усан үзмийн болон инжрийн модны доор сууна" /Мик. 4:4/.

Бие даасан байдал нь мөнгөний төлөө хөдөлмөрийг хөлслөх аливаа системд байдаг зүй бус явдлуудыг давж гарах болно. Бусдыг баян болгох гэж ажиллаж амьдралаа өнгөрөөх нь өнгөрсөн үеийн явдал болж үлдэнэ.

"Тэд гэр барьж, түүн дотроо сууна. Тэд бас усан үзэм тариалж, үр жимсийг нь иднэ. Тэд барихгүй,

өөр хүн сууна. Тэд тарихгүй, бусад нь иднэ....Миний сонгосон хүмүүс өөрсдийнхөө гараар бүтээснийг эдлэх болно. Тэд дэмий хоосон ажиллахгүй...” /Иса. 65:21-23/.

Үржил шимгүй газар хэрхэн өөрчлөгдөж түүн дээр ажиллаж байгаа хүмүүсийн амьдрал амар, сүнслэг болж, баяр баясгалан бараг газраас нэвчин манан мэт тархаж наран мэт гийгүүлсэн тухай зүйрлэшгүй эш үзүүлэлт Исаиг 35:1-7-д өгүүлсэн байжээ. “Зэлүүд газар цөл баярлан...замар цэцэг мэт дэлгэрнэ. Энэ нь машинд улам дэлгэрч цэнгэн баясаж дуулалдана...цөлөөс ус гарч...цангасан газарт ус ундарна” Тэр ч байтугай амьдатын хоорондох төрөлхийн түрэмгий байдал алга болно. “Чоно хургатай хамт бэлчиж. Хүүхдүүд могойтой тоглох болно” (Иса.65:25, 11:6-8).

Мөн энэчлэн байгалийн бүтээгдэхүүнд буулгасан хараал ихээхэн багасах ба хүн төрөлхтөнд буулгасан хараал ч мөн багасна. Илчлэлт 20:2,3-т билэг тэмдгийн хэлээр , Мянганы үеэр муу сүнс (нүгэл ба түүний нөлөө) “хүлэгдэх” буюу хязгаарлагдаж байгаагаар өгүүлжээ. Наслалт уртасч, зуун настайдаа үхсэн хүнийг хүүхэд гэж тооцох аж. (Иса.65:20). Эмэгтэйчүүд хүүхэд төрүүлэхдээ бага зовно. (Иса. 65:23). “Тэгээд сохрын нүд нээгдэж, дүлийгийн чих нь онгойно. Доголон хүн буга мэт дүүлж, хэлгүй нь баяртайгаар хашхирна.” (Иса.35:5,6).Гайхамшигт Сүнсэн бэлгүүд дахин амилснаар ийм юм болно. (Еврей 6:5).

Бурханы Хаанчлалыг үзэсгэлэнт байгальд наранд шараад зугаацаж байгаа хүмүүс шиг зөв сайнууд нь цэнгэн хөгжилдөх халуун орны арал дээрх диваажин мэт үзэж болохгүй гэж тун хэтэрхий хатуу цохон тэмдэглэж болохгүй юм. Бурханы Хаанчлалын үнгдсэн зорилго бол газар дэлхий “далай усаар дүүрэн” (Хаб 2:14) шиг Бурханыг яруу алдраар дүүртэл Түүнд яруу алдар өгөх явдал юм. Энэ бол Бурханы эцсийн зорилго юм. “Өөрийнхөө амьд буйгаар тангараглая. Бүх дэлхий Эзэний яруу алдраар дүүрэх болно” (Тоол. 14:21). Бурханд яруу алдар дүүргэнэ гэдэг нь газар дэлхийн оршин суугчид Түүний зөв сайн чанаруудыг ойлгож, үнэлж, магтан дуурайна гэсэн үг. Бурхан биед дэлхийг үүнийг тусгахад бас туслана. Ингэснээр амархан амьдралд жаргах биш “даруу хүн газар нутгийг (Хаанчлалд) өвлөж, элбэг (сүнслэг) амар амаглангаар баярлана” (Дуулал

118 БУРХАН

37:11). Хаанчлалд “зөв байдлын төлөө өлсөж цангагч хүмүүс... хангалуун болох болно” (Мат.5:6).

Хаанчлалд мөнхийн амьдрал эзэмших бодлыг, хүмүүсийн сонирхолыг Христын шүтлэг уруу татах “өгөөш” болгож ихэвчлэн ашигладаг. Гэвч тийм амьдралыг эзэмших нь биднийг Хаанчлалд байх жинхэнэ шалтгаантай бараг ижил төстөй юм. Энэ шалтгаан бол Бурханыг алдаршуулахын тулд билээ. Бадтисмын дараа бидэнд ямар цаг үлдэнэ вэ тэр хугацаанд түүнийг үргэлжлүүлэн хүндэтгэсээр явах ёстой. Зохиогчийн хувьд Бурхантай туйлын төгс байдал, сайн ухамсарын баяр дунд аравхан жил амьдарна гэдэг амьдралдаа учирсан бүх л хохирлыг нөхсөн хэрэг болно. Энэрүү яруу алдарт байдал үүрд үргэлжилнэ гэдэг нь Бидний ухааныг хүний ойлголтын хязгаараас тэлж өгч байгаа юм.

Арай илүү биет хэлбэрээр авч үзвэл Бурханы Хаанчлалд байх нь бидний дээд зэргийн урам зориг байх ёстой ба ашигтай давуу талууд болон

материализмыг таягдаж хаях юм. Ойрын ирээдүйгээ хэт их бодохын оронд дараахь зөвөлгөөг Есүс өгчээ: “Бурханы Хаанчлал болон түүний зөв чанарыг хаягтун. Тэгвэл энэ бүхнийг та натр нэмж өгөх болно” (Мат.6:30-34). Бидний одоо төсөөлж, олж авах гэж хүсэжболох бүхнийг Бурханы Хаанчлалд байх гэсэн хүсэл эцсийнэцэст хэрэгжих явдалдтай зүйрлэшгүй юм.

Бид “(Бурханы) зөвийг” эрэлхийлэх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл Бурханы шинж төрхийг хайрлаж сурахыг оролдох хэрэгтэй. Энэ нь юугэсэн үг вэ гэвэл бид Бурханы Хаанчлалд байхыг хүснэ гэсэн үг юм. Яагаад гэвэл зөв сайн явдал тэнд алдаршина. Яагаад гэвэл бид зөвхөн үхлээс зугтаж үүрд мөнх хялбар амьдралаар амьдрахыг хувьдаа хүсэхээс илүүтэй ёс суртахууны хувьд бүрэн төгс байхыг хүсэж байгаа юм.

Сайн мэдээний найдварыг хүний хувиа бодох тал уруу хандлагатай тайлбарласан байдаг. Бидний Хаанчлалд байх гэсэн хүсэл өдрөөс өдөрт ихээхэн ялгавартай байдаг. Энд бид туйлын зорилгын тухай санал болгож байна:Манай эн тэргүүний зорилт бол Сайнмэдээг сурч мэдэж Бурханд хайрын сэтгэлээр дуулгавартай байх үүднээс бадтисм дотор Сайн Мэдээнд даган орохоо харуулах явдал юм. Бурханы санал болгож байгаа найдварыг бид ойлгон үнэлж, Хаанчлалд байхыг хүсэх бидний

нарийн нягт шалтгаанууд биднийг баптисм хүртэсний дараа өсөн дэлгэрч хөгжих болно.

5.5 Мянган

Хаанчлал дахь амьдралыг сурж мэдэж буй энэ үед ухаалаг уншигч ингэж асууж магадгүй: 'Бурханы Хаанчлалын энэ зураглал бүгд хүнийхтэй адил биш харагдаж байна гэж үү?' Хаанчлал доторхи хүмүүс үр хүүхэд төрүүлж (Иса.65:23), тэр ч байтугай үхэх болно. (Иса.65:20). Эдгээр хүмүүст маргаан хэрүүл байх ба түүнийг нь Христ зохицуулна (Иса. 2:4). Тэдэнд амь зуухын тулд газар боловсруулах хэрэгцээ хэвээр байна. Гэхдээ тэр нь одооныхоос хамаагүй амар байх юм. Зөв сайн нь мөнхийнамыдралтай болж, Бурханы шиг шинж төлөвтэй болж Тэнгэр элч нартай эрх тэгш болох ба гэрлэж үр төрүүлэхгүй (Лук 20:35-36) гэсэн амлалтуудаас дээрх нь хол зөрөөтэй мэт санагдах вий. үүнд ямар хариу байх вэ гэвэл Бурханы Хаанчлалын 1-р хэсэг нь "Нэг мянган" (Илчлэлт 20:2-7) буюу мянган жил үргэлжлэх юм. Энэ Мянганы үед дэлхий дээр хоёр хэсэг буюу бүлэг хүмүүс байх юм:-

1. Хутагтууд-Энэ насандаа Христийг хүлээн авч дагасан ба шүүлтийн ширээний өмнө тэдэнд мөнхийн амьдрал өгсөн.
2. Энгийн мөнх бус хүмүүс- эд нь Христийг эргэж ирэхэд СайнМэдээг дуулж мэдээгүй хүмүүс. Өөрөөр хэлбэл шүүлтийн ширээний дэргэд хариуцлага хүлээхгүй.

Христ эргэж ирэхэд хоёр бүлэг хүмүүс талбай дээр байх юм. Нэгийг нь (шүүлтэд) авч явах ба нөгөөгийг нь үлдээнэ (Лук 17:36). "Үлдээсэн" хүмүүс нь энэ 2-р бүлэгт орно.

Хутагтууд шүүлтийн сэнтийн дэргэд Бурханы шинжийг олоод үхэх ба буюу хүүхэдгаргаж чадахгүй болно. Хаанчлалд эдгээр зүйлсийг үзэж туулж буй хүмүүсийн дүрслэл нь тиймээс 2-р бүлэг буюу Христийг эргэх ирэхэд амьд байх боловч Бурханы шаардлагуудыг мэдээгүй хүмүүст хамаарах юм. Зөв сайнд олгох шагнал нь "Хаанчлал ба тахилч: бид дэлхий дээр хаанчлах болно" (Илчлэлт 5:10) юм. Хаад нь хэн нэгнийг захирах хэрэгтэй

120 БУРХАН

болно. Хоёр дахь ирэлтийн үед Сайн Мэдээг үл хэрэгссэн нь захирагдахын тулд амьд үлдэнэ. Бил Христэд байснаар Түүний шагналыг хуваах болно. Тэр шагнал нь дэлхийн хаан болох шагнал юм: “Ялагч хүнд...Би үндэстүүндийг захирах эрх мэдлийг өгнө. Тэр хүн тэдийг төмөр таягаар захирах болно...Би Эцэгээсээ эрх мэдлийг хүлээн авсан ” (Илчлэлт 2:26,27).

Фунтийн тухай Христийн сургаалт зүйрлэл одоо зохих байрандаа орж байна: - Үнэнч зарц нар хаанчлалд арав буюу таван хотыг захирахаар шагнагджээ (Лук 19:12-19). Бурханы замын талаарх мэдлэг тэр даруйдаа таран түгэхгүй. Христ Иерусалимд Хаан хэмээн тунхаглагдав. Хүмүүс Бурханы талаар илүү мэдлэг олж авахын тулд Иерусалим уруу аялах болно (Иса.2:2,3). Тэрчлэн Дан.3:35,44-д гардаг (Бурханы Хаанчлалыг төлөөлөн) уул хэрхэн газар дэлхийд аажмаар тархдагийг санагтун. Бурханы тухай мэдлэгийг түгээх нь гэгээнтнүүдийн үүрэг юм. Энэ утгаараа Түүний Хаанчлалын талаарх мэдлэгийг ч тэр түгээнэ. Израйл түрүүнд нь Бурханы Хаанчлалд байх үед тахилчдын үүрэг бол Бурханы талаарх мэдлэгийг зааж сургах явдал байлаа (Мал. 2:5-7). Энэ зорилгоор тэднийг Израиль даяар янз бүрийн хотод байрлуулсан байв. Хаанчлалыг илүү яруу алдартайгаар дахин тогтооход гэгээнтнүүд Тахилчдын үүргийг хүлээж авна (Илчлэлт 5:10).

Христ өнөөдөр ирдэг юм бол:-

1. Хариуцлага бүхий үхэгсэд босон ирж хариуцлага бүхий амьд хүмүүстэй хамт шүүлтийн ширээ уруу хүргэгдэнэ.
2. Хариуцлага бүхий хорон муучууд нь үхэх шийтгэл авч зөв сайнд нь мөнхийн амьдрал өгнө.
3. Тэгээд зөв сайн нь тэр үед амьд байгаа хүмүүсийг захирна. Харин Бурханд хариуцлага хүлээснүүдийг захирахгүй. Зөв сайнууд нь “Хаад, Тахилчид” (Илч.5:10) мэт тэдэнд Сайн Мэдээг заана.
4. Энэ нь мянган жил үргэлжилнэ. Энэ хугацаанд мөнх бус хүмүүс Сайн мэдээг сонсож тэгснэр Бурханд хариуцлага хүлээнэ. Эдгээр хүмүүс илүү урт насалж жаргалтай амьдрах болно.

5. Мянганы эцэст Христ ба Хутагтуудын эсрэг бослого гарах ба түүнийг Бурхан дарна. (Илч.20:8,9).
6. Мянган жилийн сүүлчээр энэ хугацаанд үхсэн бүх хүмүүс дахин амилагдаж шүүгдэнэ.(Илч. 20:5, 11-15).
7. Тэдний дундах хорон муу нь устгагдаж зөв сайн нь мөнхөд амьдрахаар бидэнтэй нийлнэ.

Дэлхийтэй хийсэн Бурханы зорилт тэгэхэд бүрэн хэрэгжинэ. Дэлхий мөнх орших зөв улсаар дүүрсэн байна. Бурханы “Яхвэ Елохим” гэдэг нэр (“хүчирхэгүүдийн бүлэгт илэрч гарах нэгэн” гэсэн утгатай) тэгэхэд бүрэн төгс болох юм. Газар дэлхийд нүгэл, үүнээс үүдэн гардаг үхэл дахин дахин хэзээ ч гарахгүй: Хорт могойны үр толгой дээрээ фцохигдон бүрэн устгагдана гэсэн амлалт тэгэхэд бүрэн биелэгдэнэ (Эхлэл 3:15). Мянганы үеэр Христ “бүх дайснуудаа Өөрийн хөл доороо оруулах хүртэл ноёрхох ёстой. Эцэст нь устгагдах байсан бол үхэл мөн...бүх юмч Өөрийнх нь (Бурханы) эрхшээлд орох үед Өөрт нь бүх юмсыг захируулагч Нэгэний (Бурхан) эрхшээлд Хүү Өөрөө ч мөн орох болно. Энэ нь Бурхан бүгдэд бүх юм болохын тулд юм” (1Кор.15:25,28).

Ийнхүү “Бурхан ба Эцэгт Хаанчлалыг тушаах үед төгсгөл ирнэ” (1Кор. 15:24). Бурхан “бүх юм” болох тэр үед дараа нь яахыг нь бидэнд хэлээгүй. Бидний мэдэж байгаа юм юу вэ гэвэл бид мөнхийн амьдрал, Бурханы шинж төлөвтэй болох ба бид Бурханыг алдаршуулах, баясгахын тулд амьдрах

болно гэдэг л байна. Мянганы дараа байдал ямар байх талаар цаашид лавлана гэдэг нь таамаглал төдий юм.

“Бурханы Хаанчлалын сайн мэдээ”-г ойлгох нь эдгээр үгсийг уншигч бүрийг аврагдахад чухал юм. бид та бүхнийг энэ хичээлийг дахин уншиж, энд иш татсан Библийн хэсгүүдийг харахыг чин сэтгэлээсээ хүсч байна.

Бурхан биднийг Өөрийн Хаанчлалд байлгахыг хүсч байна. Биднийг зүгээр сэтгэлээ илэрхийлэх бус Түүний бүтээлч чадварт жинхэнээр оролцуулахад Түүний бүхий л зорилго чиглэдсэн юм. Баптисм биднийг энэ Хаанчлалтай холбоотой амлалтуудтай холбож өгдөг. Баптисм хүртээд Бурханы Үгийг цөөн хэдэн жил

122 БУРХАН

даруухан дагаснаар биднийг тэрхүү яруу алдарт, мөнхийн үе уруу орох оломжийг өгч чадна гэдгийг итгэхэд бэрх юм. Гэвч Бурханы Хайранд итгэх бидний итгэл туйлбартай байх ёстой. Бидэнд богино хугацааны ямар ч бэрхшээл учирлаа гэсэн Сайн Мэдээний дуудлагыг сөрөх ямар ч хүндэтгэх шалтгаан бидэнд байхгүй нь мэдээж?

“Хэрэв Бурхан бидний талд юм бол хэн биднийг эсэргүүцэх вэ?” (Ром 8:31).

“Энэхүү өнөө үеийн зовлонгууд нь бидэнд илчлэгдэх тэрхүү алдартай зүйрлэшгүй.” (Ром 8:18).

“Цаг зуурын ялихгүй зовлон нь бидэнд мөнх алдрыг үлэмж арвинаар бий болгож байна.” (1 Кор. 4:17).

ХИЧЭЭЛ 5: Асуултууд

1. Дараахаас Бурханы Хаанчлалыг тогтоох цаг нь аль нь вэ?

- а/Хаанчлалыг дандаа тогтоож байсан.
- б/Христыг эргэн ирэхэд.
- в/Нэгдүгээр зуунд Пентекостын өдөрт.
- г/Итгэгч нарыг шашин уруу ороход тэдний зүрхэнд.

2. Мянган гэж юу вэ?

- а/Бидний зүрхэн дэх нигүүлслийнх аанчлал.
- б/Итгэгч нарын Тэнгэр дэх 1000 жилийн хаанчлал.
- в/Дэлхий дээрх Сатаны 1000 жилийн хаанчлал
- г/Дэлхий дээрх Бурханы ирээдүйн Хаанчлалын эхний 1000 жил

3. Мянганд одоогийн итгэгч нар юу хийх вэ?

- а/Мөнх бус хүмүүсийн захирагч нар болно.
- б/Тэнгэрт захирагч нар болно.
- в/Бид мэдэхгүй.
- г/Өөр гаригт амьдарна.

4. Бурханы хаанчлалын тухай мэдээ номлогдсон уу?

- а/Зөвхөн Шинэ гэрээнд.
- б/Зөвхөн Есүс ба эш үзүүлэгчид номолсон
- в/Шинэ болон Хуучин Гэрээний аль алинд.
- г/Зөвхөн Хуучин Гэрээнд.

6.1 Бурхан ба Муу Ёрын Сүнс

Христийн шүтлэгийн болоод бусад шашны олон урсгалууд нь газар дэлхий дээрх хийгээд бидний амьдрал дахь бэрхшээл зовлонгуудыг зохион байгуулагч, бидний үйлдэж буй нүглийг хариуцагч Сатан буюу Дьявол хэмээх мангас байдаг гэж үздэг. Библи нь Бурхан бүхнээс хүчтэй гэдгийг тун ойлгомжтой номлодог. Тэнгэрийн элч нар нүгэл үйлдэггүй болохыг бид хичээл 4.1-т үзсэн. Бид эдгээр зүйлд үнэхээр итгэдэг бол ертөнцөд Бүхнийг Чадагч Бурханы эсрэг зогсох аугаа хүчит зүйл байх үндэслэлгүй юм. Хэрэв бид ийм зүйл байдагт итгэдэг бол бид Бүхнийг Чадагч Бурханы аугаа дээд байдалд эргэлзэх нь гарцаагүй. Диоваль болон сатаныг зөв таньж мэдэх нь маш чухал номлол болох тул энэ асуудал маш их чухал юм. Еврей 2:14-т Есүс өөрийн үхлээр диовалийг устгасан гэж үзсэн. Иймд бид диовалийн тухай зөв ойлголттой болохгүй бол бид Есүсийн мөн чанарыг буюу үйлсийг нь ойлгож чадахгүй.

Ертөнцөд ерөнхийдөө, нэн ялангуяа 'Христийн' гэх ертөнцөд амьдралын сайн зүйлс Бурханаас, харин муу юмс Диовал буюу Сатанаас гардаг гэсэн санаа байдаг. Энэ нь бол цоо шинэ санаа биш, энэ нь Христээс урвагсдад ч зөвхөн хязгаарлагдах санаа биш юм. Жишээ нь Вавилончууд хоёр бурхан байдаг гэж итгэдэг ба нэг нь сайн сайхан болоод гэрэл гэгээний бурхан нөгөө нь гай гамшиг, харанхуйн бурхан бөгөөд энэ хоёр үхлийн тулаанд оршдог гэжээ. Персийн хаан Сирус үүнд итгэдэг байжээ. Иймд Бурхан түүнд "Би бол Эзэн, өөр хэн ч байхгүй, Надаас өөр бурхан байхгүй... Би гэрлийг буй болгон харанхуйг бүтээж энх амгаланг тогтоон хорт гэм(гай гамшиг) бүтээж: Би бүгдийг хийдэг Эзэн мөн" (Иса.45:5-7,22) гэж айлдсан билээ. Бурхан энх тайванг бүтээсэн, мөн Тэр гай гамшиг буюу хорт гэмийг бий болгожээ. Бурхан зохиогч мөн. Энэ утгаараа "хорт гэм"-ийг бүтээгч болно. Иймд "хорт гэм" хийгээд хүний үйлдэгч нүгэлийн хооронд ялгаа бий. Нүгэл нь газар дэлхийд Бурханы бус хүний үр дүнгээс гарч ирсэн. Бурхан Сирус болоод Вавилоны ард түмэнд "Надтай зэрэгцэх хэн ч (өөр) байхгүй" гэж айлдсан юм. "Эл" хэмээх Еврей үг нь "Бурхан" гэж орчуулагдах ч угтаа "хүч чадал буюу хүч эрх мэдлийн эх сурвалж" гэсэн утгатай. Бурхан Өөрөөс нь гадна орших ямар нэг эрх мэдэл, хүчний эх сурвалж байхгүй гэж айлддаг билээ. Чухам ийм учраас ч Бурханд жинхэнэ итгэгч хүн

аугаа хүчит диоваль буюу чөтгөрийн тухай санааг хүлээн зөвшөөрдөггүй юм.

Бурхан: Гай гамшгийг Бүтээгч

Библи хүмүүсийн амьдрал дахь болон энэ дэлхий дэх “зовлон бэршээл”-ийг авчирсан Бурханы тухай жишээг өгүүлсэн байдаг. Ам.3:6 нь хэрэв хотод хорт муу үйл байгаа бол Бурхан үүнийг хийсэн хэрэг гэжээ. Жишээ нь хэрэв хотод газар хөдлөлт болвол хотын дээр диоваль оршиж гэнэтийн гай гамшгийг авчирсан гэж ихэвчлэн боддогдог. Гэхдээ жинхэнэ итгэгч хүн Бурхан энэ бүхний хариуцлагыг хүлээдэг гэдгийг ойлгох ёстой. Иймд Мик.1:12-т “хорт үйл Эзэнээс Иерусалимын дааман хаалга уруу бууж ирсэн” гэжээ. Иовын номноос бид зөв шударга Иов хэрхэн энэ амьдрал дахь зүйлсээ алддагыг уншдаг. Энэ ном нь хүний амьдрал дахь ‘зовлон бэршээл’-ийн мэдлэг Бурханыг дагах, эс дагахаас шууд хамаардаггүйг заадаг. Иов “Эзэн өгсөн, Эзэн зайлуулан авна”(Иов 1:21) гэж хэлжээ. Тэр “Эзэн өгсөн, Сатан зайлуулан авлаа” гэж хэлээгүй. Тэр энхэртээ “Бид үнэндээ Бурханаас сайныг хүлээн авч, зовлон бэрхшээлийг хүлээн авахгүй байх ёстой юу?” (Иов 2:10) гэж хэлдэг билээ. Номын төгсгөл хэсэгт Иовын найзууд түүнийг “Эзэний түүнд учруулбал зохих бүх зовлон зүдгүүр”-ээс (Иов 42:11 мөн 19:21, 8:4) тусладаг. Иймд Бурхан бидний амьдрал дахь бэрхшээлүүдийг хүлээн зөвшөөрөгч гэсэн утгаараа ‘зовлон бэршээл’-ийн эх сурвалж юм.

“Эзэн нь хайрладаг хүнээ сахилгажуулдаг юм...Хэрэв та нар сахилгыг тэсэн давбал...дараа нь энэ нь түүгээр ургагдсан хүмүүст зөвт байдлын амар амгалан бүхий үр жимсийг төрүүлж өгнө”(Еврей 12:6-11) гэсэн нь Бурханаас бидэнд өөрсдийн сүнслэг өсөлтийг шүүх шүүлт юм гэдгийг харуулж байна. Энэ нь диоваль нь биднийг нүгэл хийх болон зөвт бус байхад хүргэдэг мөн “зөвт байдлын үр жимс”ийг хөгжүүлэх бидний амьдралын бэрхшээлүүдийг нэг дор авчирдаг гэж Бурханы үгийг өөрийнх нь эсрэг тавьдаг юм. Диовалын тухай ортодокс санаа нь ноцтой бэрхшээлүүдэд хүргэж байгаа юм. Ялангуяа үүнд ноцтой нь хүнийг сатанд хүргэх тухай ярьдаг “түүний сүнс аврагдаж байна” буюу “доромжлохгүй байхыг сургасан”,гэх мэт ишлэлүүд юм. (1Кор 5:5; 1 Тим. 1:20). Хэрэв Сатан үнэхээр хүмүүсийг нүгэлд хүргэж хүмүүст сөрөг сүнслэг үр дүн үүсгэхэд чиглэгдсэн бол яагаад ишлэлүүд Сатаныг эерэг талаас өгүүлсэн юм бэ? Хариулт нь “Сатан” буюу амьдрал дахь хүнд хэцүү байдлууд нь итгэгчийн

126 БУРХАН

амьдралд эерэг сүнслэг нөлөөг авчирч болно гэсэн баримтад оршино.

Хэрэв бид Бурханаас гай гамшиг ирдэгийг хүлээн зөвшөөрвөл бид Бурханд өөрсдөдөө байгаа бэрхшээлүүдийн талаар ямар нэг юм хийхийг өөрөөр хэлбэл зайлуулахыг хүсч мөргөж болно. Хэрэв тэр хийхгүй бол Бурхан бидний сүнслэг сайн сайхны төлөө тэдгээр бэрхшээлийг илгээсэн гэдгийг мэднэ.

Одоо хэрэв бид бидний зовлонгийн шиалтгаан болох диовал буюу сатан гэж нэрлэгдэх ямар нэг гай гамшиг байдагт итгэвэл тэдгээрийн талаар ямар нэг юм хийх арга байхгүй. Тахир дутуу болох, өвдөх, гэнэтээр үхэх, буюу гай гамшиг нь азгүй тохиолдол гэж авч үзэгддэг. Хэрэв диовал нь ямар нэг хүчтэй, нүгэлтэй Тэнгэрийн элч байсан бол тэр биднээс хүчтэй байх тул бид түүний гарт зовохоос өөр сонголт байхгүй сан. Түүнчлэн бид Бурханы хяналт дор байдаг тул итгэгч нарын хувьд “бүх зүйлс (амьдрал дахь) сайн сайхны төлөө үйлчилдэг” юм (Ром 8:28). Тэгэхээр итгэгч хүний амьдралд ‘аз’ гэсэн тийм зүйл байхгүй.

Нүглийн эх үүсэл

Нүгэл нь бидний дотроос гарч байдаг гэдгийг дурдах нь зүйтэй. Нүгэл үйлддэг нь бидний буруу юм. Мэдээж нүгэл үйлдсэнээ бид өөрсдийн буруу биш гэж итгэх нь сайхан байлгүй яахав. Бид чөлөөтөйгээр нүгэл үйлдэж дараа нь энэ нь диовалын буруу гэж бодон өөрсдийгөө уучилж өөрсдийн нүгэлд түүнийг бүрэн буруутгаж болдог. Энэ нь маш их нүгэлт шинжийн хувьд, буруутай этгээд өөрийгөө тухайн үед диовалд өмчлөгдсөний улмаас хариуцлага хүлээхгүй хэмээн өршөөл хүсэх нь ховор байдаг. Гэхдээ, ийм сул дорой уучлал нь усаар угаалгахгүй байхаар шүүгдэж тэр хүн нь өөртөө шийтгэл хүлээдэг.

Бид “нүглийн хөлс бол үхэл”(Ром 6:23) юм гэдгийг санах хэрэгтэй. Нүгэл үхэл уруу аваачдаг. Хэрэв нүгэл үйлддэг нь бидний буруу биш харин диовалын юм бол Бурхан биднээс илүүтэйгээр диовалыг шийтгэх нь зүйтэй болхсон. Гэвч бид өөрсдийн нүглийн төлөө шүүгддэг нь бид нүглийнхээ төлөө хариуцлага хүлээж буйг харуулна. Бидэн *доторх* нүглийн зарчмаас илүү биднээс гадна байх ямар нэг онцгой хүн гэсэн диовалын тухай санаа нь бидний өөрсдийн нүглийн төлөөх хариуцлагаас биднийг холдуулах гэсэн оролдлого юм. Энэ нь Библийн хүний мөн чанарын тухай заасан

зүйлийн дүгнэлтэд хүрэхээс эсэргүүцдэг хүмүүсийн өөр нэг жишээ юм. Энэ нь уг үндсэндээ нүгэлтэй байх юм.

“Хүний дотор орж хүнийг бузарлаж чадах юм хүнээс гадна ер байхгүй...Дотроос хүмүүсийн зүрхнээс хорон муу бодол, садар самуун, хулгай аллага, завхайрал,...бардам зан, мунхаглал гардаг. Энэ бүх хорон зүйлс дотроос нь гарч хүнийг бузарладаг.” (Марк 7:15-23).

Биднээс гадна оршиж, бидэн дотор орж нүгэл үйлдүүлэх шалтгаан болдог ямар нэг зүйл байдаг гэсэн санаа нь энд Есүсийн заасан зүйлүүдтэй ер нийцэхгүй. Дотроос, хүний зүрх сэтгэлээс хорт муу үйлсийн бүх зүйлсүүд гарч ирдэг юм.

Иймээс үерийн үед Бурхан “Хүний зүрхний хандлага нь бүр багаас нь бузар муу байдаг”(Эхлэл 8:21) гэж айлдсан байдаг. Иаков 1:14-нь бид хэрхэн хүсэлдээ хөтлөгддөг болохыг өгүүлсэн:“хүн бүр (бүхий л хүн төрөлхтөнд адилхан байдаг) өөрийн хүсэл тачаалдаа (“өөрийн хорт муу хүсэл”)автаж, уруу татагддаг”. Бид, биднээс гадна байх зүйлсээр бус харин өөрсдийн хүсэл тачаалаар, өөрсдийн хорт муу хүсэлээрээ уруу татагддаг байх нь ээ. Иаков “Та нарын дундах хэрүүл болон зөрчлийн үндэс юу вэ” гэж асууж “Тэр нь эрхтэнгүүдэд чинь дайтаж буй та нарын хүслүүд биш гэж үү,”(Иаков 4:1) хэмээдэг. Бид нар бүгд онцгой, хувийн сонирхолтой. Эдгээр нь бидний өөрсдийн хорт хүслээр өдөөгддөг. Учир нь эдгээр нь бидний хувийнх байдаг юм. Бид өөрсдөө өөрсдийнхөө хамгийн муу дайсан нь юм гэж үнэнийг хэлэх нь зүйтэй.

Ромын номд нүгэл, түүний гарал үүсэл, хэрхэн түүнийг даван туулах тухай ихийг өгүүлдэг. Энэ номонд Диаволь болон Сатаны тухай ер дурдаагүй нь тун анхаарал татна. Нүглийн гарал үүслийн тухай өгүүлсэн хэсэгт Паул нь Диавол буюу сатаны тухай дурдаагүй байдаг. Нөгөөтөйгүүр “диавол” нь Шинэ Гэрээний номлол юм.Хэрэв биднийг нүгэл хийлгүүлдэг гаднах ямар нэг биет байдаг бол тэрээр Хуучин Гэрээнд ч өргөнөөр дурдагдсан байх учиртай сан? Гэвч түүнд энэ тухай онцгойлон, чухалчлан ер дурдаагүй юм. Зэрлэг байдал дахь Израйлын буюу Шүүгчдийн үеийн тэмдэглэлд тэр цаг үед Израйль маш их хэмжээний нүгэл үйлдэж байсныг харуулдаг. Гэвч Бурхан тэдэн дотор ороод тэднийг нүгэл үйлдүүлж буй ямарваа нэг аугаа хүчит биет бую хүчний тухай айлдаж анхааруулаагүй юм. Харин ч Тэр тэднийг

128 БУРХАН

Өөрийн үгийг дагахыг захиж, ингэснээр тэд өөрсдийн махан биеийн замд унахгүй болж байсан. (Дэд хууль 27:9,10; Иош.22:5).

Паул “Миний дотор буюу (миний махан биед) ямар ч сайн зүйл байдаггүй. Сайныг хийх нь үгүй...хэрэд би хүсдэггүй зүйлээ хийж буй бол цаашид би биш, харин миний дотор оршин байгч нүгэл нь үүнийг үйлддэг”(Ром 7:18-21) гэж харамсдаг. Одоо тэр өөрийн нүгэл хийснээ диавол гэгч гадны хүчин зүйлд тохож буруутгаагүй байна. Тэр өөрийн хорт муу мөн чанараа нүглийн эх үндэс хэмээж байна: “Би биш харин миний дотор оршин байгч нүгэл үүнийг үйлддэг. Ингээд сайныг үйлдэхийг хүсдэг (миний дотор) бузар муу нь байдаг гэсэн хуулийг (миний доторх) би олж мэдлээ” Тэгэхээр тэр “миний дотор оршин байгч нүгэл” хэмээн нэрлэсэн зүйлээс сүнслэг оршигч сөргөлцөн гарч ирдгийг хэлжээ. Бодлоготой, сүнслэг оюун ухаант хүн бүр өөрийгөө танин мэдэх ийм мэдлэгт хүрэх болно. Дээд Христич Паул хүртэл шашинд орсоны дараа шинж чанар нь ч өөрчлөгдөөгүй, мөн нүгэл үйлдээгүй, үйлдэж чадахааргүй байр сууринд ч тавигдаагүй. Орчин үеийн “эвангел” урсгал нь өөрсдийгөө мөн ийм байр суурьтай байгаа бөгөөд Ром 7:15-21 дэх түүний мэдэгдэлийг үндэслэн Паулыг ‘аврагдаагүй’ чүүдийн эгнээнд оруулсан. Тэдний ярьж байгаа зүйлүүдийг нотлоход эдгээр ишлэл гол хүндрэл учруулж байгаа юм. Давид хэмээх өөр нэг яриангүй зөв шударга хүн өөрийн үнэн мөн чанарын нүгэлтэй талыг бас дурдсан

байдаг: “Гэм буруугийн дунд би төрсөн бөгөөд Нүглийн дунд эх минь намайг олж тээсэн” (Дуулал 51:5).

Библи хүний уг үндэс дэх нүгэлт мөн чанарын тухай маш тодорхой өгүүлдэг. Хэрэв энэ нь магтан дуулагдвал бидний нүглийн төлөө хариуцлага хүлээх, хүн төрөлхтөнөөс гадуур орших хүнийг төсөөлөх хэрэггүй болно. Иеремиа 17:9 нь хүний зүрх сэтгэл нь маш аюултай нүгэлтэй мөн бид түүний нүгэлгүй байх явдлыг өргөжүүлэх загалмайг магтан дуулж чадахгүй болох шударга бус болохыг өгүүлдэг. Есүс мөн хүний мөн чанарыг уг үндсээрээ хорт муу болохыг мөн түүнийг цэвэр байж чадахгүйг Матай 7:11, Номлогчийн үгс 9:3 (Еврей ном)-т өгүүлжээ. “Хүний хүүхдүүдийн зүрх бузар булайгаар дүүрсэн” (Ефес 4:18) гэсэн нь Бурханаас ялгагдах хүний мөн чанарын төрөлх ялгааны шалтгааныг “өөрсдийн зүрхний харанхуй байдлаас, өөрсдийнхөө доторх хайхрамжгүйгаар” тайлбарлаж байгаа юм. Учир нь бид сүнсний хувьд сохор, зүрх сэтгэлийн хувьд үл хайхарч,

өөрснийгээ Бурханаас холдсон гэж боддог ажээ. Үүний хамт галат 5:19 нь бидний нүглийг “махан биеийн үйлс” гэсэн бөгөөд биднийг нүгэл үйлдэхэд хүргэдэг зүйлс нь бидний өөрсдийн махан бие, бидний оршихуй, мөн чанар юм. Эдгээр ишлэлүүдийн аль нь ч бидэн доторх нүглийн гарал үүслийг диавол энд хийсэн гэж тайлбарлаагүй. Нүгэлт байдал биднийг төрөхөөс уг үндэст маань байдаг. Энэ нь хүнийг бий болоход үндсэн хэсэг нь болно.

6.2 Диавол ба Сатан

Заримдаа Библийн номлолын үндсэн үгс орчуулагдаагүй үлдсэн байдаг (Матай 6:24 дэх “Маммон” гэсэн эртний үг нь үүний нэг жишээ). ‘Сатан’ нь ‘сөргөлдөгч’ гэсэн утгатай орчуулагдаагүй Еврей үг бол ‘диавол’ нь ‘диаблос’ буюу худалч, дайсан, хуурмаг гүтгэгч гэсэн утгатай Грек үг юм. Хэрэв бид Сатан болон Диаволыг нүглийн төлөө хариуцлага хүлээж биднээс гадна оршигч гэж итгэвэл Библид эдгээр үгтэй тааралдвал түүнд хорт муу хүнийг хамааруулж ойлгох болно. Эдгээр үгийг Библи энгийн хүнийг дүрсэлсэн ердийн тэмдэг нэрийн хувьд хэрэглэсэн байна. Библид хэрэглэгдсэн диавол болон сатан зэрэг үгс нь аугаа их нүгэлт хүн буюу биднээс гадна оршигч гэж дүгнэж болохгүй.

Библид гардаг ‘Сатан’ хэмээх үг

Хаадын Дээд 11:14 нь “Эзэн едом хүн Хаадыг Соломоны өстөн (“сатан” гэсэн Еврей үгийн нэг орчуулга) болгов” гэсэн байдаг. “Бурхан бас өөр нэг хүнийг (өөр сатан)...Резоныг ...Израйлын (сатан)өстөн болгов” (Хаадын Дээд 11:23,25). Энэ нь Бурхан эгэл биш хүчтэн буюу Тэнгэр элчийг Соломоны сатан / өстөнөөр болгоогүйг харуулна. Тэр энгийн хүмүүсийг хувиргасан юм. Матай 16:22,23-т өөр нэг жишээг харуулна. Петр Есүсийг Иерусалимд очин загалмай дээр үхэхийг болиулах гэж оролддог. Есүс эргэж хараад Петрт “Миний араас зайл, Сатан аа!...чи Бурханы юмыг бус харин хүнийхийг л боддог.” Хэмээсэн билээ. Ийнхүү Петрийг Сатан гэж дуудсан юм. Энэ тэмдэглэл Христ Тэнгэрийн Элчтэй буюу шулмастай энэ үгсийг хэлээгүй харин Петртэй ярьсан болохыг тодоор харуулж байна.

‘Сатан’ гэсэн үг нь зөвхөн сөргөлдөгч, сайн хүн, бүр Бурханыг Өөрийг нь хүртэл илэрхийлж болно. Үгийн хувьд энэ нь нүгэлтэй

130 БУРХАН

гэсэн утгыг агуулах албагүй. 'Сатан' гэсэн үгний нүгэлийг илэрхийлэх утга болбоос бидний өөрсдийн нүгэлт мөн чанар нь бидний өөрсдийн хамгийн том 'сатан' буюу өстөн болон хэлний энэ үгний хэрэглээ нь нүгэлтэй ямар нэг байдлаар холбогдох болно гэсэнд оршино. Бурхан бидний амьдралд шүүлт хийхдээ эсвэл бидний хийх гэж буй үйлдэлийн буруутай үйл ажиллагааг зогсоох гэж Өөрөө сатан болж болно. Гэхдээ Бурхан 'сатан' гэж дуудагдснаараа Тэрээр нүгэлтэй болно гэсэн үг биш юм.

Самуел болон Шастирын номуудад нэг учралын талаар зэрэгцсэн зүйлсийг өгүүлжээ. Энд нэг үйл явдлын тухай дөрвөн сайн мэдээг өөр өөр хэлээр бичсэн байна. 2 Сам 24:1 –т Израйлын хүн амыг тоолуулахаар “Эзэн...Иерайлын эсрэг Давидыг ятгав.” гэжээ. Шастирын Дээд 21:1-т хүн амыг тоолохоор “Сатан Израйлийн эсрэг босоод Давидыг хөдөлгөв” гэсэн зэрэгцсэн зүйлийг хэлсэн байдаг. Нэг ишлэлд Бурхан Сатанаар түүнийг хийлгэх гэж хилэнгэдэг юм. Бурхан Давидтай 'сатан' буюу сөргөлдөгчийн хувьд харьцсан гэсэн ганц дүгнэлтийг хийнэ. Тэр Иовтой түүний амьдралд шүүлт хийхдээ мөн адил зүйлийг хийдэг бөгөөд Иов бурханд хандан “Өөрийн мутрын хүчээр та намайг хавчдаг” (Иов 30:21) хэмээн хэлдэг. Үндсэндээ Иов 'Та миний эсрэг сатан болж харьцдаг' гэж хэлсэн ажээ.

Библи дэх 'Диавол' хэмээх үг

Энэ нь мөн адил тэрхүү 'диавол' гэсэн үг. Есүс “Би та арван хоёр (дагалдагч нарыг) мөн та нарын нэг нь диавол гэж сонгоогүй юм үү?” гэж хэлсэн бөгөөд “Тэр Иуда Искариотын (энгийн, мөнх бус хүн) тухай хэлжээ ...”. Тэр эвэртэй оршигч нэгэний буюу 'сүнслэг оршигч' хэмээгдэх зүйлийн тухай яриагүй. Энд дурдагдсан 'диавол' хэмээх үг нь зүгээр л нүгэлт хүнийг илэрхийлжээ. 1Тим.3:11 нь өөр нэг жишээг гаргажээ. Сүмийн үйлчлэгчидийн эхнэрүүд нь “хов жив хөөцөлдөгчид” биш байх ёстой. Энэ нь 'диаболос' буюу зарим газарт 'диавол' гэж орчуулагдах жинхэнэ грек үг юм. Ийнхүү Паул Титыг цуглаан дахь настай эмэгтэйчүүд “худал буруушаагч” буюу “диавол” байж болохгүй гэдгийг анхааруулдаг (Тит 2:3). Мөн үүнийг тэрээр Тимоход “Эцсийн өдрүүдэд...хүмүүс...гүжирдэгжид (диавол) болно” хэлдэг (2Тим.3:1,3). Энэ нь хүн төрөлхтөн хүнээс дээгүүр амьтан болно гэсэн үг биш харин улам хорон муу болно. Эд бүгдээс үзэхэд 'диавол' болон 'сатан' хэмээх үгс нь муу Тэнгэрийн элч буюу

биднээс гадуур орших амьтан гэсэн утгатай биш болох нь тод харагдана.

Гэм нүгэл, Сатан болон Диавол

Хичээл 6.1-д бидний үзсэнчлэн ‘Сатан’ болон ‘диавол’ хэмээх үгс нь бидний доторх төрөлхийн нүгэлт баримтлалыг илэрхийлнэ. Эдгээр нь бидний үндсэн ‘сатан’ буюу сөргөлдөгч юм. Эд мөн хүнчлэгддэг ба эдгээрийг ‘диавол’ буюу бидний дайсан, үнэнийг гүжирдэгч гэж ярьж болно. Энэ бидний жинхэнэ шинж чанар туйлын диавол болохыг харуулна. Диавол болон бидний хорт муу хүсэл хоёрын холбоо нь бидэн доторх нүгэл ба хэд хэдэн ишлэлүүдэд дурдагджээ: -Хүүхдүүд нь (бид) цус ба махан биеийн тасархай болов. Түүнчлэн Тэр (Есүс) өөрөө бас тасархай болсон. Ингэснээр Тэр үхлийн хүч буюу диаволийг (өөрийн) үхлээрээ устгав” (Еврей 2:14). Энд диавол нь үхлийн төлөө хариуцлага хүлээх болохыг харуулжээ. Гэхдээ “нүглийн төлөөс нь үхэл”(Ром 6:23) юм. Иймд нүгэл болоод үхэл нь зэрэгцэн оршино. Үүнтэй төстөй Иаков 1:14 нь бидний хорт муу хүсэл биднийг уруу татаж нүгэл уруу хөтөлдөг, иймд үхэл уруу ч мөн хөтөлнө. Гэхдээ Еврей 2:14 нь диавол үхлийг үхлийг авчирсан гэжээ. Энэ ишлэл нь Есүс диаволыг устгахаар бидний мөн чанартай байсан гэсэн утгатай болно. Ром 8:3 –т “Тэр өөрийн Хүүг нүгэлт махан биетэйгээ (өөрөөр хэлбэл бидний мөн чанартай) адил байдалд нүглийн тулд илгээж, махан биеийн дотор нүглийг шийтгэв” гэсэн нь бий. Энэ нь угтаа хүний мөн чанарт орших диавол болон нүгэлт үзлүүд нь үр дүндээ адил гэдгийг харуулж байна. Энд Есүс бидэнтэй адил хүсэлдээ хөтлөгддөг байсан гэдгийг ойгох нь тун чухал юм. Диаволийн тухай номлолыг буруу ойлговол бид Есүсийн мөн чанар хийгээд ажлыг зөвөөр магтан дуулж чадахгүй болно. Энэ нь зөвхөн, Есүст бидний мөн чанар оршиж мөн ‘диавол’ ч түүний дотор байсан учир бид авралын найдвартай байж болно. (Еврей 2:14-18; 4:15). Тэрээр өөрийн мөн чанар Библийн

диаволын хүслээ даван гарахаар Есүс загалмай дээр диаволыг устгасан ажээ. (Еврей 2:14). Хэрэв диавол нь хүнэн амьтан байсан бол тэр удаан оршихгүй. Еврей 9:26-д Христ “өөрийгөө тахил болгон нүглийг зайлуулахын тулд” үзэгдсэн юм гэжээ. Еврей 2:14 нь Христ өөрийн үхлээр өөрт байсан диаволыг устгасан хэмээсэн бий. Өөрийн үхлээр Есүс “нүглийн биеийг”(Ром 6:6) өөрөөр хэлбэл хүний мөн чанар, бидний биед оршсон нүглийг устгасан.

132 БУРХАН

“Нүгэл үйлддэг нэг нь диаволийнх юм” (1Иох.3:8), учир нь нүгэл нь бидний өөрсдийн мөн чанарын хорт муу хүсэлдээ буюу (Иаков 1:14,15) Библид хэлснээр ‘диавол’-д зам тавьж өгсний үр дүн юм. “Диаволийн үйлсийг устгахын тулд Бурханы Хүн энэ зорилгын төлөө үзэгджээ” (1Иох.3:8). Хэрэв диавол нь бидний хорт муу хүсэл юм гэсэн нь зөв байх ахул бидний хорт муу хүслийн ажлууд өөрөөр хэлбэл тэдгээрийн үр дүн нь нүгэл болно. Энэ нь 1Иох:3:5-д “Нүглүүдийг зайлуулахын тулд Тэр(Есүс) үзэгдсэн” гэж баталсан байна. Энэ нь “бидний нүглүүд” болон “диаволын ажлууд” нь адил юм гэдгийг харуулж байна. Үйлс 5:3-т диавол ба бидний нүглүүдийн хоорондох холбоог харуулсан өөр нэг жишээ байна. Петр Аанаиад “Чиний зүрх яагаад Сатанд авдагдах болов?” гэж хэлдэг билээ. 4-р ишлэлд Петр “Ийм юм чиний сэтгэлд яаж төрөв өө?” хэмээмүй. Бидний зүрх сэтгэл дэх ямар нэг муу юмыг илэрхийлэхдээ бидний зүрх сэтгэлд дүүрсэн Сатантай адилтгадаг. Хэрэв бид өөрсдөдөө ямар нэг юм өөрөөр хэлбэл нүгэлт төлөвлөгөөг боловсруулвал энэ нь бидний дотор эхлэнэ. Хэрэв эмэгтэй хүн хүүхэд олж тээвэл энэ нь түүний гадна бий болохгүй харин түүний дотор бүрэлдэх билээ. Иаков 1:14,15 нь бидний хүсэл тачаал хэрхэн бүрэлдэж, үхэлд хүргэх нүгэл уруу аваачдагийг дүрсэлжээ. Дуулал 109:6 нь нүгэлт хүнийг “сатан”-тай адилтгажээ: “Хорон муу хүнийг түүний дээр томилж, Сатаныг түүний баруун гар талд нь зогсоогтун ” өөрөөр хэлбэл түүний дээр эрх мэдэлд зогсоогтун гэжээ (мөн Дуулал 110:1).

Хүнчлэл

Гэлээ ч та “Гэхдээ л энэ чинь диаволыг хүн байгаа мэтээр ярьж байна шүү дээ” гэж эргэлзэнгүй хариу хэлж болно. Энэ нь ч зөв. Еврей 2:14 нь “үхлийн хүч буюу диаволын ”тухай өгүүлдэг. Библийн уншлагын өчүүхэн хэсэг хүртэл хүнчлэлийг буюу хүн байгаа мэт хийсвэр санааг олон хэрэглэсэн болохыг үзүүлнэ. Иймд Сургаалт үгс 9:1 нь ‘Мэргэн Ухаан’ хэмээх эмэгтэйд байшин барьж байгаа тухай мөн тэрчлэн Ром 6:23-д нүглийг, үхлээр хөлс өгч буй төлөгч эзэнтэй зүйрлэсэн байдаг. Энэ тухай ГАЖИЛТ(Digression) 5-д хэлэлцэх болно. Гэхдээ та бүхэнд хийсвэр диоволизм байж болохгүй. Хүний зүрх сэтгэл дэх хорт муу хүслүүд хүнээстусгаар байдлаар илэрч гарахгүй. Имийн учир ‘диавол’ нь хүнчлэгдсэн ажгуу. Нүгэл нь дандаа эзэн мэтээр хүнчлэгддэг.(жишээ нь Ром 5:21, 6:6,17, 7:3). Тэгэхээр ‘диавол’ нь мөн хүчлэгдсэн тул ‘диавол’-ыг нүгэл гэж үзэж болно. Үүний зэрэгцээ Паул бидний махан бие дотор хоёр оршигч бий тухай

ярьсан. (Ром 7:15-21). Махан биеийн хүн буюу 'диавол' нь Сүнслэг хүнтэй тэмцэлдэж байдаг аж. Тэгэхээр энэ нь хоёр тусдаа, хүмүүн биетэн бидний дотор тэмцэлдэж байдаггүйг нотолж байгаа юм. Бидний мөн чанарын нүгэлт хэсэг нь "бузар муу нэгэн"(Мат.6:13)-Библийн диавол мэтээр хүнчлэгдсэн байна. "Бузар муу нэгэн" хэмээн орчуулагдсан энэхүү грек хэллэг нь 1Кор:5:13-т "нүгэлт хүн"

гэж орчуулагдсан ба үүнд хүн нүгэлд зам тавьж өгөхөд түүний "бузар муу нэгэн"-тэр өөрөө -"бузар муу нэгэн" ба "диавол" болж хувирахыг харуулжээ:

'Диавол' ба' Сатан' улс төрийн утга санаанд.

Эдгээр 'диавол' болон 'сатан' гэх үгс нь бидний амьдарч буй нүгэлт, хорон муу ертөнцийн дэг журмыг мөн харуулжээ. Хүн төрөлхтөний нийгэм, улс төр, болон хуурамч шашны эрх мэдэл бүхий бүлгийг 'диавол'-той холбон ярьж болох юм. Шинэ Гэрээн дэх диавол болон сатан нь ихэвчлэн Еврейн буюу Ромын системн нийгэм, улс төрд хамаарах юм. Иймд бид диаволыг шоронд итгэгч нарыг хаясан гэж (Илчлэлт 2:10), мөн итгэгч нарыг шоронд хорьсон Ромын эрх мэдэлтэнгүүдэд хамааруулан уншдаг. Уг өгүүлэлд бид Сатаны сэнтий буюу ширээ байгаа Пергамосын сүмийн тухай өөрөөр хэлбэл бүлэг итгэгч нарын байсан Пергамос дахь Ромын колончлолын удирдлага байсан газрын уншдаг билээ. Бид хэрэв Сатаныг оршиж байсан бол Сатанд өөрт нь Пергамост ширээ байсан гэж хэлж чадахгүй сан.

Хувь хүний нүгэл нь Бурханы хуулийг зөрчсөн ёс бус хэрэг гэж тодорхойлсон байдаг (1Иохан 3:4). Гэвч нүгэл нь Бурханы эсрэг улс төр, нийгмийн хүчийн нэгдлээр илрэхийн хувьд хувь хүмүүсийнхээс илүү чадалтай хүч юм. Энэ нь заримдаа диавол гэж нэрлэгдэх хүчтэй оршигчоор хүнчлэгдсэн нэгдсэн хүч байдаг. Энэ утгаараа Иран болон бусад Исламын эрх мэдэлтэнгүүд Америкийн Нэгдсэн Улсыг "аугаа Сатан" буюу өөрөөр хэлбэл тэдний улс төр, шашны хувьд аугаа сөргөлдөгч гэж нэрлэдэг байна.Иймээс 'диавол' хэмээх үг Библид байнга хэрэглэгдсэн байгаа юм.

Эцэст нь энэ сэдвийн тухай дүгнэж хэлэхэд, диавол хэмээх нийтлэг итгэлд хамаарах ишлэлийн цөөн хэдэн ишлэлүүдэд тулгуурлан нүсэр номлол номлохоосоо илүүтэйгээр Библи судрыг

134 БУРХАН

бүхэлд нь хамарсан тэнцвэртэй үзэл дээр тулгуурлан өөрсний ойлголтод суурь дэвсгэр болгох нь юунаас илүү чухал юм гэдгийг хэлэх нь зүйтэй болов уу. Хичээл 6.1 болон энэ хэсгийг маш анхааралтай, сүжигтэйгээр/ залбирч дахин дахин унших хэрэгтэй юм. Үүгээр авч үзсэн номлолын байр суурь нь диавол болон сатанд хамаарах бүх ишлэлүүдийг ухаалгаар ойлгуулах цорын ганц зам гэж

хүлээн зөвшөөрөгдсөн юм. Эдгээр үгс энгийн тэмдэг нэрийн адил хэрэглэгдэж болно. Мөн зарим нэг газарт бидний хүний мөн чанарт орших нүгэлтэй холбоотой байж болно. Зарим түгээмэл санаан дахь нийтлэгээр буруу ойлголт төрүүлдэг ишлэлүүдийг энэ хичээлийн ГАЖИЛТ(Digression) -д авч үзсэн байгаа. Бидний дүгнэлтийг хүлээж авахад бэрхшээлтэй байгаа бол өөрсдөөсөө үүнийг асуугаарай: (1) Нүгэл хүнчлэгдсэн үү? Мэдээж тийм. (2) 'Сатан' нь зөвхөн тэмдэг нэрийн хувьд хэрэглэгддэг үү? Тийм ээ. Гол бэрхшээл нь юу вэ гэвэл нүгэл бидний дайсан/сатан мэтээр хүнчлэгдсэн гэсэнг хүлээн зөвшөөрч болох уу? Энэ үг нь Иоханы захидалууд болон Сайн мэдээнд байнга хүнчлэгдсэн байдаг. 'Сатан' болон ' диавол'-аас илүү хүнчлэлд тохирсон ямар нэр байж болох вэ?

6.3 Бугууд

Өмнөх хэсгүүдэд яагаад бид диавол буюу сатаныг биеэр оршигч болон шулам гэж итгэдэггүйг тайлбарласан. Хэрэв бид ийм оршигч байхгүй гэж хүлээн зөвшөөрвөл диаволын үйлчлэгч байх чөтгөр мөн оршихгүй болно. Олон хүмүүс Бурхан бидэнд амьдралын бүх л сайн сайхныг бэлэглэж харин түүний чөтгөр муу муухай юмсыг авчирч, Бурханы өгсөн сайн сайханг булаан авдаг гэж боддог. Библи Бурхан нь бүх эрх мэдэл хүчний эх сурвалж бөгөөд Тэрээр бидний амьдрал дахь сайн ч юмс, муу ч юмсын хариуцлага хүлээх юм гэдгийг тун тодорхой заадаг.(Иса.45:7). Иймд бид шүүгдэл хүлээн авахдаа түүнийг диавол буюу чөтгөрөөс бус харин Бурханаас ирж байгаа юм гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Иов “Эзэн өгсөн, Эзэн (муу ёрын сүнс биш) зайлуулан авсан. Эзэний нэр алдаршиг” (Иов 1:21) гэсэн нь бий.

Бурхан бүх эрх мэдэл хүчний эх үндэс (Иса.45:5, 44:8). Бурхан Өөрийн хүмүүсээ өөр бурхадад итгэж эхлэхэд уурлан тэднийг

Түүнд 'Та бол аугаа Бурхан. Аугаа хүчит Бурхан, гэхдээ хэдийгээр Тань шиг хүчирхэг биш ч хамаагүй би Таниас гадна өөр бурхад байгаа гэдэгт итгэж байна.' гэж хэлэхэд хилэгнэдэг юм. Ийм учраас бид жинхэнэ Бурханаас өөр ямар нэг диавол буюу чөтгөрт итгэж болохгүй. Энэ нь израилын хийсэн алдаатай адил болно. Хуучин Гэрээний ихэнх хэсэг Израйл хэрхэн Бурханаас өөр бурхадад итгэн Түүнийг хилэгнүүлсэнг харуулдаг. Бид Библээс өнөөдөр ч

хүмүүсийн итгэж буй "чөтгөр" нь Израилын итгэсэн худал бурхадтай адил юм гэдгийг харах болно.

Бугууд нь Хуурамч Шүтээн

1 Коринтод Паул чухам яагаад христичүүд онгон шүтээнгүй мөн тийм юманд итгэдэггүйг тайлбарладаг. Библийн цаг үед хүмүүс чөтгөрийг өөрсдийн амьдралд байгаа бэрхшээлүүдээ болиулахаар шүтэж болох жижиг бурхад гэж итгэж байжээ. Тэд иймд онгон шүтээнтэй адил чөтгөрийн загварыг хийж шүтэж байлаа. Энэ нь яагаад Паул захиандаа "чөтгөр" болон "онгон шүтээн" хэмээх үгсийг хооронд нь сольж хэрэглсэнг тайлбарлана. "Тахидаг юмсыг тэд Бурханд бус харин чөтгөрүүдэд тахидаг аж. Та нарыг чөтгөрүүдийн хамсаатан болоосой гэж би хүсдэггүй...Хэрэв хэн нэгэн хүн Энэ бол шүтээнд тахисан мах гэж хэлбэл хэлж өгсөн хүний төлөө түүнийг бүү ид" (1Кор.10:20,28). Иймд онгон шүтээн ба чөтгөрүүд нь дүндээ адилхан. Паул "чөтгөрүүдэд зориулсан (шүтээнд), бурханд биш " гэж хэлсэнг анхаар. Энэ нь зөвхөн ганц л бурхан оршдог тул чөтгөрүүд нь Бурхан биш гэсэн үг. Иймд чөтгөрүүд нь бурхад биш мөн жинхэнэ хүчгүй юм.Энэ санаа 1Кор.8:4-т үнэхээр харагдана:-

"Иймд шүтээнүүдэд өргөсөн юмсын хувьд...энэ ертөнцөд шүтээн гэдэг нь байдаггүй бөгөөд ганцаас өөр Бурхан байхгүйг бид мэднэ." Шүтээн буюу чөтгөр нь ерөөсөө байхгүйюм. Зөвхөн ганц л Бурхан ертөнцийд бий. Паул цааш нь (ишлэл 5,6):-

"Хэдийгээр бурхад хэмээгчид нь байдаг ч...(бурхад ч мөн эзэд ч олон [хүмүүсийн итгэснээр өнөөдөр олон төрлийнчөтгөрүүд байдаг байна-нэгчөтгөр нь ажлаас чинь халуулж, нөгөө нь эхнэрээс чинь салгах гэх мэт]) Гэхдээ бидний хувьд (жинхэнэ итгэгчдийн хувьд) ганц бурхан, Эцэг байна. Түүнээс бүх юмс (өмнөх сэдвүүдэд үзсэн муу, сайн бүх юмс) гарсан " гэжээ.

136 БУРХАН

Хуучин Гэрээнд эргэн очиход тэнд “чөтгөрүүд”-ийг шүтээнтэй адилтгасан олон нотолгоо байна. Хуучин Гэрээний Грек (Септуагинт) хувилбарт Дэд Хууль 32:17 болон Дуулал 106:37-д ‘даимонион’ нь “шүтээн” гэж хэрэглэгдсэн байна. Энэ нь шинэ гэрээнд “чөтгөр” гэж орчуулагдан буужээ. Дуулал 106:36-39 нь Израйлын эндүүрэлийг өгүүлж, Канааны шүтээнийг чөтгөртэй адилтгасан байдаг билээ.

”Тэд (Израйл) өөрсдөд нь урхи болсон тэдний шүтээнүүдэд үйлчилсэн. Түүгээр ч барахгүй тэд өөрсдийн охид, хөвгүүдээр чөтгөрүүдийг тахиж гэмгүй цусыг буюу Канааны шүтээнүүдэд тахисан өөрсдийн охид хөвгүүдийн цусыг урсгажээ.”

Шинэ Гэрээнд Гардаг Бугууд

Гэхдээ та бүхэн “Чөтгөрүүдийн тухай тун тодоор өгүүлсэн байдаг Шинэ гэрээний ишлэлүүдийг юу гэх сэн бол?” гэж хэлж болно.

Нэг зүйлийг бид тодруулах хэрэгтэй: Библи нь Бүхнийг Чадагч Бурханы Үг учир өөртөйгөө зерчилдөж болохгүй. Хэрэв бид Бурханыг бидний бэрхшээлүүдийг авчирдаг мөн Тэр бүх эрх мэдэл хүчний эх үндэс гэж үзвэл Библи чөтгөрүүд буюу Бурханы эсрэг зогсох жижиг бурхадын тухай өгүүлж, тэдгээрийг бидэнд хүргэж чадахгүй. “Чөтгөрүүд” хэмээх үг нь Хуучин Гэрээнд зөвхөн дөрвөн удаа гарсан ба ихэнхдээ онгон шүтээн гэж илэрхийлсэн нь бий. Гэхдээ Сайн Мэдээнд энэ нь олон удаа гардаг. Сайн Мэдээ бичигдэх тэр үед тайлбарлах боломжгүй ойлгогдохгүй аливаа өвчин зовлонг чөтгөрийн гайгаар боллоо гэж тэр үед хэлдэг байсан гэж бид санаж байна. Хэрэв чөтгөрүүд үнэхээр оршиж, бидний өвчин шаналал, зовлон бэршээлийн хариуцлага хүлээх бол бид тэдний тухай Хуучин Гэрээнээс илүү их унших байсан сан. Гэвч бид энэ утгаар нь ер уншдаггүй.

Хэн нэгнээс чөтгөрийг аваад хаячихлаа гэдэг нь тухайн үед мэдэгдээгүй өвчин буюу мэдрэлийн өвчинг анагаахаа гэсэн үг юм. Нэгдүгээр зуунд амьдарч байсан хүмүүс өөрсдийн ойлгохгүй аливаа зүйлсийг ‘чөтгөрүүд’ хэмээх хийсвэр оршигчид тохож байсан байна. Мэдрэлийн өвчин тэдний анагаах ухааны мэдлэгийн төвшинд ойлгоход хэцүү байсан тул тэдгээр хүмүүсийг ‘чөтгөр шүгэлсэн’ гэж нэрлэж байжээ. Хуучин Гэрээний цаг үед хүнийг оюун санааны тавгүй байдалд ороход хорт муу буюу бузар

сүнтэй холбож үздэг байсан аж. (Иуда 9:23; 1Сам.16:14, 18:10). Шинэ Гэрээний үед хорт муу сүнс/чөтгөр шүгэлсэн гэсэн хэл нь мэдрэлийн өвчтэй хүмүүсийг чөтгөрт авагджээ гэж үзэж байжээ. Чөтгөр болон өвчиний хоорондын холбоо нь дараах байдлаар илэрнэ: “Тэд чөтгөр шүгэлсэн олон хүнийг Түүнуруу (Есүс) аваачихад Тэр сүнсүүдийг үгээрээ хөөн зайлуулж өвдсөн бүгдийг эдгээжээ. Энэ нь эш үзүүлэгч Исаиагаар (Хуучин Гэрээнд) Тэр бидний сул байдлыг өөртөө авч бидний өвчинг үүрсэн гэж хэлүүлсэн нь биелэхийн тулд байлаа” (Матай 8:16,17).

Иймд хүний сул дорой байдал, өвчин шаналал нь “чөтгөрүүд” болон “хорт муу сүнс”-эд шүгэлсэнтэй адил юм. Тэд эдгэрэхээрээ “чөтгөр шүгэлсэн” хүмүүс өөрсдийн “зөв оюун ухаан”-д эргэж ордог байна- Марк 5:15; Лук 8:35. Энэ нь “чөтгөр шүгэлсэн” байх нь оюунухааны хувьд эрүүл бус өөрөөр хэлбэл өөрсдийн зөв оюун ухаандаа үл байгаа хүнийг хэлэх өөр нэг утга юм. Эдгээр “чөтгөрт шүгэлсэн” хүмүүс “эдгэрч” буюу “эмчлэгднэ” –Матай 4:24; 12:22; 17:18-чөтгөр шүглэсэн гэдэг нь өвчтэй байхыг илэрхийлсэн нэг утга юм.

ХИЧЭЭЛ 6: Асуултууд

1. Бидний зовлон зүдгүүр, бэрхшээлүүдийн гол хариуцлага хэнд ногдох вэ?
 - a) Бурхан
 - b) Сонголт
 - c) Сатан гэгдэх нүгэлт оршигч
 - d) чөтгөр гэгдэх нүгэлт оршигч

2. Бидний нүгэл үйлдэх үйлдээд байдгийн хариуцлага юунд ногдох вэ?
 - a) Бидний өөрсдийн хүний мөнчанаар
 - b) Бурхан
 - c) Хорт муу сүнс
 - d) Сатан гэгдэх нүгэлт оршигч

3. 'Диавол' нь үгийн хувьд юуг илэрхийлэх вэ?
 - a) Нүгэл
 - b) Хорт могой
 - c) Худал гүжирдлэг/хов жив
 - d) Нүгэлт Тэнгэрийн элч нарын удирдагч

4. 'Сатан' гэдэг нь үгийн хувьд юуг илэрхийлэх вэ?
 - a) Нүгэл үйлдэгч
 - b) Сөргөлдөгч
 - c) Муухай юм
 - d) Чөтгөрүүдийн хаан

5. 'Сатан' ба 'диавол' нь дам утгаар юунд хамаарч байна вэ?
 - a) Нүгэл ба уруу таталт
 - b) Гадна ертөнц дэх хорт муу хүч
 - c) Луу

6. Шинэ Гэрээнд гардаг 'чөтгөрүүд' –ийг юу гэж ойлговол зохилтой вэ?
 - a) Нүгэлт тэнгэрийн элч
 - b) Өвчин
 - c) 'чөтгөрөөс' болсон хэмээн хүмүүсийн боддог байсан үеийн өвчинг хэлсэн хэл
 - d) Сүнслэг оршигч

7.1 Есүсийн тухай Хуучин Гэрээнд Зөгнөж хэлсэн нь үзүүлэх

Хичээл 3-т хэрхэн хүний аврах Бурханы зорилго Есүс Христын эргэн тойронд төвлөрч байсаныг тайлбарласан. Түүний Ева, Абрахам болон Давид нарт өгсөн амлалтууд бүгд Есүсыг тэдний шууд удам угсаа гэдгийг харуулдаг. Үнэхээр ч Хуучин Гэрээ болон Христийн тухай зөгнөж хэлсэн нь бүхэлдээ Есүс уруу хандуулсан байдаг. Христээс өмнөх Израйлийн мөрдөж байсан Мосегийн Хууль нь үргэлж Есүсийг заасан байдаг. “Хууль нь биднийг Христ уруу хандуулах зааварлагч болов” (Гал.3:24). Тиймээс Дээгүүр өнгөрөх баяраар төгс байдалд байгаа хургыг золиосолдог байжээ (Египитээс гарсан нь 12:5 мөн 1Петр 1:19). Энэ нь Есүсийн золиос болохыг: “Ертөнцийн нүглийг үүрэгч Бурханы хурга”-ар (Иохан 1:29, 1Кор 5:7) төлөөлүүлж байгаа юм. Золиос болох бүх амьдаад тавигддаг шаардлага нь толбогүй байх явдал бөгөөд энэ нь Есүсийн төгс шинж чанарыг зааж байгаа юм. (Ег. 12:5, 1Петр 1:19).

Дуулал болон Хуучин Гэрээнд Аврагч ямар байх тухай тоо тоомшиггүй олон эш үзүүлэлүүд бий. Тэд ялангуяа Түүнийг хэрхэн үхэхийг дүрслэхэд гол анхаарлаа хандуулдаг. Үхдэг Аврагчийн тухай санааг Иудазм хүлээж авахаас татгалздагийн шалтгаан нь тэдгээр эш үзүүлэхүүдийг анхаараагүйд оршино. Тэдгээрээс цөөн хэдийг дор дурьдая:

Хуучин Гэрээний эш үзүүлэлт	Христэд биелсэн нь
“Бурхан минь, Бурхан минь, юунд Та намайг орхисон юм бэ?”(Дуулал 22:1)	Энэ үг загалмай дээр Есүсийн яг хэлсэн үг байсан (Мат.27:46).
“Би бол хүмүүсийн буруутгал бөгөөд ард олонд жишигдсэн Намайг хардаг бүхэн намайг тохуурхан инээдэг.Тэд уруулаа нээж толгойгоо сэгсрэн Тэр өөрийгөө Эзэнд даатгасан. Тэр түүнийг авраг.Тэр түүнийг авраг” (Дуулал 22:6-8).	Израйль Есүсийг буруутгаж тохуурхсан (Лук 23:35, 8:53).Тэд толгойгоо сэгсрэн (Мат.27:39) Түүнийг загалмайд цовдлогдох үед үүнийг хэлж байсан (Мат.27:43).

140 БУРХАН

“Мийний хэл түүшиндээ наалдсан... тэд миний гар хөлийг нэвт хатгасан” (Дуулал 22:15,16)	Энэ Христийг загалмай дээр байхад цангах үед биелэгдсэн Гар хөлийг хатгана гэдэг нь загалмайд цовдлоход хэрэглэдэг арга юм.
“Тэд миний гадуур хувцсыг хоорондоо хувааж Миний дотуур хувцасны төлөө шоддог” (Дуулал 22:18)	Энэ зөгнөлийн биелэлт Матай 27:35-д бий
Дуулал 22:22-ийн ишлэл нь хамааралтайг анхаар.	Еврей 2:12-т гардаг Есүсд
“Би ахан дүүстээ харийн хүн болж, эхийнхээ хөвгүүдэд ч гадны хүн болсон Таны өргөөний төлөөх хичээл зүтгэл намайг залгив” (Дуулал 69:8,9)	Энэ нь Христийн Еврей ах дүүс, өөрийнхөө гэр бүлээс гадуурхагдахад төрсөн сэтгэгдэлийг гаргасан байна (Иох.7:3-5, Мат.12:47-49). Энэ нь мөн Иохан 2:17-д тэмдэглэгдсэн.
“Тэд бас надад миний хүнсэнд цөсийг, намайг цангахад уулгах цууг өгсөн.” (Дуулал 69:21).	Энэ явдал Христийг загалмай дээр байхад болжээ(Мат.27:34)
Исаиа 53 нь бүхэлдээ Христийн үхлийн болон амилалтын тухай гайхамшигтай эш үзүүлсэн бөгөөд ишлэл бүрт гардаг зүйл нь алдаа мадаггүй биелсэн зүйл юм. Зөвхөн хоёр жишээг дурдая:-	
“Алагдахаар хөтлөгдөх хурга шиг хяргагчийн өмнө дуугарахгүй хонь шиг Тэр амаа нээсэнгүй” (Иса.53:7)	Бурханы Хурга Христ нь шүүх хурлын үеэр дуугүй байсаар байжээ. (Мат.27:12,14).
байжээ. (Мат.27:12,14). байх байсан, Тэр үхэлдээ баян хүнтэй хамт байсан” (Иса. 53:9).	Есүс нүгэлт гэмт хэрэгтэнгүүдтэй хамт цовдлуулсан. (Мат.27:38). Гэвч баян хүний булшинд оршуулагдсан. (Мат.27:57-60).

Хуучин гэрээний “хууль ба эш үзүүлэгчид” нь бидний Христийг ойлгох үндэс болохыг Шинэ Гэрээ нь бидэнд сануулж байгааг гайхах зүйл байхгүй. (Үйлс 26:22, 28:23, Ром 1:2,3; 16:25,26). Хэрэв бид “Мосе ба эш үзүүлэгчидийг” зөв ойлгохгүй бол түүнийг ойлгохгүй гэж Есүс өөрөө анхааруулж байсан (Лук 16:31; Иохан 5:46,47).

Мосегийн хууль Христийг зааж, эш үзүүлэгчид нь түүний талаар зөгнөж байсан нь Есүс төрөхөөсөө өмнө биетээр оршиж байгаагүй гэдгийн хангалттай нотолгоо болно. Христийг төрөхөөсөө өмнө биетээр 'урьдчилан оршиж байсан' тухай худал номлол нь түүнийг Ева, Абрахам, Давид нарын үр (удам) болох тухай удаа дараа давтагдсан амлалтыг утга учиргүй болгож

байна. Хэрэв тэр эдгээр амлалтын үед тэнгэрт хэдийнээ оршиж байсан бол хүмүүсийг удамтай болно, тэр нь Аврагч гэж амалсан Бурхан буруутай болж таарна. Матай 1 болон Лук 3-д тэмдэглэсэн Есүсийн урагийн бичигээс үзэхэд Есүсийн угсаа нь Бурханы амлалт өгсөн тэдгээр хүмүүсээс гарч байгаа юм.

Христтэй холбоотой амлалтыг Давидад өгч байх үед Христ биетээр оршиж байх учиргүй нь харагдаж байна. "Би чамаас гарах үрийг чинь чиний дараа босгож, түүний хаанчлалыг тогтооно...Би чиний Эцэг болж, тэр Миний хөвгүүн болно" (2Самуел 7:12,14). Энд ирээдүйн цаг хэрэглэсэн байгааг анхаар. Бурхан Христийн Эцэг нь болох учраас Бурханы Хүү амлалт хийгдэж байх үед орших ямар ч боломжгүй. Энэ үр "*чиний хэвлийнээс гарч ирнэ*" гэдэг нь түүнийг шууд утгаар Давидын бие махбодийн удам угсаа байна гэдгийг харуулж байна. "Эзэн эргэн буцахгүй үнэнийг Давидад тангараглахдаа Чиний биеийн үр жимснээс Би чиний сэнтийнд залрана" (Дуулал 132:11).

Соломон амлалтуудын эхний биелэлт байсан, гэхдээ тэрээр амлалтын үед аль хэдийнэ биетээр оршиж байсан болохоор (2Сам.5:14), Давидад Бурханы Хүү бие махбодийн удам угсаа нь болох тухай амлалтын гол биелэлт нь Христэд хамаарах юм. (Лук 1:31-33). "Би Давидад зөв шударга мөчир /өөрөөр хэлбэл Аврагч/ ургуулах өдрүүд ирж байна" (Иеремиа 23:5).

Христтэй хамаарах бусад эш үзүүлэлтүүдэд үүнтэй төсөөтэй ирээдүй цагийн хэлбэрүүдийг хэрэглэсэн байдаг. "Би тэдний ах дүү нарын (Мосе) дундаас чам шиг нэгэн эш үзүүлэгчийг гаргана" (Дэд Хууль 18:18) буюу 'Эш үзүүлэгч'-ийг Есүс гэж тодорхойлж Үйлс 3:22,23-т тэмдэглэгдсэн байдаг. "Нэгэн онгон бүсгүй хүүхэдтэй болж, хүү төрүүлээд түүнийгээ "Иммануел" гэж нэрлэнэ" (Иса. 7:14). Энэ Христийг төрөхөд тодоор биелсэн (Мат.1:23).

7.2 Онгон төрөлт

Христ хэвлийд олдсон болон төрсөн тухай тэмдэглэл нь түүнийг төрөхөөсөө өмнө оршиж байсан гэсэн санааг няцааж байна. Нэг цаг үед тэнгэрт гурван хүн оршиж байсан ба тэдний нэг нь алга болж тэгснээ нөгөө хоёрыгоо нь тэнгэрт үлдээгээд Маригийн хэвлийд үр хөврөл болсон гэсэн дүгнэлтийг 'Гурвал'-ын тухай худал номлолыг баригчид хийжээ. Бурханыг оролцуулаад бүх оршихуй нь биетээр буюу биеийн хэлбэрээр байдаг гэж Бид Сударт үзсэн. Иймд бид 'урьдчилан орших' үзлээс үүдэн, Христийг тэнгэрээс биеэр

буун Маригийн хэвлийд орсон гэж дүгнэхээс аргагүй болж байна. Эдгээр ээдрээтэй шашны онол нь Судрын хичээлд огт таарахгүй зүйл юм. Христийн эхлэлийн тухай тэмдэглэл нь түүнийг биеэр тэнгэрийг орхин Маригийн хэвлийд орсон гэх ямар ч шалтгаан биш юм. Энэ талаар нотолгооны дутмаг байгаа нь 'гурвал'-ийн номлолд том 'холбох юмгүй хоосон зай' үлдээж байгаа юм.

Тэнгэрийн элч Габриел Марид харагдахдаа "Чи хэвлийдээ үртэй болж хүү төрүүлнэ. Түүнийг чи Есүс гэж нэрлэх болно. Хүү аугаа нэгэн болох ба Хамгийн Дээдийн Хүү гэж дуудагдана...Мариа тэнгэр элчид "энэ нь яаж бүтэх билээ?" (тэр онгон байсан) гэсэнд тэнгэр элч Ариун сүнс чам дээр ирж Хамгийн Дээдийн хүч чамайг бүрхэнэ. Тиймээс төрөх ариун нэгэн нь Бурханы Хүү гэж дуудагдах болно" (Лук 1:31-35) гэсэн мэдээтэй ирдэг.

Есүс төрөхдөө Бурханы Хүү байхыг хоёр дахин онцгойлон тэмдэглэж байна; түүнийг төрөхөөс өмнө Бурханы Хүү оршиж байгаагүй бололтой. Ирээдүй цаг олон байгааг тэмдэглэх нь зүйтэй.- жишээ нь "тэр аугаа нэгэн *болно*" гэжээ. Хэрэв Тэнгэр элчийг Марид тэдгээр үгсийг хэлж байхад Есүс бодитоор оршиж байсан ахул тэр аль хэдийнээ Аугаа байх байсан. Есүс Давидын "удам"(Илчлэлт 22:16), ба Грек 'генос' нь Есүсийг Давидаас 'гаралтай' гэсэн утгатай юм.

Есүс хэвлийд бүрэлдсэн нь

Ариун сүнс (Бурханы амьсгаа/эрх мэдэл) Марид үйлчилснээр тэрээр эр хүнтэй энгэр зөрүүлэлгүй Есүсийг хэвлийдээ олж

чадсан. Иймд Иосеф Есүсийн жинхэнэ эцэг биш юм. Ариун Сүнснийг эр хүн биш гэдгийг ойлгох хэрэгтэй. (Хичээл 2-г үз). Есүс Ариун Сүнсний бус харин Бурханы Хүү байсан юм. Бурхан Өөрийн Ариун Сүнсээ Мари дээр хэрэглэснээр “тиймээс тэр ариун нэгэн нь” түүнээс төрж “Бурханы Хүү гэж дуудагдах” болсон (Лук 1:35). “Тиймээс” гэсэн үгийн хэрэглээ нь Ариун Сүнс Маригийн хэвлийд үйлчилээгүй бол Бурханы Хүү оршин тогтнохгүй байсан гэсэн санааг агуулана.

Есүс Маригийн хэвлийд ‘олдсон’ (Лук 1:31) нь түүнийг тухайн цагаас өмнө бодитоор орших боломжгүй байсны нотолгоо юм. Хэрэв бид санааг ‘олвол’

энэ нь бидний дотор талд эхлэнэ. Есүс Марийн хэвлийд олдсноор тэр бусад хүн төрөлхтөний адил үл хөврөл болж эхэлсэн. Библийн хамгийн алдартай ишлэл болох Иохан 3:16-д Есүсийг “өгөгдсөн цорын ганц хүү” гэж тэмдэглэсэн байдаг. Энэ ишлэлийг иш татдаг олон сая хүмүүс түүний утга санааг анхааралтай бодож үздэггүй. Хэрэв Есүс “өгөгдсөн” юм бол тэр Марийн хэвлийд олдсон үеэс ‘эхэлсэн’ (“өгөгдсөн” гэсэн үгтэй холбоотой). Хэрэв Бурхан Есүсийн эцэг болсон юм бол Эцэг нь түүнээс ах гэдгийг энэ нь тодорхой нотолгоо юм. Бурханд эхлэл байхгүй (Дуулал 90:2) тиймээс Есүс Өөрөө Бурхан байх учиргүй (Хичээл 8-д энэ тухай хөндсөн).

Бурхан Есүсийг Адам шиг бүтээгээгүй харин “өгсөн” нь тун ач холбогдолтой юм. Энэ нь Бурханы Есүстэй тогтоосон холбооны дотно ойрын тайлбарлаж байгаа юм.- “Бурхан Дэлхийг Христ дотор Өөртэйгээ эвлэрүүлсэн” (2 Кор.5:19). Христ зөвхөн тоосоор бүтээгдэхээс илүүтэй Бурханаас *өгөгдсөн нь* Өөрийн Эцэг Бурханы замын төлөө түүнд төрөлхийн чадвар байдгийг тайлбарлахад мөн туслана.

Иса.49:5,6 нь Христийг дэлхийн гэрэл гэгээ гэсэн эш үзүүлэхийг агуулдаг. Тэрээр түүнийг бүтээсэн. (Иохан 8:12). Түүнийг “Намайг Өөрийнхөө зарц болгохоор эхийн хэвлийнээс буй болгосон Эзэн”-ий зуучлагч гэж дүрсэлсэн байна. Христ тэгэхээр Марийн хэвлийд Бурханаас Өөрийн Ариун Сүнсээр дамжуулан ‘хийгдсэн’ юм. Ингэхээр Марийн хэвлий Христийн биет гарал үүслийн газар нь болж байна.

144 БУРХАН

Бид Хичээл 7.1-р Дуулал 22 Христийн загалмай дээрх бодлын талаар эш үзүүлснийг үзсэн. Тэрээр Бурханд “Намайг эхийн хэвлийнээс гаргасан...Би төрөхөөсөө Таньд даалгасан. Эхийнхээ хэвлийд байх үеэс минь Та миний Бурхан байсан” (Дуулал 22:9,10) гэдэг. Үхэх үедээ Христ Бурханы хүчээр бүтээгдсэн өөрийн гарал үүсэл- өөрийн эх Марийн хэвлий руу эргэж хардаг. Сайн Мэдээн дэх Христийн “эх”-ийн хувьд Мариг дүрсэлсэн дүрслэл нь Маригаас төрөхөөс өмнө Түүний оршиж байсан гэсэн санааг үгүйсгэдэг.

Мари энгийн эцэг эхтэй ердийн хүн байсан. Тэрээр энгийн хүн болох баптист Иоханыг төрүүлсэн үеэлтэй байсан явдал үүнийг нотолно (Лук 1:36). Мари энгийн хүн байгаагүй гэсэн Ромын католикийн санаа нь Христ нэг дор “хүний хүү” мөн “Бурханы Хүү” байх боломжгүй гэсэн утгыг харуулдаг. Шинэ Гэрээнд түүнийг эдгээр нэрээр байнга нэрлэдэг. Тэр цэвэр хүмүүн ээжтэй учраас “хүний хүү” бөгөөд Бурханы Ариун Сүнсээр Марид үйлчилснээр “Бурханы Хүү” мөн (Лук 1:35) ба энэ нь, Бурхан түүний Эцэг гэсэн үг юм.

Энэ сайхан төлөвлөгөө хэрэв Мариг энгийн бус эмэгтэй байсан бол бүтэхгүй байх сан. “Хэн бузраас цэврийг бий болгож чадах вэ? Хэн ч үгүй...Цэвэр байхаар Хүн гэдэг нь юу юм бэ? Зөвт байхаар эмэгтэйгээс төрсөн нэгэн нь юу юм бэ? Эмэгтэйгээс төрсөн тэрээр яаж цэвэр байж чадах вэ?”(Иов 14:4; 15:14; 25:4). Энэ нь Мари буюу Есүсийн хувьд ямар ч нүгэлгүйгээр, ёс суртахууны цэвэр байдлаар төрөх боломжтой гэсэн санаанд анхаарлыг хандуулж байна.

Энгийн хүмүүн эцэг эхтэй, “эмэгтэйгээс төрсөн” Мари бидний цэвэр бус, хүний мөн чанарыг “эмэгтэй хүнээс хийгдсэн” Есүст дамжуулсан байх нь гарцаагүй.(Гал.4:4). Маригаар дамжуулан “хийгдсэн” гэсэн хэл нь түүнийг Маригаас төрөлгүйгээр биетэйгээр оршиж байгаагүй нь нотлох нэг нотолгоо болно. Диаглот Галат 4:4-т “Эмэгтэй хүнээс *бүтээгдэх*” гэж өгүүлсэн.

Сайн Мэдээ байнга Маригийн хүмүүн шинжийг дурьддаг. Христ Марийг гурван ч удаа өөрийнх нь сүнслэг ойлголт дутмаг байгааг буруушаан хэлдэг (Лук 2:49;Иохан 2:4) Мари түүний хэлсэн зүйлийг бүгдийг нь ойлгодоггүй.(Лук 2:50). Энэ нь Бурханы Хүүтэй боловч хүний шинж чанартай эмэгтэйг хүнээс гарах зүйл бөгөөд хэдийгээр Тэрээр хүний шинж чанарыг агуулсан ч Марийгаас

илүү сүнслэг ойлголттой юм. Христээс хойш Иосеф Маритай харьцаанд ордог (Мат.1:25) учир тэднийг хэвийн гэр бүлийн харилцаагүй байсан гэж бодох үндэслэл үгүй юм.

Матай 12:46,47 –дахь Христийн “эх болон ах дүүс”-ийн тухай дурдсан нь Марид Есүсээс өөр хүүхдүүд байсаныг харуулна. Есүс зөвхөн “түүний анхны төрөлт” байсан юм. Католик хичээлүүд Мариг онгоороо байсаар тэнгэрт очсон гэсэн нь Библитэй ямар ч холбоогүй болно. Мөнх бус шинжтэй хүмүүн болохын хувьд Мари хөгширч нас барсан. Үүнээс гадна бид Иохан 3:13 –т “Тэнгэрт дээш гарсан хүн нэг ч байхгүй” гэснийг уншина. Христ хүний мөн чанар байгаа гэсэн баримт нь (Еврей 2:14-18; Ром8:3 – г үз) Түүний Эцэгт эл шинж байхгүй гэдгээс энэ нь түүний эхэд байгаа гэсэн үг болно.

7.3 Бурханы төлөвлөгөөн дахь Христийн байр суурь

Бурхан Өөрийн төлөвлөгөөн дээр гэнэтийн шийдвэр гаргадаггүй. Хүний төрлөхтний түүх цаашид үргэлжлэх ахуйд Тэрээр зорилгууддаа нэмэлт

хэсгүүдийг боловсруулж оруулдаг. Бурханд бүтээлийг эхлэсэн яг тэр үеэс бүрэн төлөвлөгөө хийсэн байсан. (Иохан 1:1). Тэгэхээр Түүний Хүүтэй болох хүсэл эхнээсээ Түүний төлөвлөгөөнд байсан аж. Хуучин Гэрээ бүхэлдээ Христэд аврал байх талаархи Бурханы төлөвлөгөөний янз бүрийн санаануудыг гаргасан байдаг.

Бурхан Христэд ямар зорилготой байсныг Хуучин Гэрээнд амлалтууд, эш үзүүлэгчдийн зөгнөл, Мосегийн Хуулийн хэлбэрүүдээр дамжуулан ямагт дурьддаг гэдгийг бид байнга харуулж ирсэн. Бурханы мэдлэгийн ачаар Иэрээр Хүүтэй болж, бүтээлийг бодит болгов. (Еврей 1:1,2, Грек өгүүлэл; “-аар” гэснийг “дагуу” гэж орчуулвал дээр).

Христээр дамжуулж Бурхан хүн төрөлхтөний түүхийн үеийг ийн зөвшөөрөв. (Еврей 1:2 Грек)Хуучин гэрээнд тэмдэглэгдсэнчилэн, Бурхан хүнд бүх л цаг үед хийсэн илчлэлт нь Христийг дурьдсан зүйлсээр дүүрэн байдаг.

146 БУРХАН

Христийн давамгайлал байдал ба Бурханд тэрээр ямар агуу их, үндсэн чухал ач холбогдолтойг бид бүрэн ойлгоход бэрх юм. Иймд Христ хэдийгээр Маригаас төрж бодитоор орших болсон ч эхнээсээ Бурханы оюун ухаан, зорилгод багтан оршиж байсан байна. Еврей 1:4-7,13,14 –т Христ тэнгэрийн элч байгаагүй; мөнх бус амьдралдаа тэр тэнгэр элч нараас дор байсан ч тэдний харж байсан Бурханаас “өгсөн цорын ганц Хүү” (Иохан 3.16) гэдгээс ч илүү аугаа их хүндэтгэл хүртсэн байсан. Бид өмнө нь Сударт заасан оршихуйн цорын ганц хэлбэр нь бие махбодийн хэлбэр гэж үзсэн. Иймд Христ төрөхөөс өмнө ‘сүнс’ байдлаар байгаагүй. 1Петр 1:20-д энэ нөхцөлийг өгүүлсэн: Христ “ертөнцийн сууриас өмнө урьдаас мэдэгдсэн боловч цаг хугацааны төгсгөлд та нарын төлөө үзэгдэнэ” гэжээ.

Есүс Сайн Мэдээний гол цөм нь байсан. Энэ нь Бурханы “эш үзүүлэгчдээрээ дамжуулан Ариун Сүнсүүдэд урьдаас амласан тэрхүү сайн мэдээ нь түүний Хүүгийн тухай юм. Тэр нь махан биеэр Давидын үр удмаас төрсөн бөгөөд ариун байдлын Сүнсээр үхэгсэдээс амилуулагдснаар хүч дотор Бурханы Хүү гэж тодорхойлогдсон бидний Эзэн Есүс Христийнх болохоор дуудагдсан” (Ром 1:1-4).

Христийн түүхийг хураангуйлвал:-

1. Хуучин Гэрээнд амлалт өгөгдсөн - өөрөөр хэлбэл Бурханы төлөвлөгөөнд;
2. Онгоноороо төрөх замаар Давидын үр болж бодит хүн болж бүтээгдсэн.
3. Өөрийн төгс шинж чанарыг (“ариун байдлын сүнс”)өөрийн мөнх бус амьдралын үеэр үзүүлсэн.
4. Тэр дахин амилсан ба дахин нийтэд Бурханы Хүү гэдгээ эш үзүүлэгчдын сүнсний бэлэг хүртсэн номлолоор тунхаглагдсан.

13 Бурхан урьдчилан мэддэг

. Хэрэв бид Бурхан ‘ирээдүйд’ болох бүх зүйлсийг мэддэг гэдэг баримттыг хүлээн авч чадвал Христ бодитойгоор оршилгүйгээр харин Бурханы оюун ухаанд эхнээсээ бүрэн байсаныг ойлгон хүндэтгэхэд бидэнд ихээхэн тустай. Тэрээр бүрэн ‘урьдчилсан мэдлэгтэй’. Бурхан тэгэхээр байхгүй юмсын талаар байгаа юм

шиг ярьж, бодож чадна. Энэ нь ирээдүйн тухай Түүний бүрэн мэдлэг юм. Бурхан “байхгүйг байгаагаараа дуудагч” (Ром 4:17) юм. Тэр тэгэхээр “Би эхлэлээс төгсгөлийг тунхаглаж, хийгдээгүй байгаа зүйлийг өнө эртнээс мэдүүлсэн. Миний зорилго хэрэгжинэ. Би өөрийн тааламжит бүхнийг гүйцэтгэнэ” (Иса.46:10) гэж тунхаглаж чадна. Ийм учраас үхсэн хүнийг амьд юм шиг ярьж, төрөхөөсөө өмнө амьд байсан юм шиг ярьж чадна

Бурханы “Зөвөлгөө” буюу Үг нь эхнээсээ Христийг зөгнөж байсан. Тэр үргэлж Бурханы зорилгод буюу “тааламжид” байсан. Тиймээс Христ аль нэг үед бодитоор төрөх байсан нь тодорхой юм. Бурхан Христэд тавьсан зорилгоо биелүүлэх юм. Бурханы урьдчилан мэдлэг баттай гэдэг нь тиймээс Түүний үгний итгэлтэй байлдлаар харагддаг. Библийн Еврей нь Бурхан ирээдүйд хийхээр амалсан зүйлсийг дүрслэхдээ өнгөрсөн цагийг хэрэглэсэн нь ‘эш үзүүлэхийн төгс’ цагийн хэлбэр байна. Иймд сүмийг зөвхөн Бурхан амласан байтал Давид түүнийг “Энэ бол Бурханы Эзэний Өргөө” (Шастирын Дэд 22:1) гэж хэлжээ. Давид ирээдүйн зүйлсийн тухай ярихдаа одоо цагийн хэлбэрийг хэрэглэлээ тийм их амлалтын үгэнд итгэжээ. Сударт Бурханы урьдчилсан мэдлэгийн талаар өгүүлдэг. Бурхан Абрахамд өгсөн түүний амлалт биелнэ гэдэгт тэр маш их итгэлтэй байсан. Абрахамыг үргүй байх үед Тэр түүнд “Би энэ газрыг ...чиний үр удмыханд өгсөн билээ”. (Эхлэл 15:18) гэж хэлжээ. Яг ийм адил үед үр (Исаак/Христ) төрөхөөс өмнө Бурхан цааш нь амлахдаа “Би чамайг олон үндэстний өвөг болгосон...” (Эхлэл 17:5). Үнэхээр Бурхан “байхгүйг байгаагаар дуудагч” юм.

Иймд Христ номлолынхоо үеэр хэдийгээр тэр үед болоогүй байсан ч Бурхан хэрхэн “Түүний (Христын) гарт бүх юмсыг өгөхийг”(Иохан 3:35) ярьжээ.

“Та бүх юмсыг түүний (Хримтийн) хөл дор оруулсан...харин эдүгээ түүний эрхэнд бүх юмс оруулагдсныг бид харахан үзээгүй л байна” (Еврей 2:8).

Бурхан Есүсээр дамжуулан Өөрийн аврах төлөвлөгөөний тухай “эртнээс ариун эш үзүүлэгчдийнхээ амаар” дамжуулан айлдсан (Лук 1:70). Тэд Бурханы төлөвлөгөөтэй тун нягт холбоотой байсан учир тэдгээр эрчүүлийг эхнээсээ байгаагүй ч байсан юмшиг ярьдаг.

148 БУРХАН

Нөгөөтөйгүүр эш үзүүлэгчид нь Бурханы төлөвлөгөөнд эхнээсээ байсан гэж хэлж болно. Иеремиа нь анхны жишээ. Бурхан түүнд “эхийн хэвлийд чамайг бүрэлдэхээс өмнө би чамайг мэдсэн бөгөөд төрөхөөс өмнө Би чамайг ариусгаж эш үзүүлэгч болгон томилсон”(Иер.1:5) гэжээ. Иймд Бурхан бүтээлээс өмнө Иеремиагийн тухай бүгдийг мэддэг байжээ. Ийм байдлаар Бурхан Персийн хаан Сирусын тухай төрөхөөс нь өмнө айлдаж түүнийг орших үеийн хэлийг хэрэглэжээ. (Иса.45:1-5). Еврей 7:9-10 нь хэн нэгэнийг төрөөгүй байхад хэрэглэж байсан оршихуйн хэлийг хэрэглэсэн жишээ юм.

Үүнтэй нэг адилаар Иеремиа болон бусад эш үзүүлэгчидийг Бурханы төлөвлөгөөнд үүрэг гүйцэтгэсэнийг үзвэл тэднийг бүтээлээс өмнө оршиж байсан хэмээн ярьдаг. Тэгэхээр жинхэнэ итгэгч нарыг тэр үед оршиж байсан гэж хэлдэг. Ингэхээр бид Бурханы оюун ухаанаас өөрөөр бодит биеэр оршиж байгаагүй нь илт. Бурхан “биднийг ...өөрийн зорилго болон бүхий л өнө мөнхөөс Христ Есүс дотор бидэнд соёрхсон нигүүслийн дагуу аварсан. Тэр биднийг ариун дуудлагаар дуудсан” (2Тим 1:9). Бурханы “өмнө биднийг Бурхан ертөнцийн сууриас урьд Түүний дотор сонгосончлон ...Тэр өөрийн хүслийн сайн тааллын дагуу үрчлэн авахаар урьдаас тогтжээ.” (Ефес 1:4,5). Бурхан хувь хүмүүсийг эхнээс нь урьдчилан мэдэж, “тэмдэг тавьдаг” (“хувь заягийг нь шийддэг”) гэсэн санаа нь тэд эхнээсээ Бурханы оюун ухаанд оршиж байсаныг харуулж байна.

Энэ бүхний дүнд, Христ Бурханы зорилгын үр дүн болохын хувьд эхнээсээ Бурханы оюун ухаан болон төлөвлөгөөнд биет байдлаар орших боломж байгаагүй ч түүнийг оршиж байсан гэж ярих нь зүйтэй: Тэр “номд ертөнцийн сууриас мөргөсөн хургын амь.”(Илчлэлт 13:8) байсан. Есүс тэр үед үнэндээ үхээгүй; Тэр загалмай дээр 4000 жилийн дараа аврагдсан “Бурханы Хурга” байсан. (Иохан 1:29, 1Кор.5:7). Ийм замаар Есүсийг эхнээсээ сонгосон байсан (1Петр 1:20) тэгэхээр итгэгч нарыг ч мөн адил юм.(Ефес 1:4; Грекийн “сонгосон” гэсэн үг эдгээр ишлэлүүдэд хэрэглэгдсэн). Эд бүгдийг ойлгоход бидний хүндрэлтэй зүйл нь Бурхан хэрхэн цаг хугацааны үзлээс гадуур ажиллаж байдгийг бид хялбараар төсөөлж чаддагүйд оршино. ‘Итгэл’ гэдэг

нь цаг хугацаанд баригдалгүйгээр Бурханы үзэл бодлоос юмс уруу харах чадвар юм.

7.4 “Эхэнд Үг Байсан”, Иохан 1:1-3.

“Эхэнд үг байсан, Үг Бурхантай хамт байсан ба Үг нь Бурхан байсан. Энэ нэгэн эхэнд Бурхантай хамт байсан. Бүх юм Түүгээр бий болсон” (Иохан 1:1-3).

Эдгээр ишлэлүүдийг зөвөөр ойлгох юм бол сүүлчмйн хэсэгт хийсэн дүгнэлтүүдийг батжуулж, өргөжүүлнэ. Гэлээ ч энэ ишлэлийг буруу ойлгох нь түгээмэл бөгөөд ингэснээр энэ нь Есүсийг төрөхөөсөө өмнө тэнгэрт байсан гэж заадаг аж. Эдгээр ишлэлийг зөв ойлгох нь юун түрүүн “Үг” гэдэг нь текстэнд ямар утга илэрхийлдэгийг ойлгохоос шалтгаалана. Энэ нь хүнд шууд хамаархагуйв Учир нь хүн “Бурхантай хамт” байхын зэрэгцээ нэг зэрэг Бурхан байж чадахгүй юм. Грекийн “логос” гэсэн үг нь “үг” гэж энд орчуулагдсан бөгөөд “Есүс” гэсэн утгыг илэрхийлэхгүй. Энэ ихэвчлэн “Үг” гэж орчуулагддаг ч мөн тэрчлэн дараахь байдлаар орчуулагдна:-

Тооцоо	Учир шалтгаан
Харилцаа холбоо	Онол
Санаа	Номлох
Шалтгаан	хэлэх
Цэвэр байдал	

Грекээр “логос” нь эр хүйсний үг учир “Үг” нь зөвхөн “тэр эр” буюу “he” гэж яригддаг. Гэхдээ энэ нь эрэгтэй хүн буюу Есүс гэсэнтэй ямар ч хамаагүй. Герман (Лутер) хувилбарт ‘das Wort’ (саармаг) гэж гардаг. Францаар (Сегон) хувилбарт ‘la parole’ гэсэн эм хүйсний үг байдаг учир “үг”- бол заавал эрэгтэй хүнийг илэрхийлэх албагүй гэдгийг харуулж байна.

“Эхэнд”

‘Логос’ нь үгээр буюу бусад харилцааны хэлбэрээр гадагш илэрхийлэгдэх дотоод бодол санаа юм. Эхэнд Бурханд энэхүү ‘логос’ байсан. Энэ ганц зорилго нь Христэд төвлөрсөн. Бид Бурханы Сүнс хэрхэн дотоод бодлоо ажиллагаанд оруулдагийг харуулсан. Ингэснээр Түүний Сүнс болон Түүний

150 БУРХАН

Үгийн хооронд холбоо үүссэн. (2.2 Хэсэгээс хар). Бурханы Сүнс хүмүүстэй Өөрийн төлөвлөгөөг биелүүлж, Өөрийн бичигдсэн Үгээ эхнээсээ онгод оруулж Христийн санааг үйл ажиллагаа болон үгэнд холбосон. Христ Бурханы “логос” байсан учир Бурханы Сүнс Христийн талаархи Бурханы төлөвлөгөөг бүх л үйл ажиллагаанд илэрхийлж байсан. Хуучин Гэрээнд гардаг үйл явдлууд яагаад ихэвчлэн Христийн хэв шижит байдгийн учир нь энэ юм. Гэхдээ хүн доторхи Христ “үг” байгаагүй гэж хэтрүүлж хэлж болохгүй. Энэ нь “үг” байсан Христээр дамжуулан аврах Бурханы төлөвлөгөө байсан юм. “Логос (“Үг”) нь ихэвчлэн Христийн тухай Сайн Мэдээ, өөрөөр хэлбэл “Христийн үг”тэй холбогдон хэрэглэгддэг - (Кол 3:16, Мат.13:19, Иохан 5:24, Үйлс 19:10, 1Тес.1:8 гэх мэт). “Логос” нь Христийн хувийн шиж чанараас илүүтэйгээр Христийн тухай байсан гэдгийг анхаар. Христ төрөхөд энэ “үг” нь махан болоод цусан хэлбэрийг олсон- “Үг нь махан бие болжээ” (Иохан 1:14). Есүс уг чанартаа “үг” бус харин “махан бие болсон үг” байсан. Тэрээр өмнөх цаг үед бус харин уг чанартаа Маригаас төрсөнөөр “үг” болжээ.

Христийн тухай төлөвлөгөө буюу мэдээ нь эхэндээ Бурхантай байсан. Гэхдээ 1-р зуунд Христийн хүн төрөл болон түүний тухай Сайн Мэдээний номлолд ил тод илчлэгдсэн юм. Иймд Бурхан Өөрийн үгээ Христээр дамжуулан айлдсан. (Еврей 1:1,2). Христ Бурханыг бидэнд нээхийн тулд Бурханы үгсийг хэлж, Бурханы тушаалын үгээр гайхамшигийг хийж байсаныг дахин давтан өгүүлдэг. (Иохан 2:22, 3:34, 7:16, 10”-,38, 14:10,24).

Паул “бүх үндэстнүүдэд” түүний тухай Сайн Мэдээг тунхаглах Христийн тушаалыг дагаж мөрдөж байсан. “Өнө эртний турш нууцлагдаж байсан боловч эдүгээ илэрхий болсон нууцын ичлэлийн дагуу, миний сайн мэдээ ба Есүс Христийн тунхаглалын дагуу одоо та нарын байгуулах чадалтай...бүх үндэстнүүдэд мэдүүлнэ”(Ром 16:25,26 мөн 1Кор.2:7). Мөнхийн амь зөвхөн Христийн ажлаар дамжуулан биелэх боломжтой байсан. (Иохан 3:16, 6:53); Гэвч эхэнд Христийн хийх золиосолыг Бурхан мэдээд хүнд мөнхийн амь санал болгох энэ төлөвлөгөөтэй байсан. Энэ саналын бүрэн илчлэлт нь Есүсийг төрсний болон үхсний дараа л ирсэн юм. “Бурхан ..газар дэлхийг бүтээхээс өмнө амласан мөнхийн амь ; гэхдээ зохистой цагт Өөрийн үгийг (амийн) тунхаглалаар илэрхийлжээ”(Тит.1:2,5). Бурханы эш үзүүлэгчидийн хэлсэн “үг” эхнээсээ

Бурхантай оршиж байсан учраас тэднийг ямагт оршиж байснаар ярьдагийг бид сая харсан.

Есүсийн сургаалт зүйрлэл эдгээр зүйлсийн ихэнхийг илчэлдэг. Тэр тэгэхээр өөртэйгөө холбоотой зөгнөлийг биелүүлсэн юм. “Би сургаалт зүйрлэлээр ам нээнэ. Би дэлхийн сууриас эхлэн нууцлагдсан зүйлсийг хэлэх болно” (Мат.13:35). Энэ нь “эхэнд...Бурхантай хамт байсан үг” нь Христийг төрөхөд “махан бие болсон” байхыг илэрхийлсэн утгатай.

“Үг бол Бурхан Байсан”

Бид одоо “Үг бол Бурхан байсан” гэдэг нь ямар утгатайг авч үзэх боломжтой боллоо. Бидний төлөвлөгөө болон бодол санаа үндсэндээ биднийх. “Би Лондон уруу явлаа” гэдэг нь миний зорилгыг илэрхийлж байгаа харилцаа буюу “үг” юм. Учир нь энэ миний зорилго. Христ дэх Бурханы төлөвлөгөөг үүнтэй адил ойлгож болно. “Тэр нь дотроо бодогчтой (хүн) адил” (Сургаалт үгс 23:7) гэснээр Бурхан бодож байна тэгэхээр оршиж байна. Иймд Бурханы үг буюу бодол нь Бурхан юм: “Үг бол Бурхан байсан”. Иймийн учир Бурхан болоод Түүний үгийн хооронд маш ойр холбоо байгаа юм. Дуулал 29:8-ийн зүйрлэл маш нийтлэг юм: “Эзэний дуу хоолой цөл газрыг чичрээнэ, Эзэн цөл газрыг чичрээнэ”. “Та нар Намайг сонсоогүй гэж Эзэн хэлэв” (Иер.25:7) гэсэн үгс эш үзүүлэлтэд нийтлэг тохиолдоно. Үүгээр Бурхан ‘Та нар эш үзүүлэгчдээр хэлүүлсэн Миний үгийг сонссонгүй’ гэж хэлж байгаа юм. Давид Бурханы үгийг түүний дэнлүү ба гэрэл мэт авч (Дуулал 119:105) тэрээр “Эзэн минь Ма миний гэрэл учраас Эзэн харанхуйг минь гэрэлтүүлдэг” (2 Сам.22:29) гэж хэлдэг нь Бурхан хийгээд Түүний үг зэрэгцээ гэдгийг харуулж байна. Тэгэхээр Бурханы үг Тэр Өөрөө гэдгийг төлөөлж байгаа гэдэг нь ойлгомжтой. Өөрөөр хэлбэл хэдийгээр энэ нь хүн биш ч гэлээ хүн болохын хувьд ярьж байгаа юм. (5-р ГАЖИЛТ(Digression)-д ‘Хүнчлэлийн зарчимууд’-г хар) Бурхан өөрөө үнэн мөн (Иохан 3:33, 8:26; 1Иохан 5:10) бөгөөд иймээс Бурханы үг нь ч мөн адил үнэн юм (Иохан 17:17). Үүнтэй адилаар Есүс өөрийнхөө үгийг маш ойр нягтаар тодорхойлсноор үгээ хүнчлэн үзүүлжээ. “Намайг голж Миний үгийг хүлээж авдаггүй хүнийг шүүх шүүгч бий. Миний хэлсэн үг эцсийн өдөрт түүнийг шүүнэ.”(Иохан 12:48). Есүс өөрийнхөө үгсийн тухай яг бодит хүн өөрөөр хэлбэл өөрийгөө байгаа мэтээр ярьдаг. Түүний үгс Есүстэй тун ойроор холбогдсон тул хүнчлэгдсэн юм.

152 БУРХАН

Бурханы үг хүн шиг хүнчлэгдсэн, өөрөөр хэлбэл Иохан 1:1-3-дахь Бурхан Өөрөө юм. Иймд бид Үгтэй холбон “Бүх юм Түүгээр бий болсон” (Иохан 1:3) гэж ойлгодог. Гэхдээ бүх зүйлсийг Өөрийнхөө тушаалын үгээр “*Бурхан бүтээсэн*”(Эхлэл 1:1). Ийм учраас Бурханы Үгийг Бурхан Өөрөө байгаа

мэтээр яригддаг. Бидний зүрхэн дэх Бурханы үгээр Бурхан бидэнтэй ойрхон байдаг гэсэн гол чухал зүйлийг тэмдэглэе.

Эхлэл 1 нь Христээр өөрөө бус Бурхан харин Өөрийн үгээр дамжуулан Бүтээгч байсан гэдгийг нотолно. Энэ нь Христ өөрөө бус харин *үг* бүх зүйлсийг бүтээсэн гэж дүрслэгджээ (Иохан 1:1-3). “Эзэний үгээр тэнгэрүүд, амных нь амьсгалаар тэдгээрийн бүх эрхэс бүтээгдсэн. Түүнийг айлдахад тэр нь биелсэн” (Дуулал 33:6,9). Одоо ч гэсэн Түүний үгээр байгалийн юмсын бүтээгдэж байгаа: “Тэр Өөрийнтушаалыг дэлхийд илгээдэг. Түүний үг маш хурдан тархдаг. Тэр цасыг ноос шиг буулгадаг.” (Дуулал 147:15-18).

Бурханы үг Түүний бүтээгч хүч бөгөөд Тэр түүнийг Маригийн хэвлийд Есүсийг оруулахад хэрэглэсэн. Түүний Ариун Сүнсээр (Лук 1:35) үйл ажиллагаа болсон Бурханы төлөвлөгөө болох Үг нь Христийг буй болгосон юм. Мари өөрт нь Христ олох гэж байгаа мэдээний хариуд үүнийг хүлээн зөвшөөрсөн юм. “Хэлсэн үгийн тань дагуу надад биелэх болтугай” (Лук 1:38).

Бид Бурханы Үг/Сүнс нь Хуучин Гэрээнд тэр аяараа дурдагдсан Түүний зорилгыг тусгаж байгааг бид үзлээ. Үүний хэр зэрэг үнэнийг Үйлс 13:47-д харуулсан байдаг. Түүнд Есүсийг Хуучин Гэрээний эш үзүүлэгчидийн үгнүүдтэй эн зэрэгцүүлэн өгүүлсэн байдаг: “(Еврей нар) түүнийг мэдээгүй ба эш үзүүлэгчдийн дуу хоолойг ч бас адил”. Христийг төрөхөд Бурханы бүх Үг/Сүнс хүн болох Есүс Христээр илэрхийлэгдсэн юм. Дагалдагч Иохан онгод орсон дор, дагалдагчид биеээрээ уулзаж, харж чадсан Христэд хэрхэн мөнхийн амьдралын тухай Бурханы төлөвлөгөө илэрхийлэгдсэнийг баяртайгаар өгүүлсэн Тэд Бурханы Үг болоод Христ дэх авралын тухай Түүний төлөвлөгөөгөөр үйл ажиллагаа явуулж байгаагаа Иохан одоо хүлээн зөвшөөрдөг. (1Иохан 1:1-3). Хэдийгээр бид Христийг бодитоор харж чадахгүй ч түүнийг үнэнээр нь ойлогосноор бидний талаархи Бурханы зорилгыг дотно сэтгэлээрээ мэдэж тэгснээр мөнхийн амийг олго гэдэгтээ итгэж чадах болсондоо баярлаж болно. (1 Петр 1:8,9). “Би

Христийг үнэнхээр *мэддэг* үү?” гэсэн асуултыг бил өөрсдөөсөө асуудаг: Есүс хэмээх нэгэн сайн хүн нэгэн цагт байжээ гэдэг нь хангалтгүй. Библийг залибаран зогсолтгүй судалснаар Түүнийг өөрийгөө Аврагч гэдгийг хурдан ойлгож баптисмаар өөрийгөө түүнрүү холбох боломжтой болно.

ХИЧЭЭЛ 7: Асуултууд

1. Есүс төрөхөөсөө өмнө биетээр оршиж байсан уу?
 - a) Тийм
 - b) Үгүй
2. Есүсийг төрөхөөсөө өмнө оршиж байсан гэж ямар утгаар хэлж болох вэ?
 - a) Тэнгэр элчийн хэлбэрээр
 - b) Гурвалсан /нэг дор эцэг,хүү, ариун сүнс байх/ хэлбэрээр
 - c) Сүнс хэлбэрээр
 - d) Зөвхөн Бурханы зорилго болон оюун санаанд
3. Маригийн талаархи дараах зүйлсийн аль нь үнэн бэ?
 - a) Тэр төгс төгөлдөр, нүгэлгүй эмэгтэй байсан
 - b) Тэр жирийн эмэгтэй байсан
 - c) Тэр Ариун сүнсээр Есүсийг хэвлийдээ олж жирэмсэлсэн
 - d) Тэр одоо бидний залибаралыг Есүст санал болгож байна.
4. Есүс дэлхийг бүтээсэн үү?
 - a) Тийм
 - b) Үгүй

8:1 Оршил

Их Эзэн Есүс Христ төгс зан чанар хөгжүүлэх явцдаа гэдийг ялан дийлсэн учир хүндэтгэл өргөмжлөл хүлээгээгүй гэх үзэл нь Христч үзэл дэхь хамгийн том эмгэнэлүүдийн нэг яах аргагүй мөн. “ Эцэг, хүү, Ариун Сүнс гурвын холбоо” хэмээх өргөн түгсэн хоосон номлолд Есүсийг Өөрөө Бурхан гэж үздэг. Бурхан бузар муугаар соригддоггүй /Иак. 1:13/, мөн гэм үйлдэх ямар ч боломжгүй тул энэ нь Христ гэм нүгэлтэй үхэн хатан тэмцэх шаардлага үнэндээ байгаагүй гэсэн үг. Ертөнц дэхь Түүний амьдрал хиймэл байж, хүн төрөлхтөний үзэж туулдгийг тэрээр амсаагүй. Христ өөрөө үүнд нэрвэгдээгүй болохоор хүмүүн төрөлхтөний сүнсний болон махан биеийг жинхэнэ ёсоор мэдрээгүй.

Нөгөө туйлыг авч үзвэл, Мурман болон Яховын гэрчлэлүүдэд Бурханы цорын ганц Хүү байх нь Есүсийн хувьд ямар гайхамшигтай байсныг нь зохих ёсоор үнэлж чадаагүй. Христ бол ер бусын тэнгэр элч биш, Иосефийн төрсөн хүү ч биш билээ. Түүний цаг үед амьдарч асан зарим хүн Христийн шинж чанар нь Адам Бурханаас холдохоос өмнөх үеийнхтэй адил байсан гэсэн санал дэвшүүлжээ. Энэхүү үзэл нь Библийн үндэслэл байхгүйн дээр Адамыг Бурхан шавар шороогоор бүтээсэн бол Есүсийг Марийн ариун хэвлийд Бурханы Цорын ганц Хүү болгож бүтээснийг үл ойшоожээ. Хэдийгээр Есүсийн аав нь эрэгтэй хүн байгаагүй ч тэр бусад бүх талаараа бид бүхний адил хэвлийд олдож, мэндэлсэн билээ. Бидний гэмт шинж чанартай хүн төгс зан чанартай болно гэхэд олон хүн үүнийг хүлээж авдаггүй. Энэ нь Христэд жинхэнэ итгэл үнэмшил олж авахад саад болдог нэг баримт мөнөөс мөн.

Есүс бидэн шиг шинж чанартай байсан ч зан аашийн хувьд гэм нүгэлгүй байсан , тэр *ямагт* түүний сорилтуудыг даван туулдаг байсан гэж итгэхэд амаргүй. Энэ нь түүний төгс амьдралыг харуулсан Сайн мэдээний бичээсүүдэд тусгалаа маш ихээр олсон байдаг бөгөөд Библи судрын олон хэсэгт үүнийг бүр ч тодотгож, түүнийг Христийг танин мэдэж, итгэл олж авах гэсэн Бурхан байсан гэдгийг үгүйсгэдэг. Тэр Өөрөө Бурхан байсан, тиймээс яриангүй төгс байсан гэж үзэх хавьгүй амар. Гэвч ингэж үзэх нь Есүсийн гэм ба хүний шинж чанарын эсрэг байгуулсан агуу ялалтыг оргүй үгүйсгэж байгаа юм.

156 БУРХАН

Тэр хүний шинж чанартай байсан, Тэр гэм нүгэлгүй атлаа бүх талаар бидэн шиг соригдсон нэгэн /Евр. 4:15/ атал тэр Бурхны амлалтыг даган, гэмийг давж туулахад Түүний тусламжийг хайдаг байв. Энэ Бурхан “ дэлхийг Христ дотор Өөртэйгээ эвлэрүүлж, хүмүүсийн гэм бурууг үл харгалзсан бөгөөд эвлэрлийн үгийг бидэнд даалгасан билээ ” /2Кор. 5.19/.

8:2 Бурхан ба Есүсийн хоорондын ялгаанууд

Нэг талаас “Бурхан Христ дотор байсан” хэмээн онцолж үздэг хэсгүүд, нөгөө талаас Христ хүний шинж чанартай байсан гэх ялгаатай үзлүүдийг тусгаарлах баримт хангалттай байна. Хоёр дахь хэсгүүд нь Гурвалсан холбооны хоосон номлолд Есүс Өөрөө Бурхан байсан, “Бурхны Бурхан байсан” хэмээн буруу номлодгийг Библи судрын үүднээс тайлбарлах ямар ч боломж өгдөггүй. ... Библи сударт “гурвалсан холбоо ” гэх үг нэг ч тааралддаггүй. Есдүгээр хичээлээр бид Христ гэм бурууг төгс ялан дийлсэн болон Бурхан үүнд ямар үүрэг гүйцэтгэсэн тухай үзэх болно. Энэ хичээлийг үзээд эхлэхээр авралт нь жинхэнэ Есүс Христийг зөв таньж мэдэхээс хамаарна /Иох. 3.36, 6:53, 17:3/ гэдгийг санах хэрэгтэй. Тэр гэм ба үхлийг ялан дийлснийг бид үнэн зөв таньж мэдсэн цагт бид энэхүү авралыг хуваалцахын тул Түүн рүү усан баптисм хүртэж болох юм.

Бурхан ба Есүсийн хоорондын харилцааг хамгийн ойлгомжтой дүгнэсэн хэсгийг 1 Тим. 2:5т “ Учир нь *ганц* Бурхан байна. Мөн Бурхан ба хүмүүсийн хооронд *ганц зууч* байна. Тэр нь *хүн болох* Христ Есүс билээ ” гэж дүрсэлсэн байдаг. Тодоор тэмдэглэсэн үгнүүд дараахь дүгнэлтэд хүргэж байна:-

- *Ганц* Бурхан байдаг учир, Есүс Бурхан гэж үзэх ямар ч үндэс байхгүй, Эцэг нь Бурхан, Есүс өөрөө Бурхан байсан бол хоёр Бурхан байх болчихоод байна. “ Бидний хувьд ганц Бурхан, Эцэг байна” /1 Кор. 8:6/. Иймээс Эцэг Бурхан бол цорын ганц Бурхан мөн. Иймээс гурвалсан холбооны хуурамч хоосон номлолд дурддаг шиг “Хүү Бурхан” гэсэн салангид ойлголт оршин тогтох ямар ч үндэслэл алга байна. Хуучин Гэрээнд

Яхве эзэн, цорын ганц Бурхан, эцэг гэж үздэг.
/жишээлбэл, Иса. 63:16, 64:8/

- Энэхүү Цорын ганц Бурханаас гадна, хүн болох Есүс Христ хэмээх зууч байна – “ ... мөн ганц зууч байна ... ”. “Мөн” гэдэг үг нь Христ болон Бурхан хоорондын ялгаа зөрүүг тодотгож өгч байна.
- Христ “ зууч” байна гэдэг нь тэр хоёр юмны хооронд зуучлана гэсэн үг. Гэмт хүн болон гэмгүй Бурханы хооронд зуучлагч нь гэмгүй Бурхан өөрөө байж яавч таарахгүй, энэ нь гэмт хүний шинж чанартай, гэмгүй хүн байх учиртай. “Хүн болох Христ Есүс”ийн талаархи энэхүү тайлбарын үнэн зөв эсэхэд эргэлзэж тээнэгэлзэх өчүүхэн ч зүйл алга. Паул хүртэл Есүсийг одсоны дараа номлолоо бичиж байсан ч тэр хэзээ ч “Бурхан Христ Есүс” гэдэггүй байсан билээ.

“ Бурхан бол худал хэлдэг хүн биш” /Тоолл. 23:19/ гэдгийг бидэнд удаа дараа сануулж байсан бөгөөд Христ “хүний хүү мөн болох” нь нэгэнт тодорхой байсан, учир нь Шинэ Гэрээнд түүнийг ямагт “ хүн болох Христ Есүс” гэж нэрлэдэг билээ. Тэр бол “ Хамгийн Дээдийн хүү” /Дук. 1:32/ байсан. Бурхан “Хамгийн Дээд” нь байснаараа зөвхөн Тэр л хамгийн дээд мөн, харин Есүс “ Хамгийн Дээдийн хүү” байснаараа тэр өөрөө Бурхан байж чадахгүй гэдгийг тус тус харуулж байна. Бурхан ба Есүсийн тухайд хэрэглэгддэг Аав, Хүүгийн хэл нь хүртэл тэр хоёр бол ондоо байсан гэдгийг илт харуулдаг. Хүү хэдийгээр эцэгтэйгээ зарим талаараа ижил төстэй байж болох боловч яг эцэг шигээ хүн байж чадахгүй бөгөөд эцэг шигээ өндөр настай болж чадах учир үндэс үгүй юм.

Үүний нэг адил, Есүсийг Бурхан биш гэдгийг харуулах Бурхан Есүсийн хоорондын ялгаа олныг дурдаж болох байна:-

БУРХАН	ЕСҮС
“ Бурхан бузар муугаар соригддоггүй” /Иак. 1:13/	Христ “ нүгэлгүй атлаа бүх талаар бидэн шиг соригдсон нэгэн билээ”/Евр. 4:15/
Бурхан үл үхнэ - “ Тэр	Христ гурваг өдөр үхсэн.

158 БУРХАН

ганцаараа үхэшгүй мөнхийг эзэмшдэг” / Дуулал 90:2, 1 Тим. 6:16/.	/Мат. 12:40, 16:21/
Бурхан хэний ч нүдэнд үл харагдана. /1 Тим. 6:16, Египетээс гарсан нь 33:20/	Хүмүүс Есүсийг нүдээр үзэж, гараар барьсан. / 1 Иох. 1:1т үүнийг тодотгож өгсөн/

Бид соригдохдоо, гэм ба Бурханы үгийг дагахын аль нэгийг сонгох хэрэгтэй болдог. Бид ихэвчлэн Бурханы үгийг үл дагах сонголт хийдэг, Христэд мөн ийм хоёр сонголт учирч байсан хэдий ч тэр ямагт Бурханы үгийг дагахыг сонгодог байсан. Хэдийгээр тэр хэзээ ч гэм хийж байгаагүй ч гэм хийх боломжтой байсан. 2 Самуэлийн 7: 12-16д Давидын үрийн өгсөн амлалт бол гарцаа байхгүй Христ байсан гэдгийг бид нэгэнт харуулсан билээ. Ишлэл 14т Христийн гэм үйлдэх боломжтойг “ Тэр гэм бурууг *үйлдвэл*, Би хүний таяг, хүний хөвгүүний ташуураар түүнийг засан хүмүүжүүлнэ” гэж дүрсэлсэн байгаа.

8:3 Есүсийн шинж чанар

“ Шинж чанар” хэмээх үг нь бидний жинхэнэ мөн чанарыг харуулсан үг. Бид нэгдүгээр хичээлд Библи судар Бурхан болон Хүн хэмээх хоёр шинж чанарын тухай өгүүлдэг тухай үзсэн билээ. Шинж чанарын хувьд Бурхан үл үхэж, үл соригдоно гэх мэт. Христ амьдралынхаа хугацаанд Бурханы адил

шинж чанартай байгаагүй нь тов тодорхой болсон билээ. Иймээс тэрээр тэр чигээрээ хүний шинж чанартай байсан юм.

“ Шинж чанар” хэмээг үгийг бидний тодорхойлолтоор авч үзэхэд Христ нэгэн зэрэг хоёр өөр шинж чанартай байж болохгүй нь нэгэнт нотлогдсон зүйл. Христ бидний нэг адил /Евр. 4:15/ соригддог байсан нь нэн чухал баримт, тэрээр сорилтыг төгс төгөлдөр давж гарснаараа биднийг өршөөх боломжтой болж байгаа юм. Бидний соригдох гол шалтгаан болох буруу хүсэл мөрөөдөл бидний дотроос /Марк 7:15-23/ ”, хүнээс өөрөөс нь /Иак. 1:13-15/ гардаг. Иймээс, Христ бүхнийг биеэрээ туулж, эдгээр сорилтыг давж гарахын тул хүний шинж чанартай байх хэрэгтэй байсан юм.

Еврейн 2:14-18т энэ бүхнийг маш олон үгээр тайлбарласан байдаг: -

“ Тийнхүү хүүхдүүд /бид/ нь цус ба махан биеийн / хүний шинж чанар/ тасархай болов. Түүнчлэн Тэр /Христ/ өөрөө бас тасархай болсон. Ингэснээр Тэр үхлийн хүч буюу диаволыг үхлээрээ устгаж, бүх насаараа үхлийн айдсаар боолчлогдож байсан тэдгээр хүмүүсийг чөлөөлөх юм. Учир нь үнэхээр Тэр тэнгэр элч нарт бус, харин Абрахамын үр удамд тусалдаг билээ. Тиймээс Бурханд хамаарах юмсад өршөөнгүй, итгэмжит Тэргүүн Тахилч болж хүмүүсийн нүглийн төлөөх эвлэрүүллийг хийхийн тулд Тэр бүх талаараа Өөрийн ах дүү нартайгаа төстэй болгогдох ёстой байв. Учир нь Тэр өөрөө соригдон зовлон эдэлж байсан тул сорилтод орогсодод тусалж чадна. ”

Дээр иш татсан хэсэгт Есүс хүний шинж чанартай байсан гэдгийг ер бусын тодорхой өгүүлжээ: “Түүнчлэн Тэр өөрөө бас тасархай болсон” /Евр. 2:14/. Зөвхөн энэ утгыг тодруулахын тулд энэ өгүүлбэрт ижил утгатай 3 үг хэрэглэсэн байна. Түүнчлэн Тэр өөрөө *бас* тасархай болсон гэж байна, уг нь Тэр тасархай болсон гэж хэлж болох байсан боловч энд зориуд “бас” хэмээн тодотгож өгсөн байна. Евр.2:16д Христийг тэнгэр элчийн шинж чанартай байгаагүйг харуулах гэж мөн их зүйлийг өгүүлсэн байна, учир нь тэр бол хожим Абрахамын үр болох үй түмэн итгэгчид аврал авчрах Абрахамын үр мөн байсан. Ийм учраас Христ зайлшгүй хүний шинж чанартай байх хэрэгтэй байжээ. Тэр *бүх* талаараа “ Өөрийн ах дүү нартайгаа төстэй болгогдох ёстой байв” /Евр. 2:17/, ингэсэн цагт Бурхан Христийн золиослолоор дамжуулан бидэнд өршөөл үзүүлэх боломжтой болох байсан билээ. Иймээс Есүс ямар ч хүний шинж чанаргүй байсан гэж үзэх нь Христийн тухай сайн мэдээний гол үндэс суурийг гажуудуулж байгаа хэрэг юм.

Усан баптисм хүртсэн итгэгчид гэм буруу хийх тоолонд Тэд Бурхан руу ирж, /1 Иох. 1:9/ Христээр дамжуулан гэм нүглээ хүлээн зөвшөөрдөг, Христ тэдгээр хүмүүсийн нэг адил гэм буруу үйлдэхээр соригдож байсныг нь Бурхан мэдэх хэдий ч тэр төгс байсан тул тэдний давж гарч чадаагүй тийм

160 БУРХАН

сорилтуудыг ч давж гарсныг нь мөн мэдэх билээ. Иймээс “Бурхан та нарыг Христ дотор уучилсны адил бие биенээ уучлан, нэг нэгнийгээ энэрэн уян зөөлөн сэтгэлээр ханд” /Ефес 4:32/. Иймээс Христ бидний тусын тулд хэрхэн соригдож, чухам ийм болгохын төлөө бидний адил хүний шинж чанартай болох хэрэгтэй байсныг үнэлж үзэх нь туйлын чухал юм. Евр.2:14т үүнийг бодит биелэл болгохын тул Христ “цус ба махан бие”тэй байсныг тод томруун дүрсэлсэн байдаг. Хэдийгээр Тэр махан биетэй байсан ч шинж чанарын хувьд “Бурхан бол Сүнс” /Иох. 4:24/ бөгөөд Тэр Сүнсний хувьд цус ба махан биегүй байсан. Христ махан биетэй байна гэдэг нь тэр амьдралынхаа туршид хэзээ ч Бурханы шинж чанартай байгаагүй харуулж байгаа юм.

Бурханы үгийг хадгалах гэсэн хүмүүсийн өмнөх үеийн оролдлого, өөрөөр хэлбэл, сорилтыг даван туулах гэсэн чармайлтууд бүгд бүтээгүй. Иймээс “Махан бие мөхөс болохоор Хуулийн хийж чадаагүйг Бурхан хийсэн юм. Тэр Өөрийн Хүүг нүгэлт махан биетэй адил байдалд нүглийн тулд илгээж, махан биеийн дотор нүглийг шийтгэв” /Ром 8:3/.

“Нүгэл” гэдэг нь бидэнд төрөлхийн байдаг хандлагыг хэлдэг. Бид тасралтгүй гэм буруу үйлдэж байдаг бөгөөд “гэм буруугийн үр дүн нь үхэл” байдаг. Энэ мухардлыг давж гарахын тулд хүн төрөлхтөнд гадны тусламж хэрэгтэй болсон. Тэр өөрөө төгс бус байдалтай байсан. Тэр махан биеийн нүглийг гэмшихийн тулд махан биед орсон. Иймээс Бурхан энэ асуудалд оролцож, өөрийнхээ Хүүг та бидэнд өгсөн, түүний Хүү нь бидний адил “гэмт махан биетэй” байсан бөгөөд бидэнтэй адил гэм буруу үйлдэхэд өдөөгдсөн байсан. Хэдийгээр Христ бидний нэг адил бүтэлгүйтэж, гэм буруу үйлдэх боломжтой байсан хэдий ч Христ бусад хүнтэй огт адилгүйгээр сорилт болгоныг давж гарсан. Ром 8:3 т Христийн хүний шинж чанарыг “гэмт махан бие” хэмээн дүрсэлсэн байдаг. Үүнээс хэдхэн ишлэлийн өмнө, Паул махан биед оршигч нүгэл нь хүний хүсдэггүй бузар мууг хэрэгжүүлдэг /Ром 7:18-23/ тухай өгүүлдэг. Энэ утгаар авч үзэхэд Христ Ром 8:3т “нүгэлт махан бие”тэй байсныг уншихад илүү сонирхолтой байдаг. Чухам үүнээс болж, тэрээр махан биеийг давж чадсан нь бид мөн өөрсдийн махан биеэс ангижирч болно гэсэн үг, Есүс өөрийн төрөлх шинж чанарын гэм нүгэлтэй гэдгийг маш сайн мэддэг байсан. Түүнийг нэгэн удаа “Сайн багш” хэмээн дуудаж, түүний төрөлхийн шинж чанар нь сайн гэсэн утгаар бахдан дууджээ. Тэр хариуд нь : “Чи яагаад Намайг сайн гэж дуудна вэ?

Бурханаас өөр хэн ч сайн биш” /Марк 10:17,18/ гэжээ. Нөгөөтэйгүүр, хүмүүс түүний үзүүлсэн удаа дараагийн нэн гайхамшигт ид шидээс болж, Христийн агуу гэдгийг нотолдог байна. “ Харин Өөрийнхээ хувьд Есүс Өөрийгээ тэдэнд даатгасангүй. Учир нь Тэр бүх хүнийг мэдэж байв. Хүний дотор юу байдгийг мэдэж байсан тул хүний тухай хэн нэгний гэрчлэл Түүнд хэрэггүй байв” /Иох. 23-25/. Тэр бүх хүнийг мэдэж байсан тул Христ өөрийг нь магтан тунхаглахыг хүлээн зөвшөөрдөггүй байсан, түүний өөрийн нь хүний шинж чанар ямар муу ёрын сүнс байсныг тэр өөрөө сайн мэддэг байжээ.

8.4 Есүсийн Хүнлэг Шинж

Сайн мэдээний бичээсүүдэд Есүс бүхэлдээ хүний шинж чанартай байсан тухай олон жишээгээр иш татсан байдаг. Аянд ядарсан тэрээр худгийн дэргэд сууж, ус уух гэж байсан тухай Иоханы 4:6д өгүүлжээ. “ Есүс уйлсан” тухай Иоханы 11:35д өгүүлжээ. Түүнийг хүний шинж чанартай байсныг бүр илүү батлах нэг зүйл бол Тэр загалмайд хадагдахын өмнө Түүний эдэлсэн шаналал юм: “Одоо сэтгэл минь шаналж байна.” Тэр Бурханаас аврал гуймаар санагдсанаа илэн далангүй хүлээсэн. /Иохан 12:27/. Тэр “ Эцэг минь, хэрэв боломжтой бол Надаас энэ аягыг өнгөрүүлээч. Гэвч миний хүслээр биш, харин Таны хүслээр болог гэж залбирлаа” /Мат. 26.39/. Энэ нь Христийн “хүсэл” мөрөөдөл Бурханыхаас өөр ондоо байсан гэдгийг харуулж байна.

Христ бүх амьдралынхаа туршид загалмайд хадагдах бэлтгэл хийжээ “ Би Өөрийн санаагаар юуг ч үйлдэж чадахгүй. Би сонссоноороо шүүх бөгөөд Миний шүүлт шударга. Учир нь Би Өөрийнхээ хүслийг бус, харин Намайг Илгээгчийн хүслийг хайдаг” /Иох. 5:30/. Христ ба Бурхан өөр өөр хүсэлтэй байсан нь Есүс Өөрөө Бурхан биш байсан гэдгийг нотолж байна.

Бид амьдралынхаа туршид Бурханы тухай мэдлэгээ өөрсдийн амьдралд тохиолдсон сорилтуудаас улам бүр баяжуулсаар байдаг. Есүс бол үүний тод томруун жишээ юм. Есүс Өөрөө Бурханы тухайд бидэнтэй адил төгс мэддэггүй байжээ. Хар бага наснаасаа “ Есүсийн бие болон мэргэн ухаан нь өссөөр байсан бөгөөд Бурханы болон олон түмний тааллыг олжээ” /Лук 2:52/. “Хүүхэд өсөж, хүчирхэг болон мэргэн ухаанд боловсорсоор

162 БУРХАН

байлаа” /Дук 2:40/. Энэ хоёр ишлэлд Есүсийн биеийн болон сүнсний өсөлт аль аль нь зэрэг өсч байсныг харуулжээ. Хэрэв “Хүү Бурхан” байсан бол ингэх боломжгүй байх байсан билээ. Хэдийгээр Эцэг нь мэддэг байсан ч Христ өөрөө амьдралынхаа эцсийн өдрүүдэд хүртэл хоёр дахиа ирэх өдөр цагаа мэддэггүй байжээ. /Марк 13:32/.

Бид бүгд цаг хугацааны явцад Бурханы үгийг дуулгавартай сахиж сурах хэрэгтэй. Христ бусад олон хүүгийн нэгэн адилаар мөн Эцгийнхээ үгийг дагаж сурах шаардлагатай байжээ. “Тэр Хүү нь байсан хэрнээ зовсон зүйлсээсээ дуулгавартай байдалд суралцсан. Тэр *төгс болгогдсоноороо* Өөрт нь дуулгавартай байдаг бүх хүмүүст мөнх авралын эх үндэс нь болсон ” /Евр. 5:8,9/.

Фил. 2:7,8д мөн Есүсийн сүнслэг өсөлт улам бүр нэмэгдэж, түүнийг загалмай дээр үхэх үед дээд цэгтээ тулж байгаа тухай өгүүлдэг. Тэр “ харин Өөрийгээ хоослож, *боолын дүрийг* авч, *хүнтэй адил болжээ*. Хүн төрхийг олсон Тэрээр үхэлд ч төдийгүй загалмайн үхэлд ч хүртэл *дуулгавартай* байснаараа Өөрийгээ даруу болгов ”. Үүнийг дүрсэлсэн хэлээс харахад Есүс хэрхэн сүнсний хувьд өсч, өөрийгээ улам бүр даруу болгосоор эцэст нь тэр загалмай дээр үхэх ёстой гэдэг Бурханы хүслийг дагаж, *дуулгавартай болсон* байна. Ингэснээрээ тэр зовлон шаналлыг өөрийн биеэр амсаж, улмаар “ *төгс болгогджээ*”.

Есүс зөвт байхын үүднээс хувийн зүгээс ухаалаг чармайлт гаргах хэрэгтэй байсан нь эндээс тодорхой байна. Тэр зүгээр нэг Бурханы хүчинд автаагүй, хэрэв автсан бол тэр ердөө хүүхэлдэй байх байсан. Есүс бидэнд үнэхээр хайртай байсан тул чухам энэ л шалтгаанаар амь насаа загалмай дээр үхэлд бүрмөсөн өгсөн. Хэрэв Бурхан түүнийг загалмай дээх үх хэмээн шахаж дарамталсан бол Христийн бидэнд хайртай гэх агуу хайр нь худал хуурмаг зүйл болон хувирах юм / Ефес 5:2,25, Илч. 1:5, Гал. 2:20 /. Хэрэв Есүс Бурхан байсан бол тэр төгс байгаад хожим нь загалмай дээр үхэхээс өөр ямар ч сонголт байхгүй байх байсан. Харин Есүст эдгээр сонголт байсан нь бид түүний агуу хайрыг бишрэхэд хүргэж, түүнтэй хувийн харилцаа тогтоох боломжтой болгож байгаа юм.

Христ сайн дураараа амь насаараа өргөл өгөхийг хүсэмжилсэнд нь Бурхан маш их таатай хүлээж авчээ: “ Тиймээс Эцэг намайг

хайрладаг. Учир нь Би Өөрийн амийг буцааж авахын тулд амиа өгнө" /Иох. 10:17,18/. Бурхан Христийн ийм дуулгавартай хүсэлд талархан баясна гэхээр Есүс гэм нүгэлт хүнийг билэгдсэн хүн төрхтэй Бурхан байсан уу, үгүй юу гэдгийг ойлгоход хүндрэл учруулж байгаа юм /Мат. 3:17, 12:18,17:5/. Хүүгийн дуулгаварт Эцэг баясч буй тухай эдгээр бичээсээс харахад Христэд дуулгаваргүй байх сонголт байсан ч тэрээр Эцгийнхээ үгийг дагахыг ухамсартайгаар сонгодог байжээ.

Христ аврагдах шаардлага

Есүс хүний шинж чанартай байсан учир өвчин эмгэг, ядрах зэрэг хүний мэдэрдэг зүйлүүдийг мэдэрдэг байжээ. Үүнээс үүдээд хэлэхэд тэрээр хэрэв загалмай дээр хадагдаж үхээгүй бол хүн төрөлхтөний адилаар, жишээлбэл нас дээр гарснаас хэзээ нэг цагт үхэх л байсан. Энэ утгаар Есүс Бурханаар үхлээс аврагдах хэрэгтэй байжээ. Үүнийгээ ухамсарласан Есүс " махан биеийнхээ өдрүүдэд Өөрийг нь үхлээс аварч чадах Нэгэнд /Бурханд/ чанга хашхиран, нулимсаараа залбирал болоод гуйлтуудаа өргөсөн. Тэр сүжигтэй байсан тул Бурхан Түүнийг сонссон билээ" /Евр. 5:7/. Христ Бурханаас өөрийг нь аврахыг хүсч байсан гэх ийм баримтуудаас харахад тэр өөрөө Бурхан байсан гэж үзэх ямар ч үндэслэл байхгүй юм.

Христ үхлээс дахин амилсны дараа Христ хэзээ ч дахиж үхэхгүй /Ром 6:9/ болсон гэдэг нь үүнээс өмнө тэрээр үхэх боломжтой байсныг битүүдээ хэлж байгаа хэрэг юм.

Дуулалын олон хэсэгт Есүсийн тухай эш үзүүлсэн байдаг. Шинэ Гэрээнд Дууллаас зраим ишлэлийг татсан байдаг бөгөөд Дуулал дахь энэ ишлэлүүдийн ихэнх нь мөн түүний тухай гэж ойлгож болох үндэстэй юм. Христ Бурханаар аврагдах шаардлагатай байсныг тодруулсан хэсэг олон хэсэгт дурдагдсан байдаг:

- **Дуулал 91:11,12** дахь Есүсийн тухай ишлэлүүдийг Матайн 4.6д иш татжээ. Дууллын 91:16д Бурхан Есүсийг хэрхэн аврах тухай эш үзүүлж: " Би түүнийг урт амьдралаар хангаж, Түүнд Өөрийн авралыг үзүүлнэ гэдэг бөгөөд Дуулал 69:21т Христийн цовдлуулсныг хамрах бөгөөд Дуулал бүхэлдээ Христийн загалмай дээр бодсон бодлыг дүрсэлдэг: " Бурхан, Намайг авраач ... Сэтгэлд

164 БУРХАН

минь ойртон ирж, түүнийг авраач ээ, Бурхан, Таны аврал намайг өндөрт өргөх болтугай" /1, 18, 29/".

- **Дуулал 89** т Бурхан Христийн талаар Давидэд амласан амлалтыг өгүүлдэг. Есүсийн тухайд, Дуулал 89:26 д эш үзүүлэхдээ: " Тэр Над руу /Бурхан/ "Та бол миний Эцэг, Миний Бурхан болон миний авхалын хад" гэж хашхарина" / Дуулал 89:26/ гэжээ.
- Христ аврал гуйж, Бурханд мөргөсөн нь биеллээ олжээ, Түүнийг "гурвалсан холбоонд " байр суурь эзэлж байснаасаа биш харин сүжигт эй байсан тул түүний залбирлыг сонсжээ /Евр. 5:7/. Тэр *Бурхан* Есүсийг үхлээс дахин амилуулж, түүнд мөнхийн амь өгсөн тухай Шинэ Гэрээнд ийнхүү өгүүлдэг:
- " ... Есүсийг Бурхан амилуулсан билээ. Бурхан Түүнийг баруун гарынхаа захирагч мөн Аврагчаар өргөмжилсэн" /Үйлс 5:30,31/.
- " ... Бурхан өөрийн үйлчлэгч Есүсийг алдаршуулжээ. ... Үхэгсдээс Бурханы босгосон амь ... " /Үйлс 3:13,15/.
- " Есүсийг Бурхан амилуулсан юм ". /Үйлс 2:24, 32, 33/.
- Есүс *Бурхнаас* өөрийг нь алдаршуулахыг хүсэхдээ энэ бүхнийг өөрөө ухамсарлан ойлгожээ. / Иох. 17:5/.

Хэрэв Есүс өөрөө Бурхан байсан бол Бурхан үхдэггүй учраас энэ бүхнийг ингэтлээ онцлох шаардлагагүй байх байсан. Есүс Бурхан байсан бол аврал эрэх ямар ч шаардлагагүй байх байсан. Есүсийг алдаршуулсан Бурхан

Бурханы дээдийн дээдийн эрх мэдлийг харуулж, Бурхан ба Есүс тусдаа гэдгийг харуулж байна.

Яаж ч бодож үзсэн, Христ Английн Сүмийн 39 дүгээр зүйлийн 1 дүгээрт гардагчлан “ туйлын мөнхийн Бурхан, хоёрдмол шинж чанартай, Бурхан ч, хүн ч” байх үндэсгүй юм. Аливаа бүтээл гагцхүү ганцхан шинж чанартай байж болно. Есүс бидний хүний шинж чанартай байсан тухай баримт нотолгоо дэндүү их юм.

8.5 Бурханы Есүстэй Тонтоосон Харилцаа

Бурхан Есүсийг үхлээс хэрхэн амилуулсан нь биднийг Бурхан ба Есүсийн хоорондын харилцааг авч үзэхэд хүргэж байна. Хэрэв энэ хоёр гурвалсан холбооны хоосон номлолд гардагчлан “харилцан тэнцүү, харилцан мөнхийн” юм бол тэдний хоорондын харилцаа ч мөн харилцан эн тэнцүү байх ёстой билээ. Харин ийм биш болох тухай бид хангалттай баримт нотолгоо авч үзсэн. Бурхан ба Есүсийн хоорондын харилцаа бол эхнэр нөхрийн харилцаатай туйлын төстэй юм: “ Гэвч Христ бол эр хүн бүрийн тэргүүн, эр хүн бол эмэгтэй хүний тэргүүн, Бурхан бол Христийн тэргүүн мөн ” /1 Кор. 11:3/. Эр нөхөр эхнэрийн тэргүүн болохоор Христ ба Бурхан эхнэр нөхрийн хооронд байх ёстой ижил зорилготой ч Бурхан Христийн тэргүүн . Иймд эхнэр нөхөрт харьяалагддагийн адил “ Христ Бурханых мөн” / 1 Кор. 3:23/.

Эцэг Бурханыг ямагт Христийн Бурхан гэж бичдэг. Христийг мөнхийн улсад одоод байхад хүртэл Бурханыг “ Бидний Эзэн Есүс Христийн Бурхан болон эцэг” / 1 Петр 1:3, Ефес 1:17/ хэмээн дуулж байснаас харахад энэ бол *одоо* Христийн мөнх бус амьдралын үеийн тэдний харилцаа. Христ дэлхий дээр амьдрах үедээ Бурханаас арай бага байсан тухай гурвалсан холбооны үзэл баримтлагчид заримдаа маргадаг. Христийг мөнхийн улсад одсоны дараа Шинэ Гэрээний зарим захиа бичигдсэн бөгөөд одоо болтол Бурханыг Христийн Бурхан, Эцэг гэж үзсэн хэвээр байна.

Шинэ Гэрээний хамгийн сүүлийн ном болох Илчлэл нь Христийн алдаршиж, мөнхийн улсад одсоноос хойш наад зах нь 30 жилийн хойно бичигдсэн бөгөөд үүнд ч Бурханыг “Түүний /Христийн/ Бурхан, Эцэг” /Илчлэл 1:6/ гэж бичсэн байдаг. Тэр “ Өөрийн Бурхны сүм, Өөрийн Бурханы нэр, Өөрийн Бурханы хот ” /Илч. 3:12/ын тухай өгүүлсэн байдаг. Энэ нь Есүс одоо хүртэл Эцгээ

166 БУРХАН

өөрийн Бурхан гэж үздэгийг нотолж байгаа учир – тэр өөр Бурхан биш болох нь тодорхой байна.

Есүс мөнх бус амьдралынхаа үед Эцэгтээ мөн ийм замаар харьяалагддаг байжээ. Тэр мөнхийн улсад одох тухайд “Би дээшээ Эцэгтээ хараахан очоогүй байгаа тул Над бүү гар хүр. Харин Миний ах дүү нар руу очиж, тэдэнд “ Би Миний Эцэг ба та нарын Эцэгт, Миний Бурхан ба Та нарын Бурханд очно” гэдгийг хэл гэлээ” /Иох. 20:17/. Есүс загалмай дээр байхдаа хүний шинж чанараа бүрэн дүүрэн гаргаж, “ Бурхан минь, Бурхан минь, Та намайг юунд орхив? ” /Мат. 27:46/ гэсэн байдаг. Хэрэв Бурхан Өөрөө ийм үг хэлсэн бол хэн ч үүнийг ойлгож үл чадна. Есүс Бурханд хандан “чанга хашгирч нулимс асгаруулан” мөргөсөн гэх баримт нь тэдний харилцааны жинхэнэ мөн чанарыг харуулж байна /Евр. 5:7, Лук 6:12/. Бурхан Өөрөө Өөртөө мөргөж чадахгүй нь илт билээ. Христ одоо хүртэл та бидний өмнөөс Бурханд мөргөдөг билээ /Ром 8:26, 2 Кор. 3:18/.

Христийн мөнх бус амьдралынхаа үед Бурхантай тогтоож байсан харилцаа нь одооныхоос огт өөр байгаагүй юм байна гэдгийг бид үзлээ. Христ Бурханыг өөрийн Эцэг, өөрийн Бурхан гэж ханддаг байсан ба Түүнд мөргөдөг: Христ үхлээс дахин амилаад мөнхийн улсад одсоны дараа ч энэ бүхэн хэвээр үлдсэн билээ. Христ дэлхий дээр амьдрах үедээ Бурханы үйлчлэгч /Үйлс 3:13, 26, ИСаи. 42:1, 53:11/ байсан. Үйлчлэгч багшийнхээ хүслийг биелүүлдэг бөгөөд багштайгаа хэзээ ч үл эн зэрэгцэх билээ /Иох. 13:16/. Христ өөрт нь байгаа хүч чадал, эрх мэдлийг өөрийнхээ гэлгүйгээр харин Бурхан түүнд өгсөн хэмээн онцолдог байжээ. “ Би Өөрийн санаагаар юуг ч үйлдэж чадахгүй. ... Эцэгийнхээ хийдгийг Хүү нь үзэхгүй бол Хүү Өөрөөсөө юуг ч хийж чадахгүй ...” /Иох. 5:30, 19/.

ХИЧЭЭЛ 8: Асуултууд

1. Библи сударт Бурханыг гурвалсан холбоо гэж сургадаг уу?
а/ Тийм
б/ Үгүй
2. Есүс дараах зүйлүүдийн чухам алинаар нь та биднээс ялгаатай байсан бэ?
а/ Тэр хэзээ ч гэм буруу үйлддэггүй байсан
б/ Тэр Бурхны Цорын ганц Хүү байсан
в/ Тэр хэзээ ч гэм нүгэл үйлдэх боломжгүй байсан
г/ Түүнийг шударга байхыг Бурхан Түүнээс албаддаг байсан
3. Дараах Зүйлүүдийн чухам алинаар нь Есүс Бурхантай төстэй байсан бэ?
а/ Тэр дэлхий дээр амьдрах хугацаандаа Бурхны шинж чанартай байсан
б/ Тэр яг Бурхан шиг төгс зан чанартай байсан
в/ Тэр Бурхан шиг ихийг мэддэг байсан
г/ Тэр Бурхантай эн тэнцүү байв
4. Есүс дараах зүйлүүдийн чухам юугаар нь бидэнтэй төстэй байсан бэ?
а/ Тэр бидэн шиг соригдож, хүний туулдгийг туулсан
б/ Тэр жаахан хүүхэд байхдаа гэм буруу үйлдсэн
в/ Түүнд аврал хэрэгтэй байсан
г/ Тэр хүний шинж чанартай байсан
5. Доорхи зүйлүүдийн аль нь үнэн зөв бэ?
а/ Есүс төгс шинж чанартай, төгс зан чанартай байсан
б/ Есүс гэм нүгэлт шинж чанартай ч төгс зан чанартай байсан
в/ Есүс туйлын Бурхан, туйлын хүний аль аль нь байсан.
г/ Есүс гэм нүгэл үйлдэхээсээ өмнө Адамын шинж чанартай байсан

9.1 БАПТИСМ ХҮРТЭХИЙН ГОЛ АЧ ХОЛБОГДОЛ, УЧИР УТГА

Өмнөх хичээлүүдэд бид баптисм хүртэхийн учир утгыг хэд хэдэн удаа дурдаж байсан, энэ бол Сайн мэдээний мэдээг дуулгавартай дагахын эхний алхам билээ. Евр. 6:2т баптисмыг үндсэн чухал номлолуудын нэг болох тухай өгүүлсэн байдаг. Сайн мэдээг бүрдүүлж буй гол үнэнүүдийг үнэн зөвөөр ойлгосон цагт л жинхэнэ баптисм гарч ирэх боломжтой болдог учраас бид энэ сэдвийг хамгийн сүүлд авч үзэхээр сонгосон юм. Бид эдгээр зүйлийг өмнөх хичээлүүдээр цөмийг нэгэнт авч үзсэн билээ. Та хэрэв Есүс Христээр дамжуулан Библи судрын санал болгож буй агуу итгэл найдвартай үнэн голоосоо нэгдэхийг хүсч байвал баптисм хүртэх зайлшгүй шаардлагатай.

“Аврал Иудейчуудээс гарна” /Иох. 4:22/ гэдэг нь авралын тухай амлалтуудыг зөвхөн Абрахам болон түүний үр жимсэд хамаатуулжээ. Бид үр жимс *дотор* орж, Христ *рүү* /Гал. 3:22 - 29/ баптисм хүртсэн цагт л эдгээр амлалтууд бидний хувьд биелэх юм.

Иймээс Есүс дагалдагчиддаа “ Бүх дэлхийгээр явж бүтээл болгонд сайн мэдээг тунхагла ” /Гал. 3:8/ хэмээн тов тодорхой тушаасан байдаг. Тэр “хэн *итгэж* баптисм хүртэнэ, тэр аврагдах болно” гэдэгт итгэдэг байсан /Марк 16.16/. “Итгэнэ” гэдэг үгийг онцолж өгсөнөөрөө Сайн мэдээнд гагцхүү итгэснээр бид аврагдахгүй гэдгийг харуулж байна. Баптисм хүртэнэ гэдэг нь Христийн амьдралын зүгээр нэг сайн дурын ажил биш, аврагдах амин чухал угтвар нөхцөл юм. Энэ нь баптисм хүртсэнээр бид аврагдана гэсэн үг биш, баптисм хүртсэний дараа бүх насаараа Бурхны үгт дуулгавартай захирагдах ёстой. Есүс үүнийг тодотгохдоо : “ Үнэнээр, үнэнээр Би чамд хэлье. Хэн ус болон Сүнснээс эс төрнө, тэр хүн Бурханы хаанчлалд орж чадахгүй ” /Иох. 3:5/.

“ Ус болон Сүнснээс төрнө ” гэдэг нь баптисм хүртэн уснаас гарч ирж буй хүнийг хэлж байгаа хэрэг бөгөөд энэ усан ёслолыг үйлдсэний дараа хүн сүнснээс ахин төрөх ёстой. Энэ бол тасралтгүй үйл явц: “ Та нар Бурханы амьд, оршин буй үгээр дамжуулан дахин төрсөн билээ ” /Петр 1:23/. Бид сүнсний үгэнд

ямагт хариулах замаар сүнсээс дахин төрдөг. /2.2 хичээлийг харна уу./

Бид Эзэн Есүсийн *нэрээр* / Үйлс 19:5, 8:16, Мат. 28:19/ “ *Христ уруу усан баптисм хүртсэн*” /Гал. 3:27/. Бид Кристадельфианс юм уу, өөр ямар нэг хүний байгууллага бус, гагцхүү *Христ уруу баптисм хүртсэн* гэдгээ анхаарах хэрэгтэй. Баптисм хүртэхгүйгээр бид “Христ уруу” очихгүй, улмаар түүний

аврал бидэнд өгөгдөхгүй /Үйлс 4:12/. Петр энэ баримтын тухайд нэгэн хүчирхэг сургааль үг хайрлажээ: Тэр Ноахын авдрыг Христтэй адилтгаж, тэр авдар Ноах болон түүнийг гэр бүлийг гэм буруу үйлдэгчдийн шүүгдэхээс аварсныг харуулдаг бөгөөд Христ уруу баптисм хүртэх нь итгэгчдийг мөнхийн үхлээс аврах ажээ /1 Петр 3:21/. Ноах энэ авдар уруу орж байгаа нь бид баптисмаар дамжуулан Христ уруу орж байгаатай адилтгажээ. Авдрын гадна талд байгсдыг үер юу ч үгүй хөнөөв, авдрын ойролцоо байсан буюу Ноахын найз байсанд нь үл хамаарсан ажээ. Авралын цорын ганц арга зам бол Христ/авдрын дотор орох явдал юм. Энэ үерийн адил хоёр дахь ирэлт /Луук 17:26, 27/ бидний дээр байгаа гэдэг нь ойлгомжтой. Иймээс баптисм хүртэн Христ/авдар дотор яаралтай орох хэрэгтэй. Үүнийг яаралтай гэдгийг мэдээлж дамжуулахад хүний үг хэлийн хүчин чадал үл хүрэлцэх юм, Ноахын авдар дотор Библи судрын журмаар орвол илүү хүчирхэг байх болно.

Эртний Христчид Христийн үгийг дуулгавартай дагаж, дэлхий даяар хэсүүчлэн явж, Сайн мэдээ болон баптисмыг номлодог байжээ: үйлсийн номд энэ тухай бичсэн байдаг. Хүмүүс Сайн мэдээг хүлээн зөвшөөрснийхээ дараа *хэрхэн* даруй баптисм хүртэж байсныг бичсэнээс харахад баптисм хүртэх чухал ач холбогдолтой гэдэг нь илт батлагдаж байна /жишээлбэл үйлс 8:12, 36-39, 9:18, 10:47, 16:15 гэх мэт/. Баптисм хүртээгүй тохиолдолд Сайн мэдээг судлах нь талаар нэг дэмий өнгөрөх нь эндээс тод харагдаж байна. Баптисм бол авралд хүрэх замыг туулахад зайлшгүй шаардлагатай үе шат юм. Баптисм хүртэхгүй хойшуулах олон учир шалтгаан болон энэ ёслолыг гүйцэтгэхэд олон бэрхшээл гардаг ч гэлээ, хамгийн гол нь хүмүүс энэ Бүхнийг Бурхны тусламжтай хэрхэн давж туулахын чухал болохыг бичээсүүдэд онцлон тэмдэглэсэн байдаг.

170 БУРХАН

Филипи дахь шоронгийн хуяг гэнэт хүчтэй газар хөдлөлт болж, түүний чанга дэглэмтэй шоронг тэр чигээр нь нураахад аймшигтай их хөнөөлд өртжээ. Хоригдлууд оргон зайлах маш их бололцоотой болсны төлөө тэр өөрийн амь насыг алдах болоод байв. Тэгэхэд түүний Сайн Мэдээдн итгэх итгэл бодит биеллээ олж, “Хуяг ... шөнийн цагаар тэр даруй баптисм хүртжээ” /Үйлс 16:33/. Тэр бол үнэндээ баптисм хүртэхийг ямагт хойшлуулдаг нэгэн байжээ. Грект 3000 жил үзэгдээгүй аймшигт газар хөдлөлт болж, бүлэг аймшигт хоригдлууд шоронг юу ч үгүй эвдэн сүйтгэхийн даваан дээр, үүрэг хариуцлагаа хөсөрдүүлсний нь төлөө түүний толгойг цаазаар авах ял сонсохын даваан дээр, тэр бүхэл бүтэн амьдралынхаа туршид хамгийн чухал шийдвэр гаргаж, мөнхийн хувь тавиланг сонгожээ. Ийнхүү тэрээр орчин тойрны ертөнцийн бэрхшээл /газар хөдлөлт/ болон өдөр тутам ажил дээр нь гардаг даралт шахалт, сэтгэлийн зовиураа гэтэлж, баптисм хүртэхээр шийджээ. Баптисм хүртэхээс хойш суудаг хэн боловч энэ хүнээс үлгэр жишээ авах хэрэгтэй. Тэр ийнхүү итгэл үнэмшлийн үйлдэл хийсэн нь

тэрээр өмнө нь Сайн мэдээг нэгд нэгэнгүй сайн мэддэг байсныг харуулж байна, учир нь зөвхөн Бурханы Үгийг сонссон цагт л жинхэнэ итгэл үнэмшил төрдөг билээ. /Ром 10:17, Үйлс 17:11/

Үйлсийн 8:26 – 40д, Этиопийн тайган амбан цөлд тэргэндээ явах зуураа эш үзүүлэгч Исайн номыг хэрхэн уншиж явсныг харуулдаг. Тэр Филиптэй таарч, Филип түүнд Сайн мэдээг нэгд нэгэнгүй тайлбарлаж өгсний дотор баптисм хүртэх хэрэгтэй тухай ч мөн ярьж өгчээ. Хар ухаанаар бодоход, тэрхүү усгүй цөлд баптисм хүртэх тушаалыг үг дуугүй дагах боломжгүй мэт санагдана. Гэхдээ Бурхан зарим хүмүүсийн биелүүлж үл чадах тийм тушаал өгдөггүй билээ. “Тэд замаараа явсаар устай газар хүрч иржээ ” гэдэг нь өөрөөр хэлбэл баптисм хүртэж болох баян бүрд дээр ирсэн гэсэн үг /үйлс 8:36/. Усанд дүрж баптисм хүртэх нь дүүрэн, ус ихтэй газар л үйлдэж болох ёслол хэмээх ор үндэсгүй таамаглал оргүй болохыг энэ болсон явдал харуулж байна. Бурхан Өөрийн нь тушаалыг үг дуугүй дагах бодит арга замаар биднийг ямагт хангадаг билээ.

Номлогч Паулд Христ нэгэн эш үзүүлэхэд тэр тэр дороо “босч, баптисм хүртжээ ” /Үйлс 9:18/. Тэр нийгэмд эзлэх өөрийн нэр хүнд, өсөн нэмэгдэх албан тушаал, Иудаизмд өндөр амжилт амжилт олох боломж зэргээ бодоод үзэхэд баптисм хүртэхээ

хойшлуулах нь түүний хувьд сорил байсан байж мэдэх юм. Гэвч энэхүү Иудэйн ертөнцийн гэрэлт од болох Паул тэр дороо баптисм хүртэх зөв шийд гаргаж, амьдралынхаа хуучин хэв маягаас татгалзаж буйгаа илэн дадангүй мэдэгдсэн билээ. Тэрээр хожим нь баптисм хүртэх сонголт хийсэн тухайгаа: “ Гэвч миний хувьд ололт байсан бүх юмсыг би Христийн төлөө гарз хохирол болгон тооцов. Тэр ч байтугай, би өөрийн Эзэн Есүс Христийг таньж мэдэхийн давуу агуу байдлын төлөө бүх юмсыг гарз хохирол болгон үздэг. Би Түүний төлөө бүх юмсын гарз хохирлыг амсаж, тэдгээрийг хог гэж үздэг нь Христийг олохын тулд бөгөөд ... Ах дүү нар аа, би өөрөө хараахан барьж авсан гэж боддоггүй, харин нэг л юмыг хийдэг, ардахаа / энд өмнөх Иудейн амьдралаа хэлж байна/ мартаж, урьдах зүйлс уруугаа зүтгэн тэмүүлж, Христ Есүс дотор Бурханы дээш чиглэсэн дуудлагын шагналыг авахын төлөө бариа уруу урагшилдаг” /Фил. 3:7,8,13,14/.

Энэ бол барианы шугам уруу хамаг хүчээ шавхан тэмүүлж буй тамирчинтай агаар нэг юм. Оюун санааны болоод бие махбодийн оролдлогыг ийнхүү төвлөрүүлж байж, баптисм хүртсэний дараа бид хэрхэн амьдрахыг тодорхойлох учиртай. Баптисм хүртэнэ гэдэг нь Бурханы хаанчлал уруу тэмүүлж урагшлахын эхлэл гэж ойлгох ёстой, энэ нь зүгээр нэг сүмүүд болон итгэл үнэмшлээ солихын ч нэр биш, Христч зарчмууд хэмээн бүдэг бадаг нэрлэсэн хэдхэн тооны зарчимд баригдаж, сэтгэл амар явахын ч нэр биш юм. Баптисм нь биднийг Есүсийн загалмайд хадагдсан болон үхлээс дахин амилсан /Ром 6:3-5/ - сэтгэл хөдөлгөм үйл явдлуудтай холбож өгдөг.

Нас дээр гарсан, сүнслэг ялгуусан хөгшин хүнийхээ хувьд Паул ийнхүү дурсаж мэдэх юм: “ Би тэнгэрлэг үзэгдэлд дуулгаваргүй байж болсонгүй ” /Үйлс 26:19/. Паулын хувьд ч тэр, ном ёсоор нь баптисм хүртсэн хүмүүсийн хувьд энэ үнэн юм: баптисм хүртэх шийдвэр гаргасан хүн хожим хэзээ ч ингэсэндээ харамсахгүй. Бид насан туршдаа өөрснийгээ зөв сонголт хийснээ мэдэх болно. Хүн хийсэн сонголтдоо ийм итгэлтэй шийдвэр гаргах мөч тэр бүр тохиодоггүй билээ. Одоо та өөрөө өөрөөсөө “Баптисм хүртэхэд болохгүй нь юу байх вэ?” гэдэг асуултыг нухацтай асуух л үлдлээ.

9.2 БИД ХЭРХЭН БАПТИСМ ХҮРТЭХ ЁСТОЙ ВЭ?

Баптисм хүртэхэд, ялангуяа балчир хүүхдүүдэд баптисм хүртээхэд тэдний духан дээр нь ус шүрших замаар хүртээдэг гэсэн үзэл түгээмэл тархсан байдаг. Энэ бол баптисм хүртээхэд Библийн тавьдаг шаардлагатай өдөр шөнө шиг ялгаатай үзэл юм.

“Баптизо” хэмээх Грек үг нь Англи Библи сударт “ баптисм ” хэмээн хөрвүүлэгддэг бөгөөд энэ нь шүрших гэсэн утга *агуулдаггүй*, энэ нь шингэнд дүрж, бүхэлд нь угаах гэсэн утгатай /Роберт Янг, Жэймс Стронг нарын тайлбар толиос харна уу/. Энэ үгийг сонгодог Грек хэлд хөлөг онгоц живж усанд “баптисм” хүртэхийг хэлдэг. Үүнийг мөн ямар нэг даавууг “ баптислах” замаар нэг өнгөнөөс өөр өнгөнд оруулахыг бас хэлдэг. Даавууны өнгийг солихын тул будгийг даавуу руу шүрших тэдий бус харин даавууг шингэнд бүрэн оруулах шаардлагатай гэдэг нь мэдээж. Ийнхүү усанд бүрэн шумбуулах нь баптисм хүртэх зөв хэлбэр болох тухай дараах ишлэлүүдээс харж болно.

-“ Мөн Иохан Салимын ойролцоо Аенонд баптисм хүртээж байв. Учир нь тэнд ус ихтэй ажээ. Хүмүүс ирж баптисм хүртэж байлаа. ” /Иох. 3:23/ Үүнээс харахад баптисм хүртэхэд “ус ихтэй” байх шаардлагатай нь харагдаж байна, хэрэв хэдхэн дусал ус дусаагаад л баптисм хүртдэг байсан бол олон зуун хүнд баптисм хүртээхэд ганц хувин ус хангалттай байх байсан биш үү. Хүмүүс баптисм хүртэхийн тул Йордан голын хэсэгт ирдэг байсан болохоос биш Иохан тэднийг тойроод хувинтай ус бариад явдаггүй байсан нь мэдээж.

-Иохан Есүст мөн Йордан гол дээр баптисм хүртээжээ: “ Есүс баптисм хүртээд уснаас тэр даруй гарчээ ” /Мат. 3:13-16/. Түүний хүртсэн баптисм илэрхий усанд шумбаж хүртэгдсэн бөгөөд баптисм хүртсэний дараа “ уснаас гарч ирсэн байна ”. Есүс баптисм хүртэх болсны нэг шалтгаан нь бусдад үлгэр жишээ үзүүлж, хүмүүс усанд шумбаж баптисм хүртэхгүйгээр

өөрснийгээ Есүсийг дагаж буй гэж бүү хэлээсэй гэсэндээ өөрийн биеэр үзүүлсэн хэрэг юм.

- Мөн ийм маягаар, Филип болон Этиопийн тайган хүн “ Тэгээд тэд хоёулаа *ус руу* орж, Филип түүнд баптисм хүртээжээ. Тэд *уснаас гарч* ирэх үед ” /үйлс 8:38, 39/. Тайган хүн баян бүрдийг хараад “ Хараач, ус байна. Баптисм хүртэхэд болохгүй нь юу билээ?” /Үйлс8:36/ гэснийг санах хэрэгтэй. Цөл газар яваа хүн биедээ шилэнд ч атугай ус хийгээд авч явах нь хэн бүхэнд мэдээжийн хэрэг билээ. Хэрэв баптисмыг ус шүрших төдийхнээр хүртээж болдог байсан бол энэхүү баян бүрдэд хүрч байж, баптисм хүртэх шаардлагагүй байх байсан билээ.
- Баптисм гэдэг нь оршуулга бөгөөд бүрэн нөмөрч авдаг /Кол. 2:12/.
- Баптисмыг “нүглээ угаах” /Үйлс 22:16/ гэж нэрлэдэг. Жинхэнэ өөрчлөлтийг Илч. 1:5, Титус 3:5, 2 Петр 2:22, Евр. 10:22 зэрэг ишлэлд “угаахтай” адилтгасан байдаг. Угаана гэдэг нь шүршинэ гэдгийг бодвол баптисмтэй илүү нягт холбоотой үг юм.

Угаах зарим хэлбэр маягаар Бурханд хүрч болдгийг харуулсан ишлэл Хуучин Гэрээнд хэд хэд байдаг.

Санваартнууд Бурхан руу чуулганд ирэхийнхээ өмнө “ лавер” хэмээх онгоцод бүрэн угаалга үйлддэг ёстой байжээ /Лев. 8:6, Египетээс гарсан нь 40:32/. Иераэлитүүд өөрсний гэм буруугийн илрэл болох бузар бургтгийг цэвэрлэхийн тул угаал үйлддэг ёстой байжээ /Дэд хууль 23:11/.

Уяман өвчтэй Нааман гэгч нэг хүн Израилийн Бурханаар эмчлүүлэхийг бодож явжээ. Тэр бол нүгэлт хүмүүсийн төлөөлөгч бөгөөд үйлдсэн нүглийн улмаас үхэл рүү явж байжээ. Тэрээр Иордан голд булхаж эмчлэгдэх ёстой байв. Тэр эхэндээ ийм энгийн үйлдэл хийгээд эдгэнэ гэж итгэж өгөхгүй байсан, учир нь тэрээр Бурхан түүнийг ямар нэг сүр дуулиантай юм хийлгэх юм уу, аль эсвэл Абана гэх мэтийн алдартай том голд шумбуулна

174 БУРХАН

гэж санаж байжээ. Үнэндээ ийм энгийн алхам биднийг авралын замд эргэлт буцалтгүй оруулдаг гэхэд итгэх нь бидний хувьд ч бэрх асуудал билээ. Бидний хувьд ийм энгийн алхам хийснээр биш харин нэр хүндтэй том сүмүүдтэй харьцсанаар аврагдана гэж бодох нь илүү дөхөм санагддаг. Нааман явж, Бурханы хүний үгийн дагуу Иордан голд долоон удаа булхав. “Түүний бие махбод нялх хүүхдийн бие махбод мэд дахин сэргэж, тэрээр цэвэр болжээ” /Хаадын дэд 5:9-14/.

Тэгэхээр одоо Сайн мэдээний үндсэн гол мэдээний зах зухаас ойлгоод эхлэхээр “Баптисм” гэдэг нь усанд бүрэн шумбахыг хэлнэ гэхэд эргэлзэж тээнэгэлзэх тань багассан байх. Баптисмыг ийнхүү Библи сударт тулгуурлан тодорхойлохдоо өөрийн биеэр баптисм хүртээж байгаа хүн нь ямархуу байдалтай хүн байх вэ гэдгийг дурдаагүй. Баптисм гэдэг нь Сайн мэдээнд итгэснийхээ дараагаар усанд бүрэн шумбах үйлдэл, онолын хувьд өөрөө өөртөө баптисм хүртээж болох мэт. Гэсэн хэдий ч , усанд бүрэн шумбах үед үнэн зөв номлол баримталснаар л тэр жинхэнэ баптисм болно. Тэгэхээр жинхэнэ номлолд итгэгч өөр нэг итгэгчээс баптисм хүртэхэд болохгүй юм ер алга, ингэхдээ баптисм хүртээгч итгэгч нь тухайн хүнийг усанд шумбуулахынхаа өмнө мэдлэгийг нь зөв үнэлж дүгнэх чадвартай байх ёстой.

Иймээс Кристадельфичүүд жинхэнэ усанд шумбуулахынхаа өмнө баптисм хүртэх гэсэн хэнийг ч болов нухацтай авч хэлэлцдэг заншилтай байжээ. Хичээл болгоны төгсгөлд хавсаргасан шиг асуултууд асуух нь иймэрхүү хэлэлцүүлэг явуулах эх суурийг нь бүрдүүлж өгөхөд дөхөм болно. Кристадельфичүүд зөвхөн ганц хүнд баптисм хүртэхэд нь туслахын тулд олон мянган миль газрыг туулдаг байжээ, нэг хүн мөнхийн амьд жинхэнэ итгэл үнэмшлийг олж авна гэдэг бол гайхамшиг бөгөөд бидний хувьд шинээр сүнс олж буй хүмүүсийн тоо чухал биш билээ. Бид тоо ширхэг гэхээсээ илүүтэй үнэн чанарыг эрхэмлэдэг улс.

9.3 БАПТИСМЫН УЧИР УТГА

Усанд бүрэн шумбаж, баптисм хүртдэгийн нэг шалтгаан нь усан доор бүрэн орсноо бид үхэлд очиж байна гэж билэгддэг. Энэ нь биднийг Христийн үхэлтэй холбож, өмнөх амьдралдаа үйлдсэн гэм буруу маань үхэж утсаны билэг тэмдэг болдог. Уснаас гарч

ирж байгаагаараа бид Христийн үхлээс дахин амилсантай холбогдож, түүнийг буцаж ирэхэд мөнхийн амь өгөгдөх найдвар өвөрлөхийн зэрэгцээ тэр мөчөөс амьдралаа шинээр эхлүүлж, Христ загалмайд үхэж, үхлээс дахин амилж гэм нүглийг ялан дийлсэн сүнслэг ялалтыг хуваалцдаг.

“Эсвэл Христ Есүс уруу баптисм хүртсэн бид цөмөөрөө Түүний үхэл уруу баптисм хүртсэн гэдгийг та нар мэдэхгүй гэж үү? Тиймд Эцгийн алдраар Христ үхэгсдийг амилуулсны адил, бид мөн шинэ амийн дотор явахын тулд үхэл уруу баптисм хүртсэнээр Түүнтэй хамт оршуулагдсан юм Учир нь, хэрэв бид Түүний үхэлтэй адил байдалд холбогдсон юм бол, мэдээж бас Түүний амилалттай нь ч холбогдох болно” /Ром 6:3-5/.

Христ үхэж, үхлээс дахин амилснаар бид аврагдах боломжтой болсон тул бид мөн аврагдахын тулд эдгээр зүйлтэй холбогдсон байх нь нэн чухал юм. Баптисмаар дамжуулан Христтэй хамт үхэж, хамт үхлээс дахин амилж байгааг билэгдэгдэх нь үүнийг хийх цорын ганц арга зам юм. Ус шүрших төдийгээр энэ ёслол төгс билэгдэхгүй гэдгийг хатуу анхаар. Баптисм хүртэхэд “Бидний хуучин хүн нь түүнтэй хамт цовдлогддог” /Ром 6:6/, Бурхан “биднийг гэм нүгэл дотроо үхсэн байхад Христтэй хамт амьд болгосон юм” /Ефес 2:5/. Гэсэн ч бид баптисм хүртсэнийхээ дараа хүний шинж чанараа хэвээр хадгалсаар байх тул махан биеийн амьдрал хэвээр үргэлжилсээр байх болно. Иймд махан биеэ “цовдлуулах” нь тасралтгүй үргэлжилдэг үйл явц, энэ нь баптисм хүртэх үеэс зөвхөн *эхэлдэг*, учир нь Есүс итгэгчийг өдөр бүр загалмайгаа авч, түүнийг дагахыг зааварласан бөгөөд Калварийг чиглэсэн үйл явц юм. /Лук 9:23, 14:27/ Христтэй жинхэнээр цовдлуулах амьдрах нь амаргүй ч Христийг үхлээс дахин амилсантай холбогдсоноор үгээр дүрслэхийн аргагүй тайтгарал тайвшрал баяр баясгалан ирдэг билээ.

Христ “өөрийн загалмайн цусаар энх тайвныг тогтоон” /Кол. 1:20/ авчирсан – “Бүх оюун ухаанаас дээгүүрхи Бурханы амар тайван нь Христ Есүс дотор та нарын зүрх бодлыг тань хамгаална”. Энэ утгаар Христ дараах зүйлийг амлажээ: “Амар амгаланг Би та нарт үлдээнэ. Би Өөрийн амар амгалангаа та нарт өгнө. Ертөнцийн өгдгөөс өөр юмыг Би та нарт өгч байна” /Иох. 14:27/

176 БУРХАН

гэсэн билээ. Ийм агуу амар амгалан ба сүнсний баяр баяслын хажууд цовдлуулсан Христтэй шууд холбогдож, өвчин шаналлыг нь хуваалцсан бидний шаналал тун шалихгүй өчүүхэн зүйл юм: “ Учир нь Христийн зовлонгууд бидэнд арвин байдгийн адил түүнчлэн бидний тавйшрал ч мөн Христээр дамжуулан арвин байдаг ” /2 Кор. 1:5/.

Бидний жинхэнэ шинж чанар устаж мөхсөн гэдгийг мэдэрсэнээр эрх чөлөө ирдэг ба иймээс ч сорилт болгонд Есүс бидний дотор амьдарч байдаг. Агуу их номлогч Паул өөрийн амьдралын баялаг туршлагаас ийнхүү дүрсэлсэн байдаг: “ Би Христтэй хамт цовлогдсон. Амьд байгаа нь би биш, харин миний дотор Христ амьд байна. Эдүгээ би махан биедээ амьд байгаа нь намайг хайрлаж, миний төлөө Өөрийгээ тушаасан Бурханы Хүүд итгэх итгэлээр амьдарч буй хэрэг юм. ” / Гал. 2:20/

“ Баптисм нь Есүс Христийн амилалтаар дамжуулан авардаг ” / 1 Петр 3:21/, учир нь үхлээс дахин амилж мөнхийн амьтай болсон Христтэй холбогдсоноор бид түүнийг буцаж ирэх үед мөн ийм болох боломжтой болж байгаа юм. Үхлээс дахин амилсныг хуваалцсаны дараа бид эцэст нь аврагдах боломжтой. Есүс үүнийг тун энгүүнээр өгүүлсэн байдаг: “ Би амьд байна. Та нар ч амьд байна ” /Иохан 14:19/. Паул мөн үүний адил: “ Учир нь хэрэв бид дайснууд байхдаа Хүүгийнх нь үхлээр Бурхантай эвлэрүүлэгдсэн юм бол, тэр тусмаа бид Түүний амиар аврагдах болно ” / Ром 5:10/.

Бид баптисм хүртсэнээр Христийн үхэл болон шаналалтай холбогдож, шинээр эхлүүлэх амьдралдаа дахин түүний үхлээс дахин амилсан ялгуусан амилалтыг хуваалцах болно.-

- “ Бид хэрэв Түүнтэй /Христ/ хамт үхсэн юм бол,
- Мөн Түүнтэй хамт амьд байх болно. Хэрэв бид тэвчвэл,
- Мөн Түүнтэй хамт хаанчлах болно ” / 2 Тим. 2:11, 12/.

- “ Бид Христийн төлөө мулгуу аж. Харин та нар Христ дотор хашир аж. Бид мөхөс, харин та нар хүчтэй. Та нар алдар хүндтэй, харин бидэнд алдар хүнд ч алга. ... Биднийг зүхэхэд нь ерөөж, хавчихад нь тэвчиж, гүтгэхэд нь тайтгаруулахыг бид хичээдэг. Би та нарыг ичээхийн тулд бус, харин өөрийнхээ хайрт хүүхдүүдийн адил та

нарт сануулахын тулд үүнийг бичлээ ” / 2 Кор. 4:10, 11, 14/.

- Паул “ Түүнийг болон Түүний амилалтын хүч, зовлонгуудын нөхөрлөлийг таньж мэдэн, Түүний үхэлтэй адилхан болгогдож, үхэгсдээс амилуулагдахад хүрмээр байна. ” /Фил. 3:10,11, Гал. 6:14/

9.4 БАПТИСМ БА АВРАЛ

Баптисм биднийг Христийн үхэлтэй холбодгоороо бидэнд өршөөгдөх боломж олгож байгаа юм. Бид “ Ингэхдээ та нар баптисм дотор Түүнтэй хамт оршуулагдсан. Түүнийг үхэгсдээс амилуулсан бурханы үйлсэд итгэсэн итгэлээр баптисм дотор та нар бас түүнтэй хамт амилуулагдав. Та нар гэм нүглүүд болон махан биеийн хөвч хөндөх ёслолоосоо болж үхсэн байхад Тэр бидний бүх гэм нүглийг уучлаад, та нарыг Түүнтэй хамт амьд болгосон ” / Кол. 2:12, 13/. Бид “ Эзэн Есүс Христийн нэрээр болон бидний Бурханы Сүнс дотор та нар угаагдсан, та нар ариусгагдсан ” /1 Кор. 6:11/ - өөрөөр хэлбэл, Есүсийн нэрээр баптисм хүртэх нь бидний гэм нүгэл угаагдсан гэсэн үг. Үүнийг Тооллого 19:13 т ариутгалын усанд хүрээгүй хүмүүс үхэх ёстой хэмээн өгүүлсэн байдаг. Бид 10.2 хичээлээр баптисм хэрхэн гэм нүглийг угаадгийг үзсэн билээ /Үйлс 22:16/. Хүмүүс Христийн цусаар гэм нүглээсээ угаагдаж буйг дүрслээд, үүнийг баптисмаар дамжуулан үйлдэж буйг Үйлс 1:5, 7:14, Титус 3:5 т өгүүлжээ.

Энэ бүхнээс харахад, “ Бид одоо яах вэ?” гэсэн асуултад Петр “ Гэмшигтүн, хүн бүр өөрсдийн нүглийн уучлалын төлөө Есүс Христийн нэрээр баптисм хүртэцгээ. Та нар ч Ариун Сүнсний бэлгийг авах болно”/ Үйлс 2: 37, 38/ гэж хариулах болсон нь ойлгомжтой юм. Христийн нэрээр баптисм хүртэх нь гэм нүглээ уучлуулахын тулд бөгөөд үүнгүйгээр өршөөл хүртэх ямар ч боломж байхгүй, иймээс баптисм хүртээгүй хүмүүс гэм нүглийн хөлс шан болох - үхлийг хүлээн авдаг /Ром 6:23/.

Христийн нэрээр аврагдахаас өөрөөр аврал хүртэх боломж үгүй / Үйлс 4:12/, бид зөвхөн баптисм хүртэх замаар л энэ нэрийг хуваалцах боломжтой. Энэ баримтаас харахад Христч бус шашнууд авралд огт хүргэдэггүй болох нь батлагдаж байна.

178 БУРХАН

Бусад шашин авралд хүргэдэг гэдгийг жинхэнэ итгэл үнэмшилтэй ямар ч Христэд итгэгч хүлээн зөвшөөрөхгүй, Католик болон шашны бусад хөдөлгөөн өөрснийгээ авралд хүргэдэг гэлцэх нь тэднийг Ариун Сударт хэрхэн хандаж буйг харуулж буй өрөвдөлтэй тусгал юм.

Христ үхлээс дахин амилж мөнхийн амьдрал олсон нь гэм нүглийг ялан дийлсэн түүний хувийн нь ялгуусан ялалтын илрэл юм. Баптисм хүртсэнээр бид үүнтэй холбогддог, иймээс бид Христтэй хамт үхлээс дахин амилсанд тооцогддог, гэм нүгэл Түүнийг дийлж чадаагүйнхээ нэгэн адилаар биднийг ямар ч гэм нүгэл дийлж бас үл чадах юм. Иймээс баптисм хүртсэнээрээ бид : “ нүглээс чөлөөлөгдсөн зөвт байдлын боолууд болсон. Учир нь нүгэл та нарыг захирахгүй. Яагаад гэвэл та нар хуулийн дор байгаа бус, харин нигүүлслийн дор байдаг” /Ром 6:18, 14/. Хэдийгээр баптисм хүртсэний дараа бид гэм нүгэл үйлдсээр байдаг ч /1 Иох. 1:8,9/, хэрэв биднийг Бурханаас нүүрээ буруулах юм бол гэм нүгэл биднийг ноёрхоход бэлэн байдалтай анаж отож байдаг. Хэдийгээр баптисм биднийг Христийн үхлээс дахин амилсантай хэрхэн холбогдож, түүнийг буцаж ирэхэд мөн хуваалцах найдвар өвөрлөж явдгийг харуулдаг хэдий ч бид одоо Христийн үхэл ба шаналлыг хуваалцаж байдаг билээ.

Бид гэм нүглээс чөлөөгдөх нь төгс бус. Христийг хоёр дахиа ирэхэд “ Хэн итгэж баптисм хүртэнэ, тэр аврагдах болно” /Марк 16:16/. Баптисм хүртсэнээр бид шууд нэгмөсөн аврагдчихгүй, харин “ өөрөө гал дундуур гарсан мэт боловч аврагдана” /1 Кор. 3:15/. Үнэндээ, бид баптисм хүртсэний дараа шууд аврагдчихдаг бол бидэнд элдэв хоосон номлолын ч хэрэг алга, мөн үхэх ч шаардлагагүй болох нь: “ Миний нэрээс болж бүгд та нарыг үзэн ядна. Харин эцсээ хүртэл тэссэн нь аврагдах болно” /Мат. 10:22/.

Паул /болон бүх итгэгч нар/ баптисм хүртчихсэнийхээ дараа хүртэл аврал руу чадал мэдэн тэмүүлсээр байсан /Фил. 3:10-13, 1 Кор. 9:27/, тэр мөнхийн амьдралд *найдах* тухай ярьж /Титус 1:2, 3:7, 1 Тес. 5:8, Ром 8:24/, бид “авралыг өвлөх хүмүүс” /Евр. 1:14/ болох тухай ярьж байжээ. “ Тэд мөнх шийтгэлд, харин зөвт хүмүүс нь мөнх аминд орох юм гэж айлдлаа” /Мат. 25:46/. Паулын гайхалтай гэгээрэл Ром 13:11т тод дүрслэгдсэн байдаг: баптисм хүртсэнийхээ дараа бид өдөр бүрийг туулж өнгөрөх тусам Христийн хоёр дахь ирэлтэд нэг нэг өдрөөр дөхөж очиж байгаагаа мэдэрдэг, улмаар бид “ бидний аврал бидний

бодсоноос ойр байжээ” хэмээн баясна гэж тэрээр өгүүлсэн байдаг. Иймээс бидний аврал одоо дүүрээгүй байна. Аврал болзолтой: “ хэрэв бид бат итгэлийнхээ эхлэлийг эцэс хүртэл бат сахивал Христийн хуваалцагч болно” /Евр. 3:12-14/, “ өөртөө ба сургаалдаа анхаарлаа хандуулбал чамайг сонсогчийн хэн хэнийг нь аварна”/1 Тим. 4:16, 1 Кор. 15:1,2 /, “ Түүний та нарыг дуудан сонгосныг бататгахын тулд та нар эдгээрийг үйлдэж л байвал хэзээ ч бүдрэхгүй” / 2 Петр 1:10/.

“Аврагдсан” хэмээн хөрвүүлэгдсэн Грек үйл үг нь заримдаа үргэлжилсэн цагт хэрэглэгддэг нь аврал гэдэг нь Сайн мэдээг тасралтгүй дуулгавартай дагасны үр дүнд бий болдог тасралтгүй үйл явц болохыг харуулж байна.

Ийнхүү итгэгчдийг Сайн мэдээнд хариулснаараа “аврагддаг” хэмээн өгүүлдэг /1 Кор. 1:18 болон Үйлс 2:47, 2 Кор. 2:15/. ” Аврагдсан “ хэмээх энэхүү Грек үг нь зөвхөн өнгөрсөн цагт хэрэглэгдэж, Христ загалмайд цовдлогдон бидэнд боломж олгож, бид баптисм хүртсэнээрээ өөрснийгээ Түүнтэй холбож болохыг харуулдаг / 2 Тим. 1:9, Титус 3:5/.

Энэ бүхнийг Бурхан Израилтай харьцсанаар сүнслэг Израиль буюу итгэгчтэй холбогдох суурь бүрдүүлдгээр жишээ татаж болох юм. Израиль Египтээс явсан, учир нь Египт бол баптисм хүртэхээс өмнө бид бүхний оршин байдаг махан бие болон хуурамч шашнаар дүүрэн ертөнц байжээ. Тэд Улаан тэнгисийг гаталж улмаар Синайн цөлийг туулж, амлалтын газар буюу Бурханы хаанчлалын газар иржээ. Тэд Улаан тэнгисийг гаталсан нь бидний баптисм хүртэхтэй төстэй /1 Кор. 10:1,2/, бидний өнөөгийн амьдралын эцэс төгсгөлгүй аялал болон Бурханы хаанчлалын Канаантай адилтгаж болох юм. Иудагийн 5д цөл дундуур аялсны дараа хэчнээн хүн сүйрснийг дүрсэлсэн байдаг: “ Эзэн Египетийн нутгаас ард түмнийг аварсны дараа итгээгүй хүмүүсийг устгасан юм”. Израиль ийнхүү Египтээс “аврагдаж” баптисм хүртсэн бүх хүн гэм нүглээсээ мөн “аврагджээ”. Тэдгээр Израилийн хэн нэгнээс “Та аврагдсан уу?” гэж асуусан бол тэд “Тийм ээ” гэж хариулах байсан хэдий ч энэ нь тэд *бүрмөсөн* аврагдсан гэсэн үг биш ээ.

Израиль Египт рүү сэтгэл зүрхээрээ эргэж /Үйлс 7:39/ махан биеийн жаргал хөөж, хуурамж хоосон номлол дээдэлсэн амьдрал руу эргэн ороход баптисм хүртэн гэм нүглээсээ “аврагдсан” хүмүүс ивээгдсэн байрнаасаа мөн доош унадаг. Израилууд цөлд

180 БУРХАН

хэрхсэн түүхийг бид давтаж болзошгүй тухай 1 Кор. 10:1-12, Евр. 4:1,2 болон Ром 11:17-21т тодорхой харуулсан байдаг. Баптисм хүртэн гэм нүглээсээ нэгэнтээ “аврагдаж” асан хүмүүс хожим нь Христийг дахин ирэх үед харамсахаар байдалд орсон байдаг тухай жишээ Сударт олон бий /жишээлбэл Евр. 3:12-14, 6:4-6, 10:20-29/. Библи судрын ийм хэсгүүдийн хажууд “нэг аврагдсан бол үүрд аврагдана” хэмээх “Евангелийн” хоосон номлолууд махан биеэ бодсон хуурамч баримт болох нь илт байна.

Тэнцвэрийг хадгалах зөв мэдрэхүйтэй байх нь бид “баптисм” хүртсэнээр хэр зэрэг аврагдсанаа тодорхойлоход зайлшгүй тустай. Энэ нь авралын “боломжийг” баталгаажуулж буй хэрэг биш, Баптисм хүртэн “Христэд” орсноор бид аврагдаж, баптисмын уснаас гарч ирэх үедээ Христэд тасралтгүй итгэх юм бол Бурханы хаанчлалд хүрэх *бат* найдвар өвөрлөдөг билээ.

Баптисм хүртсэнийхээ дараа бид ямар ч үед Христийг буцаж ирэхэд биднийг Хаант улсад хүлээж авна хэмээн тууштай итгэж чаддаг байх ёстой. Бид “*туйлын*” итгэлтэй байж чадахгүй, учир нь бид маргааш нь няцаж мэднэ, амьдралд хувийн маань сүнс, сэтгэл санаа ирээдүйд ямар байхыг бид урьдчилан мэдэж чадахгүй билээ.

Бид Бурхантай хамт баптисм хүртэхдээ амладаг сайн мөс чанараа аль болох хадгалах ёстой. Баптисм бол “сайн мөс чанарын амлалт” / 1 Петр 3:21, Грек/, баптисм хүртэгсэд Бурхантай хамт сайн мөс чанараа хадгалахыг амладаг.

Баптисм хүртэх нь Христийн дотор байдаг агуу авралд хүргэх боломж олгодгоороо онцгой чухал юм, бид дан ганц баптисм хүртэх үйлдэл букуу “үйлсийг” гүйцэтгэснээрээ аврагдаж байгаа хэрэг биш гэдгийг бид ямагт санах ёстой. Христийн цовдлуулсныг тасралтгүй дагаж явах нь хэчнээн чухал болохыг бид өмнө үзүүлсэн билээ: “ хэн ус *болон* Сүнснээс эс төрнө, тэр хүн Бурханы хаанчлалд орж чадахгүй” /Иох. 3:5/. Энэ ишлэлийг 1 Петр 1:23тай харьцуулснаас харахад баптисм хүртсэний дараа Сүнснээс төрдөг нь бид Сүнс/Үгээр аажим нөхөн үрждэгтэй холбоотой байж таарна. Зөвхөн баптисм хүртсэнээр авралд хүрдэг юм биш, энэ бол нигүүлсэл /Ефес 2:8/, итгэл /Ром 1:5/, ба найдвар /Ром 8:24/ болон бусад зүйлсийн үр дүнд бий болдог. Гагцхүү итгэлээр авралд хүрнэ гэж зарим хүн маргах нь бий, иймээс “баптисм” гэх мэт “үйлс” нь учир холбогдолгүй юм. Гэсэн

хэдий ч, ийнхүү үзэх нь итгэл ба үйлсийн хооронд хуурамч зааг үүсгэдэг тухай Иаков 2:17-24т тодорхой харуулсан байна: жинхэнэ итгэл, жишээлбэл Сайн мэдээнд үнэн голоосоо итгэх итгэл гэдэг бол баптисм гэх мэт үр дүнд хүргэдэг үйлсийн агуу итгэл юм. “ Хүн зөвхөн итгэлээр бус, үйлсээр зөвтгөгддөгийг чи харж байна” /Иаков 2:24/. Баптисмын хэд хэдэн тохиолдолд, итгэгчийг “аврагдахын” тулд юу хийх ёстойг нь асуудаг, үүний хариулт нь ямагт баптисмтай холбоотой байдаг /Үйлс 2:37, 9:6, 10:6, 16:30/. Иймээс баптисмын “үйлсийг” бүтээх нь авралын Сайн мэдээнд итгэх бидний итгэлийн зайлшгүй илрэл билээ. Биднийг аврах үйлсийг Бурхан ба Христ үйлддэг ч бид “гэмшиж, гэмшилд дүйцэх үйл бүтээх ” /Үйлс 26:20, Марк 16:15, 16/ ёстой.

Гэм нүглээ угаах гэдэг нь бид Христ уруу баптисм хүртсэний төлөө Бурхан биднийг өршөөж байгаа хэрэг болох тухай бид дээр үзсэн билээ. Библийн зарим хэсэгт биднийг итгэл болон гэмшлээрээ гэм нүглээ угаадаг хэмээсэн байхад /Үйлс 22:16, Илч. 7:14, Иер 4:14, Иса. 1:16/, нөгөө зарим хэсэгт нь болохоор Бурхан бидний гэм нүглийг угаадаг /Езек. 16:9, Дуул. 51:2,7, 1 Кор. 6:11/ хэмээн өгүүлдэг. Энэ нь хэрэв бид баптисм хүртэх өөрсний үүргээ гүйцэтгэх юм бол дараагаар нь Бурхан бидний гэм нүглийг угаан цэвэршүүлнэ гэдгийг харуулж буй таатай баримт юм.

Ийнхүү баптисм үйлдэх “үйлс” буюу аль эсвэл үйлдэл нь Бурханы Сайн мэдээний үр шимийг хүртэх нэн чухал алхам бөгөөд Тэр Өөрийн Үгээр үүнийг бидэнд санал болгосон билээ.

Гажилт(Digression): Дахин Баптисм Хүртэх

Зарим хүн ус шүрших юм уу, аль эсвэл өөр нэг сүмд усанд бүрэн шумбах замаар “баптисм” маягийн юм хүртсэнийхээ дараа нэн дуулгавартайгаар баптисм хүртдэг. Гэсэн хэдий ч, баптисм хүртэхийн өмнө заавал гэмшиж, жинхэнэ Сайн мэдээнд зохих ёсоор итгэсэн байх ёстой /Үйлс 2:38, Марк 16:15,16/ Усанд яаран бүрэн шумбахын өмнө эдгээр зүйл ном ёсоор дарааллаараа болж өнгөрсөн цагт сая баптисм жинхэнэ баптисм болж өгнө. Матайн 28:19,20д баптисмыг Христийн сургаалийг анх сонсохтой холбосон байдаг. Балчир хүүхэд гэмшиж, аль эсвэл Сайн мэдээг ухан ойлгож үл чадна, ямар ч байсан, ус шүрших төдий нь

182 БУРХАН

баптисм биш. Усан санд ар өврөөрөө даллан сэлж буй тамирчин усанд бүрэн шумбаж байгаа хэдий ч энэ бол баптисм биш, учир нь энэ хүн жинхэнэ сайн мэдээнд ухамсартайгаар хариу үзүүлэхгүй байгаа болохоор тэр. Хоосон номлолд итгэж, усанд бүрэн шумбасан хүмүүс ч мөн ялгаа байхгүй, тэд шумбасан болохоос биш баптисм хүртээгүй.

“Цорын ганц итгэл” л байдаг, өөрөөр хэлбэл, Жинхэнэ Сайн Мэдээг бүрдүүлэх номлолын нэг цогц байх тул “цорын ганц баптисм” байна – энэ бол “цорын ганц итгэл”д итгэсний хойно бий болох баптисм билээ. “Та нар өөрсдийнхээ дуудлагын нэг найдвар дотор дуудагдсаны адил нэг бие, нэг сүнс, нэг Эзэн, нэг итгэл, нэг баптисм, нэг Бурхан байна. Тэр бол бүгдийн Эцэг бөгөөд бүгдийн дээр бүгдээр дамжуулан бүгдийн дотор байдаг” /Ефес 4:4-6/. Бидний шагнал Мөнхийн улсад юм уу, аль эсвэл ертөнцэд ирэх үү гэдэг нь хамаагүй гэж үздэг хүмүүсийн боддог шиг хоёр итгэл найдвар гэж байхгүй. “Цорын ганц Бурхан” байх тул Есүс Бурхан биш юм. Үүн дээр үндэслээд хэлэхэд, бид баптисм хүртэхдээ Бурханы хаанчлал, Бурхан ба Есүсийн шинж чанар зэрэг үндсэн номлолыг ойлгож чадаагүй байх юм бол бидний эхний удаагийн “баптисм” хүчингүй болжээ.

Баптисм хүртээгч Иохан хүмүүсийг шумбуулж, тэднийг нүглийн төлөө гэмшихийг уриалан, тэдэнд Есүсийн тухай зарим зүйлийг сургажээ /Марк 1:4, Лук 1:77/. Гэсэн ч энэ нь ямар ч үр дүн авчирсангүй. Үйлсийн 19:1-5д Иоханы баптисм хүртээсэн зарим хүн дахин баптисм хүртэх хэрэгтэй болсон, учир нь тэд зарим номлолыг хагас дутуу ойлгосон байжээ. Иоханы баптисм хүртээсэн тэдгээр хүмүүсийн нэгэн адил бид анхны удаа баптисм хүртэхдээ ер бусын гэмшиж, шинэ эхлэл эхлүүллээ гэж боддог байж мэдэх юм. Энэ үнэн ч байж болно, гэхдээ энэ нь “нэг итгэлийн” бүх элементийг нэг бүрчлэн ойлгосны эцэст л сая нэг ирдэг “нэг баптисм” хүлээж авах шаардлагыг үгүйсгэж байгаа хэрэг биш юм.

ХИЧЭЭЛ 9: Асуултууд

1. Бид баптисм хүртэхгүйгээр аврагдах боломжтой юу?
 - а/ Тийм
 - б/ Үгүй

2. “баптисм” гэж юу гэсэн үг вэ?
 - а/ үүрэг даалгавар
 - б/ ус шүрших
 - в/ итгэх
 - г/ усанд шумбах

3. Бид хэдийд баптисм хүртэх ёстой вэ?
 - а/ Жинхэнэ Сайн мэдээг судалж, гэмшсэн үедээ
 - б/ Жаахан хүүхэд байхдаа
 - в/ Библи судрыг сонирхсон цагаасаа
 - г/ Сүмд явахыг хүссэн үедээ

4. Бид юу руу баптисм хүртдэг вэ?
 - а/ Бидэнд баптисм хүртээсэн сүмд
 - б/ Бурханы үг
 - в/ Христ
 - г/ Ариун Сүнс

5. Баптисм хүртсэний дараа доорхи зүйлүүдийн аль нь тохиолддог вэ?
 - а/ Бид Абрахамын үр жимсийн нэг хэсэг болно
 - б/ Бид ахиж гэм үйлдэхгүй
 - в/ Бид бүх насаараа бүрмөсөн аврагдсан
 - г/ Бидний гэм өршөөгдсөн

6. Та баптисм хүртэхийг хүсч байна уу?
 - а/ Тийм
 - б/ Үгүй

10.1 Бодит Христич амьдрал

Библийн хичээл

Баптимсын дараа бид махан биеэр бус Сүнсээр удирдуулсан амьдралаар амьдарч, “ариусгалд хүрэх үр жимс” гаргаж ирэх хэрэгтэй (Ром 6:12, 8:1, Гал.5:16,25). Бидэн доторх Бурханы Үгээр дамжуулан бид сүнслэг жимсийг (Иохан 15:7,8) гаргаж ирнэ. Бурханы Сүнс түүний Үгэнд байдаг гэдэг утгаар бид Сүнсээр удирдуулдагаа харсан. Амьдралынхаа туршид бид Библийг тогтмол уншиж сурснаар тэрхүү Үгэнд ойр байх ёстой.

Үгийг бодлоготой судлах нь хүнд баптисмын хэрэгцээг ойлгуулж өгнө. Үгийг бидний үйл ажиллагаанд нөлөөлж, бидний амьдралыг чиглүүлэх үйл явц нь үргэлжлэх ёстой. Баптисм бол Бурханы Үгийг бүх насаараа дагах эхний алхам юм. Библи болон үндсэн номлолуудтай танилцахад Үг бидэнд цаашид нөлөөлөхөө болих байдалд оруулах жинхэнэ аюул оршдог. Бид үгүүдийг уншиж чадавч тэд бидэнд ямар ч бодит нөлөө үзүүлэхгүй (Хавсралт 2). Энэ шалтгаанаар Судрыг унших тоолондоо өмнө нь товч залбирал хэлэх нь ухаалаг болно. “Таны хуулиас гайхамшигт зүйлийг Надад харуулахаар нүдийг минь нээгээч” (Дуулал 119.18).

Бурханы Үг бидний өдөр тутмын хүнс байх хэрэгтэй. Үнэхээр бид түүндээ түшиж түүнийг угаасаа хүсэх нь биет хоол хүнсэнд төрөлхөөсөө дурлаж хүсдэгээс бүүр ч илүү байх ёстой. “Би түүний амнаас гардаг Үгийг нь өөрт минь хэрэгтэй хоолноос ч илүү нандигнасан ” хэмээсэн бодол Иовд төржээ. (Иов 23:12). Иеремиа ч бас “Таны Үг олдсон бөгөөд би тэднийг идсэн билээ. Таны үгс надад баяр хөөр болон зүрх сэтгэлийн минь таашаал болсон билээ” (Иер.15:16) гэжээ. Өдөр бүр Библийг тогтмол унших цаг гаргах нь өдөр тутмын амьдралын хэвшлээ тогтооход чухад зүйл юм. Өглөө хамгийн түрүүнд Библийг гучин минут тасралтгүй уншин судлавал биднийг өдрөө зөв оюун санааны бэлтгэлтэй эхлэхэд тустай. Итгэлээ хэвшүүлэх ийм ёс заншил нь шүүлтийн өдөрт алтнаас үнэтэй зүйл болох юм.

Судраас өөртөө сонирхолтой хэсгийг л зөвхөн унших хандлагаас зайлсхийхийн тулд Христадельфианууд “Библийн Нөхөр” хэмээх хөтөлбөрийг боловсруулжээ. (Түүнийг энэ номыг хэвлэгчдээс

олж авч болно). Үүний дагуу хэд хэдэн бүлгийг өдөр бүр унших ба үүний үр дүнд

Шинэ Гэрээг жилд хоёр удаа, Хуучин Гэрээг нэг удаа уншсан байх юм. Бүлгүүдийг өдөр бүр уншихдаа өөр олон мянган итгэгчид мөн тэр бүлгүүдийг уншиж байгаа гэж бодоход урам зориг төрдөг. Бид хэзээ ч уулзалдсан тэр даруй дотно холбоо үүсдэг. Бидний саяхан уншсан бүлгүүд бидний ярианы үндэс болох ёстой юм.

10.2 Залбирал

Амьдралд өөр нэг хөгжүүлүүштэй зүйл бол залбирал юм. “Бурхан ба хүмүүсийнхооронд ганц зууч байна.Тэр нь...Өөрийгөө Бүгдийн төлөөзолиос болгон өгсөн ...хүн болох Христ Есүс билээ” хэмээн Паул бидэнд сануулаад Христийн бүтээлийг ойлгох нь амьдрал ямар үр дүнтэй болохыг яг хэлжээ. “Имйд бид эрчүүдийг уур хилэнгүйгээр, эргэлзүйлгээр...газар бүрд залбираасай гэж хүсдэг” (1Тим. 2:5-8) гэжээ. “Учир нь бидэнд байгаа нь бидний мөхөс байдлыг хувааж чаддаггүй тэргүүн тахилч бус харин нүгэлгүй атлаа бүх талаар бидэн шиг соригдсон Нэгэн билээ...тиймд бид хэрэгцээтэй цагт туслах нигүүслийг болон өршөөлийг хүлээн авахын тулд нигүүслийн хаан ширээнд итгэлтэйгээр ойртон очигцооё” (Еврей 4:15,16).

Үнэхээр ч бидний залбиралыг Бурханд хүчтэй санал болгох бидний хүн нь бидний хувийн Тэргүүн тахилч Христ гэж үзэх нь биднийг итгэлдээ тогтмол залбирах урам хайрлах юм. Гэвч залбирал нь Бурханд мэдүүлэх зөвхөн “хүслийн жагсаалт” байж болохгүй. Хоолоо идэхээс өмнө талархах, аялалдаа амар мэнд явахад талархах гэх мэт нь бидний залбиралын чухал хэсэг болох ёстой.

Бид өөрсдийнхөө бэршээлийг залбиралаараа Эзэний өмнө гаргаж тавих нь энх амгалангийн аугаа их мэдрэмжийг өгдөг. “Аливаа зүйлд залбиралаараа болон гуйлтаараа талархалтайгаар хүсэлтээ Бурханд мэдүүл.Бүх оюун ухаанаас дээгүрх Бурханы амар тайван нь та нарын зүрх бодлыг тань хамгаална”(Фил.4:6,7).

186 БУРХАН

Хэрвээ бидний залбирал Бурханы хүсэлд нийцвэл тэдэнд хариу ирэх нь мэдээж. Бид Бурханы Үгийг сурснаар Түүний хүслийг мэдэж болох ба тэр нь Бурханы Сүнс/Ухааныг бидэнд нээж өгдөг. Тиймээс Библийн тухай бидний хичээл биднийг хэрхэн залбирах, юуны төлөө залбирахыг зааж өгч, бидний залбиралыг хүчтэй болгодог. Иймээс “Хэрэв миний үгс та нарын дотор байвал та нар юу хүссэнээ гуй. Тэгвэл та нарын төлөө биелэх болно”

(Иохан 15:7). Сударт тогтмол залбирахын олон жишээ байдаг. (Дуулал 119:164, Дан.6:10). Өглөө ба оройд, өдрийн явцад талархалын цөөн хэлэн залбирал хийх нь доод хэмжээ нь юм.

10.3 Номлол

Жинхэнэ Бурханыг мэдэх явдлаас үүсч гардаг, уруу татах аугаа хүслүүдийн нэг бол сүслэлийн хувьд хувиа хичээгч болох явдал юм. Бид бурхантай хувийн харилцаатай байдагтаа тун сэтгэл хангалуун болж, Библи% сүнслэгийг хувиараа судалж байгаадаа автагдаад тэдгээрийг бусадтай буюу итгэгч нөхөд, бидний эргэн тойртой хуваалцахаа орхигдуудлж болох юм. Бурханы Үг ба Түүнд байх жинхэнэ Сайн мэдээг харанхуйд гэрэлтэх гэрэл буюу асах дэнлүүтэй адилтгасан байдаг юм (Дуулал 119:110, Сургаалт үгс 4:18). Өөртөө ийм гэрэл бүхий хэн ч түүнийг саван дор хөмрөхгүй, харин олоннийтэд тавидаг гэж Есүс хэлсэн байдаг (Мат.5:15). “Ертөнцийн гэрэл” Христ уруу баптисм хүртсэн учраас “Та нар ертөнцийн гэрэл болно” (Мат.5:14, Иохан 8:12). “Уулан дээрх хот нуугдаж эс чадна” гэж Христ нэмж хэлжээ (Мат.5:14).

Хэрвээ бид өөрсдийн ойлгодог жинхэнэ Сайн Мэдээний дагуу амьдралаар амьдрах юм бол бидний “ариун байдал” бидний хамт амьдардаггүйчүүдэд ил тод болно. Бид Хаанчлалын найдвар “уруу салсан” ба бас өөрсдийн нийтлэг зам”аас салсан” гэсэн баримтыг нуун далдалж чадахгүй болно.

Бид Үнэний талаарх мэдлэгээ уулзаж харилцах хүмүүстэй ая дантай байдлаар хуваалцахыг эрэлхийлэх хэрэгтэй. Үүнд сүнслэг зүйлсийг тойруулан ярьж, бусад сүмийн гишүүдтэй номлолыг хэлэлцэж, шашны өгүүлэлүүдийг тарааж тэр ч байтугай ороннутгийнхэвлэл мэдээллийн хэргсэлээр жижиг сурталчилгаануудыг явуулах зэрэг нь бид гэрлээ цацруулж

байхын арга замууд юм. Бид гэрчлэх ажлыг бусад итгэгчидэд үлдээж болохгүй байх гэж бодож байна. Бид тус бүртээ өөрийн гэсэн хариуцлагатай билээ. Христадельфианууд бусад бүлгүүдтэй харьцуулахад зохион байгуулалттай томоохон хэмжээний номлолын санаачлагууд харьцангуй цөөхөн юм. Бидний тус бүрдээ ихэвчлэн өөрсдийнхувийн зардлаар чадах юмаахийдэг .

Номлол хийх хамгийн их амжилттай арга замын нэг бол гэр бүлийхэн ба шууд харьцдаг хүмүүстээ итгэлээ тайлбарлах явдал юм. Итгэгдэггүй түншүүдтэй хүмүүснэ тэдэнд итгэлээ тодорхой тайлбарлаж, өгөх хэрэтэй бөгөөд нэгэнт тайлбарласан бол түүнийгээ дахин дахин сөхөж гаргах буюу тэдэнд шахалт үзүүлэх нь ухаалаг биш юм. Бурхан шахалт хавчилтаар өөртөө оруулахыг хүсэхгүй. Бидний үүрэг бол үнэний гэрч болох явдал бөгөөд тэгэхдээ түүнээс хариу хүлээж их санаа зовохын хэрэггүй. Бид энэ гэрчийг хийхийн тулд их хариуцлага хүлээж байгаа. Хэрэв Христ бидний

амьдралын хугацаанд ирэх ахул “талбай дээрх хоёр эрийн нэгийг нь авч нөгөөг нь үлдээнэ” (Лук 17:36). Ийм зүйл болох үед эзнийхээ хоёр дахь ирэлтийг гэр бүлхийхэндээ буюу хамтран ажиллагсаддаа хэлээгүй бол тэр нь хачин явдал болно.

10.4 Сүм дэх амьдрал

Бид энэ хичээлээр одоог хүртэл хувийнхаа сүнслэг хариуцлагын тухай ярьсан билээ. Гэвч бидний найдварыг хуваалцдаг бусадтай хамтран гүйцэтгэх үүрэг бидэнд байна. Энэ нь мөн л бидний хийх гэж хүсч байсан хүсэл эрмэлзэлийн зүйл байх ёстой. Баптисмын дараа бид Хаанчлал өөд эзгүй газраар аялалд гарна гэдгийг бид харуулсан. Хамтран аялагчтайгаа холбоо тогтоох гэж хүсэх нь мэдээж. Бид Христийн ирэхийн өмнөх сүүлчийн өдрүүдэд амьдарч байна. Энэ цаг үед бидэнтэй учрах олон хүнд бэрх шалгалтуудыг даван туулахыг тулд бидэнтэй адилхан нөхцөлд байгаа нөхөдтэйгөө хамтрах хэрэгтэй. “Хамтран цуглахаа умарталгүй харин тэр өдөр (Хоёр дахь ирэлтийн) ойртох тусам нэг нэгнээ зоригжуулья” (Еврей 10:25; Мал. 3:16). Тиймээс итгэгчид бусадтайгаа захиагаар харилцах юм уу Библийн талаарх мэдлэгээ бие биентэйгээ хуваах, олон нийтийн үйлчилгээ ба

188 БУРХАН

номлолын үйл ажиллагаануудаа хуваалцахын тулд бие биен дээрээ очиж уулзах хэрэгтэй билээ.

Бид тус бүрдээ дэлхийгээс хаанчлалын аугаа их найдвар уруу “дуудагдсан” билээ. “Гэгээнтэн” гэдэг үг “дуудагдсан хүн” гэсэн утгатай бөгөөд энэ нь өнгөрсөн үеийн цөөн хэдэн алдартай итгэгчдэд бус бүх үнэнч итгэгч нарт хамаартай байж болно. Англи хэлний Библид “сүм” гэж орчуулагдсан грек үг нь “эклесиа” бөгөөд энэ нь “дуудагдсанчуудын цуглаан, өөрөөр хэлбэл итгэгчид” гэсэн утгатай юм. Тиймээс “сүм” нь итгэгчдийн уулздаг бодит байшин гэхээсээ илүүтэйгээр итгэгчдийн бүлэгт хамаарч байгаа юм. Энэ үгийг хэрэглэхдээ буруу ойлгохоос зайлсхийхийн тулд Христадельфанууд өөрсдийн “сүм”-үдийг “эклесиа” гэж хэлдэг байна.

Тодорхой хот юмуу газар нутагт хэдэн тооны итгэгчид байхад тэд тогтмол уулзах газартай болох нь ойлгомжтой. Энэ нь аль нэг итгэгчийн гэр юмуу хөлсөлж авсан танхим байж болно. Дэлхий нийтийн Христадельфануудын эклесиа сууд олон нийтийн төвүүд, зочид буудлын хуралдааны танхимууд, хувиараа барьсан танхимууд буюу айлуудад цуглацгаадаг байна.

Цугларалтын зорилго нь Библийг хамтаараа судлах замаар гишүүдийнхээ эгнээг бэхжүүлэх, номлох замаар гэрлээ цацруулж, дэлхийд хамтран гэрчлэх явдал юм. Христадельфануудын цугларалтын нийтлэг цагийн хуваарь нь иймэрхүү байж болох юм:

НЯМ	11.00	Талх хуваах
	18.00	Нийтийн номлол
ЛХАГВА	20.00	Библийн хичээл

Цугларалт нь Бурханы гэр бүлийн нэг хэсэг юм. Ойр нягт хамт олон дотор гишүүн бүр бусдадаа анхааралтай, дуулгавартай байх хэрэгтэй. Христ өөрөө үүний дээд үлгэр жишээ юм. Тэрээр сүнслэг дээд байдалтай байсан ч хэн нь хамгийн аугаа вэ гэж өөр хоорондоо маргалдаж байх зуур “бүгдийн албат” мэт байж дагалдагч нарынхаа хөлийг угааж байлаа. Есүс өөрийнхөө энэ жишээг дагахыг бидэнд айлджээ. (Иохан 13:14,15, Мат.20:25-28).

Цугларалтад заадаг зүйлүүд нь мэдээж Бурханы үгэн дээр үндэслэсэн байх нь зүйтэй. Цугларалт дотор үг хэлж буй хүмүүс, тиймээс, Бурханыг тусгаж Түүний өмнөөс ярьж байгаа хэрэг юм. Бурхан эр хүйстэй учир Бурханы Үгийн зааврыг олон түмэнд зөвхөн ах, эрэгтэй дүү нар хийх ёстой. 1Кор. 14:34-т үүнийг тодохой заажээ: “Эмэгтэйчүүд чуулганд чимээгүй байг, учир нь тэдэнд ярихыг зөвшөөрдөггүй”. 1Тим. 2:11-15-д Едений цэцэрлэгт болсон үйл явдлыг үүний шалтгаан болгож тайлбарлажээ. Учир нь Ева Адамыг нүгэл хийхэд сургасан тул эмэгтэй хүн эрэгтэй хүнийг сургаж болохгүй. Бурхан Адамыг Евагаас өмнө бий болгосон баримт нь “эмэгтэй хүний тэргүүн нь эр хүн юм” (1Кор.11:3) гэсний тэмдэг юм. Тиймээс эр хүн оюун санааны хувьд эмэгтэй хүнийг тэргүүлж байхаас биш эмэгтэй нь эрэгтэйгээ гэсэн үг бишээ.

Энэ бүх явдлаас болон “Эмэгтэй хүн дуугүй байн, бүрэн дуулгавартайгаар суралц. Харин эмэгтэй заах, эсвэл эр хүнийг захирах эрх мэдэлтэй байхыг би зөвшөөрөхгүй. Учир нь эхлээд Адам дараа нь Ева бүтээгдсэн билээ. Адам мэхлэгдээгүй, харин эмэгтэй нь мэхлэгдэж, гэм буруу дотор унасан юм. Гэвч хэрэв эмэгтэйчүүд итгэл, хайр дотор ба зохистой байн ариусгал дотор цаашид байх аваас эмэгтэй нь хүүхэд төрүүлэхээрээ аврагдана.” (1Тим. 2:11-15).

Библи эрэгтэй эмэгтэй итгэгчидийн үүргийг тодорхой зааглаж үздэг нь үүнээс тодорхой байна. Эмэгтэйчүүдэд тодорхой зүйлүүд дээр “гэрлэж, гэрээ сахиж, хүүхэд төрүүлж”(1Тим 5:14) байхыг тушаасан нь тэдний оюун санааны талбар гэр нь байх юм гэдгийг харуулж байна. Иймээс экклеси доторх олон нийтийн ажил нь эрэгтэйчүүдийн үүрэг юм. Энэ нь хүйсийн эрх тэгш байх хүмүүнлэгийн онолтой эрс тэрс үөрчилдөж байгаа билээ. Уг онолын дагуу албан тушаал дэвших хүсэлтэй эмэгтэй хүн нөхөртөйгөө гэрийнхээ төсвийг зохицуулахаас өгсүүлээд адилхан хувцас өмсөх хүртэл бүх талаар эрх тэгш гэж хэлдэг. Хүүхэд бүтээх үйл ажиллагааг тааламжгүй байдлаар зохицуулж байсан бололтой. Энэ нь бүрэн материалист бахувиа хичээсэн ертөнцөд сэтгэл санааны эрүүл төвшинг хадгалахад үүнийг зайлшгүй чухал гэж үзжээ. Жинхэнэ итгэгчид цаг үеийн энэ байдлыг тойрон гарна. Гэхдээ тэнцвэр ямагт байх ёстой.

Нөхөр нь эхнэрээ захирч болохгүй, Харин Христ биднийг хайрласан шиг эхнэрээ хайрлах хэрэгтэй (Ефес 5:25).

190 БУРХАН

“Нөхрүүдээ, эхнэр чинь эмэгтэй хүн тул түүнийг өөрөөсөө сул дорой сав мэт үзэж (Бурханы Үгийн тухай өөрийн мэдлэгийн дагуу эхнэртэйгээ зөөлөн харьу) эхнэртэйгээ ойлголцож амьдар. Амийн нигүүслийн хамтран өвлөгчийнх нь хувьд түүнийг хүндэтгэ” (1 Петр 3:7).

Сүнслэг үг хэллэгээр Христ уруу баптисм хүртэх нь эрэгтэй, эмэгтэйчүүдийг эрх тэгш болгож байгаа юм. (Гал.3:27,28, 1Кор. 11:11,). Гэсэн хэдий ч гэр бүлийн дотор ч , экклесиагийн дотор ч амьдралын болон ариунсүнсний хэргүүдэд “эр хүн бол эмэгтэй хүний тэргүүн мөн” (1Кор. 11:3) хэмээх тодорхой зарчимд энэ нь нөлөөлөхгүй.

Энэхүү зарчмыг хүлээн зөвшөрч байгааг харуулахын тулд эмэгтэй итгэгч ах буюу эрэгтэй дүүг Бурханы Үгээс номлож байх үед толгойдоо өмсгөл өмссөн байх ёстой. Энэ нь амьдрал дээр тэд экклесиан уулзалт дээр малгай эсвэл толгойн бүтээлэг өмссөн байх ёстой гэсэн үг болно. Эрэгтэй, эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүргийн ялгаа нь тэдний үсээр илэрнэ.(1Кор. 11:14,15). “Залбирах үедээ толгойгоо бүтээгээгүй эмэгтэй хүн бүр үсээ хусуулсантай адил юм. Хэрэв эмэгтэй хүн толгойгоо бүтээхгүй бол үсээ басхяргаг. Гэвч үсээ хяргах хусуулах нь эмэгтэй хүнд ичгэвтэр байвал тэр өөрийн толгойг бүтээг. Тиймээс тэнгэр элч нарын улмаас эмэгтэй хүн толгой дээрээ эрх мэдлийн тэмдэг байлгах ёстой” (1Кор. 11:5,6,10)

10.5 Талх хуваах

Залбирах болон Библийг уншихын зэрэгцээ Христийн золиос болсны дурсгалд дарс уух, талх хуваах Түүний тушаалыг дагах нь зайлшгүй чухал.

“Намайг дурсаж үүнийг хий” гэж Есүс тушаажээ (Лук 22:19). Есүс хоёр дахиа ирээд өөрийгөө дагагчидтайгаа дахин талх, дарсаа хуваах үе хүртэл үүнийг тогтмол хийж байх нь Бурханы хүсэл юм. (1Кор. 11:26; Лук 22:16-18).

Талх нь загалмайд цовдлогдсон Христийн биеийг, дарс нь Түүний цусыг төлөөлж байгаа юм (1Кор. 11:23-27). Эртний итгэгчид энэ ёсыг байнга хийдэг байсан бололтой (Үйлс 2:42, 46). Долоо

хоногт нэг удаа хийдэг байсан байж магадгүй (Үйлс 20:7). Хэрвээ бид Христийг үнэхээр хайрладаг бол бид түүний тушаалыг дагана (Иохан 15:11-14). Хэрвээ бид түүнтэй жинхэнэ хувийн харилцаатай бол түүний золиосыг түүний хүссэнээр нь санахыг эрмэлзэх бөгөөд түүний хүрсэн тэр аугаа их авралыг санахдаа өөрсдийгөө зоригжуулах болно. Түүнийг загалмай дээр зовсныг чимээгүйхэн бодоход бидний өөрсдийн шүүлт нь манай Эзэнийхтэй харьцуулахад маш өчүүхэн билээ.

Талх хуваах нь үндсээрээ *дурсан санахын* ёс бөгөөд үүнийг хийснээр гайхалтай ямар ч зүйл тохиолдохгүй. Энэ нь Мосегийн хуулийн орох Дээгүүр Өнгөрөх баяртай тэнцүү юм. (Лук 22:15, 1Кор.5:7,8). Энэ нь Улаан Тэнгист Мосегоор дамжуулан Египетээс гаргасан аугаа их явдлыг санан дурсах зам юм. Талх хуваах ёс нь Христээр дамжуулан биднийг нүглээс аврахад дахин авачиж байгаа хэрэг бөгөөд авралд хүрэх нь загалмай дээр цовлогдож биднийг баптисмаар холбогдсны ачаар боломжтой болсон. Энэ тушаалыг биелүүлэх нь биднийг хийхийг хүсүүштэй зүйл мөн.

Талх, дарсыг биелэн хүртэх нь Христийн хайрыг бидэнд хүртээж байгаа хэрэг бөгөөд үнэхээр бидний авралтай холбоотой бүх зүйлс дахин бодит болж байгаа юм. Иймээс долоо хоногт нэг удаа талх хуваах нь эрүүл сүнслэг байдлын тэмдэг юм. Хэрэв хэн нэг нь Үнэний итгэгч нөхөдтөйгөө үүнийг хийжчадахгүй бол ганцаараахийх нь зүйтэй. Энэ тушаалыг биелүүлэхийг зогсоох ямар ч шалтгаан байж таарахгүй. Бид энэ ёслолд зориулах талх, дарсны нөөцтэй байх тал дээр аль болохоор чармайх ёстой. Зарим онцгой тохиолдолд эдгээр нь дутагдах үе гарлаа гэхэд Христийг

санах явдлыг заасан замаар нь үйлдэхэд энэ нь саад болох ёсгүй. Есүс “усан үзмийг” (Лук 22:18) хэрэглэсэн учраас бид усан үзмийн улаан дарсийг хэрэглэх нь зүйтэй.

Христийн зовлон шаналал, золиослолын тэмдэгийг хүлээж авах нь эрэгтэй, эмэгтэйчүүдэд байжболох хамгийн дээд нэр төрийн хэрэг юм. Тэдгээрийг төлөөлж байгаа зүйлийн нь зохистой анхаарал тавилгүйгээр хүртэх нь бараг Бурханыг хараасантай адил хэрэг болох бөгөөд “Энэ талхыг идэж энэ аяганаас уух бүрдээ тан ар Түүнийг Эзэний бие ба цусны буруутан болно”(1Кор. 11:26, 27) гэсэн үг юм. Иймээс талх хуваах ёслолыг хүний бодлыг

192 БУРХАН

үймүүлж самууруулахгүй тийм газарт, тийм цагт хийх ёстой. Үүнийг өглөө эрт эсвэл шөнө орой, орондоо эсвэл өөр тохиромжтой газар хийж болох юм. Биднийг цааш нь “Хүн өөрийгөө шалгаг (тэгээд өөрийгөө шалгах тэр даруу байдалд) талхыг идэг, аяганаас ууг” (1Кор. 11:28) гэж зөвлөдөг. Иймээс бид Христийн золиослолд анхаарлаатөвлөрүүлэх хэрэгтэй. Ингэхдээтэмдгийг авахаасаа өмнө Сайн Мэдээний бичвэрүүдийг харж болно. Ингэж зүй зохистойгоор нь хийснээр бид Христэд хандах өөрсдийнхөө ухамсарыг гарцаагүй шалгах болно.

Талх хуваах ёслолын зүй зохистой дэг журам нь дараах байдлаар байна:-

1. Залбирал- цуглаанд Бурханы ерөөлийг гуйх; Тэрээр бидний нүдийг Өөрийнхөө Үгэнд нээнэ. Бусад итгэгчидийн хэрэгцээг санан дурсана. Түүний хайрыг ялангуяа Христэд илэрсэн хайрыг магтана. Мөн бусад онцгой асуудалтай холбоотой залбирал
2. “Библийн Нөхөр”-т тодорхойлсон өдөрт зориулж Библийн уншилт явуул.
3. Тэднээс суралцах хичээлүүдийг бясалгаж, ‘зөвөлгөөг’ унш. Бидний ёслолын зорилго өөд удирдан залж байгаа тэдгээр Библийн бүлгүүдийг судал.- Христийг санах.
4. 1 Коринт 11:23-29 –г унш.
5. Чимээгүйгээр өөрөө өөрийгөө шалгах үе.
6. Талхны төлөө залбирал
7. Талхыг хувааж өчүүхэн хэсгийг идэх.
8. Дарсны төлөө залбирал
9. Дарснаас нэг амсах.
10. Төгсгөлийн залбирал.

Бүх ёслол нэг цаг гаруй үргэлжилнэ.

10.6 Гэрлэлт

Бид энэ хэсгийг баптисмыг хүртэхэд ганц бие байсан хүмүүсийн байр байдлаас эхлэе. Өөрсдийгөө Эзний бүтээлд бүрэн зориулахын тулд гоонь биеэр үлдэх гэж бодож байгаа ганц бие хүмүүсийг урамшуулах цөөн тооны ишлэлүүд болон Есүс, Паул болон бусдуудын жишээнүүд байна (1Кор.7:7-9, 32-38, 2Тим.2:4, Мат. 19:11,12, 29, Номлогчийн үгс 9:9). “Чи гэрлэлээ ч гэсэн хүгэл үйлдээгүй хэрэг” (1Кор. 7:28) . Эш үзүүлэгчдийн нэлээд нь гэрлэсэн байсан (1Кор. 9:5) ба Бурханы төлөвлөсөн гэрлэлт биет болон сүнслэг ашиг авчирахад зориулагджээ. “Бүгд гэрлэлтийг хүндлэгтүн. Ор дэр нь ч бузартаагүй байг. ” (Еврей 13:4) . Эрэгтэй хүн сүнслэг зүйлсэд өндөр төвшинд үнэнч байж чадахгүй бол “Эрэгтэй хүн ганцаараа байх сайн биш” (Эхлэл 2:18-24) учраас Бурхан гэрлэлтийг тогтоожээ. Тийм учраас “Эхнэрийг олдог хүн сайныг олж Эзэнээс тааллыг хүлээн авдаг. Ухаалаг эхнэр Эзэнээс ирдэг” (Сургаалт үгс 18:22, 19:14).

Эдгээр ишлэлийн утга нь гэрлэлтээс гадуур хүсэлд автах нь завхайрал мөн. Шинэ Гэрээнд бараг бүх хэсэгт нь завхайрал (гэрлээгүй хүмүүсийн хоорондох бэлгийн харьцаа) , ханиа хуурах (гэрлэсэн хүмүүс өөр хүмүүстэй бэлгийн харьцаа үйлдэх) зэрэг ёс суртахууны бус аливаа хэлбэрийг

буруушааж сануулсан байдаг. Эдгээрээс заримыг дурдвал Үйлс 15:20; Ром 1:29; 1Кор. 6:9-18; 10:8 ; 2 Кор.12:21 ; Гал. 5:19; Кол. 3:5; 1Тес. 4:3; Иуда 7; 1Петр 4:3; Илчлэлт 2:21.

Эхлэл 2:24-н гол зарчим нь нэг хүйстэнтэйгээ явалдахын нүглийг илчилдэг. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс хоорондоо гэрлэж, бие бизндээ үнэнч байх нь Бурханы төлөвлөгөө юм. Бурхан эмэгтэй хүнийг бүтээхдээ Адамд туслахаар бүтээсэн болохоос өөр хүнд зориулсан биш ажгуу. Эрэгтэй хүмүүсийн хоорондох бэлгийн харилцааг Библид буруушаасан байна. Содомыг устасан нүглүүдийн нэг нь энэ байсан юм (Эхлэл Бүлэг 18,19). Ийм зуршилыг зогсолтгүй үргэлжлүүлэх нь Бурханы хилэнг хөдөлгөж, Түүний Хаанчлалаас хасагдах болно гэдгийг эш үзүүлэгч Паул тодорхой өгүүлсэнбайдаг (Ром 1:18-32, 1Кор. 6:9,10).

Ийм зүйлд нэгэнт орсон ахул Бурханы тусламж авч чадахгүй болно гэсэн үг биш юм. Бурханы уучлалт байдаг бөгөөд Түүний

194 БУРХАН

уучлалыг хүртсэн хүмүүс Түүнд хайр хүндэтгэл өгөх ёстой (Дуулал 130:4). Коринт дахь эkkлeсиад нэлээд хэдэн гэмшсэн хөнгөмсөг эрчүүл байжээ. “Та нарын зарим нь тийм байсан. Гэвч Эзэн Есүсийн нэрээр та нар угаагдсан (баптисмаар), та нар ариусгагдсан, та нар зөвтгөгдсөн (баптисм хүртээж)” (1 Кор.6: 9-11).

10.7 Нөхөрлөл

‘Нөхөрлөл’ ба ‘хамт олон’ гэдгийг орчуулсан грек үгнүүд нь ямар нэгэн нийтлэг зүйлтэй байх, нийтлэг эвлэлдээний байдлыг гол нь дүрсэлжээ. Бурханы замыг мэдэж, амьдралд хэрэглэснээр бид Түүнтэй болон “Христэд” байх замаар мөн адил зүйлийг хийжбайгаа бусад хүмүүстэй нөхөрлөлд байна гэсэн үг юм. бусадтай нөхөрлөхдөө бид хариуцлагаа үл ойшооход амархан байдаг. “Сайныг үйлдэхдээ болон хуваалцахаа (өөрөөр хэлбэл нөхөрлөх) бүү март” (Еврей 13:16). Фил. 1:5 –д “Сайн мэдээнд нөхөрлөх ” бидний нөхөрлөлийн тухай дурьддаг. Тиймээс биднийнөхөрлөлийн үндэс бол жинхэнэ Сайн мэдээг хамруулдаг номлолууд юм. Энэ шалтгаанаар жинхэнэ итгэгчидийн нөхөрлөл бол аливаа бусад байгууллаг болон сүмээс илүү аугаа их юм. Энэ нөхөрлөлөөр тэд бие биетэйгээ уулзахаар алс замд аялдаг бөгөөд аль болох боломжтой газар нь шуудангийн хийгээд харилцаа холбооны хэрэгслийг сайн ашиглах ёстой.

Паул “сүнсний нөхөрлөл”-ийн тухай ярьдаг (Фил.2:1). Өөрөөр хэлбэл Бурханы Сүнс/ Үгэнд илэрдэг түүний сүнс ухааныг бид нэгдмэлээр дагадаг явдалд үндэслэсэн нөхөрлөл юм. Бидний нөхөрлөлийн аугаа их илэрлүүдийн нэг нь хамтдаа хийдэг талх хуваах ёслол юм. Эртний итгэгчид “байнга элч нарын сургаалыг сонсож бас нөхөрлөж, талх хувааж залбирцгааж байсан. Талхаа...баяр хөөртөйгөөр ...чин сэтгэлээсээ хувааж байсан.”(Үйлс 2:42,46). Бидний найдварын гол цөмийг төлөөлсөн тэмдэгүүд хийгээд тэдгээрийг хамтран хуваалцах нь “чин сэтгэлд” биднийг нэгтгэх ёстой. “Биднийгөрөөдөг ерөөлийн аяга нь Христийн цусан доторх оролцоо (хуваах) биш үү? Талх нэг тул бид олуулаа ч нэг бие байна. Учир нь бид бүгдээрээ нэг талнаас хуваалцдаг” өөрөөр хэлбэл Христ (1Кор. 10:16,17). Иймээс бид Христийн золиослолын тэмдэгүүдийг түүний бүтээлүүдээс ач тус олдог, “тэр ганц талхыг идэгчид” зэрэг бүх хүмүүстэй хувааж

авах үүрэгтэй. Гагцхүү христ уруу зохих ёсоор баптисм хүртсэн хүмүүс үнэнийг мэдсэний дараа ийм байрлалд орох бөгөөд эдгээрээс өөр хүмүүстэй тэмдэгийг хувааж авах нь доромжлол болно.

Бидний Бурхан, Христ болон бусад итгэгчидтэй байгуулсан нөхөрлөл “ганц итгэл”-ийг хамрах номлолын үнэнүүд уруу нийтээрээ өгсөх явдалаас зөвхөн хамаарахгүй. Бид нарын амьдралын зам нь тэдгээрт илэрхийлэгдэж байгаа зарчимуудыг дагах ёстой. “Бурхан бол гэрэл мөн. Түүний дотор харанхуй огт байхгүй гэдэг нь бидний Түүнэс сонссон мэдээ бөгөөд та нарт тунхаглаж байна. Хэрэв бид Бурхантай нөрлөвөл гэж яриад харанхуй дотор алхаж байвал бид худал хэлж, үнэнийг үйлддэггүй ажээ. Харин тэр өөрөө гэрлийн дотор байдагчлан бид гэрлийн дотор явбал бид бие биетэйгээ нөхөрлөж түүний Хүү Есүс Христийн цус биднийг бүх нүглээс ангижруулдаг” (1Иохан 1:5-7).

гэгч Библийн тодорхой сургаалуудын илэрхий эсрэг утгатай номлолуудыг дагах буюу эсрэг амьдралын замаар явбал нөхөрлөл тасран зогсоно гэдэг нь үүнээс тодорхойхарагдаж байна. “Харанхуйн үр жимсгүй ажлуудад бүү оролц, харин ч тэдгээрийг илчлэгтүн” (Ефес 5:11). Алдсан хонио хайжбайгаа сайн хоньчины жишээгээр тэднийг буцааж эгнээндээ нийлүүлэхийн тулд бүх хүч чармайлтаа тавих нь зүйтэй (Лук 15:1-7).

Нөхөрлөлийнтухай хамгийн тод өгүүлсэн ишлэлүүдийн нэг нь 2 Коринт 6:14-18-д байна. “Үл итгэгчдийн хамт нэг буулганд бүү орогтун. Зөвт байдал ба ёсбус нь яаж хамтрах билээ? Гэрэл ба харанхуйн хооронд ямар нөхөрлөл

байдаг билээ?...тиймээс тэдний дундаас гарч тусгаар бай гэж Эзэн айлддаг. ...Би та нарыг хүлээн авч, Та нарын Эзэг чинь болно. Та нар ч миний хөвгүүд, охид болно гэж төгс хүчит Эзэн айлддаг”. Бурханы Үг хэрхэн гэрэл болохыг бид харуулсан. Эдгээр ишлэлүүдэд хуурамч номлолууд заадаг сүмүүдтэй бид яагаад нөхөрлөж болохгүйг, үнэнийг мэдэхгүй хүмүүстэй бид яагаад гэрлэж болохгүйг, дэлхийн замуудаас яагаад хол явах ёстойг тайлбарладаг. Бид дэлхийгээс тусгаарлагдснаар Бурханы жинхэнэ хөвгүүд, охид, дэлхий дахинд мөн ийм харилцаатай байдаг манай ах, эгч, дүү нарын гэр бүлийн хэсэг болох аугаа их завшаан тохиож байгаа ажгуу. Зөвхөн “нэг бие”, өөрөөр хэлбэл

196 БУРХАН

ганц үнэн сүм байдаг юм (Ефес 1:23). Энэ нь ганч найдвар болох Бурхан, ганц баптисм, “ганц итгэл” дээр үндэслэдэг. Өөрөөр хэлбэл ганц итгэл (Ефес 4:4-6) итгэлийг агуулсан номлолуудын ганц үнэн цогц юм. “Нэг бие”-ийн хэсэг болох буюу үнэн итгэлийг барьдаггүй бусад шашны байгууллагуудтай нөхөрлөх боломжгүй юм. Гэрэл харанхуйтай нөхөрлөдөггүйн адил бид харанхуйтай нөхөрлөвөл өөрсдийгөө харанхуйд байна хэмээн тунхаглах болно.

Хэрвээ бид эдгээр хичээлийг нарийн суралцсан бол Бурхантай харьцах бидний харьцаанд дундах зам гэж байхгүй нь одоо тодорхой болсон байна. Бид нэг бол баптисмаар Христ дотор орж түүн дотор байна, эс бол түүний гадна байх юм. Бид нэг бол жинхэнэ номлолыг ойлгож амьдрал дээр түүнийг мөрдснөөр гэрэлд байх билээ. Эс бол харанхуйд байх болно. Бид нэгэнд нь баруун хөлөө, нөгөөд нь зүүн хөлөө тавьж болохгүй.

Эдгээрийн талаарх бидний мэдлэг биднийг Бурханы өмнө тодорхой хэмжээний хариуцлага хүлээлгэж байна. Одоо бид гудамжаар алхахдаа буюу өдөр тутмын амьдралаа явуулахдаа дэлхийн дундаж хүн шиг байж болохгүй юм. Бурхан биднээс хариуг анхааралтай ажиглаж байна. Бурхан ч, Эзэн Есүс ч, бусад бүх үнэн итгэгчид та бүхнийг зөв шийдвэр гаргахад дэмжлэг болж байна. Гэвч Бурхан, Христ болон өөрсдөө таньп туслахын тулд хэчнээн чармайсан ч тэр байтугай Бурхан Өөрийнхөө ганц Хүүг бидний төлөө үхүүлэхэд хүргэж байсан ч эцсийн эцэст та бүхний аврал санал болгоод буй аугаа их найдварыг олж авах таны өөрийн тань шийдвэрээс хамаарна. Иймд баптисм хүртэх шийдвэр гаргаж энэ замаар замнагтун. Хэрвээ та энэ номны хүүрэн дэх хаягаар бичвэл түүнийг би та бүхэнд баяртайгаар зохион байгуулах болно.

ХИЧЭЭЛ 10: Асуултууд

1. 'Ариусгал' гэж ямар утгатай вэ?
 - a) Үл итгэгч хүмүүстэй харилцахгүй байх.
 - b) Нүглээс ангижарч Бурханы зүйлс уруу орох.
 - c) Сүмд очих
 - d) Бусдад сайн зүйл хийх

2. Дараах зүйлийн аль нь талх хуваах тухай үнэн хэлж байна вэ?
 - a) Бид үүнийг бараг долоо хоног бүр хийх ёстой.
 - b) Бид үүнийг Дээгүүр өнгөрөх цагт жилд нэг удаа хийх ёстой.
 - c) Талх, дарс нь шууд утгаараа Есүсийн цус ба бие болно.
 - d) Талх, дарс нь Есүсийнбие ба цусыг төлөөлнө.

3. Дараах зүйлүүдийн аль нь гэрлэлтийн тухай үнэн хэлж байна вэ?
 - a) Бид зөвхөн жинхэнэ итгэгчтэй гэрлэх ёстой.
 - b) Итгэгчид гэрлэлтээ цуцлуулж болно.
 - c) Гэрлэсэн итгэгчийн эхнэр буюу нөхөр үл итгэгч бол тэдэнтэйгээ байхыг оролдох хэрэгтэй.
 - d) Гэрлэлтэнд эр хүн Христийг эм хүн итгэгчдийг төлөөлдөг.

"Bible Basics" in Mongolian
Duncan Heaster
Carelinks, PO Box 152, Menai NSW 2234 AUSTRALIA
www.carelinks.net info@carelinks.net